

АМЬДРАЛААС АВАХ БҮХНЭЭ АВ!

ГРЕТХЕН КРАФТ РУБИН

ЭРХ МЭДЭЭЛ

МӨНГӨ

АЛДАР НЭР

СЕКС



Эрх мэдэл мөнгө алдар нэр секс
Зохиолч: Гретхен Крафт Рубин
Орчуулсан: Т.Амардаваа
Хянасан: С.Нарангэрэл

ISBN: 978-99962-1-429-5


© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn


Оршил

Эрх мэдэл, мөнгө, алдар нэр, секс

Эрх мэдэл, мөнгө, алдар нэр ба секс нь нийгмийн шинж чанартай агуу хүсэл мөрөөдлүүд билээ. Хэрэгжүүлэх эсэх нь хүмүүсээс хамаардаг. Шатлан захирах ёс үгүй бол эрх мэдэл оршихгүй. Харьцуулалт хийхгүй аваас мөнгөний элбэг дэлбэг мэдрэгдэхгүй. Олон нийтийг дагуулахгүй бол алдар нэр ирэхгүй. Хүн хэзээ ч ганцаараа секс хийдэггүй. Эрх мэдэл, мөнгө, алдар нэр ба секс нь ойр төрлийн хүсэл тэмүүлүүд бөгөөд хэн нэгэн амжилт олсны дараа түүнтэй харьцуулагдаж явдагучраас хэзээ ч бүрэн хангагдах боломжгүй. "Эрх мэдэлд тэмүүлэгч Наполеонд атаархана. Наполеон Цезарьт, Цезарь Александрт, харин Александр үлгэр домгийн баатар Геркулест атаархдаг байжээ. "Та ганцаараа алдар нэрэнд хүрлээ гээд атаархлын мэдрэмжээс салж чадахгүй. Учир нь алдар нэр танаас илүү амжилт олсон хүмүүсийн түүх ба домогт үүрд үлддэг" гэж гүн ухаантан Бертран Рассел тэмдэглэсэн байдаг.



ЭРХ МЭДЭЛ



Нэгдүгээр бүлэг

Эрх мэдэл гэж юу вэ?

Эрх мэдэл гэж юу вэ? Та хүслээ хэлэхэд бусад хүмүүс биелүүлэхийг эрх мэдэл гэнэ. Эрх мэдлийн төлөө тэмцэхийн өмнө өөрийн одоогийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт хийх хэрэгтэй. Шийдвэр ба хийсэн алхамынхаа төлөө өөрийнхөө хэр хэмжээнд хариуцлага үүрч сурах хэрэгтэй. Цагаа өөрөө хянах ёстой. Ажилд ирэх, явах цагаа бүртгүүлэх, ажлаас эрт гарахын тулд уучлалт гуйх, ажил дээрээ байгаагүйн төлөө сануулга хүртэхийн хэрээр та арчаагүй байдлаа харуулдаг. Өөрөө өөрийгөө захирч чаддаг болсны дараа бусад хүмүүст нөлөөлөх ёстой. Үзэл санаа ба үйл хөдлөлийнхөө царааг улам өргөсгөсөөр нэг мэдэхэд та ирээдүйг олж харна. Гарын үсгээ таталгасан захидал илгээхдээ асар их таашаал авах тийм мөч танд ирнэ. Харин гучин жилийн дараа бол, та амин хайртай компаниа үхсэн хойноо ч өрсөлдөгчдөд явал алдахгүй байх вэ гэдэгт санаа зовж суух вий.

Таны амьдралын нөхцөл байдал, өрсөлдөх чадвар, хамгийн гол нь зан араншин л эрх мэдлийн хэв маяг ба далайцыг тодорхойлж өгнө. Ямар арга барил танд тохирох вэ? Эрч хүчтэй, авьяаслаг, нийтэч занд тулгуурласан арга барил уу? Эсвэл аажуу уужуу, үнэлж цэгнэмтгий, даруу төлөв байдал уу? Магадгүй өндөр шаардлагатай, огцом, түргэн ууртай байх уу? Гэхдээ энэ хэв маягуудын аль нь ч дангаараа амжилт авчрахгүй. Ямар тактик сонгох нь зөвхөн танаас хамаарна.

Эрх мэдэл нь шууд юмуу дам байж болно. Доорх сонжоогоор та эрх мэдлийн ямар хэлбэр танд тохирохыг шалгаарай.

Сонжоо.

Танд ямар эрх мэдэл чухал вэ? Шууд уу, дам уу?

Та өөрт тохирох хариултыг сонгоорой. Хоёр хариулт хоёулаа санхүүгийн асуудлыг хөндөж байгааг анхаарна уу?

1. Та өмгөөлөгч. Та албан тушаалын ямар амжилтыг илүүд үзэх вэ?

а. Түншүүддээ тулгуурлан өөрийн үйл ажиллагааны хүрээг өргөжүүлнэ.

б. Таны хуулийн онол ирээдүйн өмгөөлөгчдийн үйл ажиллагаанд нөлөөлөх

үүднээс хуулийн их сургуульд багшилна.

2. Аль нөхцөл байдал нь танд илүү нийцтэй вэ?

а.Танд үйл ажиллагаагаа дөнгөж эхэлж буй компани удирдах санал тавина.

б.Танд хамгийн нөлөө бүхий сэтгүүлд нийтлэл бичих санал тавина.

3. Ямар ололт нь танд илүү таашаал өгөх вэ?

а.Барилгын хажуугаар өнгөрөхдөө, хэрэв таны хувь нэмэр ороогүй бол энэ байшин сүндэрлэхгүй байсан гэж бодох

б.Гудамжаар алхахдаа таны нөлөөгүйгээр шинэ моод төрөхгүй байсан гэж бодох

4. Хэрэв хотын захиргааны бодлогод орсон шинэ чиг хандлага таны

дургүйцлийг төрүүлж байвал та хэрхэн зогсоох вэ?

а.Хэрэв энэ шинэ хандлага хүчин төгөлдөр болох юм бол та өөрийнхөө үйл ажиллагааг зогсооно гэж хотын даргад тайлбарлах б.Шинэ хуулийн эсрэг мэдэгдэл хийж хотын телевизээр гарна

5. Та үр удмынхаа ирээдүйг хэрхэн хангахыг хүсч байна вэ?

а.Би Итгэлийн сан байгуулах замаар өв залгамжлагчдынхаа орлого ашгийг хангана. Гэхдээ мөнгийг хий хоосон зүйлд зарцуулах боломжгүй байхаар хийнэ.

б.Би мөнгөнийхөө зарим хэсгийг үр удамдаа гэрээсэлж үлдээхэд дургүйцэхгүй. Гэхдээ энэ мөнгийг тэд өөрийн үзэмжээр ашиглах боломж олгоно. Би тэдний амьдралыг хянах хүсэлгүй байна. "а" ба "б" гэсэн хариултуудын аль нь олон болохыг тоолоорой.

"а" хариулт

Хэрэв таны хариултанд "а" давамгайлж байвал та шууд эрх мэдэлд тэмүүлдэг хүн. Та юмны үр дүнг урьдчилан харахыг хүсдэг. Жишээ нь байгууллагын дарга, мэс засалч юмуу хөтөлбөр зохиогч нар ингэдэг. Танд бүрэн дүүрэн, ил тод эрх мэдэл чухал. Та ямар ч сэв толбогүй нэр төрийнхөө үр шимийг хүртэх хүсэлтэй. Энэ нэр төр үйл ажиллагаагаа улам цэцэглүүлэхэд хэрэгтэй.

Шууд эрх мэдлийг хувийн ба төрийн аль ч хэвшилд олж болно. |Ямар ч тохиолдолд эрх мэдэл нь эд баялаг ба түүнийг хянах дээр тулгуурладаг.|

Хувийн хэвшлийн нөлөө бүхий салбарт ажиллах нь илүү хүртээмжтэй бөгөөд эрх мэдэлд хүрэх өндөр магадлалтай. Гэвч хэрэв та хувийн хэвшилд удаан ажиллахаас эмээж байгаа бол нийслэлд ирж засгийн газарт ажиллаж эхлээрэй. Хэрэв та аль нэгэн салбарт эрх мэдэлтэй болох юм бол өөр салбарт шинэ байр суурь эзлэхийн төлөө тэмүүлээрэй. Хувийн хэвслээс төрийн хэвшилд шилжих юмуу эсвэл эсрэгээр байж болно.

Шууд эрх мэдэлд дурлах таны ховдог зан ирээдүйд нөлөөнийхөө хүрээг улам өргөжүүлэхэд дээд зэргээр турхирна. Та бүхнийг хууль журмын дагуу хийхийг хичээнэ. Энэ тэмүүлэл том жижиг гэлтгүй бүхнийг хамарна. Дональд Трамп Манхэттений барилгуудын аль нэгэн дээр түүний ялгарах тэмдэг байгаасай гэж мөрөөддөг байв. Тэр өөрийн компанийн барилга дээр хэдэн футын өндөртэй алтан үсгүүдээр бичсэн нэрээ өлгөж энэ хүслээ гүйцэлдүүлсэн юм. Ерөнхийлөгч Никсоны улаан модон ширээн дээр эзнийх нь мөр үлджээ. Учир нь тэр ширээн

дээрээ хөлөө тохож суух зуршилтай байсан. Нэгэн удаа түүнийг гадаадад явах үеэр ширээг нь өнгөлж орхижээ. Эргэж ирээд үүнийг харсан Никсон "Чөтгөр ав, би ийм юм хийхийг тушаагаагүй. Би бусад ерөнхийлөгч нарын адил өөрийн ул мөрийг энд үлдээхийг хүссэн юм" хэмээн дургүйцжээ.

"б" хариулт

Хэрэв таны хариултуудын олонхи нь "б" бол танд хүмүүсийн санаа бодлыг бүрэлдүүлж байдаг дам эрх мэдэл чухал ажээ. Та үйл явдалд биечлэн оролцох албагүй. Таны нөлөө үйл явдал хэрхэн төгсөхийг шийдэж байдаг.



Дональд Трамп их мөнгөтэй байгаад зогсохгүй хамгийн их борлуулалттай номуудыг зохиосон алдартан болжээ.

Та олон бүрэлдүүлэхийн зохиолч юмуу Та академийн толгоилонгоо, эсвэл энэ зуны хамгийн сайн борлуулалттай номыг магтангаа, аль эсвэл зурагтаар зөвхөн үнэ бодит мэдээлэл гарах ёстой тухай захидлаа редакцид илгээнэ. Та хүмүүсийн бодол санаанд нөлөөлдөг. "У/оплеп'5 У/еаг Оа\у" ба "УГ сэтгүүлүүдийн эзэн Жон Феэчайлд "Богино өмдтөн" гэсэн хэллэгийг бодож олсон юм. Энэ хэллэг нь "Сайхан хүмүүс", "Моодны золиос" ба "Шинэ нийгэмлэг" гэх мэт ойлголтуудтай адилтгагдах болсон. Эдгээр нэрийг хэлэх үед тэд шууд төсөөлөгдөж байдаг. Ямар нэг юмыг тодорхойлохын тулд ямар нэг зүйлийг бий болгох шаардлагатай. Таны үзэл санаа бусдыг хөдөлгөөнд оруулах аваас таны эрх мэдэл хэмжээ хязгааргүй болно. Хэний ч үл таних чансааны шинжээч Генри Бложет удирдлагынхаа зөвшөөрөлгүйгээр интернетэд үнэ төлбөргүйгээр рейтинг байршуулах болжээ. Аптогоп.сот-д түүний олохоор төсөөлсөн ашиг 150-400 доллар

болж өсөв. Долоо хоногийн дараа гэхэд түүний рейтинг нь 325 долларын үнэтэй болжээ. Бложетын үгийн нөлөө Аптогоп.сот-ын үндэслэгч бөгөөд ерөнхий удирдагч Жефф Безосын мөнгөний байдалд шууд нөлөөлөөгүй ч тун мэдэгдэхүйц байлаа. Өөр нэг жишээ. Олон нийттэй харьцах албаны нарийн бичгийн дарга Говард Рубенштейн дам эрх мэдэлтэй байсан мөртлөө тун их амжилт олсон юм. Яагаад Жорж Штейнбрэннер, Леона Геллеслей, Майк Тайсон, Наоми Кемпбелл, Дональд Трамп зэрэг дуулиантай хүмүүс түүнийг хөлсөлдөг байв?

Хэдийгээр нөлөөллийн хүрээ нь хязгаартай боловч хошин шогчид, зураачид, телевизийн тоймч, шашныхан, менежментийн зөвлөгч ба профессорууд нь бусдыг өөртөө татаж ертөнцийг үзэх үзлийг бүрэлдүүлж байдаг. Энэ нь үр дүн гэхээсээ илүү учир шалтгаан юм.

Сэтгүүлчид асар их эрх мэдэлтэй байдаг. Яагаад гэвэл үйл явдлыг хүмүүс хэрхэн хүлээж авахад нөлөөлдөг. Энэ эрх мэдлийн хариуд "хаа сайгүй харагдах эмч" гэсэн мэргэжил гарч ирж байгаа юм. Энэ нь дам эрх мэдлийн өөр нэг мэргэжил бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд зориулан мэдээ сорчлох эсвэл бий болгох мэргэжил ажээ.

Анхаарал татсаны үр дүн нь эрх мэдлийн зайлшгүй эх сурвалж билээ. Анхаарлын төвд дөнгөж ороод ирмэгц л та улам их анхаарал татсан хүн болж хувирна. Яагаад? Яагаад гэвэл дам эрх мэдэлд үндэс суурь чухал байдаг. Энэ нь хорин оюутан суулгасан гял цал тэнхим эсвэл гурван зуун уншигч юмуу дөрвөн сая үзэгч байж ч болно. Та олонд анзаарагдахын хэрээр таны санаа бодол жин дарж эхэлдэг. Эрх мэдлийн энэ хэлбэрийг үр дүн багатай гэж бодох хэрэггүй. Опра Уинфри телевизийн алдартай ток шоуны хөтлөгч болсон. Тэрбээр дөнгөж 6800 ширхэг зарагдаад байсан романыг телевизээр магтсаны дараа 750 мянган хувь гүйж шилдэг борлуулалттай ном болсон байдаг. Та ч бас өөрийн телевизийн шоутай болж болно. Хэрэв та сургуулийн сонинд захидал бичиж хүүхдүүд дүрэмт хувцас өмсөх ёстой хэмээн эцэг эхчүүдийг итгүүлж чадвал дам эрх мэдлийг ашиглаж байгаа хэрэг. Мэдээж шууд ба дам эрх мэдлийг бие биенээс нь ялгаж салгах амаргүй. Нэгэнд нь нөгөөгийн оролцоо зайлшгүй шаардлагатай. Зарим хүний эрх мэдэл хоёулангийнх нь нийлбэр байх нь тун элбэг. Гэхдээ ийм хүмүүс тун цөөн бөгөөд асар их эрх мэдэлтэй байдаг. Тэд шийдэмгий үр дүнтэй үйлдлээ нөлөө бүхий үзэл санаатай хослуулж байдаг. Марта Стюартыг санаарай.

xxx

Та номын зохиогч байхыг хүсэх үү? Аль эсвэл түүнийг хэвлэх эсэхийг шийддэг хэвлэн нийтлүүлэгч байхыг хүсэх үү? Эсвэл та сурагчиддаа хувьсалын онолыг тайлбарладаг багш байх уу? Аль эсвэл боловсролын яамны сургалтын шинэ төлөвлөгөөний санал хураалтанд оролцохыг хүсэх үү? Эрх мэдлийн аль хэлбэрт тэмүүлж байгаагаа олж мэдээд, эрх мэдлийн боломжуудыг бүрэн ашиглаарай. Үүний тулд эрх мэдлийн найман тулгуур баганатай танилцаарай.

Эрх мэдэлтэй болох найман үндсэн арга зам

Хэрэв та олонхиос ялгаагүй бол эрх мэдлийн амтыг авмагцаа бүр илүү эрх мэдэлд дурлах болно. Та хийж болох өөрчлөлтүүдийн тухай, цаг хугацааг хэрхэн ашиглахаа ч бас мөрөөдөж эхэлнэ. Гэвч та эрх мэдлээ юунд тулгуурлан барьж босгож байна вэ? Эрх мэдлийн найман тулгуур багана дээр тулгуурлан өөрийн нөлөөллийн хүрээг өргөжүүлээрэй. Эрх мэдлийг дээд зэргээр олж авахын тулд аль болох олон тулгуурыг ашиглаарай. Гэхдээ тэдгээр нь таны хувь хүний онцлогт тохирч байгаа эсэхэд итгэлтэй байх ёстой. Хэрэв та хулчгар хүн бол сүлжээ байгуулах хэрэггүй. Хэрэв та оргилын тавцанд гарах санаандаа бүрэн автсан нэгэн бол Тэвчээрийн татах хүчний зарчим танд тус болохгүй. Эрх мэдлийг олон аргаар олж авч болно. Өөрийн боломжийг ашиглахын тулд яг тухайн нөхцөлд зөвхөн танд тохирох тэр аргуудыг сонгоорой.

1. Нийгэмд эзлэх байр сууриа өсгөх замаар эрх мэдлээ нэмнэ.

2. Бусад хүмүүсийг эрх мэдлийн эх сурвалж болгон ашиглана.

- Сүлжээ байгуулах

- Шууд өв залгамжлах

- Удирдах / Сургах

- Ойртох

- Хасах

- Орлох

- Бялдуучлах

3. Мэдээллээс бүү хоцор.

4. Төгөлдөршилийн татах хүчний зарчмыг ашигла.

5. Тэвчээрийн татах хүчний зарчмыг ашиглах

6. Мөнгийг капитал болгон хувиргах

7. Алдар нэрээ анхаарлын төвд аваачих

8. Сексийн хүсэл тачаалыг шатаах

Аргуудын талаарх онцгой санамж

Нийгэмд эзэлж байгаа байр сууриа тооцон эрх мэдлийг болгоомжтой олж авбал зохино. Таны боссод тун сайхан тохирох бодлого харин танд эсрэг үр дүн

авчирч мэднэ. Түүнд тоймгүй олон хүндрэлтэй асуудал тулгарах үед тэрбээр утсаар удтал ярих аваас бүгд л түүнийг хүнд нөхцөл байдалд тайван амгалан байж чаддаг гэж магтах болно. Харин та ингэж утасдах аваас ажлаас халж орхино. Хэрэв танай эмэгтэй дарга ням гаригийн өглөө эрт уулзалт хийхээр төлөвлөсөн бол хүмүүс түүгээр уриулахыг тэвчиж ядан хүлээнэ. Харин ийм уулзалтыг та төлөвлөх юм бол хэн ч ирэхгүй.

Анхаарал болгоомжтой байгаарай. Эрх мэдлийн төлөвлөлт таахад амархан байхын хэрээр үйлчлэл нь сулрах хандлагатай. Ямар нэг зүйлийг ямар ч хүчээр хамаагүй гүйцэлдүүлэх гэж оролдох нь сул доройн шинж. Таны эрх мэдэл байгалаас заяасан мэт байх нь чухал. Та ямар ч аргаар хамаагүй өндөр байр сууринд хүрэх гэж тэмүүлэх юм бол тоглоом тохууны бай болно. Эсвэл доод хүмүүст нэрээрээ дуудуулж харьцах гэвэл мөн л доог тохуу болно. Эрх мэдэлд тэмүүлж байгаага аажлын чухал шаардлага ба үр дүнгээр дандаа далдлан нууж байгаарай. Уг нь тан руу бусдаас илүү олон хүн утасддаг тул нэмэлт утас чухал хэрэгцээтэй хэдий ч та нэмэлт телефон утас шаардаагүй болохоороо өөрийн түвшний хүмүүсээс илүү. Та босстой харьцах илүү цагтай болохын тул оффисынхоо спорт танхимд өглөө эрт хичээллэх болсон юм биш. Зүгээр л та боссын адил ажлын өдрөө эрт эхлүүлдэг. "Миний хувьд хоногт дөрвөн цаг унтахад л хангалттай" гэж даруухан тайлбарлах хэрэгтэй.

1. Нийгэмд эзлэх байр сууриа өсгөх замаар эрх мэдлээ нэм

Таны эрх мэдлийн хамгийн ил тод эх сурвалж нь байгууллага дотроо эзэлж буй таны байр суурь юм. Энэ нь тодорхой эрх үүрэг ба зиндааг автоматаар бий болгож байдаг. Таны зорилго юу вэ? Аль болох цааш ахих.

Арай гэж захирлын нэгдүгээр орлогчийн албан тушаалд дэвшиж санаа амарлаа. Цаашдаа яах вэ? Таны цол хэргэмд нийцэх эрх дархуудыг ашиглаарай. Та тэргүүлэх мэргэжилтнүүдийн зөвлөгөөнд байлцах эрхтэй юу? Ингэхэд танд машинаа тавих тусгай зогсоол бий юу? Жижиг сажиг бүхэнд анхаарал хандуул. Захирлын нөгөө нэг туслах аливаа зөвлөгөөн дээр түүний баруун гарт сууж байгааг анзаар. Дараагийн удаа та эртхэн ирээд захирлын зүүн гарын суудлыг эзлээрэй. Тодорхой онцлох ялгаанууд нь эрх мэдлийн шатлан захирахууд эзэлж буй таны байр суурийг хэлээд өгнө. Ерөнхийлөгч Рейганий үед Цагаан ордны ажилтнууд ерөнхийлөгчийн ширээний ард суухдаа ямар байр эзлэхийг заасан хатуу журам баримталдаг байв. Дональд Риган санхүүгийн нарийн бичгийн дарга байсан үеийнхээ тухай ийнхүү дуржжээ. "Бид ил зуухны дэргэд ерөнхийлөгч рүү харан хагас дугуйрч суудаг байсан ба би яг Рейганы урдаас харсан суудалд суудаг. Энэ суудал минийх бөгөөд кабинетэд эзэлж буй миний байр суурьтай дүйцдэг байв. Энэ суудалд хуралд оролцож буй өндөр албаны хүн суудаг. Хэрэв хуралд дэд ерөнхийлөгч юмуу төрийн нарийн бичиг оролцох аваас би зөөлөн буйданд шилжин суух ёстой" гэжээ. Албан тушаалтан бүхэн өөрийн суудлыг эзэлнэ.

Цол хэргэмд анхаарал хандуулахдаа энэ нь таны хүссэн зүйл мөн гэдэгт итгэлтэй байгаарай. Тэр бүү хэл цоо шинийг бодож олсон ч хамаагүй. Жишээлбэл та дээш ахихдаа ерөнхий захирал биш дэд ерөнхийлөгч байхыг хүс. Тэр бүү хэл та нэг их чухал хүн биш байсан ч таны байр суурь маш чухал мэт хэлэгдэх хэрэгтэй.

Үйл ажиллагааныхаа далайцыг өргөжүүлэхийг оролд. Илтгэх бичиг дээш өргөхийн өмнө бусад ажилчид таныг халахыг хүсдэг гэж төсөөлж бай. Эсвэл танай хэлтэс удтал хүлээгдсэн асуудлыг шийдэж байна гэж төсөөлнө. Та өргөжүүлэхийн хажуугаар зарим эрх мэдлээ бусдад шилжүүлэх замаар тэнцвэржүүлэлт хийж байгаарай. Эрх мэдлийн хөшүүрэгт хэт ойртох нь түүнийг алдахад хүргэж мэднэ.

Компанийн эзний албан тушаал таныг бүх эрх мэдлээр хангаад өгнө гэж бүү бод. Ямар боломжийг ашиглахаа та өөрөө л шийдэх болно. Гэхдээ өндөр цол хэргэм ихээхэн эрх мэдэл өгдөг нь үнэн. |олонхийн аз болоход| "Силикон Графикс"-ын үндэслэгч Жим Кларкийгалбан тушаалаас нь огцруулсны дараа тэр онцлохдоо: "Би "Силикон Графикс"-д эрх мэдэлгүй болсон. Гэвч сэтгүүлчид үүнийг мэдэхгүй байна. Намайг дарга гэж дуудсан хэвээр. Сэтгүүлчдийн олонхи нь том компанийн дарга бол маш чухал хүн гэж боддог" гэжээ. Эрх мэдлийн тухай ойлголт түүнд эрх мэдэл өгч байсан бөгөөд энэ нь хэвлэлээр илрэлээ олов.

Нөгөө талаар сүртэй цол хэргэм үгүй байлаа гээд заавал эрх мэдэлгүй байх албагүй болохыг санаарай. Энэ нь нарийн бичгийн дарга, хүний нөөцийн албаны ажилтнууд, сахиуруудын хувьд ердийн зүйл бөгөөд хэдийгээр тэд өндөр цол хэргэмгүй боловч эрх мэдлийн төв болж байдаг.

Зөвлөмж:

Хэт урт цол хэргэм, нэгээс олон үгээр илэрхийлэгдсэн цол хэргэмээс аль болох зайлсхий. Нарийн бичгийн даргын орлогчийн нэгдүгээр туслагч эсвэл нарийн бичгийн даргын туслахын орлогчийн нэгдүгээр туслах гэх мэтийн цол хэргэмээс аль болох татгалзах ёстой. Харин ҮаЙоо-гийн босс |Үаlпоо дахь Жерри Янгийн хэргэм|, эсвэл ерөнхий дасгалжуулагч |Спортын холбооны Марти Ханакигийн цол хэргэм| эсвэл эмх журам ба оюун ухааны сайд |eпсoс1шд.сoт дахь Мартин Тобиасын хэргэм| гэх мэт цол хэргэмийг хүсч байгаа эсэхээ өөрөөсөө асуугаарай.

2. Бусад хүмүүсийг эрх мэдлээ нэмэхэд ашигла

Та эрх мэдлийг бусадтай харилцах харьцаан дээр босгох ёстой. Тэд таны амжилтанд дэм үзүүлж, албан тушаал ахихад тусалж, таны амьдралыг амар хялбар болгож өгнө. Бас эсрэгээр ч байж болно. Хэрэв тэд танд сонирхолгүй байх аваас таны төлөвлөгөөг тасалдуулах юмуу таны дэвшилд саад учруулна. Байж болох бүх холбоо хэлхээг хөдөлгөөнд оруулахыг хичээ. Таны гол зорилго нь аль хэдийн эрх мэдэлтэй болсон хүмүүстэй өөрийгөө адилтгах замаар тэднээс эрх мэдлийг нь шилжүүлэн авах явдал юм. Дараагийн долоон аргыг хэрэглэнэ.

- Сүлжээ байгуулах
- Залгамжлах
- Удирдах / сургах
- Ойртох

- Хасах

- Орлох

- Бялдуучлах

Сүлжээ

Танилын танилууд, сургууль, улс төрийн үйл ажиллагаа, хобби, доод тушаалын хүмүүс, клуб гэх мэт дээр тулгуурласан харилцааг бодож олох замаар бусад хүмүүсийн эрх мэдлийг ашиглана. Нэгэнт тогтоосон иймэрхүү харилцаа нь өнөөх танилуудаараа дамжуулан мэдээлэл авах, шадар дотно хүн болох, дэмжлэг эрэх болон бусад ашигтай зүйлсийг авах боломжийг бүрдүүлнэ. Коллежид нэг өрөөнд хамт амьдарч байсан нөхрийн зураг сонинд гарсан байхыг хараад та дурсамжинд автана. "Би чам руу яг залгах гэж байсан юм" гэсээр та түүнд утасдана.

Та хундагатай хүлээн авалт, гольф, клубын хурал, үдэшлэг цэнгүүнд ирэхдээ амрах зугаацах бодол тээж хэзээ ч болохгүй. Харин ч эсрэгээр та энд тасралтгүй ажиллах ёстой. Танилуудаа багжуулах, танилын хүрээгээ өргөжүүлэх үндэс суурийг тавих ёстой. |Гэхдээ та энд зөвхөн цагийг сайхан өнгөрөөх гэж ирсэн мэт дүр исгэх ёстойгоо бүү март.| Сүлжээний үр өгөөжийг хэтрүүлэн үнэлэх хэрэггүй. Сүлжээний нөлөө гавьяаг дарах нь олонтаа. Тиймээс хуучин найз нөхдийн сүлжээндээ онцгой анхаарвал зохино.

Таны нийгмийн ажлын хуваарь зөвхөн байнга харьцдаг хуучин найз нөхдөөр хязгаарлагдах учиргүй. Түүний оронд ажил мэргэжлийн танилуудаа найз нөхөр болго. Тэднийг гэр бүлтэйгээ хамт цанаар зугаалахаар урьж болно. Шинэхэн найзын хамгийн дуртай зугаа нь интернет тоглоом гэдгийг мэдэх юм бол түүний хамгийн сүүлчийн тоглолттой холбогдуулан баяр хүргэвэл зохино. Гэхдээ энэ гэнэтийн оргилсон сэтгэлээ юугаар тайлбарлахаа сайн бод.

Таныг дэмжих юмуу сөрөн зогсох чадвартай, шинэ, хэрэгтэй хүмүүстэй нөхөрлөх замаар өөрийгөө хамгаалаарай. Нью-Йоркийн хүчирхэг брокер ба архитекторч Роберт Моузес элэгсэг дотно харьцааг өөрийн зэвсэг болгон ашигладаг. Тэрбээр хүмүүсийг завины зугаалга юмуу эсвэл үдийн хоолонд урих замаар алмайруулдаг байв. Ерөнхийлөгч Франклин Рузвельт маргаантай асуудлыг албан бус нөхцөл байдалд ширээний ард налайн хэлэлцдэг байсан бөгөөд ирсэн зочид түүнтэй маргая гэхэд тун эвгүй байсан.

Та ямар нэг шунахайн сэдэлтэйгээр нөхөрлөж байгаагаа хэзээ ч бүү харуул. Эс тэгвэл түүнд төрүүлэх гэж байсан сэтгэгдэлийг үгүй хийнэ. Вашингтоны эзэгтэй асан Гвен Кафризын алдаан дээр суралцаарай. Тэрбээр конгрессийн гишүүн Жо Кейсигийн эхнэр рүү утасдаж шарзтай үдэшлэгт урьжээ. Цаадах нь урилгыг талархан хүлээж авч байгааг дуулангуутаа хатагтай Кафриз цааш нь хэлэхдээ: "Миний ойлгож байгаагаар танай нөхөрт Хөдөлмөрийн сайдын суудлыг санал болгосон юмаа даа" гэв. "Тийм ээ, та зөв ойлгож" гэж хатагтай Кейси хариуллаа. "Тэгвэл түүний албан тушаал батлагдсан тохиолдолд та бүхэн манайд ирж зоог баривал бид их баяртай байх болно" гэж хатагтай Кафриз хэлж орхижээ.

Цугларсан хүмүүсийн дунд хамгийн хүчирхэг байх нь хэдийгээр тун тааламжтай хэрэг боловч үүний оронд өөрөөсөө илүү нөлөө бүхий хүмүүстэй цагийг өнгөрөөх боломжийг

байнга хайж байгаарай. Лорд Честерфильд хүүдээ зөвлөхдөө "Цугласан хүмүүсийн дунд нэгдүгээр хүн гэдгээрээ бахархах нь дэндүү амархан, дэндүү тэнэг, хамгийн гол нь дэндүү хортой" гэсэн байдаг.

Та ажил мэргэжлийн болон нийгмийн хүрээний танилуудаа нэгдүгээрт тависнаар "хавтаст хэрэгтээ" шинэ уур амьсгал оруул. Их ашиг авчирдаг хүмүүс байдаг. Тухайлбал шинэ ажил бизнест удирдах дарга хайж яваа хүмүүс гэх мэт. Тэд голдуу дотно найзууд биш харин тийм ч ойр биш танилуудын дунд элбэг байдаг. Ийм хүрээгээ өргөжүүлэх боломжийг ашиглаарай.

Байнга өөрийн түвшний хүмүүс юмуу дарга нартай харьцахаас аргагүй байлаа ч өөрөөсөө доогуур хүмүүстэй харилцаагаа алдахгүй байх нь муугүй. Программист юмуу эсвэл өөр аль нэгэн ажилтанд хандаж тусламж гуйж байгаарай. Таны түвшний хүмүүсээс ч, бас таны удирдлаганд байгаа хүмүүсээс ч боломжууд гарч ирдэг.

Зөвлөмж:

Хоорондоо танилцахыг хүсч байгаа хүмүүсийг уулзуулах замаар эрх мэдлээ нэмэгдүүл. Вашингтоны зартай хатагтай нар болох Гвен Кафриц, Перл Места, Памела Харриман болон Евангелина Брюс нар гэрийнхээ зочдын өрөөг нийгмийн элитүүд цуглаж уулздаг газар болгосноор эрх мэдлийн төвд орсон. Сүлжээ байгууллагын удирдлагад багтаарай. "Тревелз групп"-ийн толгойлогч Сэнфорд Вейлл Нью-Йоркийн "Карнеги холл"-ыг уналтын үед нь дэмжсэн. Тэрбээр захирлуудын зөвлөлд нэр дэвшигчийн сонгуулийг сүлжээгээр орлуулж чадсанаар өөрөө захирлын албан тушаалыг авсан юм. Тун удалгүй олон олон мэдээж хөгжмийн хорхойтнууд хүмүүс эднийд нэгдэхийг хүссэн бөгөөд хүсэгчдийн тоо суудлын тооноос илүү гарав.

Залгамжлах

Хэрэв та шууд залгамжлагч мөн аваас их эрх мэдлийг олж авна. Холливудын алдарт жүжигчдийн нэг супер тагнуулч Майкл Овиц "Дисней"-гийн удирдагч Майкл Эйзнерийн шууд залгамжлагч болж "Дисней" компанийн захирлын албыг хүлээн авахдаа энэ суудалтай хамт асар их эрх мэдлийг олж авсан юм. Гэвч түүнд юу ч оногдохгүй нь тодорхой болсны дараа энэ эрх мэдлээс ул мөр ч үлдсэнгүй.

Зөвлөмж:

Та олон хүмүүст таалагддаггүй юу? Таныг их зантайд тооцдог уу? Бас бүдүүлэг гэдэг үү? Энэ тохиолдолд эзэрхэг удирдагч болох нь таны гол зорилго. Таны алдааны үр дагваруудаас хамгаалж чадах хүнд бол сайн бялдуулчил.

Хэрэв та үнэхээр эрх мэдэлтнүүдийн үр удам мөн бол шууд залгамжлагчийн байр суурь заримдаа тунчиг үр өгөөжтэй байх нь бий. 20 настай Лахлан Мердок бол "Мэдээллийн корпорац" хэмээх олон нийтийн мэдээллийн эзэнт гүрний эзэн Руперт Мердокийн 13 тэрбум долларын хөрөнгийн шууд залгамжлагч мөн. Тэгэхээр түүнд тэгж л хандана. Хэдийгээр АНУ эрх мэдлийг залгамжлуулахын эсрэг дайн явуулдаг ч Буш, Кеннеди, Гор нарын гэр бүл рүү хяламхийхэд л хангалттай. Эдгээр тохиолдолд улс төрийн эрх мэдэл өв залгамжлах хэлбэрээр

дамжиж байна.

Эрх мэдэл үргэлж урагшаа хардаг. Шууд залгамжлагч өнөөдөр эрх мэдэлтэй. Яагаад гэвэл тэр ирээдүйд эрх мэдэлтэн болох нь тодорхой. |Өнөөдрийн эрх мэдэлтний ивээлд байгаа шигээ.| Тийм ч учраас танай босс огцрох юмуу залгамжлах эрхийн асуудлыг шийдэхдээ дургүй байдаг, азгүй улс төрч хэнд ч хэрэгцээгүй нэгэн болдог.

Удирдах сургах

Удирдагч сурагч хоёрын аль аль нь энэхүү харьцаанаас хожиж үлддэг. Та удирдагч байхдаа доод хүмүүсээс үнэнч зүтгэл, хайр, талархал хүртэх ба өөрийн байгууллагыг сайтар сурталчилна. Нэрт найруулагч Стивен Спилберг нэгэнтээ хүлээн зөвшөөрөхдөө: "Залуу найруулагчид зорилгодоо хүрэхэд туслах нь нэрээ хичээхтэй хамт явдаг юм. Нэрээ хичээх нь бүхнийг дахин шинээр эх лэх боломж бөгөөд өөрийгөө дөнгөж эхэлж буй найруулагчийн дүрд шингээж байгаа хэрэг" гэсэн юм. Хэрэв та сайн багш гэсэн нэр алдар олох юм бол чадварлаг хүмүүсийг өөртөө татах боломжтой болно. Харин тэдгээр хүмүүс таныг тулж дэмжих нь гарцаагүй.

Сурагч нь таны хувьд холбоотон бас зөвлөгч болж өгдөг. Нөлөө бүхий ганцхан хүний дэмжлэг хүртэл таны амжилтанд хүрэх замыг түргэсгэж өгнө. Түүнээс гадна таны байдал эвгүй болсон үед энэ хүний хамгаалалт таны аюулгүй байдлыг хангана. Багш сурагч хоёр үнэтэй мэдээллүүдийг солилцож байдаг. Гэвч иймэрхүү төрлийн харилцаанд бүрэн татагдан орохоос болгоомжлоорой. Хэрэв та хэн нэгний одонд хэт ойртож гагнагдах аваас өөрийн хувь тавиланг хянах чадваргүй болно.

Зөвлөмж:

Танд эрх мэдэл байгаа эсэхийг боддог уу? Хэрэв таны сэтгэл санаа өнөөдөр ямар байгаа талаар бусад хүмүүс идэвхитэй хэлэлцэж байвал эрх мэдэлтэйн баталгаа.

Хэрэв та багштайгаа сайн харьцаа тогтоохын тулд байдгаараа хичээж байтал өөр хэн нэгэн түүний хайртай сурагч болохыг хүсвэл яах вэ? Хэдийгээр тэр хэн нэгэн давуу байдал эзлэн жаргаж байхыг харах нь хэцүү байлаа ч та хэзээ ч увайгүй нэгэн бүү болоорой. Хайр ивээлд орсон тэр хүний нэр алдарт халдах оролдлого нүдэнд ил болсоноор та сул дорой хүч чадалгүй харагдах болно.

Ойртох

Нөлөө бүхий хүнд ойртох юмуу ойртох замыг хянах аваас та эрх мэдэлтэй болно. Ларри Кингийн эрх мэдлийг санаарай.

Ойртох гэдэг нь дам утгатай үг биш. Шууд утгаараа эрх мэдэлтэнд ойртож чадвал та түүний ивээлд орно. Ерөнхийлөгчийн ажилтнуудыг удирдаж асан Хендеман өөрөө ерөнхийлөгч Никсоны үед хамгаалагчийн албан тушаалд багтай суух, бас нарийн бичгийн дарга Роуз Мэри Вудзыг ерөнхийлөгчтэй ойр дөт эрх мэдэлтэй байхад нь саад болох үүднээс голдуу нарийн бичгийн дарга нарын эзэгнэдэг байсан ерөнхийлөгчийн дугуй танхимын дэргэдэх өрөөг

Эзлэхэд нь саад хийжээ.

Биеийн хувьд ойр дөт байх нь шатлан захирахуйд ямар байр эзэлж байгааг харуулна. Төвд хичнээн ойр байх тусам сайн. Засгийн газрын гишүүдийн нөлөө даац нь цуваа явж байх үед түүний машин ерөнхийлөгчийн машинаас хэр хол байх зайгаар тодорхойлогддог. "Мөрөөдлийн фабрик"-ийн амжилт олоогүй бөөн жүжитчдийн тухайд хэн Энди Уорхолын машинд сууж байнав тэр л хамгийн их ивээл хүртэнэ гэдгийг андахгүй.

Эрх мэдлийн эх сурвалж байгаа газраасаа хамааран өөр өөр. Гэвч ойр дөт байх нь үргэлж асар их ач холбогдолтой. Холливудын одод гэхэд Оскарын шагнал гардуулах үед суух зогсох байрлалдаа маш их санаа зовдог. Нью-Йоркийн мундагчуул "Жилийн улирлууд" зочид буудал юмуу захирлуудын зөвлөлийн хурлын танхимд ямар байрлал эзлэхдээ санаа зовдог. Та хэн байлаа ч гэсэн зөв байрлал сонгох ёстой. Жишээ нь та загварын үзүүлбэрт ирлээ гэж бод. Та эхний эгнээний голд яг тайзны эсрэг талд суухыг хүсээрэй. Энэ байрлалаас холдох тусам л таны түвшин доошилж байдаг.

Эрх мэдэлд ойр байхын хэрээр сэтгэл санаа өөдрөг явдаг. Энэ нь танд өөрийн салбараас гаднах үйл явдалд ч оролцох боломжийг олгоно. Ерөнхийлөгч Клинтонтой итгэлт харьцаа тогтоохоос өмнө Дик Моррис хэний ч үл мэдэх улс төрийн зөвлөгч байв. Тэгвэл "Тайм" сэтгүүлд бичсэнээр энэ харилцаа түүнийг "Америкийн хамгийн нөлөө бүхий иргэн" болгосон юм.

Салбадай: **"Хэрэв уулан дээрээс том дугуй өнхөрч байвал хүзүүгээ хуга дайруулахгүйн тулд хажуу тийш зайл. Харин том дугуй уул руу өгсч байвал түүнээс байдгаараа зуур"**. Уильям Шекспир "Лир хаан".

Гэхдээ эрх мэдэлд ойр дөт байх нь нэг их удаан үргэлжлэх үзэгдэл биш учраас ихээхэн найдваргүйд тооцогдоно. Энэ нь сургахтай тун төстэй. Хэрэв танаар хичээл заалгасан нөхөр бүтэлгүйтэх юм бол таны амжилт ч бас үгүй болно. Гари Харт Колородад шилжин очих шийдвэр гаргамагц түүний багийнхан шинэ ажил хайхад хүрсэн. Учир нь Майамигийн загвар өмсөгч Донна Райстай холбоотой болох нь илэрч 1988 оны ерөнхийлөгчийн сонгуулиас нэр нь хасагджээ. Утга учиргүй ажилд ойр дөт байх нь хэт аз үзсэн хэрэг.

Дүрэм:

Хэрэв та өөрийн байр суурийг бусдад дамжуулж байгаа бол та тэдний амжилтын барьцааны хүн болно.

Хасах

Ямар нэг юманд татагдан орох түгээмэл хүсэл ба түүнээс ч илүү хүчтэй хасагдах мэдрэмж хоёрын аль алинаас ашиг гаргаж сур. Танд тохирох хүмүүсийн хүрээллийг үүсгэж, хяналтандаа аваарай. Ядахдаа тийм хүрээлэлд нэгдээрэй. Энэхүү бүлэглэл нь "Хэн нэгэн болж чадсан хэн бүхнийг" өөртөө нэгтгэнэ. Энэ бүлэглэлд албан |хүн бүр ням гаригт босстой шуурхай уулзахаар ирэх| байж болохын зэрэгцээ албан бус |хүн бүр Пэтийн өрөөний дэргэд

цугларч шинэчлэн зохион байгуулалтын асуудлаар ярилцах| байж болно. Хаалга тасхийн хаагдах үед өрөөнд байгаа хэн бүхэн түүний дотор та ч бас аюулгүй байдалд байхыг хүснэ. Бусдаас өөрийгөө бүү тусгаарла.

Бүлгийн доторхи хүмүүс бие биетэйгээ нягт холбоотой байдаг. Тиймээс бүлэгт харьяалагдахгүй хүмүүс тухайн бүлэгтэй хамтран ажиллахын тулд тийшээ орохыг хичээнэ. Эсвэл тэдгээр гадны хүмүүс өөрийн бүлгийг бий болгоно. Бүлгийн

гишүүд бүлгийн гишүүн бус хүмүүсээс өөрсдийгөө тусгаарладаг. Бүлгийн гишүүд нэг байр суурь, нэг сонирхол, тэр бүү хэл нэг хэв маягаар гагнагдсан байдаг. Тэд бие биенээ бахдан бахархах замаар тулж дэмждэг. Бас гадны хүмүүст зэвүүцэн ханддаг.

Зөвлөмж:

Хурал дээр суух байрлалаа сонгохдоо ширээний хойморт залрах нь шилдэг суудал гэж бүү бод. Харин ширээний дунд хавиар, ширээнд суусан бусад хүмүүстэй аль болох ойр суух аваас тэдэнтэй ярилцах, тэдэнд нөлөөлөх боломж тань ихэснэ.

Хасах зарчмыг өөрийн удирдлагад байгаа хүмүүсээс гадна тантай ижил байрлалд байгаа хүмүүст ч хэрэглэж болно. Өөрийгөө тойруулан бүлэг нягтруулахын тулд хүмүүсийг "манайхан" ба "тэднийхэн" хэмээн хувааж харагдуулах тийм нөхцөл байдлыг бий болгоорой. Өөрийн бүлгийн оршин байгаа тухайг мэдүүл. Та "манай" хүмүүсийн нэгэнд бусдад дуулдахуйц чангаар "манай хэд маргааш ажлын дараа кафед суух гэж байгаа" гэж хэлнэ. Зөвхөн хэрэгтэй хүмүүстэйгээ чухал мэдээлэл хуваалцахын тулд электрон шуудангаар оролддог хаалттай бүлэглэлийг бий болго.



Рональд Рейган Цагаан ордонд орж ирэнгүүтээ тансаглалыг сэргээжээ.

Хэрэв та хэн нэгнийг удирдаж байгаа бол хасах зарчмыг ашигласнаар өөртөө үнэнч зүтгэлтэй бүлэг хүмүүсийг бүрдүүл. Тэдэнд нэмэлт ажлаар ачаалал өгөх, гэр рүү нь утасдах, хүнд асуултууд тавих замаар танд дуртай хүмүүсийг ялгаж ав. Илүү шаардамтгай болохын хэрээр та хүмүүсийн үнэнч байдлыг өөгшүүлнэ. Хэмжээнээс нь илүү ажил ноогдуулахын хэрээр тухайн хүнийг онцолж байгаагаа харуулна. Та таагүй хандлагыг аль болох дарах хэрэгтэй. |Эсвэл их үсрээд л таны дагалдагчид бие биедээ гомдоллохоос цаашгүй| Тун удалгүй та зөвхөн таны төлөө илүү их зүтгэн ажиллах, танд үнэнч бүлэг хүмүүсийг бүрдүүлж чадна. Тэд энэхүү бүлэг дотроо өөрийн байр суурьт тохирох бүхнийг хийнэ. Хайртай хүмүүстээ тусгай нэр бодож олох хэрэгтэй. Жек Кеннеди хамгийн ойр хүмүүстээ хүүхдийн нэр өгч бусдаас ялгаруулдаг Рональд Рейган Цагаан байв- |Яагаад хүүхдийн нэр өгдөг гэж та бодож байна ордонд орж ирэнгүүтээ вэ?| Тухайлбал Бен Бредли хэмээх найз сэтгүүлчээ

тансаглалыг сэргээжээ. Бенни, найз бүсгүй Инга Авадыг Инга-Бинга, өөрийн

ах Роберт Кеннедиг Бобби гэх мэтээр дууддаг байв. [Хэдийгээр ах нь энэ нэрэнд тун дургүй байсан ч дуудсаар л байсан.] Та болон бүлгийн бусад гишүүд бүгд адил тэгш анхаарал халамж авч байгааг мэдэрч байгаарай. Та бүлгийн гишүүдийн нэг. Тэгэхээр таны алгуурлал нүдэнд нэг их тороод байхгүй. Энэ нь анхааруулга авахгүй байх сайн талтай. Бүлэгт багтаж байгааг батлах өөр ямар баталгаа илүү санагдах юм бэ?

Зөвлөмж:

Хэрэв та өөрийн тань төлөө ажиллаж буй хүнд онцгой анхаарал үзүүлэхийг хүсвэл доорхи утга бүхий зурвас илгээ. "Энэ асуудлаар би таны хувийн байр суурийг мэдмээр байна". Авсан хүн өөрөөрөө тун их бахархах болно. Иймэрхүү зурвас юмуу баримтыг өөр хэд хэдэн хүнд илгээ.

Орлох

Зарим албан тушаал орлогчтой байхаас аргагүй. Энэ нь хоёр талын аль алины эрх мэдлийг багжуулдаг. Тухайлбал улс төрчид туслахуудынхаа бүлэг дээр тулгуурлах ба тэд түүний төлөөлөгчид болж өгдөг. Албан хаагч дарга дээрээ тулгуурлах бөгөөд ингэснээр түүнд улам илүү сүр хүч нэмнэ. Та толгойгоо сэгсрэн "Энэ бүтэхгүй ээ. Манай босс үүнийг хүлээж авахгүй" гэж хэлнэ. Энэ үед та |өрөөнд байгаа бусад бүх хүний адил| босс энэ ажлын тухай юу ч мэдэхгүй, яагаад гэвэл тухайн ажлыг таны гарт бүрэн өгсөнийг мэдэж буй.

Магадгүй танай босс тэмцэл сэргэлдөөнөөс зайлсхийдэг байж болно. Тэгвэл та хэний ч үл дурлах хөлсний алуурчин юмуу "муу цагдаа"-гийн дүрийг өөртөө авснаар эрх мэдэл рүү шунаж болно. Энэ үед танай босс "шударга цагдаа"-гийн дүрд тоглох боломжтой болж өгдөг. Аливаа хянамгай ерөнхийлөгч бүхэнд иймэрхүү ажлыг хийдэг доод тал нь нэгийн зэрэг хүн байдаг. Хелдемен, Дональд Риган, Жон Сумуни нарыг санахад хангалттай. Ерөнхийлөгч Клинтон засаглалынхаа эхэн үед Томас Маклатиг хүний нөөцийн даргаар тавьсныхаа төлөө саад тотгортой учирч байсан. Гэвч Томастачаал ихт Клинтонд ус агаар шигхэрэгтэй байсан "муу цагдаа"-г олж түүнд төлбөр хийх зүрх зориг гаргаагүй юм. Кино үйлдвэрлэл, утга зохиол хэвлэлийн салбарт менежер, хувийн туслагчид, хуульчид ба агентуудын шаардлага хоорондоо эсрэг тэсрэг байдгийн улмаас авьяаслаг хүмүүс тухайн үйлдвэрлэлтэй найрсаг харьцаа тогтоож чадахгүйд хүрдэг.

Үндсэн тоглогчийн орлогч болох нь эрх мэдэлд хүрэх тал дээр бол дэндүү дэмий байж мэднэ. Учир нь энэ дүрийг хэн ч анзаарахгүй өнгөрдөг. "Челленжер"-ийн сансарын нисгэгчдийн тухай "Энэ хүмүүс дэлхийн бүрхэг хязгаарыг орхиж бурхантай нүүр тулахаар одлоо" гэж хэлсэн үгний төлөөх магтаалыг яг хэн хүртэх ёстой юм бэ? Энэ магтаал ерөнхийлөгч Рональд Рейган юмуу түүний илтгэл бэлтгэгч Пегги Нуман нарын хэнд ч оногдох ёсгүй нь хожим тодорхой болсон.

Итгэл олох гэж зүтгэх нь бүтэлгүйтэхийн цондон. Яагаад гэвэл боссын амжилтын төлөө орлогч хэзээ ч харамж хүртэхгүй. Өөрийнх нь ажил бусдын нэрээр гарч байгаад орлогчууд ихэнхидээ бухимдан ханддаг. [Хожим өөрийнх нь уншаа ч үгүй ажлын дор нэр нь байхыг

хараад бүр биеэ барьж чаддаггүй|. Мэдээж туслагч бүхэн нэрд гарахгүй үлдэнэ гэж байхгүй. Улс төрийн мэдээний тоймч Жек Жермонд ерөнхийлөгчийн илтгэл бэлтгэгчдийн тухай: "Үл үзэгдэх зохиогч нь Дик Гудвин юмуу Билл Сефайе нарын хэн байсныг бид тэртэй тэргүй олж мэднэ" гэж хэлсэн байдаг.

Бялдуучлах

Хэдийгээр гэрчүүдийн дэргэд бялдуучлах нь нэр төрд сайнгүй ч энэ нь дээш ахих тун үр дүнтэй арга байдаг. Илүү нөлөө бүхий хүмүүст бялдуучилснаар, эсвэл "тэдэнтэй чадварлаг харьцсанаар" та эрх мэдэлтэй болно. Өөрийн чадал хүч, идэвхи зүтгэлийг нийгмийн шатлал дээр танаас өндөрт зогсч байгаа юмуу эсвэл танд илүү ашигтай тэр хүмүүс рүү хандуул. |хэн ч байж болно|.

Таны бялдуучлал илүү үр дүнтэй байхын тулд хэрэгтэй хүнийхээ дадал зуршил ба зан араншинг сайтар судлаарай.



Генри Киссинжер нэгэн удаа ерөнхийлөгч Никсонд "таны гольф тоглох чадвар үнэхээр сайжирч байна шүү" гэж хэлээд алдаа гаргажээ.

-Түүнд ямар нэг юм шаардлагтай болох нөхцөл байдлыг үүсгээд үүнийг нь хийж өг. "Дарга аа илтгэл түгээх хүмүүсийн жагсаалтанд таны нэр байгаагүй. Тэгэхээр нь би танд хүргэхийн тулд бүхнийг хийсэн". Уг нь таныг ингэж хэлэх хүртэл тэр хүн энэ илтгэлийг авах талаар нэг их санаа зовж байгаагүй. Харин одоо таны зүтгэлийн төлөө талархаж эхэлнэ. Энэ зарчим |бусад бүхний адил| зөвхөн ажил дээр үйлчилдэг юм биш. Питер Дачин өөрийн дурсамжинд бичихдээ улс төрч, бизнесмен Эверелл Харриман эхнэр Памелатайгаа гэрлэх үедээ "Бүх юм үнэхээр гайхалтай байна. Яагаад гэж үү? Яагаад гэвэл Памела өглөө бүр миний дуртай цэцгийг орон дээр минь тавьдаг" гэжээ. Тэгэхээр нь Дачин "Үнэн гэж үү? Танд дуртай цэцэг байдаг гэж би огт мэдээгүй юм байна. Тэр чинь тэгээд ямар цэцэг юм бэ?" гэж асуужээ. Харин Харриман бодол болсноо "Яг ямрыг нь би мэдэхгүй байна. Ямар ч гэсэн л тэр өглөө бүр цэцэг тавьдаг" гэж хариулсан байх юм.

• Хэрэгтэй хүнийхээ нууц хүсэлд таацуул.

Магадгүй тэрбээр өндөр зиндааны хүмүүс, тамирчид юмуу загвар өмсөгчидтэй харьцахыг хүсдэг байж мэднэ. Тэгвэл үүний төлөө бүхнийг хий. Тэр бусдад ямар сэтгэгдэл төрүүлэхийг хүсч байгааг нь тааж ол. Моодтой хөл нийлүүлэн алхдаг дээдэс юмуу эсвэл бүх хүний хайртай хурц ухаантай нэгэн мэт сэтгэгдэл төрүүлэхийг хүсч байж болно. Магадгүй бусад хүмүүс түүнээс айдаг байхыг хүсч мэднэ. Боловсролтой, их юм уншсан хүн мэт харагдахыг хүсч байж ч магадгүй. Энэ бүхнийгтооцоол.

"Деций: -Түүнд

бялдуучлахыг үзэж чаддаггүй хүн гэж өөрт нь хэл. Тэр энэ нэрэнд тун дуртай байх болно"

Уильям Шекспир "Юлий Цезарь"

Та "бай" болгон сонгосон хүнээ бялдууч болон зусарч хүмүүст хичнээн дургүй болохыг нь өөрт нь хэлж байхад илүүдэхгүй. Тэр ийм болхи бүдүүлэг, арга ядсан тактикт автах хүн биш гэдгийг нь өөрт нь хэлээд байгаарай.

- Өөрийн бахдан биширч байгааг илэрхийлэх боломжийг бүү алд. Гэхдээ болгоомжтой байгаарай. Нэгүдээ ерөнхийлөгч Никсон Кэмп-Дэвид дэхөрөөндөө ирэнгүүтээ "Би дөнгөж сая 26 оноо авч чадлаа" гэжээ. Төрийн нарийн бичгийн дарга Генри Киссинжер тун их бялдуучлан "Таны гольф тоглох чадвар улам илүү болж байна шүү ноён ерөнхийлөгч өө" гэхэд ерөнхийлөгч "Би боулинг тоглосон юм л даа" гэж хэлээд мушийжээ.

Дүрэм

Бялдууч хүн хэзээ ч худлаа санагддаггүй. Яагаад гэвэл бялдуучлуулж байгаа хүн нь бүхнийг үнэн шүү гэж хүлээн авдаг.

- Даган дууриах нь бялдуучлалын ил хэлбэр юм. Өөрийн "бай"-г их бага юм бүхэнд хуулбарлаарай. Түүний амьдарч байгаа хороололд амьдарч, яг тэр хүн шиг хувцаслаарай. Билл Гейтс "лексус" машин унадаг байжээ. Удалгүй "Майкрософт" компанийн зогсоол зөвхөн ийм машинаар дүүрсэн гэдэг. [Мэдээж даган дуурайхдаа хэтрүүлж болохгүй. Учир нь дуурайгаад байгаа тэр хүнээ бухимдуулж мэднэ]. Жинхэнэ бялдууч хүн ууган хүүгээ төрөхөд өөрт хэрэгтэй тэр хүнийхээ нэрийг хүртэл өгдөг. Шахин сануулахад тухайн нөхцөл байдлаас хамаарч энэ бүхэн засдаг зантай хүн мэт санагдуулах аюултай.| Түүнтэй ижил хувиараар амьдар. Таны бай Арманигийн хувцас өмсдөг үү? Хамгийн ойрын кафед хуульчид уу? Дуурьт дуртай юу? Яг түүнийг нь хий. Түүнд таалагддаг кинонуудыг үз. Түүнтэй нэг сэдвээр ярилцахын тулд түүний дуртай номуудыг унш. Ерөнхийлөгч Клинтон "Эргэцүүлэл" номонд дуртайг мэдээд Вашингтоны барагхүн бүхэн Марк Аврелийн энэ номыгуншсан гэдэг.

-Байтайгаа үе үе тоглоом наргиан хийх юмуу маргалдах гэх мэтээр нөхөрсөг харьцаа тогтоо.

Болгоомжтой бялдуучил. Хэрэв таны бялдуучлал нүдэнд өртөхүйц байх аваас өөртөө ижил түвшний хүмүүс болоод өөрийн удирдлагад байгаа хүмүүсийн зүгээс дургүйцэлтэй тулгарна. Өнөөдрийн жирийн түшмэл маргаашийн хүчирхэг магнат байж мэднэ. Өөртөө дайсан үүсгэх хэрэгцээ байхгүй.

"Марк Антоний хүмүүс яагаад бялдуучлалыг үнэнч шударга зангаар

хааж нуудагийг хэзээ ч ойлгож байсангүй. Ийм хүмүүс юм ярихдаа дээрэнгүй, үргэлж тоглоом наргиан хийх ба ялангуяа баярласан үедээ бүр их. Тэд ингэж илт зусардах нь хаашаа шийдэгдэхийг шийднэ гэж үздэг. Гэвч тэд хүнтэй зүгээр л бялдуучлах гэж уулзаж байна гэдгээ огт боддоггүй"

**БУСДЫГ ЭРХ МЭДЛЭЭ НЭМЭХЭД
АШИГЛАХАД ЗОРИУЛСАН ЗУРАГЛАЛ**

| Нөхцөл байдал | Ингэвэл дээр | Ингэх хэрэггүй |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Үдэшлэг дээр та Питертэй бараг бүтэн цагийг ярилцаж өнгөрөөв. Тэр бол авъяаслаг залуу продюссер Рендигийн найз ажээ. Та хамгийн сүүлийн зохиолоо санал болгохын тулд Рендитэй танилцахыг мөрөөддөг. | Долоо хоногийн дараа Питерт утасдаад ингэж хэлээрэй. "Би агаарт гарч мах шарах гэж байгаа, хэд хэдэн найз нөхөд маань ирнэ. Чамайг ч ирнэ гэж найдаж байна. Бас хэн нэг найзаа дагуулж ирж болно шүү". | Долоо хоногийн дараа Питерт утасдаж хэлэх нь "Би агаарт гарч мах шарах гэж байгаа, найзууд маань ирнэ. Чамайг ирнэ гэж найдаж байна. Өө нээрээ, найз Рендигээ дагуулаад ирээрэй". |
| Нөхцөл байдал | Ингэвэл дээр | Ингэх хэрэггүй |
| Танай босс өнгөлөг тод хувцаслагдгаараа ихэд бахархдаг. Нэг удаа тэр нэр хүнд бүхий хуулийн товчооны оффист хэт моодны хурц зангиа зүүсээр орж ирэв. | Худлаа цочирдсон царайлан хэлэх нь: "Таныг хүүүндээ зүүсэн наргианы чинь төлөө шийтгэж мэднэ шүү. Учир нь энэ байгууллагын дүрэм журамд нэг их нийцэхгүй байна". | "Таны зангиа надад таалагдаж байна. Ёстой гоё" |
| Нөхцөл байдал | Ингэвэл дээр | Ингэх хэрэггүй |
| Таныг болон өөр бас нэг ажилтныг дөнгөж саяхан ажилд авсан. Гэхдээ та түүнээс арай түрүүнд ажилд орсон учир даргын өрөөний хажуугийн юмуу эсвэл урдаас нь харсан өрөөний аль нэгийг сонгох боломжтой. | Даргын өрөөний өөдөөс харсан өрөөнд байрлаарай. Та даргыг хэнтэй уулзаж байгааг харах, утсаар ярьж байгааг нь чагнах боломжтой. Түүнээс гадна анзаарагдах боломжтой болно. | Өөр хонгилын өрөөнд орох. Та нэгэнт даргын нүдэнд өртөхгүй учраас цагаасаа эрт ажлаас гарах юмуу хувийн ажлаараа утасдаж болно. |
| Нөхцөл байдал | Ингэвэл дээр | Ингэх хэрэггүй |
| Танай босс таныг өөрийн байгууллагын өрсөлдөх чадварын түвшинд дүгнэлт хийж нийтлэл бичихийг хүслээ. Бүтэн сар шаргуу хөдөлмөрлөсний эцэст та өргөх бичгээ түүнд барив. Дарга үг үсгийн хэдэн алдааг зассанаа гарын үсгээ таталлаа. Ингэснээр өргөх бичгийг бусад хүмүүс өндөр үнэлэв. | Та бусдад ингэж хэлээрэй. "Энэ өргөх бичиг дээр босстой хамт ажиллахад үнэхээр гайхалтай байлаа. Энэ хугацаанд би түүнээс маш их юманд суралцлаа". | Бүх хүнд "энэ ажлын талаар магтаал сонсох ёстой ганц хүн нь би. Гэтэл дарга гарын үсгээ зурсанд би итгэж чадахгүй байгаа юм. Тэр энэ бичиг баримтыг боловсруулахад оролцсон гэж өөрөө өөртөө хэлэхийн тулд хэдхэн засвар хийснээс цаашгүй" гэх. |

3.Мэдээлэлтэй бай

Мэдээллийн гурван зарчмыг ашиглаж сур. Мэдээллийг бүтээ. [Бодож олоод өөрөө тараа], мэдээлэлтэй бай [бусад хүмүүсээс мэдээ бүтээхийг шаард], мэдээллийг хяна [мэдээлэлд хүрэх замыг хянаж манаач шиг байгаарай], Энэ бол яг тойрог гүйхтэй адил. Танд мэдээлэл их байхын хэрээр та эрх мэдэлтэй болно. Харин эрх мэдэл их байхын хэрээр их мэдээлэл олж авдаг.

Их юмтай хүнд улам их оногддог гэсэн алтан дүрэм бий. Алтан дүрэм мэдээллийн солилцооны хүрээнд ч хүчинтэй үйлчилнэ. Хэн шилдэг эх сурвалжтай байна тэр шинэ мэдээлэлд хүрэх замыг эзэмшинэ. Холбооны нөөцийн сангийн дарга Алан Гристпен эдийн

засгийн асуудлаар мэдээлэл тун сайтай байсан. Хэрэв Нью-Йоркийн Эдийн засгийн клубт илтгэл тавьсных нь дараа та түүнээс юм асуухын тулд үлдэж хоцорсон бол түүний мэдлэг танд илүү ашиг авчрах уу эсвэл хөрөнгө оруулагч Уоррен Баффетад авчрах уу?

Мэдээллийн гинжнээс тасрах юм бол жинхэнэ сүйрэл. Тийм учраас мэдээллийн гинжин хэлхээн дотор байхын тулд тэмцэх хэрэгтэй. Мэдээлэл амттай байх тусмаа сайн. Эдгар Гувер өөрийн олж авсан мэдээллийнхээ ачаар ер бусын эрх мэдэлтэй болдог байв. Конгрессийн гишүүд түүнээс айж, ерөнхийлөгч хүртэл халах зориг хүрдэггүй байлаа. Учир нь Гуверын нууц файлд албан тушаал ахих замыг нь сүйрүүлж мэдэх мэдээлэл байгаа гэдгийг бүгд мэддэг байсан.

Сониуч байгаарай. Оройн 20.30 болж байхад нэгэн ажилтан оффист хүнгүй болсныг далимдуулан бичиг баримтнаас хулгайгаар хэд хэдэн хуулбар хийхийг та санамсаргүй анзаарав. Ажилтан явахдаа хувилах машины таг дор баримтын эх хувийг мартаад явчихжээ. Ингэхэд тэр юу орхисныгяагаад харж болохгүй гэж. Танай босс утсаар ярихдаа хаалгаа хааж байвал их хачин байна даа. Нарийн бичгээс нь "Түүн рүү Пэт Смит утасдсан уу? Үгүй гэж үү? Тэгээд хэн юм бол?" гэж асуугаарай. Хэвлэх машинаас баримт бичгээ авах гэж тонгойтол өөр хэвлэгч машинд илгээсэн "Маш нууц. Цалин ба шагнал" гэсэн толгой бүхий хуудас харагдвал сонирхохгүй байх аргагүй. Та хэнд ч анзаарагдамгүй шаламгай хөдөлгөөнөөр энэ хуудас цаасыг хавтсандаа шургуулаарай.

Мэдээлэлд хямгатай ханд. Танай дарга тун удахгүй Дикийг халж харин Жейнийг дэвшүүлэх гэж байгаа тухай сонин мэдээг дөнгөж сая танд хэллээ. Та энэ тухай цааш хэлбэл нөлөө бүхий хүн болох уу? Богинохон хугацаанд магадгүй л юм. Гэхдээ урт хугацаанд бол болгоомжгүй байдал танд багагүй гай тарина. Танай дарга болон хамтран зүтгэгчид таныг нууц хадгалах чадваргүйд тооцно. Нэгэнт та "чалчаа" гэсэн алдартай болох тул цаашдаа мэдээллийг тун бага авах болно.

Дүрэм

Танд нууц дэлгэж байгаа хүн таны нууцыг ч задруулах болно.

Энэ дүрмээс гажиж болох ганц тохиолдол нь санаатай болгоомжгүй байдал буюу мэдээллийн гадагш урсгал бөгөөд энэ нь сэтгүүлчдийн эрх мэдлийн суурь

нь юм. Та сэтгүүлчдийн тусламжтайгаар шинэ мэдээллийн агуулгыг дамжуулж, нөлөө бүхий хүмүүс ба зохиолчидтой харьцаатай байж, мэдээллийн эх сурвалжийн илрүүлэлтийг хянадаг хүчнээс хараат бус байдлаа харуулна. Гэхдээ иймэрхүү тактик нь тун аз үзсэн хэрэг. Консул Кеннет Старрын албан өрөөнөөс мэдээлэл алдагдсанаас үүдэн мөрдөн байцаагчийн хэргийн мөрдлөг эхэлсэн байдаг. Ер нь мэдээлэл гадагш алдагдах явдал нь аливаа корпораци, алдар нэртэй хүмүүс ба ерөнхийлөгчдийн хувьд асар хүндрэлтэй асуудал болдог. [Мэдээлэл алдагдахаас сэргийлэх ёстой ерөнхийлөгч Никсоны хүмүүсийг санаж байна уу?] Ерөнхийлөгч Клинтонь танхимын дарга Леон Панетта "Мэдээлэл алдагдахад хэрхэн саад тавьж чадсан" тухай улс төрийн асуудлаарх зөвлөгч Дик Моррис ярьжээ. Панетта юуны өмнө болзошгүй "чалчигч"-ийг илрүүлдэг. Мэдээлэл алдагдаж байгаа тухай мэдээ нийтлэгдсэний дараа сэтгүүлч танай хэн нэгэн албан тушаалтныг магтсан уу? Тэр албан хаагч өөрөө энэ үзэл

бодлыг дэмжиж байгаа юу? Ямар ажилтны үгнээс сэтгүүлчид байнга иш татдаг вэ? Мэдээлэл алдаж байгаа тухай сэжиг авмагцаа Панетта эсрэг мэдээллийг түгээдэг байв. Нэргүй түгээдэг тэр мэдээнд ["Уолл Стрит журнал" сонинд үе үе тавина| албан тушаалтан нөлөөгөө алдаж одоо ерөнхийлөгчийн зүгээс түүнд таагүй ханддаг болсон тухай бичдэг байв. Ийм маягаар тэр мэдээллийн алдагдлыг олж тогтоодог байжээ.

Мэдээлэл авах хамгийн гол арга нь мэдээлэлд хүрцтэй байх явдал. Лобби хийдэг хүн өргөн хэлхээ холбоотойнхоо ачаар амьдрах мөнгөө олдог. Та ч бас үйл ажиллагааныхаа хүрээг өргөжүүлэх ёстой. Та хүрцтэй байхын хэрээр мэдээллийн эх сурвалжтай болно. Бас итгүүлэх үндэстэй болно. Та хов жив бүхнийг мэдэж сонсоно. Та өөрт тань мэдээлэл өгч чадах хүмүүсийг мэддэг болно. Тэр хүмүүс танд утасдахаа амална.

Мэдээллийн эх сурвалжийг хамгаалах хэрэгтэй. Хэрэв та бусдын мэдээлэлд хүрэх хүрцийг хаах юмуу дамжуулж чадаж байвал эрх мэдэлтэй болно. Ингэснээр та өөр рүүгээ мэдээллийн тогтмол урсгалыг чиглүүлж чадна.

4.Төгөлдөршлийн татах хүчийг ашиглах

Хүмүүс аль ч салбарт гарсан амжилт ололт ба чадварыг үнэлж байдаг. Энэ мэдрэмжийг бид "Төгөлдөршлийн татах хүч" хэмээн нэрлэх болно. Энэ нь хүмүүсийг ямар ч хэлбэрийн авьяас ба авхаалж самбаанд дууддаг татах хүч юм. Үзэгчид өндөр түвшний тоглолтоос таашаал авч, ялалттай хамт сэтгэл догдолж, гар бие оролцоход бэлэн байдаг.

Хэрэв та төгөлдөршлийн татах хүчээр нөлөө үзүүлж чадах юм бол бүлэг хүмүүсийг ичиж зоволгүй удирдах бөгөөд нөгөөтэйгүүр таны эрх мэдэл хэзээ ч сулрахгүй. Хүмүүс өөрийгөө гялалзаж яваа суут удирдагчид өргөн барих дуртай байдаг. Хэрэв та өөрийгөө төгс төгөлдөр хэмээн баталж чадах юм бол тэд үхэн үхгэлээ таныг дагах болно.

Тантай хамт ажиллаж байгаа хүмүүс таны мэдээллийг төгс эзэмшсэн байдал, сандарч тэвдэлгүй шийдвэр гаргах чадамж, бүгдийг нь сэргээхүйц даалгавар өгдөг чадвараар тань бахдах болно. Та тэдэнд "сайхан хийжээ" хэмээн хэлж баяр хөөр түгээнэ. "Бид энэ үгийг бэлдэх гэж хэдэн долоо хоног ажилласан. Гэтэл түүний илтгэл тавих үедээ онцолж хэлсэн хэдхэн үг бидний хэзээ ч зохиож байгаагүй сайхан байлаа" гэж тэд бие биедээ ярих болно. Тэд таны түвшний хүмүүстэй ажиллаж байгаагаараа бахархана. Тэд таны итгэлийг хөсөрдүүлэхгүйн тулд илүү их юманд хүрэхийг хичээнэ. Тэд өөрийгөө танд зориулж байгаа учраас зүтгэл нь илүү үр дүнтэй байх ёстой гэдэгт итгэлтэй байдаг.

Төгөлдөршлийн татах хүч нь нийгмийн шат болгонд өөрийн нөлөөг үзүүлдэг. Туслагч ерөнхий захирлыг эрж хайдгийн адил ерөнхий захирал ч гайхалтай бяцхан туслагчийг хайж байдаг. Хүний үйл ажиллагааны салбар бүхэнд ийм таталцал үйлчилнэ. Та суут мэс засалч байлаа гээд анд явахдаа улсын хамгийн шилдэг анчны дэргэд бол өөрийгөө "ногоон" болохоо мэдэрдэг. Та алсан шувуугаараа анчинг даллан хамт зургаа татуулаач гэж хулчгардуу гуйх болно.

Төгөлдөршлийн татах хүчний үр дүнг илүү хүчтэй болгоё гэвэл давтагдашгүй чадварыг эзэмших хэрэгтэй. Ганц салбараар бүү хязгаарлагд. Даацтай хоббитой удирдагчдыг

дууриа. "Вержин групп"-ийн дарга аэростатаар нисдэг, "Оракул"-ийн толгойлогч Лари Эллисон усан завины тэмцээнд оролцдог, найруулагч Вуди Аллен даваа гариг болгон жааз хамтлагт кларнет дээр тоглоно. Өөр ямар боломж байна вэ гэж үү? Усан доор махчин загастай сэлэх, оодой мод үржүүлэх, ууланд авирах, Африкт бух барих. Жүжигчин Жон Траволтад аэропланаар нисэх эрх байгаа гэж бодохоор түүний энэ чадвар улам даацтай санагдана. Аэропланаар нисэх нь таныг хичнээн эрэлхэг болохыг харуулах сайхан сонголт мөн боловч аюултай. |Нөгөө талаар их үнэтэй|



Вуди Аллты харцанд вртсөн залуу жүжигчний од болох зам нээгддэг

Төгөлдөршлийн татаххүч нь таны чадвар тухайн ажилд хамааралгүй байсан ч үйлчилдэг. Та коллежид байхдаа хөл бөмбөг тоглодог байсан гэж үү? Та хөрөнгө оруулалтын банкны ажилд авахыг хүсч байгаа тэр хүн яг мөн. Гольфын тэмцээнээр хэд хэдэн удаа аварга болсон нэгний оюуны чадавхи нь хязгаарлагдмал байсан ч хэн ч түүнийг нь анхаарахгүй. Тэрбээр оффисын байр сууриндаа туйлын сэтгэл ханамжтай байдаг. Заримдаа хүний ур чадвар өдөр тутмын үйл ажиллагаатай нь огт хамаагүй байлаа ч сэтгэл хөдлөх нь бий. Жүжигчин Жина Дэвис Олимпийн байт сурын багт багтсанаар нэр төрөө өндөрт өргөснийг бүү мартаарай. Кино од ба дэлхийн хэмжээний харваач гээд л.

Хүмүүс оффисын тоног төхөөрөмжтэй харьцаж чаддаггүйгээрээ гайхуулдаг байсан цаг саяхан. Машин дээр хэвлэх чадварыг хэн ч тоодоггүй байв. Зөвхөн нарийн бичгийн дарга нар л ердийн факсны нууцыг ойлгож чаддаг байсан бололтой. Технологи хөгжихийн хэрээр хэрэв танд тодорхой чадвар үгүй бол хоцрогдсон ойлгоц муутай этгээд шиг харагдаж эхэлнэ. Орчин цагийн бүх тоног төхөөрөмжийг төгс эзэмшдэг тухайгаа зарлаарай. Хэрэв та үүрэн телефон, захирамж дуудлага, интернет гэж юу болохыг мэдэхгүй юмуу цахим шуудантай харьцаж чаддаггүй бол аль хэдийн хөлгийн гадна хаягджээ. Мэдээж илүү эрх мэдэлтэй байхын тулд энэ бүхнийг заавал мэдэх албагүй. Хэн нэгэн энэ талаар санаа тавихад хангалттай. Гэвч та техникийн шинэ бүхэн таныг айдас сандралд оруулдаг талаар дурсах ч

хэрэггүй. Тэр бүү хэл ерөнхий захирал Питер Олсон өөрөө цахим шуудангаа хэвлэхээс татгалздаг байсан ч |туслахдаа уншиж өгдөг| тэр энэ талаар мэдлэггүй гэдгээ хэзээ ч хүлээхгүй. Бусад хүмүүсийн хийж байгаа бүхнийг хийж чадна гэсэн сэтгэгдэл төрүүлэх гэж байнга хичээгээрэй.

Гэвч надад ямар нэг онцгой чадвар байхгүй гэж та бодож байж болно. Надад үзүүлээд байх хобби үгүй. Би ажилдаа агуу хүн биш. Бүү санаа зов. Эрх мэдлийн бусад эх сурвалжийг

ашиглан амжилт олж болно. Тэднийг сөхөн харцгаая.

Зөвлөмж:

Нэгдүгээр байранд түрэн гарах арга замуудыг байнга хай. Эсвэл чадвараа хөгжүүл. Агуу Ричард Вагнер оркестрын парти бичихдээ албаар алдаа гаргадаг байсан. Цэвэр "си" ноот бичихийн оронд тэр си бемоль зурж орхидог байжээ. Дараа нь сургуулилт явагдаж байх үед тэр гэнэтхэн хөгжимчин хагас ая алдаад байна гэж хэлдэг байсан бөгөөд ийм замаар өөрийнхөө хөгжмийн сонсгол хичнээн төгс болохыг харуулдаг байв.

"Хөл угаах" талаархи тусгай зөвлөмж

Хэрэв та ихээхэн эрх мэдэлд тэмүүлдэг бөгөөд мөн Төгөлдөршлийн татах хүчийг эзэмдсэн нэгэн бол хүмүүсийн танд таалагдах гэсэн хүсэл дээр ихийг хожих болно. Хүмүүс бусдын зөвлөгөөнийг дагах зөн совинтой байдаг. Тэр бүү хэл өөрөөсөө дээгүүр хүмүүст боолчлогдоххандлагатай. Энэ хүслийг Мария Магдалена өвдөг сөхрөн байж Есүсийн хөлийг угаасны адил "Хөл угаах" гэж нэрлэе.

Танд онцгойлон хандахыг хичээх хүмүүсээр хүрээлэгдсэн үү? Таныг хаашаа ч эргэсэн хүмүүс танд зусардана. Тэд таны хүслийг биелүүлэх гэж арьсандаа хэд хувирна. Таныг наргихад инээлдэнэ. Танд итгэх үнэмшихийн тулд өөрийгөө тушаана. Сонссон бүхнээ танд дуулгана. Яагаад үдийн хоолоороо ресторанд морилсон санхүүгийн магнатад үйлчлэхийн төлөө үйлчлэгчид хоорондоо зодолддог юм бэ? Яагаад америк бүсгүй Английн хатан хааны өмнө өөрийгөө танилцуулан нахисхийж байна гэж бодонгуугаа сандарч тэвддэг вэ? Яагаад жолооч нар хэдэн цаг бөглөрөлд зогсох мөртлөө ерөнхийлөгчийн цуваа хажуугаар өнгөрөхөд сэтгэл нь өргөгддөг билээ? Яагаад гэвэл бүгд "хөл угаах" мэдрэмжийг мэдэрч байгаа нь тэр.

Бялдуучлалаас ялгаатай нь ийм хүмүүс хариу юмуу шан харамж горилохгүй. Тэд эвэртэн туурайтанд зүгээр л үнэнч гэдгээ харуулахыг хичээж байгаа юм. Тэдэнд анхаарал хаяж болно. Гэхдээ гайхаж байгаагаа харуулах хэрэггүй.

"Хөл угаах" тэмүүлэл, нэг талаар буянтай ч нөгөө талаас их доромж юм. Энэ нь хэн нэгэн хүнд биеллээ олсон шударга ёс, суу билэг, эх оронч үзэл гэх мэт дээд үзэл санааг хүндэлж байгаагийн илэрхийлэл учраас буянтай. "Хөл угаах" нь агуу хүнд хүчин зүтгэх, түүнд талархах бага зэрэг болхи ч гэсэн нэг төрлийн арга билээ.

"Бид (гэрийн зарц нар) илүү сайхан ертөнцийг бий болгоход хувь нэмрээ оруулж байна. Үүнийг хийх хамгийн шилдэг арга нь яг одоо соёл иргэншлийг гартаа атгаж буй цагийг эзэлсэн агуу хүнд үйлчлэх явдал гэдгийг мэднэ".

Казуо Исихуро

"Өдрийн үлдэгдэл"

Нөгөө талаар "хөл угаах" нь доромж юм. Таны өмнө хөглөрч доошилж байгаа хүмүүсийн улаа бутарсан царайг хараад та давхийн цочиж мэднэ. Тэдний "хөл угаах" нь онцгой хүндлэлийн

илэрхийлэл байж болно. Эсвэл гоо үзэмж, алдар нэр, эд хөрөнгө гэх мэт гадаад үзүүлэлтийг сохроор бурханчлах явдал ч байж мэднэ. Магадгүй шүтэн бишрэгчдэд түгээмэл байдаг хүчирхэг хүмүүстэй харьцах тэмүүллийн илэрхийлэл байж болно. Боолчлогдоход тэмүүлэх нь онцгой мэдрэмж.

Иймэрхүү шүтэн бишрэгчид хүндлэл илэрхийлж байгаа тэр хүнээ өөрийн энгийн болхи байдлаар эвдэх нь түгээмэл. Ухаангүй болтлоо бахадсан бөөн хүний инээмсэглэл ба сээтэгнэлийг дааж гарах хүн тун цөөн. Та өөрийн муу араншингуудыг нуужчадсан учраастэднээс ийм их бахдал бишрэл урсан гардаг. Та хээ шаагүй, дээрэнгүй, эсвэл уур хилэнт байдлаа ил сул тавих хүртэл ийм байж болно. Хэрэв та болгоомжтой байхгүй бол таны биеэ авч явах байдал дордож эхэлнэ. Яагаад гэвэл та шүтэн бишрэгчид алдааг тань харахгүй сохор бөгөөд алдаа гаргасан ч тэд гайхалтайд тооцох юмуу зөвтгөнө гэсэн бодолд дасдаг. Та өөрчлөгдөж эхэлнэ.

"Өөртөө бурхан мэт итгэх итгэл ба эмгэнэлт зүйл үл бодох хүсэл нь жинхэнэ жентельмений төрөлх чанар юм"

Торстин Веблер

"Ноёлох ангийн онол"

5.Тэвчээрийн татах хүчний зарчмыг ашиглах

Хүмүүсийг зөвхөн ур чадвар биш тэвчээр бас татаж байдаг. Энэ нь эрхэмсэг байдал, тайван амгалан байдал, бардам болон өөртөө итгэлтэй зэргийг багтаасан чанар билээ. Таны сэтгэлийн тэвчээр эргэн тойронд байгаа хүмүүст соронзон мэт үйлчлэх бөгөөд ингэснээр эрх мэдлийн эх сурвалж болж өгнө.

Сэтгэлийн тэвчээр хатуужил гадагшаа юмуу дотогшоо чиглэсэн байдаг. Хэрэв та энэ чанарыг ил гаргаж чаддаг ховор авьяасын эзэн бол та харизмтай гэсэн үг. Хэрэв эсрэгээр, та сэтгэлийн тэвчээрээ дотогшоо -айдас, их санаа, найдваргүй байдал- чиглүүлж байх аваас биеэ эзэмдэх чадвартай болно.

Харизм

Харизм бол эрх мэдлийн хамгийн гайхалтай эх сурвалж юм. Хэрэв та төрөлхийн ийм чанартай биш бол түүний тухай бүр мартвал зохино.

Харизм гэдэг нь дотоод хүчээр хүмүүсийг өөртөө татах онцгой авьяас. Та хүмүүсийг өөртөө татаж, тэд танд шүргэх, таныг дагах, таныг дууриахыг хүснэ. Таныг талархагчид санасанаас ихийг хийнэ. Тэд үнэ цэнэт зүйлсийн тухай ойлголт ба дүрэм горимоо сольж эхэлдэг. Тэд таны төлөө болон таны өмнөө тавьсан зорилгын төлөө өөрсдийнхөө ашиг сонирхолыг гарзанд гаргахад бэлэн байх бөгөөд үүнийгээ бүр тун баяр баясгалантай хийнэ. Та тэдэнд хамгийн хүнд хэцүү, бохир заваан ажил санал болгосон ч тэд ийм байх болно.

Харизмтай хүн ямар чанаруудтай байдаг вэ? Эрэлхэг, бодол санаагаа тод илэрхийлдэг, ажил

хэрэгч, жүжиглэх ба бэлгийн дур төрүүлэх чадвартай, дээр нь онцгой эрхэмсэг. Нэгэн сэтгүүлч 18 настай Мухаммед Алигийн тухай 1960 онд бичихдээ түүний харсан хүмүүсээс хамгийн хурц амьд хүн хэмээн дүрсэлсэн байдаг. "Энэ бол цуутай жүжигчин юмуу илтгэлээрээ хүмүүсийг цэнэглэдэг улс төрчидтэй уулзсантай адил. Энэ бол онцгой гэгээ татуулсан, онцгой эрч хүч нэвчсэн хүн. Түүнтэй дөнгөж нүүр тулах үедээ л хэдэн жилийн дараа түүний суу алдар дуурсах болно гэдгийг шууд ойлгоно" гэжээ.

Өөрөө харизмтай Черчилль өөрийн үеийн агуу хүн болох Арабын хэмээн алдаршсан Лоуренсын харизмын тухай дүрслэн бичихдээ: "энэ бол зөвхөн хүмүүст зүтгэх чадвараас гадна суу билгийн ямар нэг зүйлийг өөртөө шингээсэн хүн. Түүнийг нь хүн бүр мэдрэх боловч ян тан тодорхойлж чаддаггүй. Агуу адал явдал ба манлайллын он жилүүдэд ч, сүүлд өөртөө албаар нялзаасан хийх ажилгүй алхайсан тэр үедээ ч Лоуренс харьцсан хүн бүрээ захирдаг байлаа. Тэд ер бусын хүн дэргэд нь байгааг байнга мэдэрдэг. Тэд түүний хязгааргүй сэтгэлийн тэнхээ ба нууц эрч хүчийг мэдэрдэг. Тэр оролцох юм бол үл шийдэгдэх маргаантай асуудал юмуу шийдвэрлэж болохгүй зүйл гарч ирнэ гэж нэг ч хүн боддог ч үгүй байв" гэжээ.

Хэрэв та харизмтай бол заавал нийгэмд байр суурь эзлэх албагүй. Гэвч та бага Лютер Мартин Кинг шиг хувийн эрх мэдэл ба зохион байгуулах чадвараа хослуулж болно. Танд ийм бааз суурь байсан байгаагүй танай байгууллагыг бүхэлд нь авч үзсэнээс ч илүү хүч танд бий. Харизмтай удирдагчид өөрийн үе тэнгийнхнийг томоохон өөрчлөлтөнд өдөөн дуудаж чаддаг. Үргэлж сайн тал руу биш л дээ. Жишээ нь Адольф Гитлерийг санаж болно.



"Хэзээ ч, хэзээ ч, хэзээ ч бүү бууж өг" хэмээх домогт үгийг хэлсэн Уинстон Черчилль дайны тарчиг хатуу цагт ч вдөр бүр халуун усанд хэвтэх тансаглалаа орхиогүй.

Хүч багатай харизм гэж бий. Түүнийг эзэмшигчид нь мөн л төгсөшгүй сэтгэл татах юмуу бурханчлах мэдрэмжийг бусдад төрүүлдэг ч жишээ нь Махатма Ганди гэх мэтийн агуу удирдагчдын өдөөн дууддаг шиг зорилго тэмүүлэл үгүй байдаг. Диана гүнжийн тухайд түүний харизм нь үлгэрийн мэт өөрчлөлтийн үр дүн болохоос биш түүний үе тэнгийнхний бодож байгаа шиг "сайн ажил" юмуу нийгмийг хувьсган өөрчлөх хувьсгалт үзэл санааных нь үр дүн биш. Салж сарнисны дараа хааны гэр бүл дэх байр сууриа алдсан ч Дианагийн харизм бүр илүү хүчтэй болсныг тэмдэглүүштэй.

Хэрэв та харизмтай бол таны ойр хавьд түүхч юмуу зохиолчид байгаа эсэхэд санаа тавиарай. Есүсийн үгсийг апостолууд тэмдэглэж үлдээсэн. Жек Кеннедигийн богинохон засаглал

Артур Шлезингер, Теодор Сорензен, Вильям Манчестер, Бенжамин Брэдли нарын бүтээлд мөнхлөгджээ. [Тэд түүнийг тойрон хүрээлж байсан нь тохиолдлын зүйл биш. Кеннеди өөрөө ч энэ талаар тэмдэглэж хэлэхдээ: "Бидний зарим нь түүхчидтэй харьцах ба тэдэнтэй сайн харилцаатай байх нь мэргэн ухаан гэж боддог" гэсэн байдаг.] Гарольд Росс бол гайхамшигтай хэвлэн нийтлэгч гэсэн нэр алдар "The New Yorker" сэтгүүлийн бүлэг зохиолчдын нийтлэлүүддээ мөнхөлсний хүчээр өнөө хүртэл оршоор байна. Агуу Александр хүртэл аян замдаа түүхчид ба яруу найрагчдыг авч явдаг байсан бөгөөд баатарлаг үйлсийг нь тэд бичээсэй гэсэндээ тэр. Ингэхэд түүнд агуу гэдэг нэрийг хэн хайрласан билээ. Гэвч тэр Ахиллийн шарил дээр уйлсан гэдэг. Яагаад гэвэл Гомер шиг баатарлалыг нь мөнхөлж өгөх хүн үгүй болоод тэр. Хэдийгээр харизм нь хүнд цутгаад хийчих юмуу дууриалган хийх боломжгүй ховор чанар боловч харизм эзэмшихэд сургахыг оролддог хэд хэдэн сургууль байдаг. 1936 онд Дейл Карнегийн бичсэн "Найз нөхөд ба нөлөө бүхий хүмүүсийг хэрхэн байлдан дагуулах вэ?" хэмээх сонгодог бүтээл өнөөдрийг хүртэл давган хэвлэгдсээр байна. Хэдийгээр энэ ном анх нартад мэндэлсэнээс хойш хэдэн арван жил өнгөрсөн ч конгрессийн номын санд энэ номыг захиалсан хүн доорх утга бүхий бичигтэй хурц ягаан хуудсыг өнөө хүртэл дагуулд нь авсаар байна.

Хамгийн их эрэлттэй ном

Төлөөлөгчдийн танхимын гишүүд ба сенатчдын урт жагсаалт энэхүү номыг хүлээж байна. Тийм учраас дугаарт буй дараагийн гишүүд ба сенатчдад хүртээхийн тулд номыг зөвхөн АРВАН ӨДӨР хэрэглэх боломжтой.

Конгрессийн гишүүдээс гадна хэн төв америкийн худалдагчийн бичиж өргөн барьсан олны унших дуртай энэ номноос харизмын нууцыг хайх вэ?

Харизмыг Ур чадварын татах хүчтэй эндүүрэх нь элбэг. Майкл Жорданыг харизмтай хүн гэж тооцох нь олон. Гэвч сагсан бөмбөг тоглох ер бусын техник болохоос биш түүний зан араншин, эсвэл тавилан, эсвэл байр суурь нь шүтэн бишрэгчдийн анхаарлыг татаж байсангүй.

Олон хүмүүс харизмыг үнэн хэрэгтээ зүгээр л дур булаам байдал хэмээн нэрлэх нь ч бий. Энэ нь харизм шиг хурц биш боловч бас үнэтэй чанар. Дур булаам байдалд суралцаж болно. Гэхдээ энэ нь ихээхэн хүч шаардана. Хүмүүсийг нэрээр нь дуудаж харьцах юмуу тэдний хүүхдүүдийн нэрийг санах гэх мэтээс ч илүү хүч хөдөлмөр шаардана.

Сэтгэл татам харилцаа

1. Вильям Жеймсийн тэмдэглэснээр "Хүний хамгийн гүнзгий тэмүүллийн нэг нь бусад хүмүүст өндрөөр үнэлэгдэх хүсэл юм". Та ярилцаж байгаа хүнийхээ хаана ажилладагийг мэдээд зогсохгүй түүний сүүлийн ололт амжилтуудыг мэддэг болохоо харуулахуйц тийм асуултыг түүнд тавих, эсвэл түүний санаа бодол таны хувьд ямархуу жинтэйг харуулах хэрэгтэй. "Жон та Оросоор аялаад ирсэн. Энэ улсын өнөөгийн байдлын тухай та юу гэж бодож байна вэ?"

2. Хүмүүст өөрсдийнх нь тухай ярих аваас таныг хэдэн цагаар ч сонсоно. Тэдний нүд рүү эгц

ширтгэж анхаарал хандуулаарай. Чин сэтгэлээс сонирхих арга ол. Яагаад гэвэл та бусад олонхи хүмүүсийн адил, удтал сонирхсон дүр исгэж чадахгүй.

3. Яриаг нэгэн хэвийн урсгалд бүү оруул. Сэдэвт хамаарахгүй урт ярианд шохоорхох юмуу эсвэл жижиг сажиг бүхнийг тоочихгүй байхыг хичээ. "Тэгэхэд 1995 оны 12 сар билүү эсвэл 1995 оны 1 сард ч билүү, бишээ 1996 оны 1 сард гэх гэж байгаад... Үгүй ээ, 1995 оны 11 сар юм байна. Яагаад гэвэл Талархалын өдрийн өмнө манай нагацийгэмнэлэгтхэвтүүлсний дараа болсон явдал гэдгийг би санаад байна. Ямар ч тохиолдолд..."

4. Юу хэлэхээ дандаа мэдэж байгаарай. Тухайн цагийн үйл явдлыг мэдэж бай. Энэ нь чухал (сөргөлдөөнийг зохицуулах даалгавар) юмуу үл ялиг (Эммигийн шагнал гардуулах) гэх мэт үйл явдал ч байж болно. Тодорхой салбарт сонирхолоо хандуул. Нарийн сонирхол (цанаар гулгах, загасчлах, иргэний дайн) таны нөлөөг гайхалтай ихэсгэж өгөхийг та харна.

5. Өөрийгөө шоолж инээ. Өөрийн алдааг шоолон инээх аргаар бусадтай харьцаагаа зохицуул. Нисэх онгоцны буудалд паспортоо мартаж ирснээр онгоцондоо сууж чадаагүй, чухал уулзалт эхэлж байхад бүдэрч унасан, урилга дээр зааж бичээгүйн улмаас өглөөний 7 цаг 30 минутанд хуримын ёслолд ирэхдээ хар өнгийн смокинг өмсч ирээгүй ганц хүн нь та гэх мэтийн алдаанууд байж болно.

6. Таныг алдаа хийх үед засч залруулах нь хүмүүст туйлын их таалагддаг. Өөрийн бурууг хүлээж бай. "Тийм, тийм би одоо саналаа. Таны зөв. Крис Рок хэсэг хугацаанд 5a1игc1ay г>Пд1г1 Ыуө хамтлагийн гишүүн байсан шүү дээ" гэх мэт.

7. Хүмүүс бялдуучлалыг их хүлээн авамтгай байдаг. "Чиний даашинз надад таалагдаж байна" гэж яриан дундуур хурдан хэлэх нь үр өгөөж өгөхгүй. Түүний оронд "Та энэ талаар тун мэдлэгтэй юм шиг байна. Та энэ салбартаа олны танил хүн үү? Ингэхэд та сургуульд спортоор хичээллэж байсан байх" гэх мэтээр тэмдэглэж хэлэх нь илүү үр дүнтэй. Бусдын алдааг шоолж байгаарай.

Дунд нь байж дур булаах

1. Эргэн тойрондоо эрч хүч ба өөдрөг санаа сэтгэлийг түгээгээрэй. Хуучин гомдолоо дурсаж хонзогнох хэрэггүй. Хүмүүс таалагдаж байгаа хүндээ дуртай байдаг учраас бүх хүнд найрсаг хандаарай.

2. Соронзон долгио цацруул. Жижиг сажиг юмаар сэтгэл тавгүйтэх хэрэггүй. Зочдын нэрийг зарлаагүй, хоолны ширээнд хэн хэнтэй зэрэгцэн суух, хэн тасалбар авах гэх мэт жижиг сажиг зүйлсээр бүү догдол. Та үйлчлэгч юмуу цагдаа шиг биеэ авч явах хэрэггүй.

3. Та сайхан харагдаж байгаа гэдэгтээ итгэлтэй бай. Мөрөн дээрх хагаа гөв. Гаатай бохьажил. Хүмүүстэй гар барьсны дараа гараа угаа. Мэдээжийн мэт санагдаж байгаа ч аймшигтай муухай дадал зуршлуудыг битгий авчихаарай даа. Дэргэд чинь хооллож суугаа хүн чанга дуу гарганажилж байсан ч түүн шиг бүү байгаарай.

Өөрийгөө эзэмдэх

Харизм бол туйлын цөөн тааралддаг эрх мэдлийн эх сурвалж юм. Тэвчээр хатуужил гадна биш харин дотроо илэрч эхлэх үед энэ нь ердийн, хэн хүнд байж болох, өөрийгөө эзэмдэх чадвар болно. Хэдийгээр энэ чанар харизм шиг бусдыг ухаангүй даллан дуудахгүй ч бас багагүй соронздох хүчтэй. Өөрийгөө эзэмдэх чанар нь өөрийгөө таних ба өөрийгөө хянах хоёрыг дотроо агуулна. Та өөрийн сул ба хүчтэй талуудыг сайн мэдэх учир өөрийгөө эзэмдэж чадна. Тун удалгүй танд нэгэн онцгой мэдрэмж бий болох ба энэ нь та агуу үйлс бүтээхийн тулд төрсөн бөгөөд бусад хүмүүс таныг заавал тоох ёстой гэсэн мэдрэмж.

Өөрийгөө эзэмдэх нь таныг хамгаалж өгнө. Энэ мэдрэмж үгүй бол та өөртөө үл итгэх, ихэрхэгзан, хэрэгцээ шаардлага гэх мэтэд амархан автана. Басхэн ч таныг төвөггүй хуурна. Таны хүсэл ба хэрэгцээ далд байхын хэрээр бусад хүмүүсийн заль мэхнээс хол байна.

Өөрийгөө эзэмдэх нь таныг засдаг хуурамч зан, хорт явуулга, хуурамч маягаас чөлөөлнө. Та дур зоргоор хүмүүсээр өөрийгөө хүрээлүүлж, аюулгүй байдлаа хангах гэж хичээхгүй. Магадгүй та математикийн хүнд тооцоонд муу, эсвэл бичиж хэвлэхдээ дулимаг байж болно. Тэгвэл та өөрөө өөртөө "Онц. Би зүгээр л миний оронд энэ бүхнийг хийх хүнийг хөлсөлчихнө" гэж байгаарай. Та авьяаслаг хүмүүсээс айхгүй байхын хэрээр эрх мэдэл тань өснө. Бусдаас өндөрт байх хэрэгцээ шаардлага таныг зовоохгүй. Нэгэнт та өөрийгөө хянаж чаддаг учир тойрон хүрээлж байгаа хүмүүсийнхээ санаа бодол ба мэдрэмжийг тооцоолж чадна. Хамтран зүтгэгчдээ ингэж ойлгохын хэрээр эрх мэдэл баталгаажина.

Өөрийгөө эзэмдэх нь |эсвэл эс эзэмдэх| их утга учиртай. Яагаад гэвэл зан авирын онцлог үргэлж их утга учиртай байдаг. Тэрбум доллар хуримтлуулсан ерөнхий захирал сөргөлдөөнөөс их айдаг юмуу нэртэй уран барималч хэвлэлийг үзэн яддаг, эсвэл цагаач инженер Америк дахь технологийн хөгжлийн төлөө санаа зовдог зэрэг нь үүнтэй холбоотой.

Олон олон хүчирхэг хүмүүс биеэ эзэмдэх чадваргүйн улмаас нэр төрөө бардаг. Харамч хахир, бор дарсанд дурлах, бэлгийн замбараагүй байдал, параной, үл ялиг алдаа-ингээд л тэдний алдар цуу нь дуусна. Ерөнхийлөгч Рейганы илтгэл бэлтгэгч Пегги Нуман анхааруулахдаа "Хэрэв Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга нөлөөгөө сулруулахгүй зүтгэвэл болгоомжтой байгаарай. Тэрбээр далд явуулга хийх замаар ур чадвараа харуулах оролдлого хийх нь гарцаагүй. Энэ нь түүний хүн чанар муутайг хамгийн тодоор харуулж өгнө. Хэрэв шинэхэн дарга хамт олноосоо дөлж байвал болгоомжтой байгаарай. Тэр хүн өөрийн ихэрхэг зангаа давж гарах болно" гэжээ.

Харин эсрэгээр, өөрийгөө эзэмдэж чадсанаар та бусдад ялалтаа тэмдэглэх шалтаг гаргаж өгнө. 1927 онд Лорд Уинтертон тэр үед 52 настай мөртлөө үнэн хэрэгтээ нов ногооноороо байсан Черчиллийг дүгнэн захидал бичжээ. "Энэ хүн парламентад хэт оройтон ажиллаж эхэлсэн мөртлөө гэнэт яаж эрхэм чанаруудыг өөрийн болгосон нь гайхалтай. Ямар ч шалтгаанаар тоглож наргих чадвар, гайхалтай наргианч зан, тэвчээр, хөдөлгөөний онцгой мэдрэмж. Одоо тэр бүгдтэй нөхөрлөж, бүгдэд таалагдаж байна. Парламентад ч, лобби хийгчдийн дунд ч тэр. Тэгснээр энэ хүн дайны өмнө байснаасаа шал ондоо болсон. Тэр парламентад маш нэр хүндтэй. Энэ нь парламентад өдгөө эзэлж буй түүний сүрдэм эрх мэдэл дээр сайхан хачир болж өгч байна" гэжээ.

Ашигтай дутагдал бахортой сайн талууд

Сэтгэлийн хүч нь дутагдал ба сайн талуудаа хамт ашиглах боломж олгодог. Эрх мэдэлтэй олон хүмүүс өөрийн дутагдлыг ил гаргадаг. Гэхдээ энэхүү алдаагаа амжилттай засах замаар улам их эрх мэдлийг олж авч байдаг. Ричард Никсон найдваргүй итгэлгүй нэгэн хэдий ч ерөнхийлөгч болсон шүү дээ. Магадгүй эдгээр чанар нь түүнд бага ч гэсэн тусалсан байх. Алексис де Токвевелли "Хүмүүс эерэг чанарууд нь шаардагдах тэр салбарт амжилт олдог. Гэвч бид дутагдлаа ашиглаж чадах юм бол мөн том амжилтанд хүрдэг" гэсэн байдаг. Танд ямар өө сэв байгаа вэ? Үрэлгэн үү? Маш сайн. (Хэвлэлийн магнат Стив Росс шиг өөрийн үрэлгэн занг өгөөмөр байдлаар нууцалж, Барбара Стрейзанд, Стивен Спилберг болон бусад алдартнуудын зүрхийг эзэмдсэн шиг байж болно.) Та гомдомтгой гэж үү? Бас л сайн хэрэг. Сагсан бөмбөгч Майкл Жорданаас жишээ ав. Тэрбээр гомдолоо илүү сайн тоглоход өдөөгч болгон ашигласан.

Нийтгэч, егөөтэй, шүтэн бишрэгч, итгэмтгий гэх мэт нэг зан чанар хоёр зорилгод үйлчилж болохыг олон хүн мэддэггүй. Эсвэл амжилтанд хүргэж, эсвэл нөгөө талаас сүйрч унахад түлхдэг. Жорж Стефанопулос ерөнхийлөгч Клинтонь засаг захиргаанд ажилласан тухай номын сүүлчийн мөрүүдэд бичсэнийг үзэцгээе. "Одоо би холоос харж байна. Шоунаас ханамж авахын хажуугаар гайхаж байна. Энэ сайн ерөнхийлөгч маань жинхэнэ сайн хүн байсан бол ер нь юу болох байсан бол гэж гайхдаг" хэмээжээ. Зохиолчийн бодож байгаагаар хэрэв Клинтон шилдэг хүн байсан бол сайн ерөнхийлөгч болж чадахгүй байсан. Түүний уналтанд хүргэсэн зан араншингууд бас түүнийг дэмжин тулж байжээ. "Би" гэж дөвийх, агуу их санаа юмуу ихэмсэг байдал зэрэг хүмүүсийг манлайд гаргадаг зан чанарууд тэдний зан араншинг бас эвдэж чаддаг. Удирдагчдын юу нь биднийг ингэтлээ татдаг вэ? Картерын буянч өглөгч зан уу, эсвэл Жонсоны хачин өвөрмөц араншин уу?

Дүрэм

Бид зарим сайн талд дургүй хүрэх мөртлөө бас дутагдлууд биднийг татах юм.

Сайн талууд ч хор хүргэх нь бий. Ерөнхийлөгч Рузвельтын чанаруудын нэг нь ойр тойрны хүмүүстээ асар их эерэг ханддаг явдал байв. Харамсалтай нь авьяас чадваргүй хүмүүсийг багаасаа хөөж чаддаггүй байснаар энэ сайн зан чанар нь түүнийг балласан.

Өөрийгөө мэдэж бас хяна. Өөрийн сул талыг ойлгож мэдрэхээс илүү таны амьдралд туслах юм үгүй.

6. Мөнгийг капитал болго

Мөнгөөр эрх мэдлийг худалдан авдаг. Эрх мэдэл олохын тулд мөнгөө хэрхэн ашиглахыг тус номны "Мөнгө" гэсэн бүлгээс уншаарай.

"Давуу тал, сайн үйлс бүхэн өөртөө дутагдал ба нүгэл хилэнцийг агуулж байдаг. Хэрэв тодорхой хүрээнээс гарах юм бол тэд нэг нэгэндээ шилжинэ. Өгөөмөрөөс үрэлгэнд шилжих нь олонтаа. Хэмнэгч зан харамч болох нь бий. Зориг бодлогогүй

байдаг. Харин болгоомжлол хулчгарыг төрүүлнэ. Энэ бүхнийг эцэс төгсгөлгүй гэж хэлж болно.

Тэгэхээр сөргүүлэн тавьсан дутагдлаас зайлсхийхийн оронд сайн талуудаа хэрхэн зөв залах талаар бодох хэрэгтэй"

Лорд Честерфилд "Хүүдээ бичсэн захидал"

7. Алдар нэрийг анхаарлын төвд аваач

Мэдээллийн энэ эрин зуунд алдар нэр нь эрх мэдлийг төрүүлж байна. Өчигдрийн алдартай хүн өнөөдөр гал сөнөөгчийн хувцас өмсөх юмуу телевизээр үг хэлжбайна. Эрхмэдлээ хадгалахын тулд анхаарлын төвд байх зарчмыг ашиглаарай. Алдар нэрийг эрх мэдэлтэй болоход хэрхэн ашиглах тухай 16-р бүлгээс уншаарай.

8. Дур тачаалыг өдөө

Секс нь эрх мэдлийг олж авах тал дээр эргэлзээтэй боловч ихээхэн үр дүнтэй арга байж болно. Эрх мэдлээ хадгалахын тулд сексийг хэрхэн ашиглах талаар 19, 20, 21-р бүлгийг уншаарай.

Соронзон долгионы талаархи онцгой сануулга

Та эрх мэдэл, мөнгө, алдар нэр ба сексийн алийг нь ашиглаж байлаа ч гэсэн үргэлж соронзон долгиог өөрөөсөө цацруулж бай. Энэ нь хэцүү бүхнийг хялбар болгодог. Таны амжилт бол аяндаа хийсэн уран гоё үйлдэл хөдөлгөөний үр дүн гэж харуул. Өөрөө хичнээн их хүч зарцуулснаа хэзээ ч бүү ярь. Таны үйл хөдөлгөөн аяндаа болж байгаа, санаа зовоолтгүй өрнөж байгаа мэт санагдвал зохино.

Өнгөрсөн зууны 80-аад онд дунд сургуулиуд цэцэглэн мандах хүртэл, түүнээс хойш ч гэсэн дунд сургууль төгсөгчдийн соёлын түвшин хүмүүсийн анхаарлыг маш их татдаг байсны нэг нол шалтгаан нь соронзон долгионд оршино. Лиза Бирнбах өөрийн "Төгсөгчдийн удирдамж" номондоо "Тэд үргэлж чадварлаг ба амгалан тайван харагдахыг хүсдэг. Тэдний хийж байгаа, өмсч зүүж байгаа бүхэн зүгээр л бодлогогүй хийсэн мэт харагдах ёстой. Зангиа хэрхэн зангидахад зарцуулсан цагаа март. Хамгийн гол нь энэ бүхэн олон түмнийг хянаж байгаа мэт харагдах ёстой" гэжээ. Та хувцаслахдаа ийм стилийг хүссэн хүсээгүй хамаагүй, гол нь тэдний амгалан тайван байдлыг дууриах учиртай. Төгөлдөр хуур тоглох, наргих, зарлал унших, зочин хүлээн авах гээд бүх юм урсгалаараа байгаа мэт санагдах учиртай.

"Би ахлах ангид ханхар том биеийнхээ ачаар нилээд нэртэй хүүхэд байлаа. Би хэдийгээр хичээнгүйлэн дасгал хийдэг байсан ч соронзон долгион цацруулах тухай мэдэхгүйн улмаас олонхи тамирчдын хувьд танил биш нэгэн болсон юм"

Дэвид Шилдс

"Ганцаардал"

Далд санаа агуулсан, тиймэрхүү муу юм бодож төлөвлөсөн гэдгээ хэзээ ч бүү хүлээн зөвшөөр. Сэтгүүлд ярилцлага өгөх үедээ алдаа гаргасан нэгэн цадиггүй урлаг сонирхогчоос

суралцаарай. Тэрбээр музейн удирдах гишүүн болохын тулд л цуглуулга хийсэн хэмээн "У/о|Ип" сэтгүүлд ярьж орхисон байдаг. Бичигдээгүй хуулиудыг давахын тулд их хүч гаргаж байгаагаа харуулахгүй байхыг хичээ. Жишээ нь ажил эрж байгаа хүн ярилцлаганд орох үедээ "Миний гуталд хэдэн нүх байх ёстой гэж үү? Нэг залуу тохирох тооны нүхгүй гуталтайнхаа улмаас ажилгүй болсон гэж сонссон юм байна" гэж ярих хэрэггүй л дээ. Жижиг сажиг зүйлд өчүүхэн ч санаа зовсон гэдгээ хүлээх ёсгүй. (Гэхдээ энэ нь жижиг сажиг зүйлс ямар ч үр нөлөөгүй гэсэн үг биш. Үдээсний нүх дөрөв, тав юмуу зургаа байх нь стандарт. Харин үүнээс олон бол моод хөөсөнд тооцогдоно.)

Бусад хүмүүсийн эрх мэдэл байх л ёстой зүйл мэт, харин бусад хүмүүс танд үйлчлэх нь мөн л тийм зүйл мэт дүр исгээрэй. Энэ бүхэн бол таны зан араншин болоод төрөлх чанаруудыг хослуулсан ердийн л үр дүн. Жек Кеннеди ба Ричард Никсон нарыг харьцуул. Тэд хоёулаа төрөлхийн өршөөлгүй улс төрчид. Гэвч Никсоны хүч хөдөлмөр, түүний зурагтаар гарах үедээ царай төрхдөө анхаардаггүй байсан явдал, түүний Мэдисон-авеню тактик зэрэг нь бүхний нүдэнд ил байсан. Харин Кеннеди маш зальтай улс төрч. Тэрбээр туйлын овсгоо самбаатай боловч нигүүлсэнгүйн багны цаана үүнийгээ нуудаг байв.

Өчүүхэн төдий хичээл зүтгэлээ ч мэдэгдүүлэн нэр хүндээ бүү гутаа. Хүнийг нэрээр нь дуудаж хандах нь түүнд сайнаар хандаж байгаагаа илэрхийлэх шилдэг арга мөн боловч ойр ойрхон ингэх хэрэггүй. "Таслал-нэр-таслал" гэсэн зохион байгуулалтыг ойрхон ойрхон ашиглах, жишээ нь "алив би жишээ гаргая, Пэт, би шийдвэрээ хэрхэн гаргаж байгаагаа..." гэх мэт ярих аваас таны найрсаг байдал нь үзүүлбэрийн чанартай, хэтрүүлэгтэй болоод үнэн сэтгэлээс биш гэдгийг харуулж өгнө.

xxx

Дээр дурьдсан долоон эх сурвалжийн аль нэгийг ашиглан эрх мэдлийн ямар нэг түвшинд хүрч чадах үед эрх мэдэл мэдрэгдэх ёстой бөгөөд түүнийг тэмтрэх боломжтой гэдгийг та сая ойлгоно. Гэхдээ эрх мэдлийг хэрхэн бусдын нүдэнд ил болгох вэ? Та эрх мэдлээ үзүүлэх ёстой.

"Гайхамшгийг төрүүлдэг аль нэг урлагийг төгс эзэмших ямар хэцүү болохыг хүн бүр л мэднэ. Хүнд хэцүү хөдөлмөр бидний анхаарлыг татах гавьяагүй бөгөөд аймшигтай, бүр зугтмаар сэтгэгдэл төрүүлж байдаг"

Балдезар Кастиглион "Ордоны ёс зүйн ном"

Гүравдугаар бүлэг

Эрх мэдлээ харуул

Хүмүүс таны эрх мэдлийг хүлээн зөвшөөрөхийн тулд та эрх мэдэлтэйгээ батлах ёстой. Энэ нь ихэнхидээ тун хэцүү, ойлгоход бэрх үйл явц байдаг. Аз болоход эрх мэдлээ харуулах түргэн бөгөөд шууд арга замууд бий. Тэднээс доорх 13 нь хамгийн түгээмэл.

Хэдийгээр доор дурьдах аргууд ихээхэн үр дүнтэй боловч зарим нэг нь дайсагнал дагуулдаг учраас тунг нь тохируулж хэрэглэх ёстой. Эрх мэдлийг ил тод үзүүлэхэд хүмүүс эсэргүүцдэгийг мэдэж байх ёстой бөгөөд энэ тохиолдолд эрх мэдэл бүрэн хүчээ алдахад хүрдэг. Жишээлбэл та ажлынхандаа сүүлчийн илтгэлийг баасан гариг гэхэд таны ширээн дээр тавих тухай шаардлага илгээжээ. Эрх мэдлээ ингэж илт, ил тод харуулснаар та дайсантай болох нь гарцаагүй.

Эрх мэдэл өсөхийн хэрээр та арга барилаа солих ёстой. Нэг шат ахихад таны арга барил илүү бодлоготой болох учиртай. Тиймээс хэтэрхий тод аргуудаас зайлсхий. Та ихээхэн эрх мэдэл хуримтлуулсан учир хүмүүс шинэ нөхцөл байдалд дасах ёстой. Эхлээд та цахим шуудан илгээхийн өмнө давхар шалгах ёстой. Дараа нь хэдийгээр ийм шаардлага байхгүй ч та "яаралтай" гэсэн тэмдэглэгээ хийж өгнө. Энэ нь захидлыг авсан хүн өөрийн бүх ажлаа орхиод танд яаралтай хариулах ёстойг тодотгож байна. Харин асар их эрх мэдэлтэй болох юм бол та ийм юм хийхгүй. Ийм юмны хэрэг ч байхгүй.

Эрх мэдлийн стратеги нь өөрчлөлтөд дасан зохицох учиртай. 20 жилийн өмнө та орой болтол ажилласан гэх сэтгэгдэл төрүүлэх үүднээс пиджакаа ажлын ширээний арын сандал дээр тохож үлдээдэг байв. Хоёр жилийн өмнө та одоо болтол унтаагүй байгаагаа харуулахын тулд цахим захидал илгээхдээ доор нь 4.00 хэмээн цаг зааж өгдөг байсан. Харин өнөөдөр ийм аргуудаар хэнийг ч хуурахгүй учир шинэ арга бодож олоорой.

Хэрэв та эрх мэдлээ дэлгэн үзүүлэх түргэн аргыг хайж байгаа бол доор дурьдсан аргуудын аль нэгийг хэрэглэх юмуу эсвэл хэд хэдийг хослуулах маягаар хэрэглэсэн нь дээр. Хэзээ ч бүү зогс. Эрх мэдлээ батжуулах ба сайн сайхнаар харуулахын тулд энэ бүхэн хангалтгүй. Эрх мэдлээ батжуулах ба улам түгээхийн тулд та байнга ажиллах учиртай. Эрх мэдлээ гайхуулах нь аз туршсан давуу тал. Учир нь эрх мэдэл өөрөө эрх мэдлийг төрүүлж байдаг. Таны мэдэрч байгаа эрх мэдэл таны жинхэнэ агуу эрх мэдлийг бий болгох өчүүхэн хэсэг нь билээ.

Эрх мэдлээ харуулах 13 арга

1. Дархлал

Асар их илүүдэл зардал

Бусдыг айлгах уур хилэн

Өөрийн дураар шагнах юмуу шийтгэх

Өөрийн хэв загварыг бусдад нялзаах

2. Эрх дарх ба хэлбэрдэлт
3. Эд хөрөнгө захиран зарцуулах
4. Найзуудаа шагнаж дайснаа шийтгэх
5. Өрсөлдөөнийг бут ниргэх
6. Аялал
7. Цаг хугацаа
8. Аюулгүй байдал
9. Яриа
10. Ажлын байр
11. Утас
12. Гар цайлгах
13. Заль мэх

1. Дархлал

Бусдын хувьд ямар ч дүрэм журам үйлчилдэг байлаа гэсэн харин та түүнгүйгээр байж чадна гэж ярин эрх мэдлээ гайхуулна. Бусад хүмүүс анхаарал болгоомжтой байх ёстой атал та алдаж болох ба хүсэлдээ захирагдаж ч болно. Таныг шийтгэе гэсэн ч боломжгүй. Учир нь та дэндүү их эрх мэдэлтэй. Дархан байдлаа гайхуулах хэд хэдэн үр дүнтэй арга зам бий.

Асар их мөнгө үрж үүнийгээ компани юмуу засгийн газрын нэр дээр бичих. Олонхи хүмүүс ажилчиддаа зориулан их мөнгө зарцуулж чаддаггүй байтал та чадна. Чухал хүмүүсийг үдэшлэгт урих юмуу бэлэг гардуулах хэлбэрээр энэхүү аргыг илүү хүчтэй болгоно.

Жишээ: 1961 дэх далангийн нээлтийг хийхийн тулд Роберт Моузес ер бусын баяр наадам зохиосон байдаг. Зочдод нисэх онгоц захиалж, аялал зохиож, мартин дарсыг оргилуур мэт урсган хүлээн авалт хийсэн ба бүгдийг нь төрийн данснаас гаргажээ.

Жишээ: "Барууны нефть"-ийн эзэн Арманд Хаммер корпорацийн мөнгө хөрөнгийг урлагийн бүтээл худалдан авахад ашиглаж байв. Тэрбээр төрсөн өдрөө компанийн мөнгөөр тэмдэглэхээс гадна хувийн өмгөөлөгч бие хамгаалагчид болоод Боинг-727 онгоцныхоо төлбөрийг ч тэндээс гаргаж байжээ.

Айж хэрдхийм уур хилэнтэй байх. Олонхи хүмүүс сөрөг чанаруудаа дотроо барьж байх

эсвэл ил гаргасан бол түүнийхээ төлөө хариуцлага хүлээх ёстой болдог. Харин та тэгэх ёсгүй. Та өөрийгөө хянах амаргүй гэдгээ харуулахын хажуугаар бусдыг өөртэйгөө зөвшилцөх ба таны уур хилэнгээс айхад хүргэвэл зохино.

Жишээ: Холливудын студийн захирал Лью Вассермены уур хилэн асар хүчтэй байсан бөгөөд түүний амнаас урсах зүхлийг сонссон хүмүүс ухаан алдан унадаг байжээ. Ийнхүү харьцсанаар тэр бүрэн ноёрхсон байдаг.

Жишээ: Холливудын алдартан Дон Стил шинэ ажилтанд сануулахдаа "Сүүлд манайд ажиллаж байсан хүн |туслах ажилтан| өөрийг нь тэнэг гэж дуудлаа гээд ажлаа хаяж одсон. Би таныг тэгж дуудлаа гээд та явчихгүй гэж найдъя" гэдэг байв. Шагнал ба шийтгэлийг өөрийн дураар зааж байгаарай. Хүмүүс ихэнхдээ харьцааны тэнцвэр, зүй зохистой байдал ба шударга ёсны илрэлийг ядахдаа тулж түших үүрэгтэй. Харин та үүнийг дагахгүй байх тал дээр чөлөөтэй. Та өөрийн дураар бас огцом байж болно. Бүх хүнийг тодорхойгүй байдалд барих хэрэгтэй.



Линдон Жонсон нойлд сууж байхдаа туслахуудаа хаалганы дэргэд жагсааж илтгэлийг нь сонсдог байв

Жишээ: Кино продюссер Дон Симпсон хоолны дэглэм барьж байх үед нэг туслах нь кофенд нь зөөхий хийсний төлөө түүнийг ажлаас халж орхижээ. Гэтэл дэглэм бариагүй үед нь кофенд нь ямар ч тослоггүй сүү хийлээ гээд бас нэг туслахаа халсан. Тэгээд түүний иддэгээс өөр гич өгсөн юмуу нарийн боовыг нь хэт их халаасан гэх мэт шалтгаанаар халдаг байлаа.

Ишлэл:

Их жанжин Суллийн харамч хахир нь дэндүү хэдий ч түүний өгөөмөр зан бүр их байв. Тэр ямар ч шалтгаангүйгээр хүмүүсийг дэвшүүлэх юмуу эсвэл хүмүүсийг доромж байдалд орох хүртэл тийм ачгүй байж чаддаг байв. Тэр төрөлхөөс хонзогногч харгис хатуу нэгэн байсан гэсэн дүгнэлтийг бид хийж болно. Гэвч тэр төрөлхийн харгис хэрцгий авираа өөрийн сонирхолын үүднээс хянаж чаддаг нэгэн байсан".

Плутарх "Намтар"

Хэв маягаа бусдад нялзаах. Хүмүүс таны хүссэнийг л хийх ёстой гэдгийг тэдэнд харуулаарай. Зөвхөн таны хүсч байгаа зүйл л тооцогдох учраас тэд даруу ба ёсорхог байх хэрэггүй.

Жишээ: Линдон Жонсон жорлонд сууж байхдаа туслахуудаа хаалган дээр зогсож түүнтэй ярилцахад хүргэдэг байв. Мөн уулзалтуудын завсарлагаар Цагаан ордон дахь усан санд туслахуудаа нүцгэн сэлэхэд хүргэдэг байжээ. Бас түүний дуртай онцгой сортын самрыг олох ухаангүй "авд" цагдаа нар хагас цаг мордсоноор Цагаан ордны цагдаагийн ажил тасалддаг байлаа.

Жишээ: Хэвлэлийн магнат Барри Диллер нэгэн хүлээн авалт дээр халбага таваг харших дуунд цухалддаг учраас бүх хүн хооллож дуусах хүртэл илтгэлээ эхлүүлэхээс татгалзаж байсан.

Таны өдөр зөвхөн таны хуваарь ба дадал зуршилд нийцэж байхыг шаард. Энэ нь эвгүй юмуу үнэтэй байх нь хамаагүй.

Жишээ: Холливудын од Элизабет Тейлор 20 жилийн турш гэрээндээ сарын тэмдэг ирэх өдрүүдэд ажиллахгүй тухай заалт оруулж иржээ.

Дархлалаа хэтрүүлэн үнэлж болохгүй.

Леона Хелмслигийн "Зөвхөн жижигхэн хүмүүс татвар төлдөг юм" гэсэн алдартай хэллэгийг санаж яваарай. Хөөрхий тэр шоронд очих үедээ шал ондоо юм ярьдаг болсон байсан. "Студи-54" шөнийн клубын эзэн Стив Рубелл ч бас иймэрхүү юм ярьсан бөгөөд "Энэ их жижигхэн бизнес учир та бүхэн санаа зовох хэрэггүй" хэмээжээ. Харин үүний дараа засгийн газрын бүлэг түшмэд түүнийг татвараас зайлсхийж байсныг тогтоож удаан хугацаанд шоронд илгээсэн байдаг. Таны эрх мэдлийн олгож буй эрх чөлөөний хэр хэмжээг болгоомжтой хэмжээрэй.

Зөвлөмж:

Томчуудын хүлээн авалт дээр бяцхан хүүхдээ дагуулан ирж дархлаагаа гайхуулаарай. Хурим дээр дөнгөж хөлд орж байгаа хүүхэдтэйгээ ирэх юмуу лекц уншихдаа нярай ачаа авчирч болно. Хэн нэг нь таныг эндээс явахыг хүсч зүрхлэх үү?

2. Эрх дарх ба хэлбэрдэл

Эрх дарх ба хэлбэрдэл нь таны эрх мэдлийг бэхжүүлж, танд хүндлэл үзүүлэхэд хүргэнэ. | Тэдний зарим нь тун чухал учир цаашид бүлэг болгон авч үзнэ| Ариун цэврийн өрөөний түлхүүр, машин тавих талбай, хүлээн авалтын үеийн шилдэг суудал, гадаа гармагц шүхэр дэлгэгдэн угтах гэх мэт эрх дархууд нь зөвхөн танд зориулагдсан бөгөөд танд давуу байдлыг олгох юмуу таашаал өгөх болно. Таны байр суурийн олгосон онцгой эрхийг харуулахдаа итгэлтэй байгаарай. Шүүгч юмуу дуудлагын худалдаа хөтлөгчийн алх, эмнэлгийн халат ба

малгай гэх мэт.

Жишээ: Ерөнхийлөгч Никсоны засаглалын үед Х.Р.Хелдемен Цагаан ордон доторхи эмх журмыг хариуцдаг хамгаалчдад, ордонд орж гарч байгаа бүх хүнийг анзаарах шаардлага давхар тавьдаг байв.

Жишээ: Дэлхийн хоёрдугаар дайны үед Английн хаан 4-р Жорж хүртэл ард иргэдийнхээ адил даруухан амьдрахыг оролдож байх тэр үед Черчилль түүний

хоол хүнсэнд ямар нэг хязгаар тавихгүй байхыг шаардаж, бас орой бүр халуун ванн бэлдэхийг тушаадаг байлаа. л^

Зарим нэг эрх дарх аяндаа бий болдог бөгөөд чимээгүй зөвшөөрлөөр хэрэгжиж эхлэх боловч цаашид хэн бүхэн даган мөрддөг. "Морган Стенли" банкны ажилтнууд өмдний татуурга хэрэглэх үедээ биенд эвгүй байгааг мэдэрдэг байсан ч дээд шатны албанд дэвших хүртлээ тэвчдэг байв. "Вог" сэтгүүлийг тасралтгүй удирдаж байсан Анна Уинтурын хувьд тэр ам нээгээгүй цагт доод албан тушаалтнууд ярих эрхгүй байжээ. Нэг шинэ ажилтан лифтэнд Уинтуртай таараад мэндэлснийхээ төлөө зад загнуулсан байдаг.

Эрх мэдлийн олгодог эрх дархуудаас татгалзсанаар амжилт хүндэтгэл олно гэж бодох хэрэггүй. Харин ч эрх ямба, хэлбэрдэл зэрэг нь таны татах хүч ба агуу байдлыг илтгэх бүрхүүлийг улам нэмж байдаг. Угаас хүмүүс удирдагч нь сүр хүч ба нууцаар бүрхэгдсэн байхыг таашаадаг учир хэн ч халдашгүй байхыг хичээ.

Хэрэв гадаад илрэл үгүй бол та эрх мэдлийн зарим нэг хэсгийг алдахад хүрнэ. Ерөнхийлөгч Картер "Эзэн хаан шиг ерөнхийлөл"-ийн эсрэг кампанит ажил өрнүүлсэн. [Тэрбээр албан тушаалд орох үедээ өөрийн төрөлх Жеймс нэрийг Жимми болгон сольсон.] Мөн засгийн газрын хэд хэдэн уламжлалаас татгалзсан. "Ерөнхийлөгчийн мэндчилгээ" явах үед дуугаа хурааж, бас өөрөө хавтас барьж явдаг байв. Гэтэл сайн сэтгэл өвөрлөн үйлдсэн эдгээр ухралтууд түүний алдар хүндийг доошлуулсан байдаг. Картер бодохдоо америкчууд жирийн хүн шиг байх түүний хандлагыг үнэлнэ гэж бодсон ч тэд тэгсэнгүй. Харин ерөнхийлөгч Рейган ёслол тансаглалыг дахин сэргээн батлах үед бүгд түүнийг асар хүндэтгэх болсон бөгөөд тэрбээр зуйван танхимд ч гадна хувцастайгаа хүмүүстэй мэндэлдэг болжээ.

Ерөнхийлөгч Клинтон эхэндээ жирийн залуу болох гэж Картерийн алдааг давгаж эхэлсэн. Тэрбээр оройн сонины хуудас дээр спортын богино өмдтэй гардаг байсан ба түүний танхим хүндлэл алдаж эхэлсэн. Эцэст нь түүний баг бүхнийг ойлгосон бөгөөд энэ талаар туслах Жорж Стефанопулос хэлэхдээ "Сонгуулийн кампанит ажлын үеэр популист байдлаар биеэ авч явдаг шиг удирдан захирах үед эзэн хааны уур амьсгалыг барих нь үр дүнтэй байдаг. Бид төрийн бүх ёслол дээр "Ерөнхийлөгчид өргөх мэндчилгээ"-г дуулдаг болсон" гэжээ. Харин хоёр дахь удаа улс орныг захирах хугацаанд ерөнхийлөгчийн давуу байдлыг хадгалах нь "түүний нүцгэн хөлийг хаах"-аас илүү хэцүү болсон. Та үргэлж амжилтанд хүрэх албагүй. Гэхдээ өөрийн эрхийг нэмэгдүүлэхийн төлөө шаардлагатай бүхнийгхийж байгаарай. Ерөнхий шүүгч Уоррен Бергер унааны тал дээр эрх дархаа дээшлүүлэхийн төлөө бүхнийг хийсэн.

Тэгээд хамгаалалтын албатай болж, ерөнхий шүүгч лимузин хөлөглөдөг болжээ. Гэвч үүний дараа ерөнхийлөгчийн онгоцны тухай хүслээ хэлж үзмэгц нь түүнийг тэнгэрээс газарт буулгасан байдаг.

Та юу хийж чадах вэ? Магадгүй та хувьдаа лимузин нэхэж чадахгүй. Тэгвэл та өөр ажилд очиж албан тушаал дэвших боломжтой. Та мах иддэггүй гэдгээ тайлбарла. Тэгээд ч хүмүүс мах идэж байгаа нь танд таалагддаггүй учраас бүгд ногоо идвэл яасан юм бэ? Баярлалаа.

Та олгогдсон эрх дарх болоод хэлбэрдэлтээс хэзээ ч бүү зайлсхийгээрэй. Танай албан газрын сайн сайхан нь ганцхан таны гавьяа биш гэж зүтгээрэй. Израилийн ерөнхий сайдын оршуулганд оролцохоор ерөнхийлөгчийн онгоцоор явах үед Клинтон өөртэй нь тоомсоргүй харьцсан тухай тэр үеийн Цагаан ордны спикер Ньют Жингрич баахан үглэснийхээ төлөө доог тохууны бай болсон. Жингрич гомдоллосон гэж үү? Түүнийг аваарын шатаар буухаас аргагүй байдалд хүргээд зогсохгүй, нислэгийн үеэр Клинтон нэг удаа түүнтэй ярилцахаар дуудсангүй.

Зөвлөмж:

Эрх дархыг ашиглахдаа бүдүүлэг харагдахгүйн тулд хичээ.

Хэн нэгэн таны нэрийн өмнөөс шаардлага тавих ёстой. ["Хүндэт зочидтой танилцуулахгүй байх аваас манай дарга тун сэтгэл дундуур үлдэх болно"]

Энэ эрх дарх нь бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал хэрэгцээтэй гэж батлах ["Надад хувийн онгоц хэрэгтэй гэж би хэлээгүй. Гэвч арилжааны рейсээр нисч цаг алдах ёстой гэж бодохгүй байна"]

Жишиг ашиглах ["Миний ойлгосноор ахлах менежерүүдэд туслагч хэрэгтэй, ажлын эрх ашгаар шүү дээ"]

Зохис дээр тулгуурлах ["Надад бол хамаагүй л дээ. Гэхдээ би өөрийн утсаар хариу хэлэх нь онц биш санагдахгүй гэж үү?"]

Ямар нэг эрх олдох юм бол ашиглахаас бүү ичээрэй. Ширээний толгойд байраа эзэлж, туслагчаа цагаасаа өмнө ажлаас гарахыг үл зөвшөөр. Учир нь танд бичиг баримтуудыг өөрөө эмхлэх цаг хүрэлцэхгүй. Эхэндээ ерөнхийлөгч Клинтон цэргийнхэнд уламжлалт мэндчилгээ хийхдээ нэг л тодорхойгүй хөдөлдөг байжээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөгч Энтони Лейк түүнд энэ тухай хэлсэн байдаг. Үүнээс хойш ерөнхийлөгчийн дохио зангаа илүү итгэлтэй болсон.

Эрх мэдлийн олгодог нэг тааламжтай эрх дарх бол өөрийгөө танилцуулах шаардлагагүй болох явдал. Нэрийн хуудас юмуу нэр бичсэн энгэрийн зүүлт хэрэггүй. Таны хэн болохыг бүгд мэднэ. Үнэндээ таны нэр тун жинтэй болж, хэн ч таныг нэрээр дуудахаа болин "босс", "дасгалжуулагч", "амбан захирагч", "шеф" гэх мэтээр хандах юмуу таны цол хэргэмийг товчлон дуудах болно. Жишээ нь Цагаан ордны туслагчид АНУ-ын ерөнхийлөгчид хандахдаа АНУЕ гэдэг байна. [Мэдээж нэр ашиглан харьцах нь хүмүүсийн их ойртож дотноссоны гэрч

бөгөөд энэ нь нэмэлт давуу тал юм.

3.Эд хөрөнгө захиран зарцуулах

Байгаа бүх хэрэгслийг ашигла. Ажилтнууд, оффисын тоног төхөөрөмж, бусад хүмүүсийн цаг зав. Туслагчдыг нааш цааш гүйлгэх ба багийн ажиллагаа зэрэг нь таны эрх мэдэлтэйг хэлээд өгнө. Танд юу шаардлагатай байгааг, мөн олон тооны хүнтэй гэдгээ харуулна. Түүнээс гадна таны ажил илүү идэвхитэй, үр бүтээлтэй гэдгийг ч харуулна. Гадаад үзэмж бол бүхнийг өгүүлдэг. Таны үйлдэл анхаарал татахуйц гэдэгт итгэлтэй байгаарай. Асуух биш ярих ёстой гэдгээ сана. Гэхдээ эелдэг байгаарай. Таны хүсэлт иймэрхүү байж болно. "Тун удахгүй би гэртээ факс бүхий утасны тусдаа үзүүр хэрэглэх шаардлага гарна. Маргааш суурилуулж өгөөрэй" гэхээс биш "Энэ компани гэртээ факс тавихыг зөвшөөрдөг болов уу, хэрэв тэгдэг бол надад тун аятай байх болно" гэж хэлж болохгүй. Тэгээд эдгээр зүйлс танд амин шаардлагатай гэж зүтгүүлэхээ мартуузай. Та бусдаас дээгүүр цоройхын тулд үүнийг сонирхоод байгаа юм биш. Зүгээр л та илүү үр өгөөж, илүү хурдан хөдөлгөөнийг хүссэн хэрэг.

Уран сэтгэлгээгээ ашигла.

Зөвлөмж:

Ямар ч хэлбэрдлийг анхаарахгүй өнгөрч болохгүй. Тэр бүү хэл хүмүүс юмуу байгууллагын нэрний өмнө тавигддаг "ТНЕ" угтварыг ч бүү алд. Англи хэлний хямсгар судлаачдынүзэж байгаагаар эртний сурвалжит гаралтай хүмүүс л хэргэмийнхээ өмнө энэ угтварыг тавих эрхтэй байдаг. Тэгэхээр тодорхой угтвар хүртэл таныг чухаг буурьтай хүн болгон харуулна.

Дуу хураагуур, дотуур утас, компьютерийн шинэ программ, өндөр өртөгтэй бага хуралд оролцох урилга зэргийг нэхэж шаард. Хэрэв энэ бүхэн чухал хэрэгтэй ганц хүн нь та юм бол та бусдаас илүү ажилладаг байж таарна биз дээ. Танд тоон утасны шугам хэрэгтэй гэж мэдэгдээрэй. Ажлынхан алмайрах болно. Энэ бүхэн юунд хэрэгтэй гэдгийг тэд ойлгож чадахгүй. Ямар ч тохиолдолд тэд бол ийм юм гуйх зориг зүрх хүрэхгүй. Та зүгээр л ямар нэг юм хүсээд л таатай сэтгэгдэл төрүүлчихэж бай. Харин зорилгодоо хүрлээ гэхэд хүсэлттэйгээ яв цав нийцэх давуу талуудтай гэдгээ үзүүлсэн хэрэг. Та өөртөө баяр хүргээрэй. Дөнгөж сая тавьсан тоон утасны шугам таны хувийн үйлчилгээнд ашиглагдана.

Аливаа арга хэмжээ таны шаардлагад нийцэн өөрчлөгдөх ёстой. Нууц баримт хадгалах таны систем, хүнд суртлыг өөрчлөх таны анхааруулга, зардлыг бүртгэх таны арга гээд бүх юмыг тантай зөвшилцөх учиртай. Оффисоо шинээр чимэглэж, боломжтой бол шинэ тавилга захиал. |Арга ядахад ширээний чийдэн ч болтугай захиал|. Эсвэл тавилгын байршлуудыг сольж тавь. Таны хүсэлт өвөрмөц байх ёстой. Хэрэв таны шаардлага үрэлгэн байх юм бол сайн л хэрэг. Ерөнхийлөгч Ричард Никсон зуны халуун өдөр ч өрөөнийхөө ил зууханд гал түлүүлдэг байсан.

Таны төлөө ажиллах хүмүүсийн тоог нэмэгдүүл. Та хэрэгцээтэй бүхнийг ашиглахын зэрэгцээ дэмжлэг авах болно. Энэ нь таныг бусад хүнд баймгүй арга чадвартай гэсэн сэтгэгдлийг төрүүлнэ. Таны өмнөөс үнэмшилтэй нийтлэл бичих, илтгэлийн вариант санал болгох юмуу

өргөх бичгийг гурван янзаар зохиож танаар аль шилдгийг нь сонгуулах тийм хүн хэрэгтэй. Нөгөөх нь танд онцолж хэлэх боломж олгохын тулд мэдээллийг хянаж байг. Гурав дахь нь таны зөв дүгнэлт гаргахад зориулан тооцоо хөтлөх бөгөөд эцсийн дүнд та их юм уншсан, өргөн хүрээний мэдлэгтэй юм шиг харагдах болно. Ийм арга барилыг анх удаа ашиглаж байгаа юм биш. Ромын сенатчидад чухал түшмэд ойртох үеэр чихэнд нь нэрийг нь шивнэж өгдөг хүмүүс байдаг байв.

Зөвлөмж:

Алгуур хөдөлгөөн нь эрх мэдэлтнүүдийн дуртай боловч эрх дархаа үзүүлэх найдвар муутай аргын нэг. Нэг талаас их үр дүнтэй. Яагаад гэвэл бусад хүмүүсийн цаг хүч хэрэгслийг ашиглаж байгаа юм. Түүнээс гадна аливаад хоцрох нь их завгүй хүн гэдгийг өгүүлдэг. Нөгөө талаас хааяа ч гэсэн юмыг цагт нь хийвэл сайн гэсэн бухимдлыг дагуулж байдаг. Тиймээс алгуур байдлыг ашиглахдаа болгоомжтой байгаарай.

Зөвлөмж:

Цезарь хуанлид өөрчлөлт оруулснаараа хүмүүсийн ой тойнд үлдсэн. Та ч бас далайцтай сэтгэх ёстой. Таны хүсэлт агуу бөгөөд хэцүү байхын хэрээр олох эрх мэдэл хүчирхэг болж ирнэ.

Өөрийгөө шалга

Юуны өмнө ажлын хамт олноосоо хоцроогүй гэдгээ мэдэж ав. Дараа нь ашиглаж болох нэмэлт нөөц боломжуудын тухай бодох хэрэгтэй. Хэд хэдэн санал байна:

Цалин, шагнал, мөнгөн тусламж - та их мөнгө ба эрх дарх нэхэж шаардах гавьяатай. Таны саналууд хэлэлцэх сэдэв болно. Ямар ч тохиолдолд өөрийгөө үнэлсэн хүмүүс илүүд тооцогддог.

Удирдлагын дэмжлэг - танай баг олуулаа байх тусмаа сайн. Олон хүнтэй бол ихийг бүтээнэ. Тун удалгүй танд бүр олон ажилтан хэрэг болно. Таны ажилтнуудын ашигласан хэрэгсэл бүхэн таны ашигласанд тооцогдоно. Тиймээс чухал шаардлагатай зүйлээ шаардах ёстой гэдгийг тэдэнд итгүүл.

Нэрийн хуудас, талархлын зурвас, албан ёсны бичиг баримт, тэмдэглэл хөтлөх цаас гэх мэт. Хэрэв танд шуудангийн цаасны бүхий л төрөл зүйл байгаа бол тамга дарахын оронд товойлгож хэвлэсэн дардастай байхыг шаардаарай.

Унаа үйлчилгээ - хэрэв танай ажилтнууд бизнес юмуу нэгдүгээр ангиллаар нисч байгаа бол та ердийн ангиллаар битгий нисээрэй.

Спортын танхим, тусдаа хооллох өрөө, сагсан бөмбөгийн тэмцээний тасалбар, шоуны тасалбар, дарсны амталгаа гэх мэт эрх дарх бүхэнд хүрч амсах хэрэгтэй. Хэрэв энэ бүхнээс та ямар нэг ашиг олохгүй байлаа ч энэ бүхэн танд хэрэгтэй гэдгийг батлаарай. [Хэрэв та өөр илүү чухал ажилтайн улмаас энэ эрх дархгүйгээр болно гэдгээ харуулж тасалбарыг буцаан

4. Найзаа шагнаж дайснаа шийтгэ

Найзуудаа шагнах замаар та тэдний талархалыг хүлээж ач санах сэтгэлийг нь бэхжүүлнэ. Тэдний байр суурийг бэхжүүлсэнээр өөрийнхийгөө бас бэхжүүлдэг. Ерөнхийлөгч Рузвельтын албаны дарга нь шинээр мандаж буй одод тусалдаг байсан. Түүний ачаар "Хот-дог"-ууд гарч иржээ. Тэднийг мань хүн ерөнхийлөгчийн захиргааны үед "шинэ зам"-ын үед дагуулж ирсэн байна.

Дайснуудаа шийтгэснээр эсрэг байр суурьтай хүмүүсийг сулруулна. Түүний хажуугаар болзошгүй дайснуудыг гар нүцгэлдэг. Холбооны мөрдөх товчооны дарга Эдгар Гувер дайснуудтайгаа хайр найргүй арга хэмжээ авдаг байв. Түүний замыг хөндөлссөн л бол санал нийлээгүйн шалтгаан юмуу тухайн хүний байр суурины далайцаас үл хамааран шийтгэдэг байлаа. Гэвч болгоомжтой байгаарай. Гүйцэд шийтгэж чадалгүй оромдсон дор дайснаа шийтгэлгүй орхисон нь дээр. Хэрэв та хаан руу гал нээсэн бол заавал алах ёстой гэдэг.

Зөвлөмж:

Таныг ажилд хөлслөөгүй байсан ч өгсөн бүхнийг ашигла. Хэрэв ярилцлагын үеэр кофе санал болговол заавал уугаарай. Хэрэв та эрт ирэх юмуу эсвэл аль хэдийн явах гэж байгаа бол утсаараа ярих зөвшөөрөл хүсээрэй.

5. Өрсөлдөөнийг бут ниргэ

Эрх мэдлээ харуулах гэдэг нь өөрийгөө бусдад мэдүүлэхийг шаарддаг учраас эрх мэдэлд шатлан захирах ёсон гарцаагүй хэрэгтэй. Та нийгмийн шатаар дээш өгсөхийн тулд ажиллах учиртай. Энд өрсөлдөгчөөс салах арван арга бий.

1. Тушаалыг дага. "Мем5меек"-ийн хэвлэн нийтлэгч Мейнард Паркер үргэлж нэр хүндтэй хүмүүсийг дагадгаараа алдартай. Нэгэн удаа үдийн хоолонд хоцорч ирээд суудал нь хаана байгааг асуулгүй ширээний толгойд суучихжээ. Гэтэл мах хэрчихээр боссон хүндэт зочны байранд суучихсанаа Паркер хожим мэдсэн юм.

2. Нөхцөл байдлыг дага. Аяндаа дэврэн гарч буй урам зоригт анхаарал хандуул. Роберт Моузес ажилтнуудтайгаа уулзах үеэрээ түүнийг эсэргүүцэх гэсэн хэний ч дуу хоолойг шууд дардаг байсан.

3. Өөрийнхөө төлөө тэмцлийг зохион байгуул. Таныг хэд хэдэн нэр хүнд бүхий хуулийн компани ажилд урьж байгаа гэж хэлээрэй. Шинэ хүмүүсийн дундаас ялгарахын тулд өрсөлдөгч хоёр компанийн алийг нь сонгохоо шийдэж чадахгүй байгаа дүр эсгээрэй. Хоол, цайны цаг юмуу утсаар ярилцах зэрэг нь энэ асуудлыг шийдэхэд туслана. Та хоёр байгууллагын хоёуланд нь байр сууриа бэхжүүл.

4. Бодлоготой үйлдэл хий. Таны ухаалаг байдал сонирхол төрүүлнэ. Ерөнхийлөгч Буш ба "Женерал Электрикс"-ийн захирал ЖекУэлч нар гараар бичсэн нийтлэлийн мастерт

тооцогддог байлаа. Холливудад бэлэг гардуулах явдал нь хамгийн гол ёслолд тооцогддог.

5. Шаардамтгайгаараа ялгар. Мөн үйл ажиллагааны салбарын мэдлэгээрээ ялгар. Эрх мэдлээ хэзээ ч хэт үнэлж болохгүй. Та бусдаас илүү бичсэн юмуу мэдээлэл авсан байсан ч хамаагүй. Клинтон жижиг сажиг зүйлийн талаарх мэдлэг ба өндөр шаардлагаараа өөрийн болоод нөгөө талын хүмүүсийн гайхлыг бардаг байсан.

6. Ялимгүй санагдаж байсан байгууллагыг өөрийнхөө хүчирхэг тулгуур болго. Линдон Жонсон мандах замынхаа эхэнд дампуурлын ирмэгт тулаад байсан нэгэн компанийг нөлөө бүхий төв болгож чадсан байдаг.

7. Эрч хүч цацруул. Ижилгүй эрч хүч танд өөрийгөө бусдад зориулах агуу тасралтгүй мэдрэмжийг өгөх ба энэ нь таныг бусдаас ялгаруулж өгнө. [Эрч хүч нь өндөр идэвхи ба байнгын анхаарал төвлөрлийг агуулна.] Санхүүч Майкл Милкен үргэлж уурхайчны дуулга өмсч явдаг бөгөөд галт тэрэгт суух үедээ бичиг баримтуудаа уншихын тулд гэрлийг нь асаадаг байсан ба үүнийг нь бүгд шоолон инээлдэж тэр хүн муу нэртэй болжээ. Түүнээс гадна хоёр хүн адилхан үр дүн үзүүллээ гэхэд илүү эрч хүчтэй нь эрэлттэй байх болно.

8. Өөрийн шаардлага дээр хатуу зогс. "81top апс! 3с1ш51ег"-ийн ерөнхий редактор Роберт Готтлибын залгамжлагч болохын тулд гүйцэтгэх редактор Майкл Корд шинэ редактор томилогдох хүртэл түүний хоосон өрөөг эзэлж байх хэрэгтэй хэмээн итгүүлжээ. Тэгээд залгамжлагчийг нэрлэхээс өмнө Корд түүний өрөөнд нэвтрээд зогсохгүй өрөөг цэнхэрээр будаж, цэнхэр хивс дэвсч, оффисын цэнхэр тавилга, тэр бүү хэл цэнхэр өнгийн хэвлэх машин суурилуулан шаардсандаа хүрсэн байна. Удалгүй тэр ерөнхий редактор болжээ.

9. Маргалд. Бага зэрэг холдоод, өөрийн нөхцөл байдлыг сүр дуулиан болгож маргаан өдөөнө. Таныг хүмүүс дэмжихгүй байж болно. Магадгүй амгалан тайвныг алдагдуулагч гэсэн нэр зүүнэ. Гэхдээ хэнд ямар хамаатай юм бэ? "Нью-Йоркер"-ийн редактор Тина Браун өдөөн дуудсан хавгасаар уншигчдаа бужигнуулдаг байлаа. Негр бүсгүйг үнсч байгаа сахалтай эрийн зураг, эсвэл өндөгний баярын туулайн хүүхэлдэйг 1040 дахин өсгөсөн зураг гэх мэт маш их шуугиан тарьдаг байсан.

10. Өөрийн амьдралыг өөрөө бүтээ. Тохиолдолд бүү найд. Хамгийн хүчирхэг хүмүүс ч тохиолдлын агуу үүргийг ойлгодог байсан. Гэхдээ түүнд бүрэн найддаггүй байжээ. Ричард Никсон хэлэхдээ "Аз хөлөглөсөн хүн хол явахгүй" гэсэн байдаг.

6. Унаа

Таны унаа тэрэг нь эрх мэдлийн үзүүлэлт. Хувийн юмуу засгийн газрын онгоцоор нисэх, ядаж нэгдүгээр ангиллаар нисэх нь эрх мэдлийн нотолгоо юм. "Женерал Электрик" компанийн захирал Жек Уэлч компанийн онгоцыг насаараа хөлөглөх зөвшөөрөл хүсч байв. Нью-Йоркод эрх мэдлийн том хэлбэр нь хувийн жолоочтой машин. Лос-Анжелест та өөрөө жолоогоо барих боловч |гэрээний дагуу танд жолооны үнэмлэх өгдөг| машиныг зогсоолд байршуулахыг өөр хүн хариуцна.



Мадонна студийн онгоц хөлөөлөж Холливууд дахь нөлөөгөө гайхуулдаг

Хүмүүс тан дээр өөрсдөө ирэх, эсвэл замын дунд уулзахыг хэлж шаардах хэрэгтэй. Автомашинны аварга замуудтай хотуудын хувьд энэ онцгой чухал.

Жишээ: Бушийн засаг захиргааны тэргүүн Сумуни шүдний эмчид очих, цанын бааз явахдаа ч эрх мэдлээ ашигладаг байсан ба Нью-Йорк руу маркны үзэсгэлэнд очихдоо Цагаан ордны лимузинг хөлөглөдөг байв. [Нэгэн удаа тэр алдаа гаргаж арай хэтрүүлсэн бөгөөд түүнээсээ болж халагджээ].

Жишээ: Мадонна мэтийн холливудын одод холливуд дахь нөлөөгөө гайхуулахын тулд студийн онгоц ашигладаг байжээ. Тэгээд ч тохь тухтай.

7.Цагийн үнэ цэнэ

Таны цаг хугацаа хичнээн өндөр үнэтэй болохыг онцгойлох ёстой. Таны өмнөөс хэн нэгэн утас залгаж, гэрээ хийж, тасалбар захиалж, машин жолоодож, нохойг тань эмчид хүргэж, таны өмнөөс сонин гарчиглан илтгэх хуудас бэлтгэнэ.

Таны эргэн тойронд байгаа хүмүүс таны хувийн цагийг хамгаалахын тулд өөрийн асар их цаг хугацааг зориулж байдаг.

Жишээ: Төрийн нарийн бичгийн дарга Олбрайтын толгойлсон төрийн департаментын тэргүүн Рубин аливаа бага хурлын өмнө эцсийн мөчид утасдаж, өндөр хэмжээний түшмэд түүний дотор Цагаан ордны төлөөлөгч Майкл Маккарриг хүртэл хүлээлгэдэг байлаа.

Жишээ: Пит Петерсон "Лерман Бразерс" компанийн түншүүдээсээ хотоос хамт гарах юмуу нисэх буудал хүртэл хамт явахыг шаарддаг байв. Энэ хугацаанд тэр утсаар ярих юмуу илтгэх хуудас уншин тэднийг огт тоохгүйгээ харуулдаг байжээ.

Танд цаг хугацаа тийм их дутаагүй байсан ч хүрэлцэхгүй байгаа мэт сэтгэгдэл төрүүл. Уулзалтын үеэр таны утас хангинан дуугарвал сайн. Та уулзалтыг яаран дуусгаж хичнээн завгүй хүн болохоо харуулна.

Таны эрх мэдэл өсөхийн хэрээр таныг дагалдагсадын тоо өсөх ба таны ажлыг тэд гүйцэтгэнэ. Тэд танд аливаа асуудлын тухай хамгийн сүүлийн шатанд бодохоос өөр юу ч хийхгүй байх

боломж өгнө. Таны бичиг цаас онгоцны тасалбар, паспорт ба түлхүүрүүдийг хэн нэгэн хариуцна. Бичиг баримтыг бүхэлд нь уншиж тэмдэглэхэд та хэзээ ч цаг зарахгүй.

Дүрэм

Хичнээн их эрх мэдэл олж авахын хэрээр та бага ажиллана.

Та хяналтанд байсаар л байна. Танай багийнхан таны цаг хугацааг минутыг хүртэл сахин хамгаална. Та хуваарьт анхаарал хандуулахгүй байж чадна. Уулзалтын дараа хүмүүстэй ярилцан эрх мэдлээ харуул. Ингэснээр та оройтож явах учраас тантай уулзахаар төлөвлөсөн хүмүүс өөрийн ээлжийг тэвчээртэй хүлээхэд хүрнэ. Ажлын өдрийн бужигнаан дунд ч утсаар удтал ярих цаг гаргаарай. Танай ажилтнууд ичиж зовоходоо юу хийхээ ч мэдэхгүй суухад хүрнэ. [Эрх мэдлээ ийнхүү гайхуулах нь өөрийн гэсэн сул талтай. Алгуурлын тухай зөвлөмжийг уншаарай].

Жишээ: 1988 онд Хятадад айчлах үеэр ерөнхийлөгч Клинтон эртний цэргийн шороон баримлын тухай асууж хөндсөн байдаг. Хэдийгээр ийнхүү саатах нь нарийн хуваарьтай ажлын өдрийг баллаж мэдэхээр байсан ч тэр ингэсэн юм.

Эрх мэдлийнхээ зиндааг шалга

Таны ажлын өдрийн хуваарь бол хэнтэй уулзах ба цагаа хэрхэн өнгөрөөх тухай тэмдэглэл юм. Хуваарийн харагдах байдал таны эрх мэдлийн хэмжээг хэлээд өгнө.

Эрх мэдлийн доод түвшин: Та хуваарь дагаж мөрдөхийг өөрөө хариуцна.

Дунд түвшин: Таны хуваарийгхэн нэгөөрхүн бэлдэж, аливаасөргөлдөөнийг зохицуулна.

Завсарын буюу дунд ба өндөр түвшний хоорондох түвшин: Таны

өдрийн хуваарийг таны өмнөөс сайтар бодож боловсруулна. Танд нэмэлт мэдээлэл өгнө. Жишээ нь хэрэг болж магадгүй утаснуудын дугаар, арга хэмжээ болох газрын тухай, хаана болох, машин байрлуулах газар гэх мэт. Ингэснээр та ямар ч нөхцөл байдалд бэлтгэлтэй болох юм.

Эрх мэдлийн өндөр түвшин: Нэмэлт мэдээлэл байхгүй. Зөвхөн хамгийн чухал зүйлсийг сонордуулна. [Гэхдээ таны асуусан мэдээллийг жишээ нь зочид буудал дахь спорт танхимын ажиллах цагийн хуваарийг танд мэдээллэх гэх мэт] Та өөрөө их яваад байхгүй. Хүмүүс өөрсдөө тань дээр ирнэ. Хэрэв танд хөдөлж явах шаардлага гарвал бусад хүмүүс хэрэгтэй газарт чинь хүргэж, хэрэгтэй хүмүүстэй уулзуулна. Эсвэл таны хуваарь бичигдсэн эсэхэд та огт санаа тавихгүй.

Эрх мэдлийн дээд түвшин: Таны өдрийн хуваарийг зөвхөн хэрэгтэй хүмүүс мэдэх боломжтой. Өөр цаашаа тараахгүй хянах ба бусад ямар ч хүн хүрч мэдэх аргагүй.

8. Аюулгүй байдал

Та хамгаалалтгүй явж болохооргүй дэндүү чухал хүн учир хувийн аюулгүй байдал ба өмч хөрөнгөө хамгаалахын тулд арга хэмжээ аваарай. Ерөнхийлөгч болон засгийн газрын гишүүд хамгаалалтанд байдаг. Ерөнхий захирлууд байнгын хамгаалалттай байхын тулд жилд 500 мянган доллар төлдөг. Холливудын одод 24 цагийн хамгаалалттай байдаг. Танд ч бас хамгаалалт хэрэгтэй. Хамгаалалтыг сонгохдоо уламжлал болсон нүдэнд ил хүрээлэл хэрэгтэй юу эсвэл үл ажиглагдах бие хамгаалагчдын бүлэг хэрэгтэй юу гэдгийг шийдээрэй. Танд сум үл нэвтрэх хантааз хэрэгтэй юу эсвэл таны байгаа газрыг тодорхойлох бяцхан төхөөрөмж үү?

Жишээ нь: Хэдийгээр бизнесмен Рональд Перелмин чухал хүн биш боловч аюулгүй байдалдаа тун их санаа тавьдаг. Өнөөдөр тэр үдэшлэг найраа зэвсэгт хүмүүсээр хамгаалуулах ба өмч хөрөнгөө пулеметаар хамгаалуулдаг гэдгээрээ алдартай.

Жишээ: "Санбим"-ын гүйцэтгэх захирал Данлоп түүний амь насанд заналхийлснээс хойш хувийн аюулгүй байдлаа тун чухалд тооцож компаниасаа сум үл нэвтрэх хантааз, бие хамгаалагчид болоод галт зэвсэг хүсчээ.

Хэрэв та жинхэнэ хамгаалалт авахад бэлэн биш бол бэлэг тэмдэгийн хамгаалалт аваарай. Нарийн бичгийн дарга нар танд хүрэх замд хяналт тавьж, хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг. Хэрэв чадахаар бол хэд хэдэн нарийн бичигтэй болоорой. Эсвэл илүү сайн хамгаалалттай болохын тулд эрэгтэй нарийн бичиг авсан ч болно. Гамшгаас өөрийгөө хамгаалахын тулд ул суурьтай арга хэмжээ авна. Та маш чухал хүн учир дусал бороо ч тань дээр буух ёсгүй. Хажуугаар өнгөрч байгаа хүн ч таны санааг зовоох учиргүй.

Жишээ: Бушийн арилжааны асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Роберт Мосбачер багийн бусад гишүүдээс тусдаа газарт суудаг. Тэрбээр зөвхөн тэр өөрөө болон түүн дээр ирэх зочид л орж гардаг онцгой хаалганы дэргэд байрлана. Хаалганы дээгүүр үнэтэй улаан материалаар хийсэн хөшиг байх агаад энэ хаалт хаалганаас явган хүний зам хүртэл татаастай байдаг. Тиймээс өөрөө норох юмуу аливаа бичиг баримтыг баллах аюулгүй.

Жишээ: Иван Трамп мөн бороонд үл норох хүслээр Аппе-Ист-Сайдын төв дэх байрны хаалганаас явган зам хүртэл хөшиг өлгөжээ. Түүний тэрбумтан хөршүүд болох Пьер Карден, Дэвид Жефрен, Роуренс Рокфеллер нар энэхүү шинэ зүйлд нь тийм ч сэтгэл хангалуун байгаагүй.

Зөвхөн та биш таны үзэл санаа ч хамгаалалтанд байх ёстой. Та хэнтэй ч харьцсан байлаа гэсэн- (хэн нэгэнтэй уулзах, ярилцах, хувь нэмрийн тухай асуух, гэр цэвэрлэснийх нь төлөө төлбөр хийхдээ хүртэл)- бүгдтэй нь хэлцэл хийх түгээмэл арга болох нууцыг цааш задруулахгүй гэсэн гэрээнд гарын үсэг зуруулаарай.

9.Яриа

Өөртөө итгэлтэй, эрх мэдэлтэй хүн шиг ярих дадал зуршлыг эзэмшээрэй. Нөлөө бүхий хүмүүс удтал ярих ба ярианы сэдвийг өөрөө тогтоож, яриаг нь таслахыг үл зөвшөөрөн тоглоом наадам хийж инээлдэж байдаг. Тэд асуудлыг шийдэх төлөвлөгөөг санал болгодог. Нөлөө бүхий хүмүүс олон асуулт тавьж, өрөвдөж, толгой дохиж, бас инээмсэглэх ба өөрийн

яриаг дуусгадаггүй.



Хорвоогийн хамгийн баян хүн Билл Гейтс-т хүртэл биелээгүй мөрөөдөл байдаг ба тэр нь хаалттай гольф клубын гишүүнчлэл аж.

Таны ярих хэв маяг танай компанийн соёлд нийцэхээр байлгаарай

"майкрософт" компанийн Хорвоогийн хамгийн баян хүн Билл

Эжилтнууд БИЛЛ Гейтсийн ярих хэв маяг Гейтс-т хүртэл биелээгүй мөрөөдөл

ба биеэ авч явах байдлыг хуулбарладаг. бай^аг ба тэр нь *™лттай гольф

г-. ~ - ~ клубын гишүүнчлэл аж.

Ялангуяа түүний дэргэд бол бүр ингэнэ.

Тэд яг Гейтс шиг урагш тонгойн тохойгоо

өвдөг дээрээ тавьж ширээнд суух бөгөөд үсрэн босоход бэлэн байдаг. Цухалдсан үед сандал дээрээ найгах зуршилгүйг нь хүртэл дууриадаг. Танай компанид зоримог нотолгоо хийхийг зөвшөөрдөг үү? Эсвэл бодлоготой, болгоомжтой ярих ёстой юу? Анхаарал халамжийн шинж тэмдэг үзүүлдэг үү? Ёс зүйгүй наргиан наадмыг зөвшөөрдөг үү? Танай нөхцөл байдалд тохирох ярианы хэв маягийг өөрийн болго. (Ихэнхдээ энэ нь хүчирхэг хүмүүст орших хэв маяг)

Юу ярих, хэрхэн ярьж байгаагаараа эрх мэдлээ илэрхийл. Уулзалт нь арга хэрэгслээс ичиж зоволгүйгээр зорилгодоо хүрэх хамгийн тохирохуйц газар. Дээр дурьдсан, ажлын хамт олонд эрх мэдэлтэй болохоо мэдүүлэх зарчмуудыг ашиглах талаар туршиж үзээрэй. Гэхдээ анхааралтай байгаарай. Хэрэв та бодлогогүй хөдлөх юм бол олны дургүйцлыг төрүүлнэ.

Та аядуу ярих нь дээр гэсэн дүгнэлтэд хүрч болно. Тэгвэл бусад хүмүүс таньгилүүанхааралтайсонсоходхүрнэ. Ричард Никсон"Чангаярихынхэрээрхүний үнэ цэнэ багасдаг" гэжээ. Холливудын найруулагч Майкл Овиц бусад хүмүүсийг өөрийнх нь үгийг сонсоход хүргэдэгээрээ алдартай. Эсвэл та бүр ярихгүй байсан ч болно. Үл хөдлөх хөрөнгийн асуудлаарх Нью-Йоркийн магнат Жерри Спейер ярианд оролцохгүй байсаар тухайн ярьж байгаа хүнээ уурлаж хилэгнэхэд хүргэдэг.

Эрх мэдлээ батжуулах загварыг сонго

"Нададэнэбүхжижигсажигзүйлсхэрэггүй. Биднийсонирхожбайгааасуудалд шууд орцгооё. | Бусад хүмүүс ажлын чиг шугамаас зайлсхийж байгааг та зааж байна. Тэд хэцүү асуудлыг цэгцлэх шаардлагаас зайлсхийх боломж хайж байна|

"Тийм ээ энэ бол баримт". |Та няцаах аргагүй баримт дээр тулгуурлаж байгаагаа тэмдэглэж байна. Гэтэл бусад хүмүүс сэтгэл хөдлөл, таавар бодолд өртжээ|

"Магадгүй таны зөв байх". |Та угтах алхам хийж байгаа боловч нөгөө талаар ярилцагчдаа бүрэн итгэхгүй байна|

"Надад үүнийг мэдэх нь сонин байна. Алив тэр асуудалд эргэн орцгооё" |Та эрүүл саруул дүгнэх чадамжаа харуулж байна. Үүний хажуугаар энэ удаад илтгэл тавих албагүй Пэтийг урьд өмнө ярьсан зүйлд нь эргүүлэн оруулж байна|

"Пэт та энэ асуудлаар гайхалтай сайн ажиллажээ. |Та түүнд сайнаар ханддаг болохоо харуулахын зэрэгцээ түүнийг шүүх эрхтэй гэдгээ ойлгуулж байна.|

"Миний бодлоор Пэт ингэж хэлэхийг хүсч байна". |Та сайн сонсогч бөгөөд бусдад итгэдэгээ харуулж байна. Түүний хажуугаар Пэтээс илүү холыг харах чадвартайгаа ойлгуулж байна|

"Та яагаад ингэж бодож байгааг би ойлгож байна" эсвэл "Би ч бас ингэж бодож хэвшжээ". |Та эдгээр үгсээр сэтгэл дотно байгаагаа илэрхийлж байна. Гэхдээ тухайн асуудлын ойлголтоор та түүнийг хол хаяснаа харуулж байна.|

10.Ажлын байр

Таны эрх мэдлийг хэмжихийн тулд хүмүүс таныг бүхэлд нь үнэлдэг. Зөвхөн таны гүйцэтгэж байгаа ажил үүргээр биш бусад хүмүүс танд хэрхэн хандаж байгаа болон танай ажлын байрны байршил, гадаад дүр төрхөөр хэмждэг. Эрх мэдлийн шинж тэмдгийн доорх жагсаалтаас хэд нь танд байгаа вэ? Үүнд

Захиалгаар хийлгэсэн тавилга

Урлагийн үнэт бүтээл

Таны хувийн хурлын танхим

Таны хувийн хооллох өрөө

Таны хувийн шүршүүр ба саунтай ванны өрөө

Таны хувийн лифт

Ашигтай байрлал |голдуу булангийн өрөө|

Цонхоор харагдах сайхан үзэмж

Тасалгааны ургамал юмуу амьд цэцэг бүхий хэд хэдэн ваар.

Таны хаалгыг харж хамгаалж байгаа ажил хэрэгч нарийн бичгүүдийн бүлэг

Нэртэй түшмэд ба ододтой авхуулсан гэрэл зураг

Өргөмжлөл талархал гэх мэт өмнөх ялалтуудын цуглуулга

Өрөөндөө тусдаа шугамтай хэд хэдэн утас

Өдөр бүр гэрээсээ дагуулж ирдэг нохой |эсвэл шувуу болон өөр амьтан байж болно|

Зөвхөн таны татдаг тамхинд зориулсан үнсний сав |уг нь танай байгууллагад тамхи татах хориотой|

Бусадтай харьцуулахад илүү тохь тухтай орчин, хувийн өрөө ба хонгилын хооронд хүлээн авах өрөө байх

Хамгийн өндөр хурдтай интернетийн холбоо

Сонин хачин, эсвэл дахин давтагдашгүй үнэтэй эд зүйлс. Жишээ нь номын тавиур байх ба нөгөө тал руу нь эргүүлбэл баар болон хувирна. Эсвэл эрт дээр үеийн шүдний эмчийн сандал.

Намхан зөөлөн буйдан эсвэл өндөрт байрлуулсан таны ширээ. Ингэснээр та ирсэн хүнийг дээрээс харах боломжтой.

Интернетэд тусгайлан зориулсан: хэмжээ нь бусдынхтай адил ширээ, өндөр үнэтэй сандал, хавтгай дэлгэц

Ерөнхийлөгчийн төлөөлөгчдийн айлчлалд тусгайлан зориулсан олон тооны туг далбаа байх. Энэ нь улсын болон байгууллагын, хотын, янз бүрийн аж ахуйн нэгжийн гэх мэт.

Нөлөө бүхий хүний өрөө ямар нэгэн юм дутаж байгаагаараа онцгой байдаг. Бүр огт ширээгүй байх юмуу эсвэл ширээний шургуулга нь үгүй байх. Хэрэв өөрийн ширээн дээр зай эзлээд байна гэж үзвэл дипломоо нарийн бичгийн даргын ширээн дээр байрлуулах, эсвэл ширээнийх шигээ сайн чанарын модон жаазанд хийж дэргэдээ тавих. Элдэв бичиг цаастай өрөөнөөс татгалзах. Энэ нь та биш өөр хүмүүс бичиг цаастай харьцдаг болохыг харуулна. Таны өрөөнд зарлалын самбар, нэг удаагийн аяга, хогтой сагс байх учиргүй.

Өрөөн дэххамгийн чухал зүйл нь мэдээж стратегийн байршил. Байгууллага бүрт эрх мэдлийн зүрх нь болж бүх юм төвлөрсөн тодорхой давхар юмуу булан, эсвэл хэн нэгний хувийн кабинет байрших тийм газар байдаг. Та тэнд юмуу ойр орчинд нь байрлах ёстой. Хиллари Клинтон энэ зарчмыг дагаснаар ерөнхийлөгчийн болоод өндөр түшмэдийн өрөө байрлах Баруун жигүүрт өрөө гаргаж өгөхийг шаарджээ. Харин Зүүн жигүүрт бол тэргүүн хатагтай

нарын ашигладаг уламжлалт өрөөнүүд, тухайлбал олон нийтийн асуудлаархи ажилтнуудын өрөө байрладаг.

Эрх мэдлийн ийм төвийн газар зүйн байрлалыг хэн эрх мэдэлтэйг харуулахад ашигладаг. Үид энэ асуудлыг 34-р давхарт шийднэ" гэх мэт.

Жишээ: Никсоны засаглалын эхний жил туслагч Даниель Патрик Мойнихан Цагаан ордны дэргэдэх том байшинг эзлэх боломжоос татгалзаж баруун жигүүрт наалдсан оффисыг авчээ. Тэр хэлэхдээ "Яагаад гэж үү? Яагаад гэвэл би Хелдементай нэг ариун цэврийн өрөөнд орж гарахыг хүссэн юм" гэжээ.

11. Утас

Их эрх мэдэлтэй болохын тулд утсыг ашиглаж сур.

Танай туслах таны яриаг захиалаг.

Хэн нэгэнтэй яриагаа дуусгах хүртэлээ бусадтай холбогдохоос татгалз.

Завгүй байгаагаа харуулах үүднээс машин юмуу онгоцонд явахдаа залга.

Төрийн ордон гэх мэт газарт байхдаа залга. Эсвэл нэртэй бизнесмен Жон Доерын өрөөнд байхдаа залга.

Алтан "ГColoc1ехез"-оо бусдын хараанд өртөхүйц барь.

Ариун цэврийн өрөө, онгоц, усан сан, говь цөл гээд хаанаас ч холбогдож чадна гэдэгтээ итгэлтэй байх.

Өрөөндөө тусдаа шугамтай хэд хэдэн утас байрлуулах Машиндаа хэд хэдэн гар утастай байх

Чанга яригчтай утас ашиглахаас татгалзах замаар таны утасны яриаг сонсох боломж үл өгөх

Утас дуугарахад өөрөө авахгүй байх, үүнийг таны өмнөөс туслагч хийх ёстой.

Таны нэг хормыг ч алдуулахгүйн үүднээс туслах тань хэд хэдэн утас дээр зэрэг суух ба энэ хооронд хэд хэдэн хүн таныг утас дээрээ хүлээж байна.

Утасдсан хүнд шууд хариулах замаар хүндэтгэлээ харуулна. Харин огт хариулахгүй юмуу утсаа авахгүй байх замаар тоохгүй байгаагаа мэдүүлнэ.

Их эрт юмуу хэт оройтож утасдаж бай.

Үл ялих тушаалын хүнтэй бүү ярь. Таны мэдээллийг туслах тань дамжуулаг. Тэр хүнтэй машинд хамт байх юмуу нэг ширээний ард сууж байлаа ч түүнд юу дамжуулж хэлэхийг туслахдаа хэлж өгнө.

Утсыг ашиглахдаа бүтээлч хандах ёстой. Жишээлбэл зөвлөгөөний өмнө нарийн бичигтээ хандаж бүхэнд дуулдахуйцаар "Бүгдийг нь хүлээж бай гэж дамжуул. Гэхдээ ноён Жорж Лукасугасдах юм бол намайгтүүнтэй шууд холбоорой" гэж хэлнэ. Хэн нэгэн хүнтэй таараад түүнийг тоохгүй байгаагаа харуулахыг хүсвэл түүний дэргэд өөр хэд хэдэн хүнтэй утсаар яриарай.

Жишээ: Вашингтоны "Жефферсон" хэмээх өндөр үнэтэй зочид буудлын өрөөнүүдийн утасны санамжинд зайлшгүй хэрэгцээт үйлчилгээ тухайлбал оёдолчин, зарц юмуу цэвэрлэгчийн утасны дугаарыг суулгаж өгсөн байдаг. Гэтэл эндээс Цагаан ордон юмуу Төрийн департаменттай маш түргэн холбож өгдөг нь зочдод тун их таалагддаг.

12.Мөнгө

Хэзээ ч мөнгөтэй бүү зууралд.

Мөнгөний асуудлыг бусад хүмүүс шийдэх учиртай. Таны хувьд үнэхээр шаардлагатай бол гарын үсэг зурахад хангалттай.

Жишээ: Найруулагч Роберт Иванс Лос-Анжелесийн ресторануудад зөвхөн чекээр тооцоо хийдэг учраас түүнд хэзээ ч тооцооны хуудсыг гардуулж байгаагүй. Тэр төлбөрөө хийлгүй юмуу цайны мөнгө өгөлгүй явж одох нь бий. Хожим төлдөг байсан.

Жишээ: Английн хатан хааны адилаар тэргүүн хатагтай Нэнси Рейган түрийвчийг нь барьдаг туслахтай байжээ.

Жишээ: Английн архитекторч Роберт Максвелл хэзээ ч биедээ мөнгө авч явдаггүй. Түүний удирдлага доорх хүмүүс араас нь даган явж бүх төлбөрийг хийдэг. Тэр зөвхөн хэрэгтэй юмаа авч оддог байв.

13.Залб мэх

Эрх мэдлээ харуулах хамгийн зальжин алхамууд нь тухайн нөхцөл байдалд тохируулсан овсгоо самбаа, уран чадамгай дохио зангаа бөгөөд өөрийгөө баталгаажуулах боломж олгоно. Энэхүү аргыг ашиглах боломжийг хайж бас таны эсрэг ашиглахад нь саад учруулаарай.

Оновчтой алхам амжилтанд хүрэхийн тулд зөв хийгдсэн байх ёстой.

Жишээ нь хүмүүсийн царай төрх ба нэрийг тогтоох нь тун сайн арга боловч их эргэлзээтэй. Та хэн нэгэн бага зэрэг танил хүнд хандаж "Сайн уу Пэт, өнгөрсөн зун хурал дээр таарч байсан даа" гэж хэлнэ. Мэдээж өөрийг нь таньж бас хандаж байгаад Пэт тун баяртай байх болно. Та илүү хүчирхэг хүн болж, олон хүнтэй уулзахын хэрээр ийм хандлага нь тун сэтгэл төрүүлэм болж ирнэ. Гэвч нэр хэлж аз үзэх хэрэггүй. Цагаан ордонд хотын дарга нарт зориулсан хүлээн авалт болох үеэр ерөнхийлөгч Рональд Рейган Сэм Пирсийн гарыг шүүрч "Ноён хотын дарга тантай уулзсандаа байна" гэжээ. Гэвч тэр зөрүүлж орхисон юм. Пирс бол Рейганы захиргаанд орон сууцны асуудал хариуцсан нарийн бичгээр ажиллаад жил гаруй болж байв.

Жишээ: Кино продюссер Дон Симпсон зочдоо айлгах дуртай тухай зохиолч Лэрри Фергюсон сонсчээ. Түүнтэй анх удаа уулзах үед ширээн дээр нь гар буу сэжигтэйгээр тавигдсан байхыг олж харав. Зохиолч ямар нэг тайлбар хэлэлгүй гар бууг авч цэнэггүй болгосон байдаг. Ингэснээр Симпсон түүний өмнө мөчөөгөө өгөхгүй өрсөлдөгч байгааг ойлгосон юм.

Оновчтой алхамууд нүдэнд өртөхүйц байх ёстой. Та "Пальтоноос татгалзах" аргыг санаж яваарай. Орлид газардах үедээ Францын ерөнхийлөгч Шарль де Голль пальтогүй байхыг анзаарсан ерөнхийлөгч Никсон пальтоогоо шууд тайлсан байна. Түүний өрсөлдөгч Жек Кеннеди тангараг өргөх ёслолын өдөр хэдий хүйтэн байсан ч цув ба бүрх малгайгаа тайлснаар хүмүүст хүчтэй сэтгэгдэл төрүүлж байсныг Никсон санасан бололтой. Ерөнхийлөгч Билл Клинтон ч бас Кеннедигийн адил 1992 онд тангараг өргөх үедээ пальтогүй байжээ.

Заримдаа эрхмэдлийн шатаартаны ахижбайгаагаасүүссэн шокийгбагасгах алхам хамгийн шилдэг нь байж мэднэ. Нэгэн шинжээчийг өөр хоёр хүний хамт банк ажилд авчээ. Гэтэл тэр шинжээч түүнийг ажилд авсан тухай зарыг сонины тусгай нүүрэн дээр хэвлэхийг шаардан залхаасан байна. Гэхдээ ажлынхан нь түүнийг нэр алдарт дуртай хэмээн бодох вий гэсэндээ "Ядаж ганц удаа миний ихэрхэг занд маань таацуулж өгөөч, гуйя" хэмээн уучлал гуйж байжээ. Сайн хэлсэн байгаа биз.

Зөвлөмж:

Та алдартай хүнтэй, эсвэл мэдэж байх ёстой хүнтэй ярьж эхэлсэн боловч яг хаана харсанаа санахгүй байж болно. Ийм байдлаас хэрхэн мултрах вэ? Нэг найдвартай асуулт бий. "Та одоо яг ямар ажил дээр ажиллаж байгаа вэ?". "Ажил" гэсэн үгямар ч санаа агуулж болно. Харин "Яг одоо" гэсэн хэлцэл түүний емнөх ажилтай аль хэдийн танил гэсэн санааг өгнө.

Эрх мэдлийг төгс эзэмшсэн хүмүүс нарийн, уян налархай тактик ашигладаг бөгөөд энэ нь нарийн мэдрэмжгүй хүмүүсийн хувьд онцгой зөн совинтой мэт санагддаг байна.

-Талархал хуваалцах. Сайн хийгдсэн ажлын төлөө зөвхөн талархах ёстой гэж бодон бүү алдаарай. Үнэндээ та магтаалыг хуваалцах ёстой. Та нөхөрсөг уур амьсгал үүсгэж, шударга ялалтыг харуулснаар ирээдүйн төсөлдөө дэмжлэг туслалцаа татах болно. Түүний хажуугаар та доорх зүйлсийг хийх ёстой.

-Зэмлэл хүлээн авах. Хэрэв та алдааны төлөө зэмлэл хүлээхийг хүсч байвал хүмүүс хариуцлагыг танд дуртайяа тохих бөгөөд энэ бол эрх мэдэл юм. Дээрээс нь зэмлэлийг хүлээн авснаар хэдийгээр та байр суурьтай нэгэн боловч шударга бөгөөд алдаагаа хүлээх дуртай гэдгийг харуулна. Ийм чанар танд илүү их эрх мэдлийг авчрах болно.

-Гуй. Бен Франклин зөвлөхдөө: "Хэрэв та найз нөхөр байхыг хүсвэл гуйж байгаарай" гэжээ. Хамтран зүтгэхийг, зөвлөгөө өгөхийг, туслахыг гуйгаарай. Ингэснээр та тэдгээр хүмүүсийн өмнө өртөн болно. Тэд танд сайнаар хандах болно. Тэдний тусламж таны амжилтанд итгэх итгэлийг тэдэнд өгнө.

-Сөрөг талуудаа онцлох. Итгүүлэхийг оролдохдоо юуны өмнө өөрийн дүгнэлтийн сул талуудыг онцлох хэрэгтэй. Дараа нь хэдийгээр та энэ сул талуудыг хүлээн зөвшөөрч байгаа ч өөрийнхөө байр суурийг хамгаалах болно гэдгээ ойлгуулаарай. Сул талаа хүлээн зөвшөөрөх нь эсэргүүцэгчдийг гар хоосон болгоно. Мөн өөрийн байдлын сул талуудыг харуулснаар таны ухаан нэгдүгээр байранд гарч ирнэ.

-Өөрийн сайн талуудыг дарах. Алдаагаа хүлээх замаар бусдыг зэвсэггүй болго. Өөрийгөө шоолж инээ. Та кофеноос хамааралтай юмуу түлхүүрээ үргэлж хаяж гээх зуршилтай болсон гэх мэтийг хэлж ярьж болох насанд яваа хүн.

-Нөгөө хацраа тавьж өг. Хэт их доромжлолоос болж зовж шаналах нь нэг их сайхан санаа биш. Ерөнхийдөө та шүүмжлэлийг хүлээн авч бас бүх юманд наргиантай хандах ёстой. Хүчтэй хувь хүн зэмлэл болгонд анхаарал хандуулаад байдаггүй.

-Гайхах. Гайхах чадвар нь гайхуулах чадвараас дутахгүй ач холбогдолтой. "Та үнэхээр ой сайтай юм", "Та эмзэг газарт нь онож цохисон гэж би бодож байна". Хүмүүсийн ярьсан хэлснийг бичиж тэмдэглэж ав. Хүмүүст талархалтай хандах аваас бусад хүмүүс таныг үнэлж хүндлэх болно.

Санаанд оромгүйн зарчим ашиглах

Эрх мэдлээ харуулна гэж бүгд хүлээх атал та эрх мэдлээ бүхнээс нуух замаар эрх мэдэлтэй гэдгээ харуулбал хачирхалтай. Та ялалтаа тодотгохын тулд Санаанд оромгүйн зарчмыг ашиглаж, ердийн бодол үйлдэлийн зах хязгаарыг давсанаа харуулж байна. Заншилын эсрэг байх. Эрх мэдлийн дадал болсон гадаад илэрхийллүүд үгүй байгаа нь таны эрх мэдлийн гадаад үзэмжийг улам ч тодотгож байна.

Санаанд оромгүйн зарчмыг та хэрхэн ашиглах вэ? Танай хүрээлэлд эрх мэдлээ илэрхийлэх ямар арга зам оршдог болохыг тодорхойл. Дараа нь түүнийг эвд. Хэрэв танай түншүүдийн оффис өндөр үнэтэй гоё сайхан тоног төхөөрөмжөөр дүүрэн бол та өөрийн өрөөг ямар ч техникгүй бас энгийн тавилгатай байлга. Хэрэв эрх мэдэлтнүүд өглөөний цайндаа талхтай хоол идэж байвал та зүгээр зууш хэрэглэ. Хэрэв тэд бага идэж байвал та овъёосны каша юмуу өндгөөр хооллоорой. Бусад хүмүүс өөрийгөө ил гаргаж байхад та харин хүрэхийн аргагүй болох хэрэгтэй.

Санаанд оромгүйн зарчмыг өөрийн өрөөнд ч хэрэгжүүл. Олон магнатууд сая сая доллартай атлаа том оффисоос татгалзсан байдаг.

Эсвэл өөрийгөө таниулахын тулд хувцасаа ашиглаарай. Өмгөөлөгч Бойс мэргэжил нэгтнүүдийн энгийн костюмаас ялгарч "Сиэрс" костюм өмсдөг байв. Силикон хөндийн толгойлогчид болох Энди Гроув ба Марк Андрессен нар өдөр тутмынхувцасөмсч,хөл нүцгэнзугаалахбаямарнэгдүрэмтхувцасогтхэрэглэдэггүй байсан. Харин программ хангамжийн салбарын магнат Ларри Эллисон бусдаас илүү гарч чадсан. Баасан гаригт Силикон хөндийн Хүлээлгийн баярын өдөр болохыг мэдээд тэрбээр давхар зөрлөгтэй пиджак, гайхалтай тээглүүрээр тэвхэдсэн сөхдөг манжлагатай цамцтай ирэв. Санаанд оромгүйн зарчмыг "АОД" ба "Тайм Уорнер" хэмээх хоёр том компаний нэгдэх жишээн дээр

харж болно. 2000 оны нэгдүгээр сард болсон нэгдэх ёслолд хэвлэлийн шинэ залуу магнат "АОД" компанийн Стив Кейс костюм ба зангиатай байсан бол харин нөгөө компанийн захирал хуучин магнат Жеральд Левин энгэрээ задгай тавьсан цамц ба ноосон даавуун өмдтэй иржээ. Зарим сурвалжлагчид энэ эрс ялгааг дурдан шоглоом өдөөснөөр соронзон долгио цацруулах хичнээн чухал болохыг дурсахад хүрсэн юм. Санаанд оромгүй явдал хэзээ ч ямар нэг тогтсон байрлал мэт харагдах ёсгүй.

Санаанд оромгүйн зарчмаар хэт их хөөцөлдөх хэрэггүй. Яагаад гэвэл үр өгөөж нь сөрөг байж мэднэ. Компьютер ашиглахаас татгалзах нь нэг нөхцөл байдалд зайлшгүй шаардлагатай байлаа ч өөр нөхцөл байдалд бол ямар ч үр дүнгүй болж таарна. Энэ зарчим бэлэг тэмдэгийн түвшинд үйлчилдэг бөгөөд онцгой тохиолдолд л хэрэглэх учиртай. Хэрэв Лос-Анжелесийн бараг бүх хүн шинэ машинаар өвчлөөд байхад харин та хуучин машины жолоо мушгиж байвал энэ нь таныг хямд хувцаслаж, даруухан байшинд амьдардаг гэсэн үг огт биш.

Таны удирдлагад байгаа хүмүүс утаснаас чихээ сал гахгүй юмуу нэг өрөөнөөс нөгөө өрөө рүү гүйх замаар хичнээн завгүй болохоо харуулж байгаа бол та тэднийг давж гараарай. Та хэзээ ч бүү яар. Таны хийж байгаа бүхэнд хүнд ачаалал болох зүйл нэгээхэн ч үгүй гэсэн сэтгэгдэл төрүүлээрэй.

Санаанд оромгүйн зарчмыг маш ховор хэрэглэдэг учраас бусдаас илүү үнэлэгддэг. Энгийн болхи бодолтой хүмүүс түүнийг өмнө нь заавал толгой гудайх албагүй жирийн даруу хүний таних тэмдэг хэмээн хүлээж авдаг. Эрх мэдлийн ердийн зарчмуудтай сөргөлдөх нь үнэн хэрэг дээрээ эрх мэдлийн нотолгоо болж байдгийг тэд ойлгодоггүй. Захирал нь ажлын өрөөн дотроо гутлаа тайлчихаад ажлаа хийдэг болохыг нэгэн сэтгүүлч олж мэджээ. Тэглээ гээд тэр өөрөө, эсвэл даргын нарийн бичиг, эсвэл өөр хэн нэгэн ажил дээрээ гутлаа тайлж чадах уу гэсэн асуултыг сэтгүүлч өөрөө өөртөө олонтоо тавьсан гэдэг. Мэдээж чадахгүй. Гэтэл ийм энгийн зүйл хүртэл өөртөө дээд зэргийн итгэлтэй болохыг харуулж өгнө.

Дүрэм

Даруу ба энгийн байдал нь ялалтаа гайхуулах хамгийн үр дүнтэй арга хэлбэр

байж болно.

xxx

Хэрэв та дээр дурьдсан, эрх мэдлийг эзлэн авах ба эрх мэдлээ нэмэгдүүлэх бүх аргыг аль хэдийн хэрэглэсэн бол та одоо тун сайн нөхцөл байдалд байж таарна. Гэвч эрх мэдлийг өөрийн болгох нь чамгүй аз үзсэн хэрэг учир болгоомжтой байгаарай. Хэрэв та эрх мэдэлдээ хордох аваас одоо байгаа бүх эрх мэдлээ алдахад хүрч мэднэ.

Дөрөвдүгээр бүлэг

Эрхмэдлээ бүү алд

Эрх мэдэл эзнийхээ зан араншинг өөрчилж эхэлдэг. Зарим зан араншин нь илүү тодорч, нөгөө нь алга болох жишээтэй. Хэрэв та болгоомж алдвас эрх мэдлийг дагадаг алдаануудын гайгаар таны боломжууд багасч эхэлнэ. Хорвоод эзлэх байр сууриа хэт өндөрт тавьсны гайгаар тансаглал, хэзээ ч буруудахгүй гэсэн мэдрэмж, ихэмсэглэл, бялдуучлалд дурлаж эхэлдэг. Доод албан тушаалтнууд танд бялдуучилж эхэлнэ. "Энэ асуудлаар та бүхнээс хол тасархай - Энэ төслийг хэрэгжүүлэхэд түлхэц өгөх ганц хүн нь та - та магтуулах гавьяатай - таныг орлох хүн байхгүй" гэх мэтээр тэд таны чихэнд шивнэж эхэлнэ. Та "тэр үнэн шүү" гэж өөрөө өөртөө итгэлтэйгээр бодох болно. Тэдний магтаал таны боломжийг бэхжүүлж улам хүчтэй болгож байдаг нь худлаа биш юм. Гэвч нөгөө талаар алдаа хийхэд хүргэн таны байр суурьт заналхийлэл учруулна.

Бялдуучлалд дурлах

Хүмүүсийн танд хэлээд байгаа сайшаал магтаалд та итгэж эхэлнэ. Таны нэр алдарт дуртай байдлыг анзаарсан ажилтнууд үүнийг өөртөө ашиглана. Таны ухамсарт болон далд ухамсарт буй хүслүүдийг хангах замаар тэд танаас дэмжлэг олж авцгаана.

Хэсэг ажилтнууд таны ямар ч үйлдлийн гавьяа ба даацийг олж |эсвэл олсон мэт дүр исгэж| эхэлдэг. Ерөнхийлөгч Рональд Рейган яаралтай нөхцөл байдалд өөрөө хэрхэн утас залгаж болгоодог байсан талаар Майкл Дивер сэтгэлээ нээн бичихдээ: "Тэр өөрөө утас залгаж байгааг харахад тун сонирхолтой байдаг. Ямар ч туслагчгүйгээр операторгүйгээр. Ерөнхийлөгч өөрөө шүү дээ" гэжээ. Бялдуучид таны зан араншингийн хамгийн дур гутам талыг хүртэл магтаалд өртүүлэх арга олдог. |эсвэл олсон мэт дүр исгэнэ| Бен Бредли "Кеннедитэй ярилцсан нь" номондоо Жек Кеннедигийн бүдүүлэг яриаг "Туйлын дур булаам" гээд дэлгэрэнгүй бичсэн байдаг. |Кеннедигийн өдөр тутмын яриа нь цэрэгт алба хаасных нь үр дагавар байв. Түүний үеийн бусад бүх эрчүүдийн нэгэн адил нэгдүгээрт тавигдах чухал ажил нь мэдээж дайн байсан. Флотод алба хаах үед нь байнга хэрэглэдэг байсан үгсийг тэр үе үе ашигладаг байлаа. Тэр хараалыг зүгээр л урсгаж орхидог байв. Тэр үед нь та түүний хүмүүжилд эргэлзэхэд хүрнэ. Гэхдээ энэ бүхэн миний хувьд бол хэзээч доромж байгаагүй".| Өөрөөр хэлбэл Кеннедигийн бүдүүлэг үг яриа мань хүний сэтгэл санааг өргөдөг байсан гэнэ.

Ишлэл:

"Августын нүд цэвэр болоод хурц. Нүднээс нь онцгой бурханлаг туяа цацардаг гэж тэр бодох дуртай. Түүний харцнаас хүмүүс нарнаас гялбах мэт дальдчихад тэр асар их ханамж авдаг байв".

Сьютониус

"Арван хоёр Цезарь"

Та бялдуучдын магтаалд автах аваас бусдын шоглоомын бай болно. Си-Би-Эс сувгийн үндэслэгч урлагийн үнэт зүйлс цуглуулагч Уильям Пели дурсахдаа "Би домогт зураач Матисст Парижд байхдаа дарсан хэд хэдэн гэрэл зургийг үзүүлэв. Тэр миний зургуудыг харсанаа "Чи ямар ажил хийдэг байлаа ч хамаагүй бүгдийг нь орхи. Тэгээд гэрэл зургаар оролд" гэж хэлсэн" гэжээ. Харин Пели "Би түүнийг гайхалтай зураач гэдгээр нь биширч явдаг. Гэхдээ би түүний зөвлөгөөг дагаагүй" гэсэн байдаг. Матисс шударгаас өөрөөр байж чадна гэж Пелигийн толгойд хэзээ ч ороогүй хэрэг.

Магадгүй та өөрийг тань хэт их магтахад автахгүй байж болно. Гэтэл бусад олонхийн адил бялдуучлалаас таашаал авч эхлээд, элдэв хязгаарлалтыг тоохоо болих аваас аюулд өртөж эхэлнэ.

Ихэмсэглэл

Та өөрийгөөрүүл саруул ухаантай, улстөрийн зоримогалхамтай, гайхалтай зөн совинтой, бусад хүнээс илүү ухаантай хэмээн өөртөө баяр хүргэнэ. Өөрийн тухай ийм өндөр бодол нь тун аюултай. Хэрэв энэ бодол үндэсгүй бол байдлыг эрүүлээр харах боломжийг үгүйсгэх тул бүр аюултай. Нэгэн удаа Линдон Жонсонд олонхийн даргын албан тушаалыг хадгалах тухай удирдлагын саналыг няцаах асуудлаар ханджээ. Харин ерөнхийлөгч "Эрх мэдэл хаашаа чиглэж байна тэндээ л байх ёстой" гэж хариулсан байдаг. Харамсалтай нь мань хүн ажлаас халагдах үедээ өөрөө хүртэл захиргаанд багтахын тулд эрх мэдлээ ашиглаж чадаагүй гэдэг.

Ихэмсэг байдал нь өөрийгөө хуурахад хүргэнэ. Найруулагч Стивен Спилберг "Эрүү" киногоороо Оскарын шилдэг найруулагчийн шагнал авна гэдэгтээ бүрэн итгэлтэй байлаа. Тиймээс шагнал гардах үед түүний үйл хөдлөлийг тусгай камераар авах тал дээр хүртэл санаа тавьжээ. Харамсалтай нь бүх юм өөрөөр эргэв. Түүний "Би үүнд итгэж чадахгүй. Тэд Оскарыг надад өгөхийн оронд Феллинид өгчихлөө" хэмээн уурсч байгаа нь дуранд өртсөн байна. Ерөнхийлөгч Рейганы амь насанд халдах оролдлого гарсны дараах хэвлэлийн бага хурал дээр төрийн нарийн бичгийн дарга Александр Хейг мэдэгдэхдээ "Үндсэн хуулиар бол төрийн эрх мэдэл дараах байрлалтай. Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, төрийн нарийн бичиг. Тиймээс дэд ерөнхийлөгчийн үгүйд би төрийн толгойд байх болно" гэжээ. Харамсалтай нь Хейг буруу алхам хийж. Тэр төрийн толгойд гарах дараагийн хүн нь бишбайв. Тэр ерөөсөө хэн ч биш болсон. Түүний энэ үг нэр хүндэд нь толбо суулгаж, ажлаасаа халагдахад хүрсэн билээ.

Ишлэл:

"Глендаур: Би харанхуйгаас сүнс дуудаж чална.

Готспер: Би ч бас бусад хүний адил дуудаж чадна.Гол нь сүнс ирэх эсэхэд байна.

Шекспир, "Генрих IV"

Ишлэл:

Сонины эзэн Жулиан хүмүүсийг сургах дуртай байв. Тэрбээр элчин сайдад элчин сайдын

амьдрал ямар байх, банкирт банкны ажлын талаар бүхнийг, нэгэн нэртэй цагаачид цагаачдын асуудлыг, хөдөлмөрийн намын даргад хөдөлмөрийн талаархи бүх асуудал ба шийдлийг ярина. Түүнийг бүдүүлгээр зогсохгүй явуургүй хүн болохыг мэдсэнээс хойш зочдын нэг нь ч түүнийг хүндлэхээ больжээ.

Дон Пауэлл "Төрөх цаг"

Таны ихэмсэг зан бусад хүмүүсийн дургүйцлийг төрүүлж, таныг байх ёстой байранд нь тавих зорилгод өдөөнө. АНУ-ын мэдээллийн товчооны тэргүүн Чарльз Уикийн 1980 онд хийсэн хуурамч мэдэгдлүүд "Вашингтон пост" сонины тэргүүн нүүрэнд гардаг байлаа. Харин түүнийг Японд айлчлах үедээ хуягласан машинаар угтуулж цагдаагийн цуваагаар хамгаалуулах хүсэлт тавихад нь эелдгээр татгалзав. Тэр бүү хэл төрийн мөнгөөр тавьсан хоёр ч ширхэг хувийн утас ба гэрийн дохиоллынхоо төлбөрийг хийхийг шаарджээ. Уикийн хувьд төр түүнийг үнэлж чадсангүй гэсэн бодолтой үлдэв.

Та аль нэг салбарт чадварлаг гэдгээ харуулах нь бүх талаар чадварлаг гэсэн үг биш гэдгийг мартаж байна. Росс Перо ба Стив Форбс нар [тэд ямар нэг салбарт чадвараа баталсан уу?] өөрсдийгөө ерөнхийлөгчийн сонгуульд ялна гэдэгт хэзээ ч эргэлзэж байсангүй. Харин санал өгөгчид ингэж бодоогүй бололтой. Гүйцэтгэх захирлууд тэдний мэдлэг ба чадвар байгаа цагт аль ч хөдөлмөрт санаанд оромгүй амжилтанд хүрнэ гэж найдан хурал дээр өөрийн цэцэн мэргэнийг гайхуулах гэж хичээгээд дандаа л нурж унадаг.

Таны саруул ухаан амжилтанд хүрэх ганц эх сурвалж биш гэдгийг та мартдаг. Таны толгойд мэргэн санаа харвах юмуу эсвэл танд аз дайрч болно. Гэвч дахиад ингэхгүй. Зохиолч Жонатан Свифт "Тохиолдлын эрх мэдлийг зөвхөн азгүй хүмүүс хүлээн зөвшөөрдөг. Харин амжилт болоод алдар гавьяаг аз жаргалд хамааруулан бичдэг" гэсэн байдаг. Бүх юм өөрөөр эргэж болох байсан атал тохиолдлын эрхэнд автах нь дэндүү гашуун.

Хэрэв та ихэрхэг зангийн дор өөрийн арчаагүй байдлыг нууж байвал бүр сэжигтэй. Эрх мэдэлд тэмүүлэх тэмүүлэл ба үл найдах хандлага хоёр нь тэсрэх бодис гэсэн үг. Та шүүмжлэлээс айж эмээх бөгөөд айсандаа маш сайн хүмүүсийг ажлаас халж эхэлдэг. Иймэрхүү алхам таныг ашиггүй байрлалд аваачна. Та зөвлөгөө хайхын оронд дургүйцэж бухимддаг. Та эрх мэдлээ алдах вий гэж айхдаа ээлжийн амралт ч авдаггүй. Нөлөө бүхий хүмүүс ингэж л ярих ёстой гэж бодсоноор та өөртөө үйлчилж байгаа хүмүүстэйгээ бүдүүлэг ярьж харьцаж эхэлдэг.

Тансаглал

Та өөрийн зиндааг харуулангаа өөрөөр биеэ авч явдаг болж эхэлнэ. Таны эрх мэдлийн ихэнх нь таны байр суурины салшгүй хэсэг [улс төрийн хүчин, удирдлагын гишүүн, алдар нэр] болохоос биш та өөрөө биш юм гэдгийг мартаж эхэлдэг.

Өөрийн байр суурийг хэт үнэлснээр болхи хөдөлгөөнтэй болно. Хүмүүс танд харцаа тусгаж байгаа гэж бодсоноор хөдөлгөөн хүртэл жүжигчилсэн байдалтай. Та толинд харахгүйгээр хажуугаар нь өнгөрөхгүй. Таньж мэдэхгүй хүмүүстэй та өөрийн дураар харьцана. Тэд тантай ярилцахдаа дуртай байх болно гэсэн итгэлээс үүдэн танихгүй хүмүүс рүү баяртай чанга

хашгиран мэндлэх юмуу жолоочтойгоо чин сэтгэлээсээ ярилцана.

Өөртөө ийм их сэтгэл хангалуун байх нь бусдын инээдийг хүргэдэг. Домогт "Конде Наст" багийн бүх тамирчид зочид буудлын өрөөнд орохдоо доорх үгсийг товойлгон бичсэн мөнгөн жаазтай өргөмжлөлтэй тулгардаг байв. "Конде Наст бол 1998 оны бүх оддын баг" гэсэн байх ба ерөнхийлөгч, ерөнхий захирал Стив Флориогийн зураг байдаг. Энэ бол хүн бүхний цаг үргэлж хүсдэг зүйл мөн.

Ишлэл:

"Хэрэв бид энэ үгийг зөв ойлгож байгаа л бол Вашингтон улс төрч байгаагүй гэж Редклифф огцом хариуллаа. "Тэр улс төрөөс гадна байсан. Одоо ийм юм байж болохгүй. Хүмүүст "хааны" араншин таалагдахгүй байна". "Би юу ч ойлгосонгүй. Та яагаад үүнийг одоо хийж чадахгүй гэж?" хэмээн хатагтай Ли асуулаа. "Яагаад гэвэл би тэнэг харагдах болно" гэж Редклифф хариулав. Хатагтай Ли түүнийг Вашингтонтой нэг түвшинд тавьсанд тэр баярлаж байлаа. Хэдийгээр хатагтай Ли үүнийг яагаад одоо цагт хийж болохгүй тухай л асуух гэсэн боловч Редклиффийн нэр алдарт хичээх өчүүхэн сэтгэл ханасан байв".

Генри Адамс "Ардчилал"

Таны цэцэн мэргэнийг сорьж бас таны зөвлөгөөнийг тоохгүй байгаа хүн бүртэй та тэвчээргүй ханддаг. Нэгэн түүхт дурьдсанаар Вашингтоны нөлөө бүхий өмгөөлөгч Кларк Клиффордод өөр нэгэн өмгөөлөгч утасдаад татварыг бууруулахгүйн тулд юу хийж болох вэ гэж асуужээ. Харин Клиффорд хэдэн долоо хоногийн дараа "Юу ч хийх хэрэггүй" гэж хариулсан байдаг. Мөн 20 мянган долларын төлбөрийн нэхэмжлэлийг хамт илгээжээ. Түүнээс хийсэн алхамдаа тайлбар өгөхийг хүсэхэд Клиффорд мушийн инээгээд "Яагаад гэвэл би тэгж хэлсэн учраас төлбөр нэхсэн юм" гэснээ "мөн миний энэ хариулт бас 5 мянган долларын үнэтэй" гэжээ.

Алдаа гаргадаггүй хүн

Та дэргэд байгаа бусад бүх хүнээс илүү эрх мэдэлтэй. Таныг байнга магтаж, зөвлөгөө санал хүсэх болно. Та өөрийгөө буруу алхам хийхгүй хэмээн мэдэрч эхлэх бөгөөд энэ бол тийм биш.



Никсон Францын терийн тэргүүнийг харангуутаа пальтогоо тайлж чулуудсан байна.

Дик Моррис өөрийгөө бусдаас онцгой ялгарах чадвартай хүн гэж боддог байна. Гэвч тэр буруу боджээ. Харин биеэ үнэлэгч Шерри Роулэндс 200 мянган долларын төлбөртэйгөөр ерөнхийлөгчийн утсыг чагнахад нь түүнд туслаж

байсан тухайгаа мэдүүлсний дараа Моррисыг Клинтоны засагзахиргаанаас хөөсөн байдаг. **Реймонд Чандлер бичихдээ:** "Хүн өөрөө өөртөө ухахаас илүү том урхи занга байдаггүй" гэсэн байдаг.

Өөрийн эрх мэдлийн аюулгүй байдлыг мэдрэхдээ бусад хүмүүс түүнийг хэрхэн хүлээж авах нь ач холбогдолгүй гэж санах үе бий. Тиймээс та мөрдөгдөж байгаажурмаасхазайн, нэгдүгээрангиллаар нисэхтасалбарыгхүнээравхуулаарай. Та хурал дээр удирдлаганд байгаа хүмүүсээ шоолдог. Та цахим шуудан дээр ажиллаж буй залуусыг доромжилдог. Болгоомжтой бай. Таны хорхойд хоргүй гэж санасан хүн харин ч таны уналтын шалтгаан болох цаг хэзээ ирэхийг бүү мэд. Та энэ тухай огт мэдэхгүй өнгөрч ч мэднэ.

Хэрэв эрх мэдэлд ондоо хүн гарах аваас бүгд өөрчлөгддөг. Лорд Честерфилд хүүдээ "Чухал биш, анхаарал хандуулмааргүй тийм хүн гэж байхгүй. Ямар ч хүн тодорхой хугацаанд хэрэгтэй болдог. Харин чи тэдэнд зэвүүцэж байдгаа харуулах аваас тэд чамаас нүүр буруулна" гэж сургажээ.

xxx

Тэр бүү хэл та их хэмжээний эрх мэдэл олж авсан ба элдэв сөргөлдөөнийг даван гарч чадсан байлаа ч эрх мэдэлд урам хугарахтай нүүр тулгарах нь гарцаагүй.

Эрх мэдэлд урам хугарах

Та улам их эрх мэдэлтэй болсоор байна. Та бүр онцгой өндөрлөгт хүрлээ. Энэ бол шагналын араас шагнал хөвөрдөг ноёрхлын үе. Суут сэтгэгч Ларошфуко "Нэг хүндлэл нөгөөг төрүүлж байдаг" гэжээ. Та "Хэнд их байна түүнд улам их ирнэ" гэсэн алтан дүрмийн эзэн болжээ.

Гэтэл одоо таагүй зүйлс эхэллээ. Уг нь та эрх мэдэл таныг агуу болгож өөрийн агуу байдлыг мэдрэх боломж өгнө хэмээн боддог байтал үнэн хэрэгтээ та өөрөө огт өөрчлөгдсөнгүй. Таны ажлын байр өөр болсноос биш та өөрчлөгдөөгүй. Та шаргуу тэмүүлж байсан зүйлээ авсан атал одоо уналтын үе эхэлж байна.

Бүрэн давамгайлал гэж хэзээ ч эхэллээ. Уг нь та хаа нэгтээ хүрэх үед дутагдлууд алга болж, танайх үнэнч шударга, хөдөлмөрч, гайхалтай хүмүүсээр дүүрнэ гэж итгэдэг байв. Харин одоо эрх ямба нь дээд хүрээлэлд орох зам гаргаж өгдөг болохыг дэндүү сайн ойлголоо.

Хэдийгээр уналтын цаг үед та тодорхой эрх мэдэл эзэмшиж, тэр бүү хэл түүний төлөө тэмцэж байгаа ч гэсэн, эцсийн эцэст таны эрх мэдэл төгсч байгааг хүлээхээс аргагүй болно.

Цаг нь ирэхэд таны эрх мэдлийг булаан авах гэж байгаа тэр хүчинтэй тулалдах хэрэгтэй юу үгүй юу гэдгээ шийдэхээс аргагүй байдалд орно. Эсвэл цаг үе ба өөрчлөлттэй дуугүй эвлэрч болно. Магадгүй хүмүүст үзүүлэн болгох зорилготой арга хэмжээнүүд, үүнд хувийн жолооч, бие хамгаалагч, сайхан тохижуулсан өрөө, 20 минут тутамд хөврөх зочид, таны араас байнга анхаарал тавихбайдаггүй болохыг та харамсан ойлгож хүний зан араншин ба авьяас чадварын дутагдлууд алга болж, танайх үнэнч шударга, хөдөлмөрч, гайхалтай хүмүүсээр дүүрнэ гэж итгэдэг байв. Харин одоо эрх ямба нь дээд хүрээлэлд орох зам гаргаж өгдөг болохыг дэндүү сайн ойлголоо.

Хэдийгээр уналтын цаг үед та тодорхой эрх мэдэл эзэмшиж, тэр бүү хэл түүний төлөө тэмцэж байгаа ч гэсэн, эцсийн эцэст таны эрх мэдэл төгсч байгааг хүлээхээс аргагүй болно.

Ишлэл:

"Аз жаргалын тухай ойлголт байнга өөрчлөгддөг гэж Чарльз боддог байлаа. Чи ямар нэг юмыг авна. Гэтэл түүнээс илүү хэрэгтэй болно. Том өрөө, том хөлөгонгоц гээд л. Ноён Форбуш манайхаар яагаад ордоггүй юм бэ гэж асуух үед түүнд хичнээн тааламжтай байсныг Чарльз одоо хүртэл санасаар байна. Энэ нь тэр сайн юм хийснийг гэрчилнэ. Учир нь тэр нэг бүлгийн доторхи жижиг бүлгийн нэгээхэн хэсэг юм. Ноён Форбуш ноён Свиссийн адил тун уйтгартай хүн байх юм гэж түүний толгойд хэзээ ч орж байсангүй"

Ж.П.Марквенд "Эргэлт буцалтгүй газар"

Цаг нь ирэхэд таны эрх мэдлийг булаан авах гэж байгаа тэр хүчинтэй тулалдах хэрэгтэй юу үгүй юу гэдгээ шийдэхээс аргагүй байдалд орно. Эсвэл цаг үе ба өөрчлөлттэй дуугүй эвлэрч

болно. Магадгүй хүмүүст үзүүлэн болгох зорилготой арга хэмжээнүүд, үүнд хувийн жолооч, бие хамгаалагч, сайхан тохижуулсан өрөө, 20 минут тутамд хөврөх зочид, таны араас байнга анхаарал тавихбагийн тусламжтайгаар эрх мэдэлтэй байгаа мэт сэтгэгдлийг хадгалсаар байхыг хүсч мэднэ.

Та одоо өөрөө утасдаж, харин тэд яаралтай утсаа авдагаа больж эхлэнэ. Танд урьд нь тавьж, та байх л ёстой зүйл мэт бодож байсан анхаарал халамжийн жижиг сажиг тэмдгүүд үзэгдэхээ больжээ.

Эсвэл та хүссэн эрх мэдэлдээ хүрч чадаагүй гэдгээ мэдээд шаналж эхэлнэ. Таны мөрөөдөл таны төлөвлөгөөнүүд. Гэсэн хэдий ч та түүнд хүрдэггүй. Хамгийн гомдолтой нь бусад хүмүүс |хөдөлмөрч юмуу сэтгэлгээ сайтай биш| танаас өндөрт гарч эхлэхийг харах болно.

Sic transit Gloria Mundi - Хорвоогийн алдар ингээд л дууслаа

Энн эрх мэдлээ хэрхэн ашигласан нь

Энн нэр хүндтэй нягтлан бодох бүртгэлийн компанид бага тушаалын нягтлан бодохын ажилд оржээ. Гэхдээ тэр энэ тушаал дээр удаан байхгүй гэж өөртөө тангарагласан юм.

Заль хэрэглэн байж дарга Стефений өрөөний дэргэд өрөөтэй болов. Энн долоо хоногийн турш боссынхоо бүх дадал зуршлыг ажиглаж аваад өөрийн ажлын өдрийн хуваарийг зохиосон байна. Тэр боссоосоо таван минутын өмнө ирж, бас таван минутын дараа ажлаасаа гарахаар зохиов. Стефен шиг "Суиз Дели" ресторанаас хоол авах болсон тул даргатайгаа тэнд байнга тааралдана.

Нэгэн удаа зоориор ороод гарахдаа сандал олоод түүнийгээ оффистоо аваачиж тавьжээ. Хараад байхад одоо түүний өрөөнд нэг биш харин ямар ч зочин орж ирээд суух боломжтой хоёр дахь сандал бий болов. Өөрт нь гар утас болоод компьютерийн тусгай программ хэрэгтэй гэж Стефенийг итгүүлж чадлаа. Мэдээж тэр аль алианаас нь ашиг гаргаж чадна. |Яагаад түүнд байгууллагаас гар утас өгч байгаа юм бэ гэж бусад албан хаагчид асууна. Яагаад гэвэл тэр өөрөө гуйсан юм|.

Цаг хугацаа өнгөрөхөд Энн Стефенд хэрэгцээтэй хүн болж эхэлжээ. Сайн дураар судалгаа явуулж, басхэлтэст нь гарч буй шинэ бүхнийг богинохон буулгасан илтгэх хуудас бичих болсон. Боссын уулзах гэж байгаа хүмүүсийн намтарын тухай богинохон мэдээлэл бэлтгэх болов. |Үнэндээ үүнийг нарийн бичиг хийдэг байлаа| Даргадаа хотын захиргааны гишүүдэд зул сарын баяраар бэлэг бэлдэхэд тусалж ажиллах болжээ. Энн нь маш их ажиллаж байсан ч хэзээ ч уур цухалтай харагддаггүй байлаа. Ямар ч хүсэлт тавьсан "Асуудал байхгүй, мэдээж" гэж хариулдаг нь албан газрын наргиан болжхүртэл хувирчээ.


Хэдийгээр Стефен хангалттай зожиг нэгэн байсан ч |Үүнээс болоод их зантайд тооцогддог| Харин Эннтэй бол баяр хөөртэй харьцаж, зөвлөгөө заавар өгдөг байлаа. Энн нь түүнд жижиг сажиг бэлэг өгөх замаар анхаарлыг нь үнэлж байгаагаа харуулахыг хичээнэ. Төрсөн өдрөөр нь дуртай тамхинаас нэг боодлыг нь авч өгөх юмуу хоёр дахь хүүгийнх нь төрсөн өдөрт бэлэг өгдөг байв.

Үүний хажуугаар Энн туслахуудад цаг гаргана. Албаныхантайгаа өдөр бүр цаг гарган уулзаж, кофе уунгаа чалчиж суудаг байв. Стефентэй нягт хамт ажилладаг учир түүнээс авсан хэрэгтэй мэдээллийг цаадулдаа өгөх боломжтой. Ажлынхан нь түүнд өөрсдийн мэдээллийг ярьж, түүнийг нь Энн боссдоо дамжуулна.

Өөрийнх нь албан тушаал ахихыг шийдэх, тэгээд ч энэ компанийн жинхэнэ од болсон Стефентэй хамт ажиллахдаа Энн нь баяртай байв. Түүний зөвлөгөөнүүд Энний ажлын үр дүнг илүү сайжруулна. Удалгүй хүмүүс Эннийг боссын туслах мэтээр үзэх болжээ. Тэгээд Стефен шинэ албанд дэвшихэд Энн нь түүний оронд дарга болсон байна.



МӨНГӨ



"Ноён Вильям баян танилуудынхаа хэн нэгэнд зочлохын тулд 60 мл газрыг туулж чадна. Тээврийн хөлсөнд өндөр үнэ төлөх чадвартай. Эрхэмсэг хатагтай арван хуруундаа бөгж зүүсэн гараа өвдөг дээрээ тавьж сандлаа хойш налан суугаад бодол болох бөгөөд тэрбээр санаа зовоосон зүйлээ ийнхүү эрэгцүүлж бодол хөврүүлэн хором тутмыгтоолжявна. Тэдний хооронд алтан хана аль хэдийн босчээ. Хатагтай түүнийг төрүүлсэн. Тэд хоорондоо маргалдах болсон. Харин одоо хатагтайд санаа зовох зүйл тун бага үлдсэн учраас тайтгарчээ. Хатагтай бүхэнд хүндтэй, баян чинээлэг нэгэн учир бүгд түүнд агаархана".

Вульф "Хатагтай Дэлловэй".

Мөнгөөр аз жаргалыг авч болох уу?

Мөнгө хүнд асар боломжийг нээж өгдөг. Аз жаргалыг мөнгөөр худалдан авч болох уу? Үгүй. Гэхдээ хүнийг аз жаргалтай болгодог тэдгээр зүйлсийг худалдан авч болно. Эмнэлэг юмуу байрны төлбөртөө санаа үл зовох, үс засалт, гутал хувцас, машинаасаа ичихгүй байхад хүрнэ. Өндөр үнэтэй ресторанд хооллодог болж, десерт нэмж захиалж чаддаг болно. Таны ажил танд таалагдана. Таны уншдаг санхүүгийн өдөр тутмын хэвлэлд гардаг хүмүүсийн нэрсийг харж анзаардаг болно. Та өөртөө итгэлтэй, бас сэтгэл ханамжтай амьдарна.

Мэдээж мөнгө их болохын хэрээр таны алдар нэр дуурсч, хүрээллийн тань хүмүүс анхаарал хандуулж эхэлнэ. Их хөрөнгөтэй болмогц илүү сонирхолтой хүн болж, бусдын сонирхолыг эрхгүй татна. Та өөрийн гэсэн оффис нээж, хамгийн их ашигтайгаар ашиглахыг хүснэ. Гэвч та ажлаасаа яг юуг хүсээд байна вэ? Үүнийг ойлгохын тулд доорх сонжоонд хариулаарай. Хариугаа унших үедээ таны хүсэл тэмүүллийн тухай дэлгэн бичсэн номны тэдгээр бүлэг хэсгүүдийг онцгой анхааран судлаарай.

Сонжоо

Танд мөнгө юуны тулд хэрэгтэй вэ?

Одоогийн нөхцөл байдлаа хүсч байгаа нөхцөл байдалтайгаа, хүсэл мөрөөдөлтэйгөө харьцуул. Жишээ нь танд одоо үрэхэд яг бэлэн таван сая байна гэж бод. Та юунаас эхлэх вэ?

1. Байрандаа бүрэн засвар хийж засвар дуусмагц найр зохионо.
2. Зарцтай болж, өглөө орондоо цай ба сонин зөөлгөнө.
3. XIX зууны хуучин цагны цуглуулга юмуу зургийн цуглуулгадаа зориулж урлагийн ховор бүтээл худалдан авна.
4. Мөнгөө шууд банкинд хийж, хэсэг хугацааны дараа тийш залган дансанд байгаа сая саяын тухай хариу өгөхөд нь сэтгэл тавирч сайхан болно.
5. Мөнгөө хэд хэдэн улс төрчдөд хувааж өгөх ба тэдний хэн нэг нь хожим ач санаж засгийн газарт чухал албан тушаал өгнө гэж найдна.
6. Мөнгөө музейн ховор үзмэр засахад хандивлах ба гол нь таны нэр бүх сонин хэвлэлээр дуурсана гэсэн болзол тавина.

Хэрэв та 1-р хариултыг сонгосон бол мөнгө хөрөнгө чинээтэй хүн бөгөөд өндөр албан тушаалтан болохоо бүхэнд харуулахад хэрэгтэй юм байна. Та Мөнгөтэй хүн бүлгийг уншаарай.

Хэрэв та 2-р хариултыг сонгосон бол мөнгө өөрийн тохь тухаа хангах, мөнгөний тусламжтай

авч болох бүх таашаалыг авахад хэрэгтэй. Та Мөнгө ба таашаал бүлгийгуншаарай.

Хэрэв та 3-р асуултыг сонгосон бол мөнгө таны хувьд сонирхож байгаа эд зүйлээ өөрийн болгох хүсэл тэмүүлэлдээ хүрэхэд хэрэгтэй. Тэгэхээр та Мөнгө ба шунал сэдвийг унш.

Хэрэв та 4-р хариултыг сонгосон бол та мөнгөний нөөц багатайгаас болж байнга зовдог нэгэн бөгөөд мөнгийг хурааж хадгалах дуртай. Мөнгө ба зорь бүлгийг уншаарай.

Хэрэв та 5-р хариултыг сонгосон бол мөнгө таны хувьд алдар нэр олоход хэрэгтэй зүйл. Тиймээс Мөнгөөр алдар нэр, эрх мэдэл худалдан авах бүлгийг уншина.

xxx

Хэрэв олонхи хүмүүсийн адилаар баяжих хүсэл тань зөвхөн нэг хариултын хүрээнд харьяалагдахгүй байх аваас танд мөнгө хэд хэдэн давхар шалтгаанаар хэрэгтэй бөгөөд та тэр бүхэнд зэрэг хүрэхийг хүсдэг ажээ.



моникаЛввински ерөнхийлөгчКлинтонтой нэр холбогдоналдартай болж аваад өөрийн биэнэсийг нээв

Ишлэл:

"Мөнгө бол зөвхөн мөнгө гэх юмуу мөнгө бол зүгээр нэг мөнгө биш гэхийн аль нэгээр бодсоноос хамаарч хүн бүрийн санаа бодол бүрэн өөрчлөгдөнө. Гэвч эрт орой хэзээ нэгэн цагт бүх хүн нэг л санаатай болох бөгөөд энэ нь мөнгө бол зөвхөн мөнгө биш гэх бодол юм".

Стайн. "Бүхний намтар"

Долоо дуугаар бүлэг

Мөнгөтэй хүн

Би гэртээ бүрэн засвар хийгээд дараа нь бүх хүнийг гэртээ урьж засвар хийсэн гэрээ үзүүлэх болно"

Хэрэв танд мөнгө нь мөнгөтэй баян гэдгээ бусдад гайхуулахын тулд л хэрэгтэй бол та бусдын анхаарлыг татахын тулд тохирох зүйлийг сонгох ёстой. Мөн хүсч буй сэтгэгдэлээ төрүүлэхийн тулд өөрийн үйлдлийг сайтар чиглүүлэх учиртай. Үүнийг бид дохио өгөх хэмээн нэрлэх болно. Та амжилт ба мэдлэгээрээ гайхуулах, албан тушаал болон нийгэмд эзэлж байгаа байр сууриа харуулахын тулд эд хөрөнгөө бусдад үзүүлнэ. Бүх хүн ямар тушаалтайгаа тодотгохын тулд дохио өгдөг. Харин та баянаа гайхуулахын тулд дохио өгөх болно.

Эд зүйл бүрт өөрийн гэсэн өвөрмөц дохио байдаг. Гэхдээ дохио өөрөө тухайн эд зүйлийн үнэ өртөгөөс хамааралтай гэж битгий бодоорой. Энэ тохиолдолд моод том үүрэг гүйцэтгэнэ. Тухайн эд зүйлийн агуулга, түүний хэрэгцээ шаардлага ба зохис зэрэг нь бидний дохио хэмээн нэрлээд байгаа тэр зүйлийг бүрдүүлдэг. Дохионы систем бол тун хэцүү бүрдэл юм. Түүнийг зохион бүрдүүлэх ба бүрэн хэмжээгээр нь ажиллуулахын тулд чамгүй хугацаа хэрэгтэй.

Соёл нь эзэмшил ба эд хөрөнгө, мөн таны өсөлтийн үзүүлэлт юу болох дээр үндэслэдэг. Дохио нь таны байрлалаа өөрчилснийг бүхэнд харуулна. Дохио тогтворгүй. Харин шашин ба үндэс язгуур зэрэг нь солигдохгүй тогтмол байдаг. Гэтэл соёл нь таны нийгэмд эзэлж байгаа байр суурийг харуулах материалжсан дохиог өөртөө татаж байдаг.

Амжилттай дохио өгөх долоон дүрэм

Дохиог чадварлаг, үр дүнтэй ашиглахын тулд дараах зарчмуудыг мөрдөх ёстой.

Нэгдүгээр зарчим: Дохио харьцангуй.

Хоёрдугаар зарчим: Үзэгдэж харагдах ба онцгойрч харагдах тэр зүйл л жинхэнэ дохио юм.

Гуравдугаар зарчим: Та юу худалдан авч байгаагаараа тодорхойлогдоно.

Дөрөвдүгээр зарчим: Нийгэмд эзлэх байр сууриа өөрчлөхийн тулд дохиог удирд.

Тавдугаар зарчим: Та дохио өгөхгүй байж чадахгүй.

Зургадугаар зарчим: Та хэрхэн дохио өгөхдөө эргэлзэж байвал урлагаас тусламж эрээрэй.

Долдугаар зарчим: Сонголт маш чухал. Тиймээс:

1. Зөвхөн хамгийн шилдгийг сонго.

2. Үе дамжсан зүйл бодож олох.
3. Зөвхөн нөлөөлөх зүйлийг сонгох.
4. Захиалга хийх.
5. Моод хөөх.
6. Өөрийн цаг ба мөнгөнд гамтай хандах.
7. Соронзон долгионы хүчийг санаж өөрийн хүчлэлийг үзүүлэхгүй байх.
8. Нуух ба залилахад суралцах.

Нэгдүгээр зарчим

Дохио харьцангуй. Та зөвхөн хэрэгтэй хүмүүстэй л харилцах хэрэгтэй

Зөвхөн таны хамрагдаж буй нийгмийн тэр анги давхаргын хүмүүс ба эсвэл хамтран ажиллагсадын санаа бодол л чухал гэдгийг санаарай. Анги давхарга бүрт нэгэн хэвийн хууль үйлчилдэг. Тухайн анги давхарт тохирох хөрөнгө зоорь ба дадал зуршил хуримтлуулаад, одоо тэдний анхаарлыг татах хүн болсон гэдгээ мэдүүлэх явдал. Тийм ч учраас хөрш айлуудын амьдралын түвшний ялгаа нь өөр өөр анги давхаргын ялгаанаас хавьгүй илүү утга агуулгатай. Анги давхаргууд нийгмийн шатан дээр бие биенээсээ алс хол байрлана.

Дүрэм

Харьцуулалт нь уралдааныг бий болгоно.

Таны хүсэл тойрон хүрээлж буй хүмүүс дээр сүүдрээ хаядаг.

Харьцангуйн зарчим нь яагаад хоёр сая долларын байр худалдан авсан өмгөөлөгч өөрийгөө ядуу гэдэгт итгэдэг болохыг тайлбарлаж өгнө. Яагаад гэвэл тэрбээр өөрийгөө 3 сая долларын байртай ба хотын гадна бас өөр нэг байртай өмгөөлөгчтэй харьцуулдаг. Яагаад мэдээлэл сайтай саятан гэнэт бусдад атаархдаг болохыг харьцангуйн зарчим бас тайлж өгнө. Зарим нэг хүн өөрийгөө 60 настай гүйцэтгэх захиралтай харьцуулдаг. Тэр хүн компанийн албан тушаалын шатаар тасралтгүй мацсан бөгөөд цагтаа Блумбергийн жагсаалтын өмнө 15 цаг ширтэн сууж ажилладаг банкчин байсан. Гэтэл дөнгөж сая сургууль төгссөн 25 настай залуу таван сарын өмнө байгуулсан компани зарж мульти саятан болох юмуу жирийн программчин залуу цэвэр тохиолдлоор "Майкрософт" компанийн "Ангилал 2000" хэмээх баян хүмүүсийн жагсаалтад орж орхих юм бол бид өөрсдийгөө мөн тэдэнтэй л харьцуулж эхэлнэ. Бид өөрсдөөсөө "Яагаад би биш гэж? Тэр надаас илүү ухаантай биш шүү дээ?" гэж асууж эхэлдэг.

Хүн шинэ хамт олон дотор орох үед бүр ихийг хүсдэгт гайхах зүйлгүй. Одоо та бусад хүмүүст юу байгааг харах учир мөн тийм болохыг хүснэ. Шинэ нээлтийн уур амьсгал таны архаг зовнилд буруутан болно. Нэгэн цагт таны хүсэл мөрөөдөл хангагдлаа ч гэсэн тэр нь цаашаа

дахиад л шинэ хүсэл мөрөөдөл ба зорилгыг нээж өгдөг. Яагаад гэвэл хүн бусад хүмүүс юу эзэмшиж, тэдний өмнө ямар боломж нээгдэж байгааг үргэлж харж байдаг. Карл Маркс энэ тухай бичихдээ "Хүний хүсэл мөрөөдөл ба хэрэгцээнд оригиналь гэж бий. Энэ нь амьдралын эх үлгэр загвар юм. Бид хүсэл мөрөөдлөө харьцуулж дүгнэдэг. Бид түүнийг таашаалаа хангах юмуу шагнал болон ирэх эд зүйлстэй харьцуулдаггүй. Хэрэв хүсэл мөрөөдөл нийгмийн гадна байх аваас харьцуулах боломжгүй гэжээ".

Аливаа дохио нь хүрээлэн байгаа зүйлстэй харьцуулагдсан үед өөрийн утга учиртай болно. "Конкорд" онгоцоор Европ руу нисэх нь санаанд багтамгүй үнэтэй. Хэрэв та энэ онгоцоор нисдэг бол асар өндөр орлоготойг тань хэлээд өгнө. Гэтэл тухайн онгоцны ажилтнуудын хувьд гайхуулаад байх юу ч үгүй. Ийм нислэг бол ердийн л нэг нислэг.

Зөвлөмж:

Амжилтанд хүрэхийн тулд өөрийн бизнес төлөвлөгөөг зохио. Иймэрхүү юм зохиогоорой. Үүнд: Хамгийн эхлээд Харвардын бизнес сургуульд нэг тогооноос будаа идэж байсан нөхрийг ажилдаа татан оруул. Тэгээд би компаниа нээнэ. Бид амжилтын оргилд хүрнэ. Тэр цагт шууд ажил хэрэгч холбоог тогтоож чадна. Энэ холбоо нь онолын мэдлэг ба хэлхээ холбоонд тул гуу рл асан түн ш л эл и й г шууд худалдаатай хослуулсан байна. Манай түншүүд үнэ цэнээ өсгөхийн тулд бидний таашаалд нийцүүлж эхэлнэ. Эсвэл та ийм төлөвлөгөө зохиож болно. Үүнд: компани асар том боломж олгох ба яг юу болохыг нь хэн ч мэдэх ёсгүй. Ийм арга бас маш үр дүнтэй байдаг.

Хоёрдугаар зарчим

Зөвхөн анзаарагдаж байгаа зүйл л дохио болж чадна

Хэрэв та өөрийнхөөрөө байхыг хүсвэл бусад хүмүүст өөрийгөө харуулах хэрэгтэй. Нэртэй загвар хөөцөлдөгч Виндзорын герцогийн жишээг дагаж болно. Тэрбээрхамгийн шилдэгзүйлсийгхудалдан авахдаа зөвхөн бусадхүнд харагдахуйц зүйлс, тухайлбал орон байр, хоол хүнс ба хувцас авдаг байлаа. Холливудын одод аливаа үдэшлэгт урилга хүлээн авах нь цөөн байдаг. |иймэрхүү илгээмжийг тэдний туслахуудад факсаар явуулдаг| Яагаад гэвэл хэн ч урилгыг зүгээр нэг тараадаггүй. Яагаад ийм уйтгартай байна вэ? Зочид тэднийг олж харахгүй.

Өөрөөр хэлбэл таны дохио анхаарлыг нь татах тийм хүмүүст л дохио өгөх хэрэгтэй. Тэр бүү хэл энэ нь та урд хормойгоо хойд хормойгоороо нөхөн амьдардаг байлаа ч, Гучигийн ямар нэг юм худалдаж авахдаа таны төлбөрийн картыг энд хүлээн авах эсэхэд санаа зовж байлаа ч хамаагүй. Хэрэв хувийн дасгалжуулагчтай байх нь танд дэндүү үнэтэй тусч байгаа бол долоо хоногт ганцхан удаа хөлсөлж болно. Гэхдээ ийм үйлчилгээ авдаг гэдгээ хүн болгонд яриххэрэгтэй. Гэртээ самрын нухаш идэж байж л та хамгийн үнэтэй ресторанд дарс уух 14 долларыг хэмнэнэ.

Гуравдугаар зарчим

Та юу худалдан авч байгаагаараа тодорхойлогдоно

Таны сонгож байгаа бүхэн таны тухай дохио өгнө. Таны идэж байгаа хүнс, эсвэл унтлагын хувцас хүртэл таны оюун ухаан, гарал сурвалж ба нарийн мэдрэмжийн тухай хорвоод мэдээлж байдаг. Вильям Жеймс тэмдэглэхдээ "Хүмүүс намайг юу гэж нэрлэдэг ба би өөрийгөө хэн гэж нэрлэхийн хооронд хязгаар татах нь тун хэцүү байдаг" гэжээ.

Хэрэв ямар нэгэн зүйл худалдан авах үед таны сонголт улиг болсон юмуу оригиналь биш санагдах юм бол та зүгээр л бусдыг дууриасан гэсэн үг. Таны сонголт тохиолдлын ба ойлгомжгүй санагдах нь та өөрийгөө удтал ятгасан тул энэ таашаал угаасаа л байсан мэт болжээ гэсэн үг. Та яагаад яг энэ зүйлийг хүсээд байгаагаа өөрөө мэдэж чадахгүй ба энэ нь таны өгөх дохио болно. Үнэн хэрэгтээ дохиог нийгмийгудирдах нарийн зэвсэг болгон төсөөлжбас болдог. Кларитасын маркетингийн бүлэг дохионы ангиллыг бодож олжээ. Тэд дохионы хэлбэрүүд ба дохиолохын төлөө биеэ хэрхэн авч явах тухай санааг боловсруулсан байна. Та доорх дүрслэлүүдийн аль нэгэнд өөрийгөө олж харна.

"Хүүхдийн үрэлгэн зан". Та Диснейлэнд үзэж хүүхдүүдээ зугаацуулах ба хувийн сургууль, хувийн хүмүүжүүлэгч зэрэгт мөнгөө үрдэг. Та томчуудад зориулсан тусгай радио сонсч, сахаргүй кока-кола ууж, агаарт гарч шорлог шарах дуртай ба "Вольво" машин унадаг.

"Мөнгө ба ухаан". Марк цуглуулж, шатар тоглож, сонгодог хөгжим сонсч, аялж зугаалах дуртай сонгодог хосууд.

"Анчид ба азгүйчүүд". Савалж нөөшилсэн хүнс идэх, хамрын тамхи татах, зүйр цэцэн үгсээр ярих дуртай хүмүүс.

"Үслэг эд ба авто машин". Үдшийн шоу үзэх, сайн чанарын талх идэх, БМВ машин унах, "Architectural Digest" унших, зөвхөн тодорхой тохиолдолд дарс авах, орон байраа эд зүйлсээр битүү чихэх.

Та ямар нэг юм сонгож худалдан авахдаа өөрийн хувь хүн гэдгээ илэрхийлсэн гэж боддог. Үнэн хэрэгтээ таны сонголт хязгаарлагдсан учир хязгаарлагдмал сонголт хийсэн ба сонголт тань жижиг байжээ. Та ногоон, эсвэл тод цэнхэр, эсвэл бор өнгийн алчуур худалдан аваад өөрийгөө чөлөөтэй сэтгэдэг хүн болохоо харуулсан гэж бодож байна уу? Гэтэл таны хөршүүд брэндийн алчуур авсан байх юм.



Мерлилин Монрогийн хүзүүний зүүлтийг 1999 онд 1 сая 150 мянган доллараар худалдаж авсан хүн хэн бэ ?

Хэрэв та ховор ба үнэтэй зүйл сонирхох аваас өөрийнхөө хувь хүн талуудыг тодотгож чадах юм. Билл Гейтс "Хаммер Кодекс" худалдан авахын тулд 3 сая доллар зарцуулжээ. Харин Леонардо Да Винчигийн өдрийн тэмдэглэлийг сонирхсоноор өөрийгөө Ренессансийг мэддэг, урлагийг агуу үнэлдэг ба инженерийн санааны мэдлэгтэн гэдгээ бүхэнд

зарласан ХЭрэг. Мерилин Монрогийн хүзүүний

зүүлтийг 1999 онд 1 сая 150 мянган доллараар худалдаж авсан хүн хэн бэ?

Дөрөвдүгээр зарчим

Нийгмийн байр сууриа өөрчлөхийн тулд дохиог удирдах

Хэрэв та юу худалдан авч байгаагаараа илэрхийлэгддэг юм бол хүрээлэн буй хүмүүсийн нүдэнд өөрийн тухай төсөөллийг өөрчлөх боломжтой. Томоохон хувийн өмчтөнүүдэд үл хөрөнгөө эргэлдүүлэх эрх олго. Та дохио өгөх аргаа сонгох ёстой. Хөгжимчин Дэвид Жеффен алдарт Уорнер эдлэн газрыг худалдан авснаар Бруклины биш харин Холливудын оршин суугч болсон. Таны дохио ямар байх вэ? Өнгөрсөн зууны нэрд гараагүй романы анхны хэвлэгч нь болох уу эсвэл усан онгоц худалдан авч Карибын арлууд дээр амрах уу? Магадгүй та сагсан бөмбөгийн баг худалдан авч болох юм.

Таны дохио ямар байх загвар гаргаарай. Үүний тулд хамгийн ойр дотны хүмүүсээ ашиглана. Тэд таны дохионд өнгө нэмж өгөх юм. Гэхдээ үүний тулд аль нэг талаараа танаас хоцорч яваа тийм хүнийг сонгон авах хэрэгтэй. Түүний хувийн дохио таных шиг хурц биш байх аваас та хожно. Баян тарган айлын хүүхдүүд үе тэнгийнхнээсээ хэрхэн ялгардаг болохыг санацгаая. Тэд бусад хүмүүс хүрэхийн аргагүй газарт амьдарч, урлаг, баримал, уран зураг,

дархан хийх юмуу хоол унд гайхалтай сайхан бэлддэг. Өөрөөр хэлбэл мэдлэг боловсрол, биеэ харамгүй зарцуулах чанар шаарддаг тэр бүхнээр хичээллэдэг байна. Ямар ч тохиолдолд өмч хөрөнгө нь таны өөрийн ямар хувь хүн болохыг тодруулах боломж олгоно. Жерсигийн бүсгүйчүүд сувдаа гайхуулдагийн адил Гринвич, Гротон, Иеллийн банди нар өөрийн гараар бэлдсэн махан хоол юмуу хувийн галт зэвсэгээ бардамнан харуулдаг. Хэрэв та бусдад анзаарагдахыг хүсч байвал таны бүх дохио үр дүнтэй байхад анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл тааварлаж болохоор байх. Дохиогоор дамжуулан хүлээн зөвшөөрөгдөх зам амаргүй. Тиймээс таны дохио ойлгомжтой, хүлээн авахуйц, урьдчилан таахуйц байх учиртай. Хүмүүсийн бараг байнга хэрэглэдэг, өөрийн мэдэлгүй хэрэглэдэг болсон, байх л ёстой зүйл мэт санагддагболсон тэдгээр аргуудыг сонгох нь илүү дээр. Жишээ нь та Массачусетсаас Колорадод ирсэн баян женгельмен гэж бодъё. Та энд ирээд улаанаар будсан үстэйгээ алхлах ба энэ бол таны өөрийн бүтээл учир бусдын анхаарлыг татна, энэ бол таны дохио гэж бодно. Гэтэл та энэхүү элэгдэж хуучирсан арга болоод гаж үс засалтаараа бүх хотынхны шоглоом болохоос цаашгүй гэдгийг мэдэхгүй байна.



Барбара Стрейзанд сэтгүүлийн нүүрэнд зургаа тавих зөвшөөрөл өгөөд элдэн газраа санаанд багтаагүй үнээр заржээ

Хэрэв та шинэ газарт ирэх юм бол бүхнийг шинээр төсөөлөх, өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дохиогоо солих ёстой гэдгийг шууд л мэдэрнэ. Жишээ нь та шинэ ажилд оржээ. Эхэндээ таныг ямар хүмүүс хүрээлж байгаа, үдийн хоолонд юу иддэг, эрчүүд нь өмдний татуурга хэрэглэж, зангиа зүүдэг эсэх нь сонирхолтой. Хэсэг хугацааны дараа, магадгүй долоо хоногийн дараа та шал ондоо зүйлийг сонирхож эхэлнэ. Та гэнэт бүрх малгай, пальто, франц ханцуйны тээглүүр гээд шинэ зүйлсийг худалдан авах юмуу харах тэвчишгүй хүсэлд автана. Та яг тэдэн шиг зүйлстэй болохыг хүснэ. Таны шинэ ажил теннисийн цохиураа хүртэл солихыг шаардана. Шинэ ажилтнууд бүгд л хуучин дискүүдээ нууж шинийг сонсдог шүү дээ. Иймэрхүү зүйлстэй болсноор та тодорхой хүрээлэлд орсон гэдгээ харуулна.

Хуучин дадал зуршил, хуучин эд юмс гээд хуучин байранд таны дохио болж байсан бүхэн аажмаар үхэж мөхдөг. Гэвч та тэднээс салах нь тун бэрх байдаг бөгөөд ялангуяа өөрчилж байгаа зүйлсээс салах нь нэн хэцүү. Өөрийгөө өөрчлөхөд хичнээн хэцүү байдгийн гол

шалтгаан энэ. Америкийн хөгжмийн од Мадонна Тиффанигийн шаазан эдлэлээ хаашаа ч нүүсэн чирдэг бөгөөд тэр бүү хэл нөхөрт гарахдаа ч авч очсон байдаг. Та эндхийн ёс заншлыг зөвшөөрөхгүй гэдгээ гадаад байдлаараа харуулах, өөрийн дохиогоор энд хүлээн зөвшөөрөгдсөн дохионуудын эсрэг бослого гаргах зэрэг нь ерөөс боломжгүй. Зузаан ултай хар гутал, уранхай цамц өмсч, үсээ будаж боосон, мөн хамраа цоолж ээмэг зүүсэн ба өөрөөр хэлбэл бүхий л гадаад байдлаараа эсэргүүцэл илэрхийлж буй бүсгүйн дэргэд бас л нэг иймэрхүү боловч бага зэргийн өөр хувцас өмссөн найз залуу нь алхаж явах юм бол тэднийг хараад инээхгүй байхын аргагүй.

Дөнгөж сая баяжсан бүх хүмүүс эргэн тойронд байгаа хүмүүст баян болсон гэдгээ онцлон үзүүлэхийг байдгаараа хичээдэг. Үүний шалтгаан нь тэд баячуудын ангилалд багтсан гэдгээ үзүүлэх хүсэл. Энэ нь тэдний гол алдаа болдог. Ийм ил тод үзүүлбэр хийснээр харин ч хүрээлэн байгаа хүмүүс тэднийг дөнгөж сая гарч ирсэн цээж баячууд гэсэн нүдээр харахад хүргэдэг. Зарим хүмүүс шинэ хүрээлэлд нэр хүнд олох, эсвэл нийгмийн шинэ зиндаандаа тохирохын тулд хотын гадна шинэ баян байшин худалдан авах гэж байснаа болиод номын сан их сургууль юмуу эмнэлэгт чамгүй хэмжээний мөнгө хандив болгодог. [Ийм буян хандив нь өөрөө үр нөлөөтэй байгаад зогсохгүй танд өөрт тань жин нэмж өгнө].

Дүрэм

Та шинэ зиндаанд гарах үед дохио онцгой чухал.

Бид бүгд л дохиог хэрхэн зөв удирдах мэдлэггүй төрдөг. Гэхдээ энэ цөхрөх шалтгаан биш. Дохиог чамбай ашиглаж сурах нь хэцүү хэдий ч боломжтой зүйл. Маш олон хүмүүс, тэр бүү хэл хөдөө амьдардаг хүмүүс ч өөрийн дохио ба имижийг чадварлаг удирдах арга барил эзэмшсэн байдгийг тоо томшгүй олон жишээ харуулна. Та ч бас чадна.

Эндхийнхэн гольф хэрхэн тоглодог, ямар дарс уудаг, ямар тамхи татдаг, цэцэрлэгхэрхэн арчилдаг бүхнийг мэдэж аваарай. Шинжээчдийн зөвлөгөөг ашигла. Нью-Жерси хотын Марта Стюарт хүмүүсийг амьдралын хэв маяг, хэмнэл, биеэ авч явах байдлаа хэрхэн өөрчлөхийг зааж сургаснаар өөрөө дэвшсэн байдаг. Эсвэл жинхэнэ америк сурвалжтан шиг хувцасладаг Ральф Лоренийг харцгаая. [түүний жинхэнэ нэр Ральф Лившиц бөгөөд Бронкст төрсөн юм].

Номын лангуу тавиур бүхэн иймэрхүү гарын авлагаар дүүрэн. "OaPu 01aгу oT 1Иe Aтeпcaп Oгeапп", "У/a11 31гee1 ^oигпаГ зэрэг сонин сэтгүүлүүд мөнгөө хэрхэн үрэхийг уншигчиддаа зааж байдаг. Хотын хамгийн шилдэг дүүрэг, хамгийн сүүлийн үеийн моодны эд зүйлсийн тухай өгүүлж, албан тушаалын урт жагсаалтыг нийтэлдэг. Хэдийгээр "Ъem Yогк OЪзeп/ег" сэтгүүлийн хэвлэгдэх тоо цөөн боловч дохионы сонголтын талаар шилдэг зөвлөгч ба санхүүгийн ертөнцийн шилдэг хөтөч байжчаддаг. Түүнээс гадна эрх мэдэл, алдар нэр ба сексийн талаарх шилдэг зөвлөгч гэж болно. Ажил хэргийн ертөнцийн сэтгүүлүүд танд мөнгөө хэрхэн зарцуулах талаар сургахаас татгалзахгүй. "Pог1иpe" сэтгүүлийн нийтлэлд бичихдээ "Бид ажлын дараах амьдралд итгэдэг. Ажлын дараа зочлох, өөр газарт очих, ер бусын эд зүйлсээс таашаал авах боломж олгох ажилтай байгаадаа бид баярладаг" гэжээ. "AгcЫ1eс*ига1 0|де5Г, "Томп апс1 Соип1гу"-гаас эхлээд "Нью-Йорк" хүртэлх сэтгүүлүүд танд зөвлөгөө өгөх, танд хэрэг болох энэ чиглэлийн номнуудын рекламьг үзүүлэх зэргээр тусалдаг. Том Вульф, Жудит Кранц, Терри Макмиллиан, Доминик Дьюинн зэрэг олон

зохиолчид өөрийн номондоо танд маш чухал мэдээллийг өгч байдаг.

Тавдугаар зарчим

Та дохио өгөхгүй байж чадахгүй

Та огт дохио өгөхгүй байх, бусдаас огт ялгарахгүй байх шийдвэрт хүрч болно. Та өөрийгөө хангалттай сайхнаар харуулахын тулд хүч чармайлт тавихыг хүсэхгүй байж болно. Эсвэл алдаа гаргахаас айж мэдэх юм. Магадгүй зүгээр л ямар нэг юманд мөнгө үрэх дургүй ч байж мэднэ. Ямар ч байлаа гэсэн та бүх дохионоос бүрэн төгс салж чадахгүй. Таны ашиглаж байгаа эд юмс бүхэн таны тухай ямар нэг зүйлийг хэлж байдаг. Харахад үл ялиг мэт санагдах зүйл болох утасны дугаар хүртэл өөрийн утга агуулгатай.

Антиматериализм санаанд оромгүй харьцаанд хүргэх нь бий. Хүмүүс гашуудлыг хүртэл дөнгөж сая хийсэн юмуу энэ тохиолдолд зориулж тусгайлан хийсэн лааг гайхуулах тохиолдол гэж авч үзэх нь бий. Бизнес эрхлэгчид жижигхэн шар айрагны үйлдвэр, моодны хувцасны дэлгүүр нээж, түүнийгээ худалдан авагчдад үзүүлэн бараагаа борлуулдаг. Энэ бүхэн амьдралд антиматериалистаар хандахын тод жишээ юм. Гэтэл өөрийнхөөрөө зүтгэдэг антиматериалистууд хүртэл дохиолол хэрэглэхээс аргагүй. Тэд үүгээр өөрийнхөө хувь хүн болохыг харуулж, хүлээн авсан юмуу үгүйсгэсэн үнэт зүйлсийнхээ тусламжтайгаар өөрийгөө илэрхийлэх боломжтой болдог.

Та Санаанд оромгүйн зарчмыг үе үе хэрэглэж болох ба ингэснээр хүмүүс танд анхаарал хандуулахад хүрнэ. Та моодонд орж буй үнэтэй хувцсаар хувцаслах боломжтой байсанч хуучин хувцас өмсч, үүгээрээ хувцасны тусламжтай өөрийгөө илэрхийлэх шаардлагагүй гэдгийг харуулна. Хувцас таны хувьд дохио юмуу тэмдэг биш. Үүнийг баталж, эргэн тойрны хүмүүсийг төөрөгдүүлэхийн тулд та Гучигийн хуучин гандуу жинсийг 3800 доллараар авч өмсөөрэй.

Зургадугаар зарчим

Хэрхэн зарлахаа мэдэхгүй бол урлагт ханд

Та өөрийгөө мэдүүлэхийг хүсэх мөртлөө яаж зарлахаа мэдэхгүй байна уу? Өмч хөрөнгө эд зүйлс нь нэг арга мөн боловч олон алдаатай алхам хийж мэдэх зам юм. Олон шинэ баячууд мөнгийг хааш чиглүүлэх ба хэрхэн зөв зарцуулах талаар мэдэхгүйн улмаас муу нэртэй болжээ. Тэд буруу дохио өгч, буруу хөдөлгөөн хийж, өөрийгөө буруугаар зарласан. Урлаг бол буянтай зүйл. Та цуглуулгадаа үнэтэй зураг худалдан авсан юмуу музейд өгөөмөр бэлэг барьсан байлаа гэхэд хэн ч таныг шүүмжлэхгүй. Наанадаж та гоо сайхныг үнэлдэг ба урлагт ойрхон хүн гэдгээ мэдүүлэх болно.

Урлагийн үнэт зүйлс маш тогтворгүй, баригдашгүй бөгөөд шүүмжлэгчдийн зүгээс хир халдаахгүйн тулд зөв шийдвэр гаргах нь онцгой хэцүү байдаг. Урлагийн салбарт хийх таны ажил маш хэцүү бөгөөд үнэлэмжгүй байж мэднэ. Ямар ч тохиолдолд урлагт хандах нь туйлын хурц дохио мөн тул бүгд таныг олж харна. Урлаг бол суутнуудын бүтээсэн зүйл. Энэ нь дахин давташгүй цорын ганц бөгөөд эрч хүчийн оргилолт юм. Харин та бол урлагийн

бүтээлийг худалдан авсан эзэн. Хэрэв энэ бүтээлийг урьд нь нэртэй хүн эзэмшиж байсан бол түүнийг авснаараа та олонд цуурайтна. Та үнэт үзвэрийг музейд шилжүүлж орхивол өөртөө нэр олж, бүхэнд хүлээн зөвшөөрөгдөнө. Энд залсан талархал өргөмжлөл музей үзэж сонирхогч бүх хүнд таны урлагийн үнэтэй бүтээлийг музейд хандивласан өгөөмөр бэлэглэгч болохыг хэлээд өгнө.

Урлаг бол өөрийнхөө тухай мэдүүлэх үнэ цэнэтэй, нэр хүндтэй, эвтэйхэн арга юм. Та тодорхой өндөр түвшинд гарахын зэрэгцээ таны тухай хүмүүс заавал ярихад хүрнэ. [Таны хэрэглэж байгаа эд зүйлсэд ч энэ бүхэн хамаарна. Та үдэшлэгт "Роллс-ройс" хөлөглөн ирэх юмуу Пэтек Филиппийн цаг зүүж болно. Эсвэл бараг урлагийн бүтээл гэмээр нарны шил зүүж ч болох юм].

Хэрэв та урлагийн үнэт бүтээл худалдан авч чадахгүй бол арай хямд зүйлс тухайлбал орчин цагийн гэрэл зураг юмуу Африкийн уран баримал цуглуулж болно. Хэрэв та ингэх ч хөрөнгөгүй бол зүгээр урлагийн мэдлэгтэн гэдгээ яриад байгаарай.

Интернетийн www.1peg.com сайт юмуу "AgStone" сэтгүүлийг уншаарай

Зөвлөмж:

Хэнд ч хэзээ ч бэлэг нууцаар бүү өг

Долоодугаар зарчим

Сонголт

Асар их менге үрдэг түгээмэл алдааг бүү давтаарай. Заавал ингэх шаардлага үгүй. Хүрээлэн буй хүмүүст эд баялгаа гайхуулахын тулд зөвшөөрөгдсөн хил хязгаарыг заавал гатлах шаардлагагүй. Таны дохионууд нарийн чиглэгдсэн ба оюунлаг байх ёстой. Сайн ресторанд хоолло. Таны нэр төрд тохирох ажил эрхэл. Таны бие галбир хүртэл имиштэй тань нийцэх ёстой. Таныг бусдаас ялгарахад туслах дараах дүрмүүдийг ашиглаарай.

49. Зөвхөн хамгийн сайныг сонго.

50. Удмын өв

51. Зөвхөн үйлчлэл үзүүлэх зүйлийг сонго.

52. Эд зүйлийг урьдаас худалдан ав. Захиал.

53. Моод хөө.

54. Өөрийн мөнгө ба цаг хугацаанд хямгатай ханд.

55. Соронзон долгионы хүчийг санаж, хүч гаргаж байгаагаа бусдад бүү мэдэгд.

56. Хүрээлэн буй хүмүүсийн ойлголцол дэмжлэг туслалцааг ав.

Үргэлж шилдгийг сонго

Өөртөө хамгийн шилдгийг сонгох замаар та юм бүхэнд нарийн ойлголттой гэдгээ давхар харуулна. Танд юу хэрэгтэй байгааг мэддэг, эд зүйлсийн ялгаа ба үнэ цэнийг ойлгодог гэдгээ харуулна. Та Абиссинигаас хивс, Лероноос дотуур хувцас авдаг ба зөвхөн ноолууран ороолт зүүж дассан учир өөр юу ч танд үл зохино.

Зөвхөн хамгийн шилдгийг сонгоход туслах хэд хэдэн дүрмийг танд хэлж өгье. Хамгийн шилдэг гэж юу вэ? Энэ нь тун ховор, зөвхөн байгалийн гаралтай материалаар хийгдсэн, олдохуйяа бэрх, сайтар арчилгаа шаарддаг, гараар бүтээгдсэн ба маш үнэтэй гэсэн үг. Цахирмаа цэцэг бусдаас илүү ба үнэтэй. Афган үйлдрийн нохой немц овчаркаас илүү үнэтэй. Үнэтэй орны даавууг зөвхөн гараар индүүддэг бөгөөд хэрэв та өөрөө чадахгүй бол угаалгын газарт аваачиж сайн индүүдүүлнэ. Зарим эд зүйл хэзээ нэгэн цагт хямд байлаа ч цаг хугацаа өнгөрөхөд үнэ цэнэ нь өсдөг. Жишээ нь Викторианы үеийн ширээний тоглоомууд юмуу хивс нь цаг хугацаа өнгөрөх тусам үнэтэй болдог. Тэд бүгд ховор, үнэт эд зүйлс юм.

Зарим нэг хамгийн шилдэг бөгөөд чанартай эд зүйлс сайтар засч янзлаагүй

юмуу бүрэн дуусгаагүйн ул мөрийг өөртөө агуулна. Мөнгөн эдлэл, навчин тамхи, шил, дулаан хөнжил зэргийг гараар хийдэг. Тийм ч учраас бүрэн төгс биш. Гэхдээ энэ нь бүдүүлэг дутагдал биш бөгөөд гар хөдөлмөр учир үнэтэй байдаг.

Та өөрийгөө хамгийн шилдэгтэй харьцуулах аргыг бодож олоорой. Та тийм үнэтэй зүйлсийг ашиглаж хэрэглэх боломжгүй байсан ч хамаагүй. Хэрэв та хамгийн моодны гоо сайхны салонд үсээ засуулах боломжгүй бол энэ салонд хөмсөгөө янзлуулж болно. Тэгвэл та ажилтнууддаа "Би хурдхан салон орчихоод ирье" гэж хэлэх шалтагтай болно шүү дээ. Хэрэв та үнэтэй костюм худалдан авах мөнгөгүй бол куба навчин тамхи татаарай. Та тиффани эмийн санд худалдан авалт хийх боломжгүй байсан ч тэдний логотой уутанд эмээ хийчихэж болно.

Зөвхөн сайн эд зүйлс биш ер нь хамгийн шилдэг үйлчилгээг шаардаж байгаарай. Энэ нь та хэн нэгэн ганцхан хүний үйлчилгээг авдаг гэсэн үг. Үнэтэй зочид буудалд хонохдоо магнитофонд бичигдсэн дуу хоолой биш харин буудлын жижүүр өөрөө таныг утасдаж сэрээх ёстой гэж шаардаарай. Таны шууданг жирийн нэг шуудан хүргэгч биш тусгай шууданч авчирдаг байвал зохино.

Удмын өв

Зарим нэг эд зүйлс, тухайлбал эдлэн газар, үнэт эдлэл ба эртний эд зүйлс нь тухайн удмынхны үнэт зүйлс хэлбэрээр өв дамждаг. Үеэс үед шинэ эзэн дээрээ дамжин ирнэ. Хэрэв та нэгэнтээ энэ удамд багтаж чадсан, эсвэл зэрэг хэргэм олж авч чадсан бол сурвалжтануудын дунд адил тэгш байх эрхтэй гэсэн үг.



Техасын албан захирагч Жорж Буш богино хугцаанд ерөнхийлөгч болсон алдартай удмын ач

Тэгээд ч та өөрийгөө таниулж байгаа эсэхдээ эргэлзэх тохиолдолд сурвалжит гарал үүсэл юмуу уртаас урт удам судар нь өөрийгөө зөвөөр харуулахад туслана. Жишээ нь нэртэй

социалист үзэлтэн Жулиа Кох, тэрбумтан Онассисын байрыг худалдан авсан бөгөөд үүгээрээ Кохын орон байр үнэт зүйлс болон хувирч бусдад өгөх тод дохио боллоо гэсэн үг.

Дээдсийн хүрээлэнд багтах нь асар өндөр үнэлэгддэг учир сурвалжит гаралгүй олон олон хүмүүс алдар нэртэй юмуу сурвалжит гаралтай гэр бүлийн эд зүйлсийг өндөр үнээр худалдан авдаг. Эд зүйл нь өмнөх эзнийхээ алдар нэрийн хэрээр үнэтэй цэнэтэй байдаг. 1999 онд нэг хүн үнэ хаялцуулах худалдаанаас Мерилин Монрогийн хүзүүний зүүлтийг 1150 мянган доллараар худалдан авсан бөгөөд үүнийг Монро ерөнхийлөгч Кеннедид "Ноён ерөнхийлөгчид төрсөн өдрийн мэнд хүргэе" дууг дуулах үедээ зүүж байжээ. Харин өөр нэг худалдан авагч 240 мянган доллар төлж Монрогийн гоо сайхны хэрэглэлийн цүнхийг эзэмших эрхтэй болсон. Бас нэг худалдан авагч 29 мянган доллар төлөн байж жижигхэн цагаан хайрцаг авчээ. Энэхүү хайрцаг нь Виндзорын герцогийн хуримнаас илгээгдсэн бөгөөд дотор нь хуримын бялууны бяцхан зүсэм байжээ. Харин герцогийн хатны гоёл чимэглэлийг дуудлага худалдаагаар зарахад анхны үнэ 7 сая доллар байсан атал 50 сая долларын үнэд хүрсэн байдаг. Энэ нь тухайн эд зүйлийн үнэ биш бөгөөд өмнөх эзэмшигчийн сурвалжит гаралын үнэ цэнэ юм.

Амьдрал туулж, их юм үзэж, ухаан суусан олон олон алдар цуутай хүмүүс өөрийн угсаа гарлаас аль болох их ашиг олохыг хичээдэг. Барбара Стрейзанд эдлэн газраа санаанд багтамгүй өндөр үнээр заржээ. Гэхдээ сэтгүүлийн нүүрэн дээр гэрэл зургаа байрлуулах зөвшөөрөл өгсөнийхөө төлөө ийм үнэд хүргэж чадсан байна. Шер бас алдар нэрээ тун чадварлаг ашигладаг. Тэрбээр Лос-Анжелест байнга байшин худалдан авч эргүүлэн зөвхөн баячуудад өндөр үнэ хүргэн зардгаараа нэртэй болжээ.

Зөвхөн эд зүйлс удам дамждаг юм биш, хүмүүс ч бас тэгдэг. Лилэнд Хейвардын охины продюссер Брук ярихдаа түүний эцэг өөрийгөө асар баян, алдар нэртэй, бас эрх мэдэлтэй гэж бодох тун дуртай байсан бөгөөд ер нь түүний зиндааны авьяаслаг ба баян хүмүүст ерөнхий нэг иймэрхүү юм бий. [Түүний эхнэр бол алдарт Памела Харриман билээ]. Тэр өөрийгөө эхнэртэйгээ харьцуулах дуртай байсан бөгөөд жишээ нь Харриманы клуб бол бидний дундынх гэж үздэг байв. Харин хатагтай Харриман Францад суух элчингээр томилогдон одоход түүний оронд алдар нэрд дуртай хатагтай Арианна Хаффингтон Вашингтонд иржээ. Тэрээр ирэнгүүтээ хуучин тогооч Харриманыг шууд ажлаас халсан юм.

Яагаад гэвэл энэ хүн сурвалжит гаралтай байсан нь түүний хувьд тэвчишгүй зүйл байв. Тэр өөрөө Харриманы залгамжлагч болохыг хүсч байсан.

Зөвхөн шинээр худалдаж авсан эд зүйлс нэртэй байдаг юм биш.

Уламжлалт газрууд юмуу хуучин эд зүйлс ч сүртэй нэртэй байх нь элбэг. Эд зүйл бүхэн өөрийн оноосон нэртэй, бас сайн муу нэртэй байдаг. Та "Перфоманин, "Филенс" юмуу "Лоэманн"-аас юу ч бүү худалдан аваарай. Гэтэл аргагүй эдгээр дэлгүүрт худалдаа хийхэд хүрэх юм бол тэдний шошготой тор уутыг барьсан байдлаар бусдад харагдаж болохгүй. Ер нь таны барьсан тор юмуу цүнх хүртэл бусдад дохио болох учиртай. Брэндийн шошготой баян тор сав барьсан байхад хэн нэгэнд харагдахаас айх юун. Дотор нь юу байх хамаагүй. Гол нь гадаад байдал.

Хэрэв та өөрөө нэрд гарч чадахгүй бас угсаа гарал үгүй бол нэртэй угсаа гаралтай хүмүүстэй харьцахыг хичээ. Вуди Аллений байшинд, эсвэл түүний амьдардаг давхарт байр худалдан ав. Яг Английн хатан хааных шиг сандалтай бол. Нэртэй оффис тохижуулагчийг өөрийн дизайнераар хөлсөл.

Жинхэнэ үнэт зүйлс худалдан ав

Үнэ цэнэтэй зүйлсхарахад илт байдаг. Та зөвхөн чанартай, үнэтэй зүйлсийг худалдан аваарай. Түрийвч, шаазан, бөгж, шөнийн чийдэн гээд бүгд жинхэнэ байх ёстой. Цирконыгжинхэнэ алмазаасялгахад маш хэцүү. Бүрэлдэхүүнд байгаа ганц жижигхэн хэсгээр ялгардаг.

Хэрэв та дууриамал зүйл хэрэглэдэг бол маш сайн хийгдсэн дууриамал байх ёстой. Та хиймэл үслэг хувцас хэрэглэдэг бол маш сайн материалаар, маш сайн хийгдсэн байх учиртай.

Захиал

Хэрэв боломжтой бол эд зүйлсийг захиал. Таны таашаалд нийцүүлж бэлдэхийг шаард. Ер нь юу ч байж болно. Гутал, цамц, гольфын хувцас, ханын цаас, буу. Тэр бүү хэл захиалсан зүйл тань дэлгүүрт байдгаас бараг ямарч ялгаагүй байлаа ч хамаагүй захиал.

Ийм зүйл нь таны хувь хүн гэдгийг тодотгож өгнө. Таныг бусад хэрэглэгчдээс ялгаруулна. Тэд таны тухай, чанар ба тохь тухын төлбөр хийхэд бэлэн хүн хэмээн ярих болно. Танд зөвхөн хамгийн шилдэг нь хэрэгтэй.

Ресторанд байхдаа ч яг ингээрэй. Та үнэхээр идэхийг хүсч байгаа дуртай хоолоо л захиал. Энэ хоол таны таашаалд нийцэх ёстой. Хамгийн тансаг хоолыг нь сонгож хийж өгөхийг хүсэх үед энэ нь илүү үр дүнтэй үйлчлэл үзүүлнэ. Та өндөр үнэтэй ресторанд байгаа юмуу эндхийн тогооч хичнээн мундаг байсан ч хамаагүй та өөрийн дуртай шарсан загасаа л захиал. Хэрэв та том захиалга өгөх гэж байгаа бол энэ дүрмээ мөрд. Энэ нь мөн л таны хичнээн нөлөөтэй хүн болохыгхэлээд өгнө. Хүссэн хүн бүр ахлах тогоочийг дуудаад өөрийн дуртай хоолоо өөртөө зориулж хийлгэдэг юм биш.

Моод хөө

Моод гэдэг бол өөрийн хувь хүн болохыг илэрхийлэх, нийтийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүний тусламжтайгаар өөрийгөө "Би" хэмээн тодотгох боломж өгдөг. Хүмүүс "Поттери Барн" зэрэг моодны дэлгүүр рүү тэмүүлдэг. Тэндээс авсан эд зүйлсээ найз нартаа гайхуулах гэж тэр. Найз нар нь бас тийшээ явна.

Та үргэлж моод хөөгөөрэй. Энэ нь эргэн тойронд байгаа хүмүүст хоёр зүйлийг ойлгуулна. Нэгдүгээрт та моод хөөдөг, хоёрдугаарт ингэх хөрөнгө мөнгөтэй. Жишээ нь энэ жил Францын амттан моодноос гарч оронд нь Италийн амттан моодонд орсон болохыг та мэдэж байгаа гэдгийг бүгд мэдэж аваг. Энэ улиралд аливаа үдэшлэг цэнгүүний гол шигтгээ нь амттан ба бялуу болно. Тийм учраас та төрсөн өдөртөө ямар нэгэн сэтгэл алдрам зүйл эрж хайна. Жишээ нь Сильвия Вайнстокийн 2-3 мянган долларын үнэтэй бялуу гэх мэт. Таны сонголт таны хичнээн нарийн тансаг мэдлэгтэй, сэтгэлгээ сайтай хүн болохыг хэлээд өгнө. Сайтар хийсэн сонголт нарийн мэдрэмжтэй хүн гэсэн таны имижид тус өгнө. |байз, итали чихэр биш харин энэ хар чихэр моодонд орсон юм биш биз?|

Улирал болгонд зарим нэг гар хийцийн зүйлс нэрд гардаг нь угаас моодын шаардлага. Хүмүүс үргэлж л шинэ юмыг хүлээж байдаг. Дандаа шинэ юмны хажууд байх, цаг хугацаатай хөл нийлүүлэн алхах гэсэн тэдний хүсэл заримдаа бүр инээд хүрмээр. "Нью-Йорк таймс" сонин ил зуухны төмөр тавиур моодонд орлоо хэмээн зарлажээ. Ингэвэл хүмүүс дэлгүүр рүү гүйлдэж тавиур худалдан авна гэж найдсан редактор худалдан авагчдаа өдөөн хатгасан хэрэг. Гэтэл эсрэгээр эргэж гэрийн ил зуух өөрөө моодонд ордог байгаа.

Бусдаас ялгарах өөр нэг арга бий. Энэ бол Санаанд оромгүйн зарчим. Энэ тохиолдолд та моодыг бүрмөсөн авч хэлэлцэхгүй. Мэдээж энэ нь танд асар их амжилт авчирна. Моод хөөгч байснаас хавьгүй илүү амжилт авчирна. Гэхдээ амжилт олохын тулд өөрийгөө онцгой авч явах ёстой. Зөвхөн таны хувийн хэв маяг шаардах байдлаар хувцаслана. Асар их эд хөрөнгийн өв залгамжлагч гэрийн ханаа хар хилэнгээр доторлох замаар өөрийн хэв маягийг бусдад гайхуулдаг. Гэвч моодыг ил тод үгүйсгэлээ гээд өөрийнхөө тухай дохио өгөхгүй байна гэж бодвол алдаа. Зүгээр л энэ нь өөр төрлийн дохио юм.

Цагаа мөнгө шигээ гамна

Цаг хугацаанд хандах хандлага эд зүйлстэй харьцахтай адил таны дохио юм. Ингэхэд та чөлөөт цагаараа юу хийдэг вэ? Юу хийхээ сайтар сонгоорой. Хэрэв та аль нэг зүйл дээр сонголтгоо хийх гэж байгаа бол таны сонирхол үнэтэй, ер бусын, олон хүнд ойлгомжгүй байх ёстой.

Таны хийх зүйлс Хийх ёсгүй зүйлс

Цанаар гулгах Газрын теннис тоглох Мэргэжлийн загасчлал хийх Морь унах Цэцэг тарих

Сноубордоор гулгах Агаарын теннис тоглох Тэшүүрээр гулгах Мотоцикл унах Хадлан хадах

Зүдрээгүй царайл

Таны хувьд соронзон долгион амин чухал хэрэгтэй. Та дур булаам, өөдрөг, юунд ч санаа зовдоггүй хүн байх ёстой. Төрөхөөсөө л нийгэмд онцгой байдал ба байраа эзэлсэн хүн өөрийн мэдэлгүй л ер бусын, хамгийн шилдэг бүхэнд татагдах ба энэ бүхэнд суралцаад байх шаардлага ч үгүй. Алдарт Жулия Робертсын тоглосон "Хөөрхөн хүүхэн" киног сана. Киноны гол дүр анх дуурь үздэг хэсгийг санаж байна уу? Тэрбээр хөгжим ойлгодог мэтээр өөрийгөө харуулдаг. Гэхдээ илэрхийлэхдээ: "Надад маш их таалагдсан учир би өмдөндөө шээх шахсан" гэдэг билээ. Түүний шууд үзүүлж буй хариу үйлдэл нь нарийн мэдрэмжийг нь харуулж байна. Энэ бол түүний дотоод ертөнц.

Та өөрөө өөрийгөө хүмүүжүүлж байгаа бас маш аливаад их хичээж байгаа гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэггүй. Хамаг хүч хөдөлмөрөө нуугаарай. Та нүүр амаа бараг буддаггүй, эсвэл теннис тоглож сурах гэж хэзээ ч зүдрээгүй гэж хүмүүс бодог. Хазгай хэллэгээсээ салахын тулд урлагийн дамжаанд явсан юмуу эсвэл гоо сайхны мэс засал хийлгэсэн тухай та бусдад мэдэгдүүл. Та биеийн жиндээ огт анхаардаггүй мэт харагдаж, хоолны дараа амттан захиалжжүжиглээрэй. Гэхдээ өнөөх амттанаа зүгээр л амсаад орхих хэрэгтэй. Ингэснээр та яг мөнгөтэй харьцдаг шигээ л хоолны дэглэмтэй ч энгийн хөнгөн харьцдаг гэж харуулна.

Дүрэм

Байгалиас заяагдсан мэт санагдах бүхэн төрөлхийн байх нь тун ховор.

Та аливаад огт санаа зовохгүйгээр хандаж байгаа нь жинхэнэ эзэн нь гэдгийг харуулж өгнө. Жишээ нь та дөнгөж саяхан хоол бэлтгэх дамжаа дүүргээд одоо зочдыг гэртээ урьсан гэж бодъё. Та хэзээ ч "би ногоо гоёмсог зүсэхийг хэдэн сар суралцлаа. Энэ хоолонд хэрэгтэй бүхнийг цуглуулах гэж гурван дэлгүүр хэслээ" гэж ярьж болохгүй. Үүний оронд тоомсоргүй инээмсэглэн: "Өө энэ үү, би зүгээр л хэдэн өөр хүнс хольчихсон юм. Юу болсныг нь харъя. Надад жор ч байхгүй шүү дээ" гэж яриарай. Эсвэл та дунд сургуулийн ахлах ангид өмсч байсан цамцаа одоо болтол зүгээр л өмсдөг гэж хэлээрэй.

Үргэлж тоомсоргүй мэт загна. Жишээ нь та томчуудын клубт багтахыг цөхрөн хичээсэн байж болно. Гэхдээ тийшээ орох халуун хүслээ бүү харуул. Хэт их хүчлэл нь эзнээ доош оруулдаг. Төгс төгөлдөрт тэмүүлэх таны тэмүүлэл алхам бүхнээ сайтар бодоход хүргэж байна. Хэд хэдэн гэнэтийн, сэтгэл татам, бас хурц үг хавчуулж сур. Та их тансаг мэдрэмжтэй учир тусгай технологийн бяслаг танд таалагддаг, та Харлеквины романыг уншиж, кельт хөгжим сонсох дуртай.

Заримдаа бүдүүлэгдүү загнаж болно. Хувцасны сонголт хийдэггүй мэт. Өөрийн гадаад төрхөд хэрхэн анхаарахаа мэддэггүй хүн мэт, хуучин загварын костюм өмсдөг, ресторанд захиалга өгч чаддаггүй хүн мэт. Иймэрхүү юм мэддэггүй төрх нь зөвшөөрөгдсөн хил хязгаарыг хааяа санамсаргүй алхан гарах боломж олгодог. Бусад хүмүүсийн хувьд өршөөж үл болох тийм алдаа хийх эрхийг танд олгоно гэсэн үг.

Багасгах, зальдах

Эд зүйлс худалдан авчихаад үнэтэй цайтайг нь гайхуулах хэрэггүй. Түүний оронд нарийн таашаалтай гэдгээ харуулах аваас таны сонголтыг илүү үнэлнэ. Донна Каран, Армани юмуу

Кельвин Кляйны шошготой хувцас авахын оронд яг тэдгээр дэлгүүрээс, гэхдээ шошгогүй хувцас аваарай. Гучигийн түрийвчийг авахдаа түүний алдарт "Г" гэсэн тэмдэггүй, эсвэл Ральф Лорены цамц авахдаа мөн л хармаан дээр байдаг тэмдэглэгээгүйгээр авна. Өөрийгөө бүхэнд гайхуулах хүслээ барьж сур. Алдарт Консуэло Вандербилд Монако улсад гоо сайхны жинхэнэ үнэлэгч ба хагас харанхуй хүмүүсийн хооронд явагдсан сөргөлдөөний тухай бичсэн ба энэ дайны тухай ингэжхэлжээ. "Отеро казинод орж ирэхдээ хөлөөс толгой хүртэл үнэт зүйлс зүүж Пужиг өдсөнд гайхах зүйл нэгээхэн ч үгүй. Ёстой гудамжны амьтан харагдаж байв. Өөрийн өрсөлдөгчөөс илүү гарахыг хүсэхдээ тэр инээдтэй амьтан болсон бөгөөд бүх хүн залхсан. Энд байсан хүмүүс түүний ингэж өдсөнд Пужи хэрхэн хариу барих бол хэмээн тэсч ядан шивнэлдэж байв. Бүх юм тун энгийн. Маргааш нь тэр нэг ч гоёл зүүгээгүй энгийн цагаан даашинз өмссөөр орж ирсэн. Харин түүнийг дагасан зарц эмэгтэй өмнөх өдөр Отеро орж ирсэн шиг дүүрэн гоёл чимэглэл зүүсэн байлаа Зөвлөмж ч

Аливааг илэрхийлэх өөрийн гэсэн хэллэгтэй болоорой. Тэднийхээ тусламжтай та жишээ нь ер бусын байшинг хүртэл үнэлж чадна.

Санаанд оромгүйн зарчмыг санаарай. Олонхи хүмүүсийн адил эд баялгаараа гайхуулах биш, өөр арга замаар баян гэдгээ харуулж сур. Та ердийн хямд дарснаас ч таашаал авч чадна гэдгээ харуул. Хуучин машин унаж, гандуу хувцас өмсч, энгийн эд зүйл хэрэглээрэй. Силикон хөндийн тэрбумтнуудын жишээг дага. Тэд бүгд нүдэнд үл өртөхүйц, даруухан байдаг. [Хэрэв та үргэлж биеэ ингэж авч явах аваас Санаанд оромгүйн зарчмаар та тун баян хүн байж таарна].

Мөнгөтэй эрийн эхнэр

Та жинхэнэ эр хүн мөн үү? Хэрэв мөн л юм бол эмэгтэйчүүдийн дунд хэр амжилт олж байгаагаар хэмжигддэг амьдралын том шагналын тухай бодох хэрэгтэй. Танд таарч тэнцэх хань ижил хэрэгтэй бөгөөд тэр эмэгтэй таны хамгийн том шагнал. Гэхдээ үүнийг гол зорилгоо болгож болохгүй. Танд эхнэр хэрэгтэйн хамгийн гол шалтгаан нь гэр бүлтэй хүн гэдгээ бүгдэд харуулах явдал.



Хиллари Клинтон Цааан ордонд орохдоо тэргүүн хатагтай нарын жигүүрт суухгүй гэжээ

"Намайг хар", "Миний мөнгийг хар" - Ийм хосууд наяд оноос бий болжээ. Хэрэв эр хүн өндөр албан тушаалтай ба их мөнгө олдог, орлогоо байнга нэмэгдүүлдэг бол эхнэр нь орон гэрээ сайхан харагдуулахыг хичээж, нийгмийн амьдралд оролцож, гэр ахуйгаа хөтөлж,

үдэшлэг найр зохиож, нийгмийн асуудлаар оролдож, хувцас сонгож, амралтаар хааш явахыг шийднэ. [Эмэгтэйчүүд хувцас, гоёл чимэглэл ба нүүр будалтын тусламжтайгаар хувь хүн гэдгээ илэрхийлэх хандлагатай бөгөөд бусдад хэрхэн харагдаж байгаадаа илүүтэй анхаардаг]. Тэгэхээр эр хүн буурь суурьтай харагдахыг хүсвэл түүнд эхнэр маш чухал. Эхнэр нь юу хийх, мөнгө хэрхэн олох ба үрэхийг үргэлж мэдэж байдаг.

Гялалзсан эхнэрүүд бүх дэлхийг дагуулан эрхшээх хүсэлтэй, бөгөөд нөхөр нь хичнээн ажил ихтэйг ярьж, тийм учраас хаа сайгүй ганцаараа л явж байдаг. Та юу худалдан авахыг хүсч байна вэ? Хаашаа явмаар байна? Анхны эхнэр хүүхдүүддээ хэт дарагдаж, үдэшлэг найрт харагдахгүйн зэрэгцээ моод хөөж дэлгүүр хэсдэггүй, нөхрөө юу хийж байгааг ч мэддэггүй байжээ. Тийм учраас хоёрдугаар эхнэр нь одоо эдлэх ёстой ханамж болж өгнө.

Дүрэм

Анхны эхнэр амьдрал нь сайн муу хааш эргэхийг мэдэхгүйгээр нөхөрт гардаг. Харин дээдсийн хүрээнээс гаралтай эхнэр бол зөвхөн амьдралаа сайжруулахын тулд л нөхөрт гардаг.

Тийм учраас дээдсийн хүрээний эхнэрүүд бүгд мөнгөнд аймаар шуналтай татагддаг. Нөхрийнх нь байр суурь ба эд хөрөнгө өөрийнх нь ахилтын нэгээхэн хэсэг болохоор аргагүй биз. Энэ эмэгтэй аль болох илүү сайн байлгахын тулд дээд зэргийн хүч хөдөлмөр тавина, нөхрөө гарцаагүй хожих байдлаар харуулж, зөв дохио өгнө гэсэн нөхцөлтэйгөөр амьдардаг.

Улс төрчдөд дээдсийн хүрээллийн эхнэр хэрэггүй. Дээдсийн хүрээний эхнэрүүдийн тавилан нь мөнгө үрэх ба өөрийгөө зарлах явдал. Гэтэл хичнээн баян улс төрч байлаа гээд түүний байр суурь нь улс төрийн жин болон эрх мэдлээс нь маш их хамааралтай болохоос биш эд баялгаас бол нэг их хамааралгүй. Тийм учир түүнд мөнгийг чадварлаг зарцуулах замаар тодорхой түвшинд хүрдэг дээдсийн хүрээний эхнэр ерөөсөө хэрэггүй. Улс төрчид сонгогчдын төлөө санаа тавих учиртай. Гэтэл үслэг хувцас, гоёл чимэглэлээр хучаастай эхнэр нь түүнд саад тотгор болохоос цаашгүй.

Мэдээж моод байнга солигдож байдаг. Эхнэрийн хувьд ч ялгаагүй. 1980-аад онд моодонд орсны улмаас олон олон дээдсийн хүрээний эхнэрүүд нөхөрт гарсан. Дараа нь моод өөрчлөгдсөн учир салсан байдаг. Тэдний байр суурийг анхны эхнэрүүд дахин эзэлсэн. Харин одоо мэргэжил нэгтэй гэр бүлүүд моодонд оржээ. Эхнэр нь хуримын дараа ч өөрийнхөө мэргэжлээр ажиллах ёстой. Хэвлэлийн магнат Руперт Мердок 30 жил хамт амьдарсан эхнэр Аннагаасаа салсны дараа 69 настайдаа 32 настай телевизийн од бүсгүйтэй хуримлажээ. Мердок энэ тухай ярихдаа "Тэр хаана ч байсан хийх ажлаа олдог. Гэхдээ тэр одоо ингэж чадахгүй байгаа. Яагаад гэвэл надтай хамт аялж явна" гэжээ.

Дээдсийн хүрээний эмэгтэйчүүд урьдынх шиг анхаарал татаж чадахаа больжээ. Дээдсийн өнгө төрхтэй амьдрах байдал сэмхэн урсан одож оронд нь өөр бүрхүүл бий болж байгаа нь ажил мэргэжлийн хэлхээ холбоо. Тодорхой хүрээний хүмүүс ялангуяа эрчүүд ажил хийх, мөнгө олохоос үүдэн дэндүү завгүй болсон учраас өөрийн имижд санаа тавих, хурим найранд цаг гаргах боломжгүй болжээ. Ингээд дээдсийн хүрээний эхнэрийн моод аажмаар өнгөрч байна.

Хэдийгээр моод солигдож дээдсийн хүрээний хурим найрууд моодноос гарсаар байгаа ч амьдралд байсаар л буй.

Танд бид жинхэнэ дээдсийн хүрээний бүсгүйг эхнэрээ болгон авах сонжоог санал болгож байна.

Дээдсийн хүрээний эхнэрийн анкет

Хэрэв та энэхүү анкетын гурван бүлэгт харьяалагдаж байвал өөрийгөө дээдсийн хүрээний хатагтай хэмээн тооцож болно. Шүүдсийн хүрээний бүх эхнэрүүд нөхрөөсөө заавал өндөр байдаг. Гэхдээ энэ нь заавал байх нөхцөл биш.

Та тэр хүний хоёр юмуу гуравдугаар эхнэр байх ёстой. Анхны эхнэр байх ёсгүй. Энэ тохиолдолд та дээдсийн хүрээний эхнэр байх бөгөөд өөрийн нөхрийн жинхэнэ шагнал нь юм. Анхны эхнэр хэзээ ч шагнал байдаггүй. Учир нь тэр анх танилцсан өдрөөсөө эхлээд нөхрийнхөө байр суурь ба ажил хэргийнх нь тухай мэдэж байдаг. Харин та бол нөхрийнхөө болон түүний эд хөрөнгийн дээд зэргийн цэцэглэлтийн үеийг л гэрчилж чадна. Гэхдээ дөрөв тав юмуу зургаадугаар эхнэр байх ёсгүй. Гурван эхнэр гэдэг их шүү дээ. Түүнээс их бол арай дэндэнэ.

Та нөхрөөсөө дор хаяж найман насаар дүү байх ёстой. Харьцангуй залуу байх нь дээдсийн хүрээний эхнэрийн зайлшгүй болзол. Ийм ижил бус байдалд анхаарал хандуул. Тэрбээр алдартай хүмүүс ба үйл явдлын тухай ярина. Харин та огт мэдээгүй дүр эсгэн бүр гайхаж бахадсан байдал үзүүл. "Жон намайг нартад төрөөгүй байхад ийм юм болж байсныг санаж байна уу?".

Та гадаад байдалд бүрэн анхаарал хандуулах ёстой. Жинхэнээс анхаарч чадвал танай гэр бүлийн дохио болж хувирна.

Танай нөхөр таны хүслийг үл тоон тантай гэрлэсэн нь түүний мөнгийг үрэх шалтгаануудын нэг. Гэр бүлийн амьдралын гялалзсан зураг бүтээхийн тулд хэрэгцээтэй бүхнийг хийхийг нөхөр тань танаас хүлээж байгаа.

Хэрэв нөхөр чинь хүсэхгүй бол та хүүхэдгүй байхаас аргагүй гэдэгтэй эвлэрэх ёстой. Тэр анхны эхнэрээсээ үр удмаа үлдээх хэрэгцээгээ бүрэн хангасан байж болно. Түүний гэрт гүйлдэх хүүхдүүд хангалттай мэт түүнд санагдаж байгаа.

Хэрэв та ажил хийдэг бол сайн. Хэрэв таны ажил эхнэрийн үүргээ гүйцэтгэхэд саад болохгүй байх юм бол та эмэгтэй хүний албан тушаалын шат ахих замаар өгсөхөд өөрийгөө зориулаарай. Гэхдээ өөрийн болон нөхрийн тухай аль болох тод мэдүүлж болох тийм салбарыг сонгоно. Энэ нь сэтгүүлч, загвар зохион бүтээгч юмуу гоо сайхны салбар байж болно.

xxx

Олонхи хүнд мөнгө зөвхөн дохио өгөхөд хэрэгтэй байдаг. Хоёрдугаар байранд хангамж ба

тохь тух ордог. Өөрөөр хэлбэл мөнгө хэрэгцээгээ хангах ба өөрийн үнэлэмжинд хэрэгтэй. Мөнгө таныг хүссэн тохь тухаар хангана. Таны зардалыг үнэлэх хүн үгүй байсан ч хамаагүй. \дашрамд хэлэхэд эд хөрөнгө ба тохь тух зардалаас л хамааралтай\.

Найм дугаар бүлэг

Мөнгө ба таашаал

"Би мөнгөтэй бол өглөөний цай оронд авчирч өгөх зарц хөлсөлж авна".

Таны хувьд мөнгө өөрийнхөө хэрэгцээг хангах, таашаал ба тохь тухаа хангахад хэрэгтэй бол та өөрийгөө үнэлэх үнэлэмжинд анхаардаг нэгэн ажээ. Энд бид гурван үндсэн хэлбэрийг авч үзнэ. Чөлөөт цаг, ирээдүйг мэдэх ба тансаглал. Гэвч хувийн таашаал сонирхол нь мөн л дохио өгөх чадвартай. Хүмүүс чөлөөт цагийг эд баялагтай ижилтгэж үздэг. Тэгэхээр хэрэв танд чөлөөт цаг ба шохорхол бий болсон бол та баян хүн гэсэн үг.

Чөлөөт цаг

Яагаад бидэнд чөлөөт цагаа ашиглахад мөнгө хэрэгтэй вэ? Энэ нь та өөрийнхөө төлөө ажилласан гэсэн үг. Та өглөөг угаалгын газарт өнгөрөөх юмуу паспортоо сунгуулахын тулд дугаарлаж зогсон олон зүдэргээт цаг туулахаа больжээ.

Дүрэм

Хэн нэг нь зарц нарын жижигхэн багтай амьдраг л дээ.



Жаклин Кеннеди тэрбумтан Онассистай хуримлах үед дэлхийн хэвлэл иэдээлэл түрийвч угсаа хоёр нийллээ хэмээн шуугиж байжээ

Чөлөөт цаг нь хувийн таашаал ба сонирхолд их цаг үлдээх бөгөөд илүү олон боломжууд ч гарч ирнэ. Өөр хэн нэгэн хүн цэвэрлэж, эмх журам сахиулах үед амьдрал сайхан болж эхэлдэг. Ил зууханд үргэлж гал ноцох ба харин үнс нь таны оролцоогүйгээр алга болно. Үдийн хоолны д

араа вааранд шинэ цэцэг гарч ирнэ. Виндзорын герцог ба түүний хатагтай Австралид ирэхдээ 266 чемодан, 186 авдар ачаатай ирсэн байдаг. Холливудын одод Элизабет Тейлор, Ричард Бартон нар мөн 156 чемодан,

дөрвөн хүүхэд, зарц, булган пиджактай гурваннарийн бичгийн дарга, үсчин, асрагч, дөрвөн нохой, алмаазан хүзүүвчтэй хоёр мууртай аялж байжээ. Яагаад бүгдийг нь авч явж болохгүй гэж.

Мөнгө таныг мөнгөнөөс хүртэл хөнгөвчилж өгнө. Хэн нэгэн мөнгө үрэх хөдөлмөр ба амь зуухын тулд үхэн хатан санаа зовох шаналалаас залхжээ. Жек Кеннеди, Иоко Оно ба Эдди Мерфи нар энэ талын ажлыг туслагчдынхаа мөрөнд үүрүүлжээ.

Дүрэм

Танд мөнгө их байхын хэрээр та мөнгийг бага хянадаг.

Тун удалгүй танд юу ч хийх хэрэггүй болно. Хэрэв та өнгөрсөн зууныхан шиг аль нэг жүжигчнийг ивээн тэтгэхийг хүсэхгүй байгаа бол уран зургийн аль нэгэн галарейн эзнийг ивээгээрэй. Тэгвэл энэ галарей таных болно. Та тооцоо хийх юмуу урилгад хариу өгснийх нь төлөө нарийн бичгийн даргадаа мөнгө төлнө. Таны өмнөөс худалдаа хийх хүн ч танд бий. Гэрийн бүх цахилгаан хэрэгслийг хариуцдаг туслах зарцтай болно. Зарц нар таны найз нөхрийн холбоог хүртэл зохицуулна. Нэгэн нийгмийн зүтгэлтэн найз эмэгтэйнхээ тухай "Тэр бол хамгийн сайхан найз байсан. Надад гэрийн нөхцөлд шарсан төмс таалагддагийг мэддэг ба өөрөө бэлдээд надад илгээдэг байв" гэжээ. Үнэн хэрэгтээ энэ бол түүний мөрөөдөл юм.

Танай зарц нар бүхнийг удирдана. Зохиолч Вартон өөрийн зохиолын баатархатагтай Бьюфортын тухай бичихдээ: "Тэр үргэлж найр зохионо. Өөрийн эрхэм дээдийг тодотгохын тулд дуурь үзэхээр явах ба түүний эзгүйд зарц нар нь найранд бэлдэх явцдаа хоорондоо уралдах боломжийг үлдээдэг" гэжээ. Одоо та хувийн нарийн бичиг, зарц, тогооч, үсчинтэй болсон тул та үнэхээр чөлөөлөгдөж, чөлөөт цаг бий боллоо. Та ширээ засах, дэлгүүр явах, машин барих хэрэггүй ба өдөр тутмын санаа зовнилд дарагдахгүй болжээ. Америкийн Гринвич ба Коннектикут муж улсын олон хатагтай нар гэрийн ажлыг зарц нарт даатгаад өөрсдөө клубт явдаг. Цагийг ингэж өнгөрөөхийн тааламжгүй тал нь тохь тух хэтдэх байж мэднэ.

Гэвч хамгийн таатай нь унаа тээвэртэй холбоотой тухгүй байдал дахин үүсэхгүй. Бүх хатагтай нар хөнгөн болоод хурдан явахыг хүсдэг. Жишээ нь Цагаан ордны зохион байгуулагч менежер Дэвид Уоткинс ерөнхийлөгчийг очихын өмнө гольфын талбайг шалгахаар явахдаа өөртөө нисдэг тэрэг захиалдаг байв. Вильям Арамони маш их зэмлэл сонсдог байсан. Түүнийг зөвхөн нэгдүгээр ангиллаар нисэх ба хувийн тээврийн хэрэгсэлдээ дэндүү их мөнгө зарж байна хэмээн зэмлэдэг байжээ.

Нисэх онгоцонд суухын өмнө таны ачаа барааг нээж шалгахгүй байх нь ч тохь тухын нэг хэсэг. Та ачаа хүргэх үйлчил гээг ашигласнаар таны ачааг байшингийн чинь босго дээр аваад ирнэ. [Нэгэн нэртэй аялагч конкордоор нисэхдээ зөвхөн онгоц дотор хэрэг болох зүйлсээ л авч явдаг байсан].

Мөнгө танд тэр байтугай тохь тух бэлэглэнэ. Та зочид буудлын дугаарыг эртнээс захиалах юмуу баярын хямдрал хүлээх хэрэггүй болно. Та ямар ч үед хүссэн бүх зүйлээ худалдан авахыг өөртөө зөвшөөрч чадна. Та тухайн үеийн аясаар биеэ авч явах боломжтой болно. Хэн

нэгэн танил утасдаж амралтын өдөр хаа нэгтээ явахыг урьлаа гэхэд та "Тэгье, амарья, сайхан санаа байна. Би босоод л тэгээд хөдөлцгөөе" гэж хариулах болно. Таны нарийн бичгийн дарга болоод жуулчны товчоо онгоцонд суудал захиалчихна. Онгоцонд суухад цаг бага үлдэх аваас та "Яарах хэрэгтэй дээ" гэж сануулна. Мөн "Та нар бэлэн болоогүй байна уу, зүгээр. Ямар нэг юм мартсан байвал тэнд очсон хойноо авчихъя" гэнэ. Хувь заяаны ийм бэлгийн төлөө өөртөө баяр хүргээрэй.

Гэнэтийн зүйлс нь хүний амьдралыг хурц сонин болгож өгдөг. Гэхдээ энэ бол үнэтэй таашаал билээ. Танд бүх давуу тал байна. Та тохь тух эдлэн жаргаж, хүлээхийн зовлон үзэхгүй. Нэгэн баян нарийхан зам хараад цухалддаг байв. Тэрбээр феррари машин унадаг ба орцны өмнө машин эргэх зайтай өргөн зам хэрэг болжээ. Тэгэхээр нь инженер рүү утасдаж замыг өргөсгөхөд ямар үнэтэйг асуув. Түүгээр зогсохгүй ажил орой гэхэд дуусах ёстойг шаарджээ. Асуудал байхгүй. Тодорхой хэмжээний мөнгө бүхнийг шийднэ.

Тохь тухын сөрөг тал

Заримдаа тохь тухын төлөөх төлбөр нь хувийн халдашгүй байдал ба тусгаар байдлаа алдах явдал юм. Ажиглах камерын дэлгэц дээр таны бүх дадал зуршил бичигдэн үлдэнэ. Жишээ нь гэр дотроо наашаа цаашаа явж хөдөлж байгаа тань. Тэд таны тухай жижиг сажиг онцын ач холбогдолгүй бүх мэдээллийг цуглуулах ба таны бүх яриаг чагнаж байдаг. Таны гэрийн түлхүүрийг өөр олон тооны хүн барих бөгөөд нууц кодыг ч мэднэ. Та хайртай хүн рүүгээ утасдах үед хичнээн хүн хамар дороо мушийн инээдгийг та мэдэхгүй. Тоомсоргүй дүр эсгэсэн нарийн бичгийн дарга "таны гэртээ эзгүйд" ирсэн, танд зориулан ягаан хуудас дээр бичигдсэн бүх тэмдэглэл, итгэмжлэх, гарын үсэг ба эмийн жоруудыг хамж авна. Таны түншүүд өөрийн тань машиндаа үйлчилгээ авдаг төвүүдийн үйлчилгээг давхар ашиглана. Таны ирсэн эсэхийг тэд тусгай радиогоор сонсож байдаг. Та заримдаа гайхаж хоцорно. Яахаараа таны удирдлага доорх хүн "Риц-Карлтон" буудалд өдрийн гурван цагт буудаг байна вэ? Хэн орж гарсныг буудлын хаалгач мэдэж байгаа. Цэвэрлэгч ул мөрийг нь харжээ.

Дүрэм

Хэрэв танд санаа зовох зүйл үгүй бол танд хувийн амьдрал эрх чөлөө ба халдашгүй байдал бас үгүй.

Хэвшил

Энэ тохиолдолд мөнгө ямар хэрэгтэй юм бэ? Гайхалтай нь мөнгөний танд өгөх бүх тохь тух таашаалаас энэ нь хамгийн үнэтэй нь юм. Та үргэлж сайн буудалд бууж, хамгийн амгалан дүүрэгт амьдарч, өөлөх аргагүй ваннд хэвгэж, бүгд танд анхааралтай хандана.

Хотоос найз нөхөд тань дээр ирэхэд та энэ уулзалтад зориулан дуртай ресторанаа түрээслэнэ. Үйлчлэгч таны мэндийг мэдээд таны суух дуртай ширээнд дагуулан хүргэнэ. | Хэвшил гэдэг алдар нэр шүү дээ|. Танд хоолны цэс харах шаардлага байхгүй. Хоолны дараа та "Алив машин дуудъя" гэнэ. Харин танай найз такси дуудсан нь зүгээр биш үү?" гэхэд та толгой сэгсэрнэ. Яагаад үгүй гэж? Тохь тухын тэмүүлэл нь нийтийн автобусанд явахаас таксины үйлчилгээ авах нь хамаагүй дээр гэдгийг хэлээд өгнө. Гэвч таны хэвшил болохоор

тусгай үйлчилгээ таксинаас тухтай гэдгийг хэлнэ. Ямар ч тохиолдолд таныг босгоноос босгонд хүргэнэ. Үйлчилгээ танд ариун цэвэр, тохь тух ба тааламжтай харьцааг батална.

Иймэрхүү хэвшил таны зарлагадсан мөнгөнд дүйцнэ. Хувийн сургууль, хувийн хамгаалалт, хувийн хог цэвэрлэх үйлчилгээ, хувийн номын сан, нисэх буудал дахь хувийн амралтын өрөө, эмнэлэгт таны тохь тухын төлөө бүхэл бүтэн баг санаа тавих тусгай өрөө. Дээдсийн хүрээлэнд багтах ба түмнээс онцгой байх нь хэвшлийн төрсөн эгч нар юм. Тэдгээр нь хувийн сургууль, клуб ба компани хэлбэрээр гарч ирнэ. Мөнгө таныг хамгийн шилдэг нийгэм рүү хөтөлнө. Эндхийн хүмүүс дээд зэргийн чанартай хувцас өмсч, сургуульд яваа хүүхдүүдийнхээ төлөө, дэлгүүрийн худалдан авагчид ба теннисний талбайд ирэгсэдийн төлөө санаа тавих хэрэггүй болжээ. Таны орох дуртай ресторан өөрийнхөө утсыг лавлахын шар номонд тавихгүй. Тэгэхээр тэнд тохиолдлын хүн нэг ч орж ирэхгүй. Хөөрхий нэрд гараагүй дээрэмчид сая саяыг олж болно. Гэвч нийгэм тэднийг хүлээн зөвшөөрөхгүй. Яагаад? Урсдаг шатан дээр таарсан хэн нэгэн тэднээс шууд зайгаа барина. Мөнгө хүнийг тааламжгүй хүрээллээс тусгаарлаж өгдөг.

Дүрэм

Тусгаарла, тусгаарла, тусгаарла

Ийм хэвшлийн үнэ асар өндөр. Саятан Жулиана Дэвис 1922 онд нас барахад түүний эдлэн газрыг хэн нэгэн худалдаж аваад хэсэглэн зарах вий гэж айсан бүлэг саятанууд нийлж, энэ эдлэн газрыг хувийн "Тимбер Поинтерс" клуб болгон хувиргав. Энд зөвхөн сонгомол хүмүүс ирнэ. Тэд гольф клубын хамгийн нэртэй дизайнер, гольфын мэргэжлийн дасгалжуулагч, шилдэг тогооч нарыг хөлсөлж, бас асар том усан сан байгуулжээ. Хөрш эдлэн газрыг зарахад нь бас худалдан авсан. Харуул хамгаалалт хөлсөлж, байшин дотор буга болоод зэрлэг гургуулын чихмэл өрөв. Гэтэл энэ бүхнийг жилд ердөө арван өдөр тохиодог ан авын улирал ба бас үл таних хүмүүстэй харьцахгүй байхын төлөө хийсэн байх юм. Тэд өөрийн хөршүүдтэйгээ зүгээр л танилцахгүйн төлөө асар их мөнгө төлжээ.



Жулия Робертс зочид буудалд буувал тааралдсан хүмүүс эгцэлж харах ч эрхгүй

Хэвшил тусгаарлалтыг дагуулдаг.

ЖулияРобертсзочидбуудалд "Флорида дахь Юпитер арал" гэх мэт буувал тааралдсанхүмүүс эгцэлж байгууллагын хамгийн гол дур булаах увидас нь харах ч эрхгүй тохь тухдаа биш тусгаарлалтад байгаа юм. Үнэн хэрэгтээ зөвхөн тусгай үйлчлүүлэгчдийн төлөө оршиж байдаг олон байгууллага бий. Хэдийгээр олонхи клубууд оршин буйгаа зөвтгөхийн тулд номын сан, баар, спорт клуб, гольф тоглож сурах дамжаа гэх мэт зарим нэг тохь тухыг санал болгодог боловч хамгийн сонгомол клубууд энэ тал дээр санаа тавьдаггүй. Вашингтоны алдарт "Альф-альфа клуб" бүрэн амьдралаар бараг амьдрахгүй. Түүний орших үндэс шалтгаан нь клубын гишүүдийн өрсөлдөөн билээ. Клубын уур амьсгал туйлын ялдам. Хэрэв энэ клубт хэдэн жил явчих юм бол дараа нь яг гэртээ байгаа юм шиг болдог.

Тусгай клубуудын хуурах арга нь мөнгөөр хүлээн зөвшөөрүүлэх аргагүй зүйлс бий хэмээх үзэл юм. Бүх юмтай хүнд хандаж, чиний хүрч чадахгүй тийм зүйл бас байна гэж хэлэх нь анхаарлыг нь татах найдвартай арга. Зарим ухаалаг сурталчлагчид олон нийтэд зориулсан нээлтийн үеэр сонгомол тооны хүмүүст мөн урилга тараадаг. Энэ тохиолдолд урилгатай хүмүүс хүндэт суудалд заларч бусад нь хаалганы дэргэд шахцалдах болно.

Тусгаарлалтын тусламжтайгаар иймэрхүү байгууллагууд нэр төрөө өндөрт барьж байдаг. Эмэгтэй ба эрэгтэйчүүдийн клубуудад хэрэгтэй элсэгчийг сонгох сайтар бодож боловсруулсан системтэй. Шөнийн цэнгээний газрууд хамба хилэн туузанаас цааш зөвхөн тусгай хүмүүсийг нэвтрүүлснээр нөхцөл байдлыг улайсгаж өгнө. Ресторануудад утасны нууц дугаар байх бөгөөд чухал хүмүүст зориулсан энэ дугаарыг зөвхөн онцгой чухал зоогийн үеэр хэрэглэж болдог. Нийгмийн амьдралд тохиолдож байгаа үйл явдлууд, гала концерт, буяны зоог юмуу үдэшлэг, үзэсгэлэнгүүд бүгд хоёр хэсгээс бүрдэнэ. Эхний хэсэг нь уригдагсдад зориулагдана. Хоёрдугаар хэсэг нь сонгомол хүмүүст зориулна. Тэгээд үндсэн шоуны өмнө юмуу хойно явагддаг. Та аль алинд нь уригдсан эсэхээ нягтлаарай. [Хэрэв үгүй бол очихгүй байсан нь дээр]

Зөвхөн танд зориулагдсан зүйлсийн дур булаам чанарыг өөртөө нээ. Дэлгүүрт моодонд ороод удаагүй байгаа нэг заншил бий. Худалдан авагчид дэлгүүрийн гол танхимд ордог. Харин нэртэй хүмүүсийг хүний нүднээс далд тусгай өрөөнд залж бараануудыг үзүүлдэг байна. Жирийн худалдан авагч ба өндөр захиалагчдыг ийнхүү хувааснаар моодны дэлгүүрүүд хүндэт худалдан авагчиддаа үзүүлэх тусгай үйлчилгээгээ баталгаажуулдаг.

Зөвлөмж: олон түмний үл мэдэх үйлчилгээний салбараас зайлсхий.

Гэвч тусгаарлалтад бас хил хязгаар бий. Тэрбумтан Хьюзенг хамгийн алдартай гольф клубын гишүүн юм. Тэрбээр энд цай уух юмуу өөртөө тааламжгүй хүнтэй харилцах, тоглох вий гэж хэзээ ч айхгүй.

Хэвшил нь шийдвэр гаргах шаардлагаас таныгангижруулна. Та юу хийх хэрхэн биеэ авч явахаа мэдэж байгаа. Таны танилууд Палм-Бич, Хилтон-Хэд юмуу Сан Вaleyд амрахаар явж байна уу? Тэд үргэлж олны нүдэнд ил байх ёстойдоо тэр. Ингэхэд таны эдлэн хаана билээ? Монтанад билүү, эсвэл Йомингод уу?

Хэвшлийн сүүдэртэй тал

Хэвшил өөрийн үнэ цэнэтэй. Заримдаа танай хүрээнд тогтсон дүрэм горим ба биеэ авч явах тодорхой загварыг мөрдөх хэрэгтэй болдог. Жишээ нь та хар зангиа юмуу нарны шил зүүхэд хүрнэ. Явцуу хүрээнд хашигдсан мэт мэдрэмж байсхийгээд л төрдөг. Хэрэв тийм бол та сонгосон чиглэлдээ арай л хол явчихжээ. Та стандарт ба болзол нөхцөлийг баримтлах хэрэгтэй.

Гэтэл хэрэв та олонд танигдахыг хүсэхгүй бол нэр алдар танд тааламжтай санагдахгүй. "Жилийн улирлууд" зочид буудлынхан өөрийн үйлчлүүлэгчдийг нэрээр нь мэдэх ба хэзээ ч тэдэнд зүгээр ноён юмуу хатагтай гэж ханддаггүйгээрээ бахархдаг. Гэтэл энэ нь танд тааламжгүй байж ч мэдэх юм.

Тансаглал

Яагаад хүмүүс тансаг эд зүйлст мөнгөө үрдэг юм бэ? Тансаглал гэдэг нь бүх хэрэгцээгээ, түүний дотор агуу хүсэл юмуу өчүүхэн жижиг янтгар зангаа ч хангах боломж юм. Энэ янтгар зангийн үнэ цэнэ хэд байх нь огт хамаагүй. Ерөөсөө үнэ бол юу ч биш. Телевизийн алдарт продюссер Аарон Спеллингийн эхнэр Кэнди Спеллинг түүний унтлагын өрөөний цонхоор рекламн самбарын ион гэрлүүд харагдаж байхыг үзээд бараг баригдаж дууссан барилгыг өөрчлөн бариулж, 10 фут намсгасан байдаг. "Нью-Йорк геральд"-ын эзэн Жеймс Гордон Беннет нэгэн удаа Монте-Карло дахь дуртай ресторандаа ширээ захиалж чадсангүй. Тэгэхээр нь тэр дор нь рестораныг бүхэлд нь худалдан авч тэнд байсан бүх

"Винсентнийгмийнхуулиудыг мөрдөхийг үзэж чаддаггүй байлаа. Арчер болохоор үргэлж фрак өмсөх бөгөөд түүнийгээ биед эвтэй ба нарийн уртайд тооцно. Тэрбээр биед эвтэй ба нарийн уртай байх нь ямар ч худалдан авалтын үед онцлох ёстой хамгийн чухал үзүүлэлт гэж тооцно. Харин Винсентийн хувцасанд хандах хандлагыг бурханлиг гэж үзэх бөгөөд дээдсийн хүрээнийхэн ийм л байдаг бөгөөд хувцасаа дуугүй л сольж, гэрт байгаа зарцын тоо хэтэрсэн тухай яриагаараа залхаадаг. Тийм ч учраас тэр бусдаас энгийн ба дарууд тооцогддог байв"

Эдит Уэрстон "Буруугүйн зуун"

үйлчлүүлэгчдийг хөөж гаргаад сууж хоолоо идсэн ба гарахдаа үйлчлэгчийн гар цайлгасан аж. Тэр хүссэндээ хүрсэн.

Тэгвэл тансаг эд зүйлс авах боломжгүй нэг нь дууриамал бүхнийг мэдэх хэрэгтэй. Тэд гадаад төрхдөө анхаардаг учраас нүдэнд өртөхүйц эд зүйлст онцгой анхаарч, харин нүдэнд өртөхгүй зүйлсийг мартдаг. Эд баялаг ба тансаглал нь танд хаана ч сайхан харагдах, өнцөг булан бүрт тохь тухтай байх боломж олгоно. Одоо та сайтар бодож сонгосон гоёмсог унтлагын хувцастай болжээ. Та ноолууран бээлийтэй. Танай гэр бүлийн гишүүн бүр өглөөний өөр өөр сонин уншдаг. Хямд ном худалдан авах юмуу зочид буудлын шампунь ашиглах хэрэггүй болсон. Тэргүүн хатагтай Жаклин Кеннеди орны цагаан хэрэглэлээ өдөр бүр биш хэвтэх болгоныхоо дараа сольдог байжээ. Түүний гэрийн үйлчлэгч нь "Хатагтай Кеннеди шинэхэн даавуунд дуртай" гэсэн байх юм.

Тансаглалын гялбаа таны хамгийн ер бусын хүслийг гэрэлтүүлдэг. Загвар зохион бүтээгч Кельвин Клайн нэгэн удаа өөрийн лимузиныг ээжийнхээ гэр рүү тогоотой шөл авчруулахын

төлөө явуулжээ. Ээж нь лимузины арын суудалд цорын ганц зорчигч болон тухтай аялсан гэдэг. Загвар өмсөгч Тьерри Холлэдэй Хонконгийн алдартай хүүхэмсэг эр Сесил Чаогийн эхнэр болжээ. Нөхөр нь түүнээс хоёр дахин өндөр настай байв. Хатагтай төрөлх Майми хотын захад зардаг онцгой шоколадаа санан бэтгэрэв. Тэр хүүхэд байхаасаа энэ шоколаданд дуртай байсан ба Хонконгод энэ шоколад байгаагүй нь ойлгомжтой. Тэгээд гарах гарц олсон нь дуртай шоколадаа шуудангаар захиалсан явдал. Тэрбумтан Кристина Онассис бас нэг ийм асуудалтай тулгарчээ. Ертөнцийн нөгөө хагаст байхдаа дассан америк хүнсээ олох гээд чадсангүй. Францад байхдаа дуртай дарсаа олж чадахгүйн улмаас тэр Нью-Йорк руу долоо хоног бүр хүн илгээж авхуулж байв. Парижийн "Авеню Фох" зочид буудлын ахлах үйлчлэгч Ив яагаад лонхнууд буцаагдаад байгааг тусгай хүргэгч Хеленээс асуухад хатагтай өөр дарс хүсэхгүй гэсэн хариулт сонссон байдаг. Дарс бүрийг нямбайлан хүргэдэг ба авчруулсан дарс нэг бүрийн үнэ нь 300 доллар байв. Ингэхэд та яагаад өөрийн дадал зуршилыг дагаж болохгүй гэж?

Дүрэм

Хэт том юмуу хэт жижиг хүсэл гэж байдаггүй.

Хэтэрсэн тансаглал

Та өөртөө хэр ихийг зөвшөөрөх боломжтойг даган таны хүсэл өөрчлөгдөж байдаг. Өмнөх хүсэл мөрөөдөл хүрч хангагдсан ба тэдний оронд шинэ хүсэл мөрөөдлүүд бий болно. Таны хэрэгцээ байнга өснө. Олонхи хүний хүсэл сонирхол санхүүгийн боломжоор хязгаарлагдаж байдаг. Гэвч нэг л удаа та мөнгөний хязгаарлалтаас чөлөөлөгдөж чадвал тэсвэр алдам үнэтэй эд зүйлс худалдан авч, тансаг эд зүйлсийн хэрэгцээгээ хангахад мөнгөө үрэхийг өөртөө зөвшөөрдөг.

Та аз турших, гаж байхыг мөрөөддөг үү? Яаж? Та дараа нь шаналах, нулимас асгаруулах тийм нэг ч зүйл битгий хийгээрэй. Таны алхам бол аргагүй шаардлагатай зүйл биш бөгөөд зүгээр өөрийгөө илэрхийлэх илэрхийлэл юм. Саятан бүсгүй Лайла Эчесон Уеллейс зөв алхам хийсэн. Тэрбээр "Метрополитэн" музейд зөвхөн шинэ цэцэг авахад зориулан 4 сая доллар бэлэглэсэн байдаг. Гайхалтай буянтай бас өгөөмөр алхам.

Таны тансаглал мөнгө ба цаг хугацааг тооцохгүй байх боломжийг танд олгоно. Үнэн хэрэгтээ та огт хэрэгцээгүй маш олон эд зүйлстэй болно. Олонхи хүмүүс хэр зэрэг мөнгө үлдсэнээ байнга шалгаж, арай хямдыг нь сонгож, ямар нэг зүйлд өөртөө татгалзаж байдаг ч та бол үгүй. Та юугаар ч дутахгүй.

Дүрэм

Хувийн онгоц хэр том байхын хэрээр зорчигч нь цөөн байдаг.

Хэмнэх талаарх таны үл тоомсорлол хүрээлэн буй хүмүүст янз бүрийн мэдрэмж төрүүлдэг. Хэрэв та зардлаа нуух далдлах оролдлого хийхгүй бол иймэрхүү байдал нь хүмүүсийг шоконд оруулж тэдний зүгээс эвгүй хандлага дагуулна. Зардлаа ухаалаг хүрээнд барих хэрэгтэй. Бусад хүмүүсийн зүгээс эвгүй хандлага төрүүлж азаа үзэхгүйгээр мөнгөө үрээрэй.

Тэгээд яавал зөв гэж? Зэвүүцлийг зөөлрүүлэх ба зардлаа хэрхэн бага харагдуулах талаар долоон дүрмийг бид танд барьж байна. Дараах жишээнүүдээс хэрэв таны орлого маш их бол энгийн өнгөлөн далдлалт тус болохгүй гэдгийг та харах болно.

Орлогоо нуу

57. Энгийн

58. Хязгаарлагдмал

59. Давхцал

60. Эмх цэгц

61. Хөдөлгөөн ба хувиарлалт

62. Жижиг сажигт тэмүүлэгч

63. Бэлэг

1. Орлогоо бага харагдуул - энгийн байх. Та энгийн дуртай гэж дандаа ярь. |Танай гэр тун энгийн. Гэхдээ ийм байдал танд хэрэггүй. Учир нь гэр цэвэрлэх үйлчлэгч зэргийг хөлслөх шаардлагатай|.

Саятан Лэрри Эллисон Сан-Франциско дахь шинэхэн байшиндаа япон хэв загварын төслийг сонгожээ. Мод, модон доторлогоо, дотоод модон тавилгууд гэх мэт. Зочид нь түүний даруухан таашаалыг мэдрээсэй гэжхүссэн тухайгаа Эллисон ярив. Гэхдээ энэ даруухан байшин нь ямар үнэтэй юм дээ? 40 сая доллар.

Загвар зохион бүтээгч Кельвин Кляйн шалан дээрээ модон хөвөөтэй зүгээр л аятайхан байшинтай болохыг хүсэв. Тэрбээр тохирох модыг олж авч чадахгүйн улмаас ажилчдын бүхэл бүтэн багийг умардын ойгоос онцгой төрлийн мод олуулахаар илгээсэн ба тэр нь 300-аас дээш настай мод байх учиртай. Вермонт дахь ферм дээр энэ модыг олсоны дараа огтолсон модыг мод зүсэх үйлдвэрт илгээж, тэнд бүгдийг нь дугаарлаж, банзны бүх загварын зургийг татаж, Кляйн өөрөө нэг бүрчлэн үзсэн байна. Бүх материалыг тусгай лакаар хучиж, бүх мод шаардагдах өнгөтэй болмогц хөвөө хийж бас нойлын суултуурыг адил өнгөөр будсан байдаг.

Аннетта де ла Рента охиныхоо хуриманд хурим хөгжөөгч Изабель Робертыг урьжээ. Энэ хуриманд дээдсийн хүрээлэнгийн 5 мянган зочин цугласан байна. Газар сайгүй цэнхэр өнгийн хивс дэвсч "Вог" сэтгүүлийн гэрэл зурагчид найрын эзний сэтгэмжээр бүтээгдсэн Оскар де ла Рентагийн хувцаснуудыг өмссөн зочдын зургийг тасралтгүй дарж байлаа. "Энгийн байх хамгийн хэцүү гэж" хурим Изабеоь хөгжөөгч онцолж байв.

2. Орлогоо бага харагдуул - Давхцал. Мөнгөө өгөөд бүхний хэрэглэдэг эд зүйлсэд анхаарлаа хандуул. Ердийн эд зүйлс, даруухан эдлэн газар ба өмч хөрөнгө худалдан ав. Жишээ

Урилгыг өөрийн баян тарганыг гайхуулах нэгэн хэрэгсэл болгохдоо хэвлүүлэх юмуу гараар

бичих хэрэггүй. Уран бичлэгийн мэргэжилтэн урьж бичүүлээд хувийн шуудан хүргэгчээр хүргүүлбэл зохино. Гэхдээ заримдаа энгийн шуудангаар илгээх нь үр дүнтэй байх нь бий. Дээдсийн хүрээлэнгийн хайртай эрчүүдийн нэг Бейө Палей энэ талаараа тун нэртэй байсан.

Өөрийн байшинг барих хүсэл нь хүн бүхэнд төрдөг мөрөөдөл. Саятан эмэгтэй Айра Реннет тун жижиг талбай дээр өөрийн байшинг босгож эхэлсэн ба тун удалгүй олон нийтийн ярианы гол сэдэв болжээ. Учир нь тэрбээр байшиндаа 29 унтлагын өрөө, 30 ванны өрөө, 11 танхим, хоёр номын сан, 100 гараж байрлуулахаар төлөвлөсөн байв. Байшингийн эргэн тойронд боулингийн зам, теннисний талбай, сагсан бөмбөгийн талбай, хүүхдийн тоглоомын талбай, спорт танхим ба билльярдын өрөө байжээ.

Хью Хефнерийн хувьд хувийн авиа компанитай болох нь хангалтгүй санагдав. Учир нь олон баян хүмүүс ийм юмтай байдаг. Түүний "Биг Бани" нэртэй тийрэлтэт онгоц бол дэлхийд давтагдашгүй. Яагаад гэвэл энэ онгоцонд бүжгийн танхим, ванны өрөөнүүд, зуйван хэлбэртэй унтлагын өрөөнүүд байх ба ханыг нь хар савхиар доторлож торгон даавуугаар ороо бүтээжээ. Онгоцны үйлчлэгч бүсгүйчүүд бүгд өндөр өсгийтэй гутал ба мини юбкатай. Хефнер тийрэлтэт онгоцоо зүгээр л нэг тогтой унаа гэж байнга нэрлэдэг.

Элтон Жон дөрвөн байшингийнхаа хамгийн дуртай нэгний бүх өрөөнд шинэхэн цэцэг тавьдаг. 100 өрөөний цэцгийг шинэчлэхийн тулд хоёр цэцэгчин долоо хоногийн турш тасралтгүй ажилладаг байна.

3.Хөрөнгө зоорио бага харагдуул - Давхцал. Өөрийн хэрэгцээг өөртөө таашаалтайгаар хангахын тулд хөрөнгөө юунд үрж болохыг хар. Жишээ

Сюзанна Гатфройнд ванны өрөөндөө кондиционер байрлуулж үнэртэй усны үнэрээ түгээдэг байв.

Силикон хөндийн нэртэй баян тэрбумтан Жим Кларкусан сангийн байрлалаа хэд хэдэн удаа сольж тухай бүрт газар ухаж байлаа.

Ноён Дильюм Рандольф Хат зарц нарын бүхэл бүтэн армитай байв. Тэдний дотор нохойн хоол бэлдэх тогооч, нохойн үйлчлэгч хүртэл байжээ. Бас нэг саятан шувуунд нь сахартай ус бэлдэхэд зориулан зарц хөлсөлдөг байсан.

Та өөрийгөө улам хүн их хүндлүүлэх, таны эд баялгийн тухай бодонгуут хөл нь салгалахад хүргэхийн тулд байгалийн хуулийг ч зөрчиж болно.

Продюсор Аарон Спеллингийн эхнэр Кэнди хэдийгээр халуун бүсийн Өмнөд Каролинд амьдарч байсан ч хүүхдүүддээ зориулан жинхэнэ цастай шинэ жил тэмдэглэхээр шийджээ. Тэгээд хэдэн тонн цас авчируулж шөнө хүүхдүүд унтаж байхад байшингаа тойруулан асгуулж байв.

Нью-Йоркийн нэгэн баян ганцхан шөнийн дотор цэцэрлэгээ өөрчилжээ. Зочид орой унтахдаа цагаан цэцэг дүүрэн ургасан цэцэрлэгийг цонхоор харсан юм. Харин өглөө сэртэл цул ягаан цэцэг байжээ. Цэцэрлэгчид бүхэл шөнөжин ажиллаж ягаан цэцэгтэй ваарнууд өрсөн байна.

4. Орлогоо бага харагдуул - Эмх цэгц. Таны эргэн тойронд зөвхөн эмх цэгц ба ариун цэвэр ноёлохыг шаардана. Жишээ

Английн хатан хааны ордны бүх зарц нар ижил өндөртэй байх ёстой. Ер нь англи сурвалжтануудын хувьд эзэн баян байхын хэрээр зарц нар нь өндөр байдаг. Учир нь зарц нар 6 футаас өндөр хана ба тавилгуудыг цэвэрлэхэд хүрдэг байна.

Лондоны саятан Адели Хетерийн байшинг Трек" гэж нэрлэдэг. Учир нь тоосгон замын хоёр талаар усан үзмийн бут ургадаг. Харин зам дээр усан үзмийн толбо тогтвол саятан тун дургүй учраас зарц нар нь өдөрт гурван удаа замыг цэвэрлэдэг байна.

Виндзорын герцог ахайтан хоол идэх зуураа амны цаасыг хоёр удаа солих, өдөрт гурван удаа үс засалтаа солих ба гутлынхаа улыг өдөр бүр угаалгадаг.

б. Орлогоо бага харагдуул - Дахин хувиарлах. Хайртай дотно хүмүүс, зарц нарын төлбөр ба хүүхдүүддээ их мөнгө зарцуул.

Боксын спортын агент Вильям Наклональд охиндоо зориулан ургаа модны хөндийд байшин хийжээ. Энд хөшиг, хивс гээд ягжинхэнэ байшин шиг бүх юм л байлаа. Харин 8 нас хүрэхэд нь хөгжим тоглуулагч бэлэглэсэн юм.

Тоглоомын дэлгүүрийн эзэн Шварц 15 хүүхдэд зориулан үлгэрийн мэт аялал зохиож 17 мянган доллар үржээ. Хүүхэд болгонд тоглоом дүүртэл чихсэн үүргэвч бэлэглээд дараа нь дэлгүүр дотуур зугаалуулсан бөгөөд харин шөнө дунд кино үзүүлж бас хүүхэд бүр цаашид ийнхүү дэлгүүрээр явах эрхтэй болжээ.

Брунейн султан нэгэн удаа "Жилийн улирлууд" зочид буудлын үйлчлэгчид цайны мөнгө хэмээн 170 мянган доллар хаяжээ.

Лос-Анжелесын баячууд ресторанаас гарахдаа тооцоотойгоо яг ижил хэмжээний мөнгөөр үйлчлэгчийн гар цайлгадаг бөгөөд ингэснээр мөнгөтэйгээ харуулах болон дараагийн удаад өндөр хэмжээний үйлчилгээ авах зорилго өвөрлөдөг.

Загвар зохион бүтээгч Рентагийн нохой арлын нэгэн улсад явж байхдаа хархны хор идэж хорджээ. Эзэн нь нохойгоо аврахын тулд Америкаас тусгай онгоцоор амьтны эмчийг нэг цагийн дотор авчирсан байна.

Дэлхийн хамгийн баян хүмүүсийн буудаг "Жилийн улирлууд" зочид буудлын өрөөнүүд зочныхоо амьтадад зориулсан тусгай өрөөтэй бөгөөд мөн тусгай гал тогоотой. Тусгай жороор бэлдсэн халуун хоол эсвэл лаазалсан бүтээгдэхүүн юмуу жигнэсэн будааг амьтадад өгдөг байна.

б. Орлогоо бага харагдуул - Жижиг сажигт тэмүүлэгч. Юм болгон дээр бүрэн дуусаагүй ул мөр үлдээх хэрэгтэй. Жишээ

Найруулагч Жорж Лукас 1800 ажилтныхаа жорлонгийн суултуурыг үнэтэй модоор хийлгэжээ.

Хатан хаан Элизабета цагаан арьсан суултууртайгаа аялдаг байна.

7. Орлогоо бага харагдуул - Үдэшлэг найр зохиож бэлэг өг. Бусад хүмүүсийг эд баялаг ба мөнгөөр бул. Тэр цагт та хүмүүст хувиа хичээгч мэт харагдахгүй. Учир нь та бусад хүмүүст их мөнгө зарж байна шүү дээ. Жишээ

1980 онд Steinbergийн нөхрийн төрсөн өдөрт зориулсан нэгэн нэртэй цэнгүүн болжээ. Эхнэр нь тэгэхэд нэг сая доллар зарсан байдаг. Харин охиных нь хурим асар их зардалтай болсон учраас энэ тухай мэдээллийг гадагш ярихгүй байхыг бүх оролцогчидод анхааруулсан. Гэвч тэд итгэл алдаж мэдээ цацагдсан ба зөвхөн цэцэг нь гэхэд нэг сая доллар зарсан байжээ.

1990 онд Австралийн хамгийн баян хүн Пакерын хүүгийн хурим болсон бөгөөд таван сая доллар зарсан байна.

Нөгөө талаар үнэтэй бэлэг сэлт нь нийгэм дэх холбоо сүлбээг бэхжүүлэх ба шинэчлэхэд хэрэгтэй. Тийм ч учраас хүмүүс их хэмжээний өр ширэнд ордог. Та бэлэг түгээх замаар өөрийн нийгмийн хөрөг ба имижийг бүтээж болно. Тэр тусмаа таны өгсөн бэлэг нь авч хүний таашаалыг мэддэг гэдгийг харуулж байвал бүр сайн.

Эд баялгийн өмнө салгалан чичирэх байдал нь түүний хэт илүүдэл ба хэрэгцээгүйгээс үүсдэг. Та тансаглалаа харуулахын тулд мянга мянган доллар үрэх хэрэггүй. Заримдаа таны хүрээллийн хууль цаазыг зөрчихөд хангалттай. Таны үйлдэх "Гэмт хэрэг" нэг иймэрхүү байж болно. Та гэнэт шинэ гал тогооны тавилгыг үзэн ядаж өөрийг захиалах ба өнгө нь шалтай хослох ёстой гэж шийднэ. Эсвэл өөрөө нохойгоо салхинд гаргахгүйн тулд хөрш айлын хүүг хөлсөлж нохойгоо салхинд гаргуулаарай. Кофе ба амттаныг ресторанд хүртэхийн оронд гэртээ захиалж болно.

Гэвч таны хувьд орлогоо бага харагдуулах хэрэггүй байж болох юм. Та хамгийн аймаар зэвүү хүрмээр аргуудаар өөрийн тухай ба эд хөрөнгийнхөө тухай яриаг өдөөж, хүмүүсийн дургүйцлийг төрүүлэх дуртай байж болно. Энэ нь сүйрэлд хүрэх зам.

Сүйрлийн хамгийн зөөлөн хэлбэр нь зүсэн зүйлийн зардал үрлэг юм. Эдвард хаан усан онгоцоор аялах үедээ гольфын 3 мянган бөмбөгийг хашлага давуулан цохисон байдаг. Тэр биеийн галбираа алдахгүйн тулд дасгал хийж байгаа нь тэр.

Бөмбөг усанд унах бүрт тэр "Надад дуу нь таалагдаж байна" хэмээн дуу алдаж байжээ. Тэрбумтан Хьюгс мөнгө ба найз нөхдийг тараан цацдаг байв. Тэр өөрөө хэзээ ч амьдарч байгаагүй байшингуудаа түрээслүүлдэг. Бүрэн тавилга тавьж зарц нарын бүхэл бүтэн армийн хамт хөлсөлдөг байжээ. Тэрбумтан дөнгөж шинээр эхэлж буй залуу жүжигчдэд эдгээр байшингаа өгөх ба түүнээс гадна жолоочтой машин бэлэглэж, банканд данс нээж өгдөг байсан. Тэр өөрөө тэдэн дээр хэзээ ч очдоггүй байлаа. Гэхдээ өөр хүмүүсийг ч очуулахгүйн тулд хувийн мөрдөгч хөлслөн ажиглалт хийлгэдэг байсан.

Мөнгийг иймэрхүү байдлаар үрэх нь та өөрийгөө баян хэмээн дохио өгөх гайхалтай арга юм. Дьоннелийн "Бидэн шиг хүмүүс" номын гол баатрын эхнэр нь нийгэмд ахин дэвших замаа дөнгөж эхэлж байгаа нөхөртөө "Элиас минь ресторанд хооллохдоо таваг дээр байгаа бүхнийг

идэж болохгүй. Багахан шигийг үлдээх ёстой" гэдэг. Харин нөхөр нь яг л Скарлетт О Харагийн адил өлсгөлөн учир тэгэж чадахгүй хэмээн эсэргүүцдэг. Тэгэхээр эхнэр нь ресторанд явахын өмнө түүнд гэртээ хоол хийж өгөх болно гэж хэлж байна. Энэ тохиолдолд нөхөр нь ресторанд үйлчлүүлж буй бусад хүмүүсийн адил хоолыг идэх биш тонших болдог.

Мария Антуанеттатай тохиолдсон явдал

Хүмүүсийн хүндэлж байгаа юмуу эсвэл таашаахгүй байгаа зүйлс тэдний хараанд өртдөг гэдгийг хэзээ ч бүү мартаарай. Яагаад ч юм хүмүүс үүнийг мартчихдаг. Одоо "Мария Антуанеттагийн өвчин" хэмээн хэлц үг болсон тэр зүйлээс зайлсхийх хэрэгтэй. Францын алдарт хатан хаан Мария Антуанеттагийн нэг удаа хэлсэн үгнээс болж энэ хэллэг бий болжээ. Тэрбээр хэлэхдээ: "Хүмүүс идэх талхгүй гэх юм. Тийм бол бялуу идэг л дээ" гэсэн гэдэг. Хэрэв та бүдүүлэг харагдахуйц санамж хэлэх юмуу дохио зангаа хийх аваас Мария шиг байдалд орно. Ингэснээрээ та үнэ цэнэт зүйлсийг үл тоож, бас ёс суртахууныг уландаа гишгэсэн гэдгээ харуулж байгаа хэрэг.

Маш болгоомжтой байх хэрэгтэй. Ялангуяа ёс суртахууны сэдэв хөндсөн аливаа үгийг хэлэхдээ дээрх өвчний тухай санаж байгаарай. Хүрээлэн буй орчныг хамгаалах Медиа нийгэмлэгийн болгоомжгүй үйлдлийн тухай жишээг мөн санаж яваарай. Тус нийгэмлэг америкчуудад хандаж хүрээлэн буй орчинтой ухамсартай харьцахыг уриалсан юм. Энэ нь тэдний алдаа байлаа. Учир нь анхны уулзалт дээр л өндөр тушаалын түшмэд өөрсдөө хар утаа яндан шиг хаях аварга том лимузинууд хөлөглөн ирсэн учир тун нийцгүй харагдаж байв.



Нэнси Рейган

Ерөнхийлөгч Рейганы засаглалын үед мөн л Мариягийн өвчнөөс болж хүнд асуудлууд үүссэн. Тэргүүн хатагтай Нэнси Рейган төрийн шаазангийн цуглуулгыгхувьдаа авах зөвшөөрлийг Цагаан ордноос хүссэн юм. Ганц цуглуулга нь гэхэд хэдэн мянган долларын үнэтэй. Зөвхөн нэг цуглуулга нь 220 иж бүрдэлтэй. Үүнд долоон төрлийн таваг, эрдэнэ шиш идэхэд зориулсан аяга, жимс идэх аяга, коктейлийн гэх мэт зүсэн зүйлийн бүрдэлтэй. Таваг нэг бүрийг гар аргаар хийсэн ба тавагнууд нь хурц улаан хүрээтэй, давхар хүрээ бүхий ирмэгтэй. Аяга болгон дээр ерөнхийлөгчийн алтан тамга дарагдсан байдаг. Дараа нь болсон үйл явдлаар өвчин илэрсэн юм. Нэнси энэхүү төрийн иж бүрдлийгхудалдан авснаа зарласан тэр өдөр ерөнхийлөгч Рейган дунд сургуулийн хүүхдүүдийн үдийн хоолны санхүүжилтыг хассан тухайгаа улс орон даяар зарлажээ. Энэ давхцал мэдээж анзаарагдахгүй өнгөрөөгүй. Рейганы хуучин андуудын нэг Чарльз Вик мөн л өнөөх алдарт өвчинтэй амьдралдаа нүүр тулсан

байна. Тэр өөрийн үзэл бодлыг илэрхийлсэн юм. Ширхэг зоос бүрийг хэмнэдэг америкчууд Их хямралын он жилүүдэд холливудын оддын тоглосон киног үзэн таашаал авдаг байснаас ч илүү өнөөгийн Рейганы захиргааны гишүүдийн тансаг амьдралыг харан таашаал авдаг гээд хэлчихжээ. "Баян хүмүүсийн сайхан амьдралыг харуулсан гайхалтай кинонууд тэдэнд таалагддаг" гэсэн байна. Ингэхэд ер нь олонхид амьдралын ямар хэв маяг тохирох вэ?

Мариягийн өвчин өөр хэлбэрээр илэрч болдог. Энэ нь зайлшгүй шаардлагатай зүйлийг хүртэл хэмнэх оролдлого юм. Цуутай саятан Рональд Перелман ба Патриция Дафф нар охиндоо өдөрт ердөө гурван долларын хоол хүнс зарцуулдаг.

Таны хэрийн нийгмийн байр суурьтай бөгөөд ойролцоо насны гадаад хүмүүсийг шоолох хэрэггүй. Хүмүүсийг доромжлох үед та өөрөө инээдтэй харагддаг. Тэрбумтан Трампын эхнэр асан Марла Мейплс зоог барих үедээ зарц нарыг тусгай дүрэмт хувцас өмсөн сандалын араар эгнэж зогсохыг шаарддаг байжээ.

Тансаглалын сүүдэртэй тал

Байнга таашаал авсаар хүн эцэстээ түүний сайхныг мэдрэхээ ч больдог. Таашаалын мэдрэмжээ алдах нь байнгын таашаалын салшгүй нэг хэсэг. Таны бүх хүсэл тэр дороо биелэгдэж байсны үр дагавар. Гүн ухаантан Ницше "Бид эзэн нь болсноор хөрөнгөө алж байдаг" гэж хэлжээ.

Хүслийг хойш нь тавих юмуу эсвэл тэр дор нь биелүүлж байгаа эсэхээс таашаал хамаардаг. Таны эрх дарх хүсэл биелэх хугацааг богиносгож өгдөг.

Дүрэм

Ханамж нь ханамжгүй байдлыг төрүүлдэг.

Та энэ арал дээр олонтаа ирсэн учраас одоо энэ аялал танд ердийн нэг амралт шиг л санагдах болжээ. Эргэн тойрноос та залхсан учир одоо ийш тийш огт харахгүй. Цаг агаар гайхалтай. Таны өрөө дээд зэргийн. Хоол ба зугаа цэнгэл үгээр хэлэх аргагүй. Гэвч энд таны үзэж хараагүй шинэ юм юу ч алга. Та кофе сулхан байна гэх юмуу агааржуулагч муу ажиллаж байна гэж буудлын даргад гомдол мэдүүлнэ. Тансаглалын нэг хэвийн байдал нь мэдрэмжийг мохоодог. Амралтын өдрөө арай өөр болгохын тулд та одоо юу хийх вэ?

Хүсэл тэр дороо биелэх нь таашаах мэдрэмжийг үгүй хийдэг. Хэрэв ийм цаг ойртож байгааг мэдрэх аваас доорх алхмуудыг хийгээрэй.

Гүнжийн зовлон

Дахин таашаал мэдрэхийн тулд өөрийгөө ба өөрийн мэдрэмжийг ер бусын ханамжид сургах хэрэгтэй. Байнгын ханамж таныг явцуу хүрээнд хашдаг. Удалгүй та тэндээс мултарч чадахгүй болно. Та зөвхөн хамгийн шилдэгт дасчээ. Та үргэлж зөвхөн хамгийн шилдгийг эрж хайна. Дарс, тавилга, ариун цэвэр, эмх цэгц. Хааны гүнжийг ганц ширхэг вандуй хэрхэн зовоосон үлгэрийг санаж байна уу?

Ядуу зүдүүгийн таашаал

Хэрэв та баян байж залхсан бол ядуу болж тоглоорой. Бохир хувцас өмсч, өөр хүмүүстэй уулз. Баян хүний нэг хэвийн амьдрал таныг хэсэгхэн хугацаанд ч дахин ядуу болоход түлхэж байдаг. Та шинэ сэтгэгдэл шинэ бүхнийг эрж хайна. Танд шалиг завхай нүгэл хилэнц таалагдана. Та тун удалгүй ядуу амьдралын дэврүүн тэмүүлэл ба дур булаах чанаруудыг мэдэрч эхэлнэ.

Ердөө 100 жилийн өмнө ядуу даржин амьдрал моодонд байлаа. Тэр үед зочид уранхай навсархай болсон хувцас өмсч, саван юмуу нүүрсний хоосон хайрцагсандайлж, амны цаасны оронд сонин хэрэглэж, төмөр аяганаасууж, модон тавагнаас иддэг байв.

Цуутай хатагтай Стювесалт Филс Ньюпорт хотноо зарц нарт зориулан цэнгүүн зохиожээ. Энд ирсэн цэвэрлэгч, үйлчлэгч, цэцэрлэгчид бүгд дээдсийн хүрээллийн хатагтай, герцог ба гүнгүүдийн хувцасөмссөн байсан. Бусадтай адилхан харагдах нь инээдтэй байдаг. Тэр бүү хэл ядуу харагдах нь багагүй хөгжилтэй. Гэхдээ ядуугийн дүрд тоглож байгаа нь ойлгомжтой байх үед шүү дээ. Хуучин мэт харагдахжинс үйлдвэрлэлийн шинэ шугам нээгджээ. Гэтэл худалдан авагч нар ийм хувцасны төлөө өндөр үнэ төлөхөд бэлэн байна. Кельвин Кляйны "тансаг ядуу" стилиэр оёсон жинсэн хувцас хоёр мянган долларын үнэтэй. Хэрэв та мөнгөтэй бол ядуусын амралт зохион байгуулж болно. Цахилгаан ба усны холболтгүй харанхуй хонгилд хооллохын тулд тансаг гал тогоо ба хоолны өрөөгөө орхидог олон хүмүүс бий. Тэд ийм амралтын төлөө хэдийг ч төлөхөд бэлэн.

Дүрэм

Мөнгөөр бүхнийг тэр бүү хэл ядуурлыг ч худалдан авч болно.

Гэвч та болгоомжтой байгаарай. Үргэлжиймхэв маягбарихшаардлагагүй. Хэвлэлийн магнат Стив Росс эхнэр Кортнигийн хамт Италид Тоди цайзыг орчны тосгод ба газруудтай нь худалдан авчээ. Эхнэр нь энэ тухай хэлэхдээ "Нөхөр бид хоёр бидний цайз ба эдлэн газар сэтгэл татам даруухан гэж боддог" гэсэн юм. Үүнийг уншсан хэн нэгэн тэдний амьдран байгаа орон байр ядуу даржин харагддаг юм байна гэж бодох байх. Гэвч өмгөөлөгчийнх нь тайлбарлаж байгаагаар хатагтай эдлэн газраа даруухан гэж нэрлэхдээ ядуу даржин гэх утгаар биш харин хотод биш тосгонд байдаг гэсэн утгаар хэлсэн гэнэ.

xxx

Дохио өгөх ба хэрэгцээгээ хангах нь мөнгө байршуулах хоёр үндсэн арга. Гэвч та өөрийн хэрэгцээг хангахын тулд эд зүйлс худалдан авч мөнгөө үрж болно. Ийм хүсэл аяндаа хүчтэй шунал, тухайлбал эдийн шунал болон хувирдаг.

Ес дүгээр бүлэг

Мөнгө ба шунал

"Би мөнгөтэйсэн бол XIX зууны хуучин цаг ба зурагнуудын цуглуулгадаа зориулан урлагийн ховор бүтээл нэн даруй худалдан авах байсан".

Хэрэв мөнгө таны хувьд эдийн шуналаа хангахад хэрэгтэй бол та эд зүйлсэд хэт дурлах өвчнөөр зовж байна. Энэ тохиолдолд эд зүйлс танд зайл шгүй хэрэгцээтэй юмуу эсвэл дохио өгөхийн тулд биш өөрөө хэрэгтэй ажээ. Ноён Жорж Вэй эд зүйлсийн татах хүчинд бүрэн автсан. Нью-Йоркийн саятан бизнесмен тэрбээр бүх цаг ба мөнгөө үнэт эдлэл болоод 16-17-р зууны үеийн зураг худалдан авахад үрдэг. Тэгээд тоосонд дарагдсан гурван өрөө байрандаа бүгдийг нь хураагаад л байдаг.

Та эдийн шуналтай гэж итгэхээсээ өмнө сайн бодоорой. Энэ нь дохио өгөхийн тулд эд юмс худалдан авах ердийн хүсэлтэй тун адилхан. Танд босоо улаан судалтай "Прада" брэндийн гутал таалагддаг байя. Энэ нь эдийн шунал мөн үү? Аль эсвэл энэ нь хурц тод дохио юу? Эдийн шуналаар өвчилсөн эсэхээ мэдэхийн тулд та дараах сонжоог ашиглаарай.

Сонжоо

Хэрэв таны өмнө "Монт Бланк" брэндийнхтэй яг адил мөртлөө "Монт Бланк" гэсэн бичиггүй үзэг байвал та худалдаж авах уу?

Та үнэтэй чанартай эд зүйлсийг өөрийн болгох ухаангүй хүсэлд автах мөртлөө ердийн данх, үзэг юмуу сойзонд огтхон ч тоомсоргүй ханддаг уу?

Таны хүрээний хүмүүсийн сонгодог цаг, үслэг пальто, спортын машин зэрэг нь таны мөрөөдлийн эд зүйлс мөн үү?

Давтагдашгүй сам юмуу гоёмсог шүхэр хэрэглэх нь танд илүү таалагддаг уу?

Хэрэв та бүх асуултанд "тийм" гэж хариулсан бол эдийн шуналгүй хүн. Гэтэл эдийн шуналтайг тогтоох сонжоо гэж байдаг уу? Та сонжооны тусламжтай дохио өгөх хүслээ тодорхойлж болно. Хэрэв та эдийн шуналтай бол бусдад гайхуулах тэмүүлэл үгүй. Энэ бол зүгээр л сайхан эд зүйлсэд шунах явдал юм.

Хэрэв танд эдийн шунал цэвэр утгаараа үгүй бол та эд зүйлсийг үнэлэхийг хэзээ ч суралцаж чадна. Худалдааны ажилтан юмны материал, бүрхүүл ба эд ангийг үнэлдэг. Галерейн эзэн зураачийн авьяас чадварын тухай ярина. Харин загвар зохион бүтээгчид гоёмсог хийцтэй буйданг шууд л анзаарна. Та ч бас гоо сайхныг олж харж эд юмсыг үнэлж чадна. Эсвэл та хүслээ хязгаарлаж бас болно. Виржиния Вульф бичихдээ "Бичих хэрэгцээ гармагц би хүчээр хувцасны тухай боддог. Тэгэхэд бичих хүсэл маань мэдрэгдэж онгод орно. Хувцаст дурлах миний хайр надад хүч өгдөг. Гэхдээ энэ бол хайр биш л дээ. Энэ юу болохыг нээх хэрэгтэй" гэжээ. Эдийн шунал нь хангаж чадах аваас баяр хөөрийг авчирдаг. Харин хүссэн зүйлээ авч

чадахгүй сар жилээр хүлээх аваас уйтгар гуниг, дүйнгэ байдалд автдаг.

Хүрч чадахгүй байгаа эд юмс биднийг даллан дуудаж зовоон тарчлаадаг. Хуучин цаг цуглуулах хорхойтой нэгэн эр дэд ерөнхийлөгчээр нь ажиллаж байсан компаниасаа 12 сая 400 мянган доллар хулгайлж түүгээрээ 18-19-р зууны үеийн цагнууд худалдан авч цуглуулгаа нэмжээ.

Алдагдал бүхэн харуусал зовнил авчирдаг. Худалдан авч болох эд зүйлсийг хайн хүслээ шатаах хэрэг танд байна уу? Хүслээ дарахын тулд танд их мөнгө хэрэгтэй юу? Энэ эд зүйлийг анзаарч хараад хүсэхгүйн тулд олж харахгүй байх нь дээр ч байж болно. Зүгээр л гадуур алхаж, хүрэхийн аргагүй тийм эд зүйлсийг харна. Өсвөр насны хүүхдүүд шилэн хоргоны өмнө цуглажээ. Харин хаалттай хаалганы цаана тэднийг зүсэн бүрийн тоо томшгүй бараа хүлээж байна.

Хэдийгээр эд зүйлсийг эзэмдэх нь тухайн эзний ялалт омогшил мөн боловч та хэзээ ч түүний бүрэн эзэн болж чадахгүй. Та тэр эд зүйлийг эвдэж сүйтгэлээ ч эзэн нь болохгүй. Эд зүйлийг өөрийн болгох хүсэл нь түүнийг шатаах, сүйтгэх, устгах хүслийг төрүүлж байдаг.

Эд зүйлийг хайрлана гэдэг нь түүнийг үнэлнэ гэсэн үг.

Шуналын хэлбэрүүд

Шунал цэвэр утгаараа байх нь их ховор үзэгдэл. Голдуу янз бүрийн хэлбэрээр тохиолдоно. Энэ нь цуглуулах, дарж хураах зэрэг юм.

Дарж хураах

Энэ нь шуналын нэг хэлбэр. Хүүхэд наснаас үлдсэн дарж хураах тайлбарлашгүй мэдрэмж. Дарж хураах нь харамлахыг хэлнэ. Ямар нэг зүйлийг өөрийн болгохын тулд та үүнийг мэдэрдэг. Яагаад хүмүүст өөрт нь бараг хэрэггүй аяга таваг, цохиур, түлхүүрийн зүүлт гээд маш олон эд зүйл байдгийг үүгээр тайлбарладаг.

Дарж хураах нь янз бүрийн хэлбэрээр илэрхийлэгдэнэ. Жек Крэкерийн шагналаас эхлээд онгоцны нэгдүгээр ангиллаар нисч байгаа зорчигчдод өгдөг бэлэг гэх мэт. Хэрэв та өгөөмөр бэлэг тараалаа гэхэд энэ нь таны ач буянтайг бүгд анзаарч, сонин хэвлэлд бичнэ гэсэн үг биш.

Хэрэв та эд зүйлс хурааж эхлэх юм бол та тэнцвэрээ алдаж хил хязгаарыг давсан гэсэн үг. [Эд зүйлийн өндөр үнэтэй байх нь таны өмчлөх таашаалыг үгүй хийж чадахгүй] Харамлах дуу хоолойг сөрж зогсох боломжгүй. Та аль хэдийн хооллож, тэр бүү хэл амттан идсэн байлаа ч, дүүрэн зоог өрсөн ширээний ард суувал хүслээ ялан хооллохгүй байж чадахгүй. Зарц таны машиныг зогсоолоос авчирч өгөхдөө танд сарнай цэцэг бэлэглэлээ гэхэд хэдийгээр та гэртээ орохоосоо өмнө энэ цэцгийг цонхоор гаргаж чулуудах боловч бахдан баярлахгүй байж чадахгүй.

Хэрэв таны дотор дарж хураах шунал сэрсэн бол та ямар ч эд зүйл ба дайллагад тэсвэр алдана. Ли Глакспен навчин тамхи тараадаг зарц нарт смокинг өмсгөх зуршлаас татгалзахыг

хүсчээ. Хэдийгээр Глакспен зочдод навчин тамхи тараахыг болиулж зүрхлээгүй ч харин одоо зочид өөрсдөө навчин тамхи нэхэж эхлэв. Ер нь хүмүүс ямар нэг юмыг өөрийн болгохыг үргэлж хүсдэг. Хэд байх нь хамаагүй. Ерөнхийлөгч Рейган ба тэргүүн хатагтай Нэнси Рейган нар Цагаан ордны хоол унд, өрөө тасалгаа ба үйлчилгээний төлбөрийг хийх ёстойгоо мэдээд маш их гайхсан. Угаас баян хүмүүс дарж хураах тал дээр тун дуртай байдаг. Тэд бусад хүмүүсээс энэ талаараа хавьгүй илүү. Тэдний баримталдаг зарчим нь хэнд бүх юм байнав түүнд улам их ирнэ гэх аж. Бусад хүмүүсийн төлбөрөө хийх ёстой тийм эд зүйлс баян хүмүүст үнэгүй ирдэг. Сонин, хандивын бэлэг гэх мэт. Та хурим юмуу төрсөн өдрийн бэлэг сонгохдоо хэнд зориулж хамгийн үнэтэй бэлгийг авдаг вэ? Баян хүнд үү эсвэл ядуу хүнд үү?

Та дарж хураах мэдрэмжтэй юу? Та ямар нэг юмыг өөрийн болгох хүслээ мэдэрдэг үү? Зарим хүнд яг тэр өөрийн болгох үйл явц нь тун их таалагддаг. Эд зүйлсийг сонгонгоо худалдагчийн чалчихыг сонсох нь тун тааламжтай ч байж мэднэ. 10 өвлийн пальто, 100 хос гутал, хэдэн арван усны хувцас... Танд альхэдийн бараг хэзээ ч өмсөөгүй хувцас хунарын асар их хураалт бий болжээ. Хөрөнгө зoorь ингэж илэрдэг. Мөнгө ба өмч хөрөнгө таныг үргэлж өдөөдөг.

Сугалаанд дурлах нь мөн л хурааж дарахын нэг хэлбэр. Үүнээс болоод л хүмүүс телевизийн саятан шоу зэрэгт оролцдог. Сугалаа бол гэнэт баяжих тухай орчин цагийн үлгэр юм. Тэнгэрээс гэнэт тань дээр эд хөрөнгө асгаран ирэх тухай үлгэр, алтан солонго юмуу орчин цагийн алтан ээрүүлийн үлгэр.

Тэгсэн мөртлөө сугалаа нь бусад оролцогчдод дургүйцэх мэдрэмж өгдөг. Яахаараа бүх мөнгө ганцхан хүнд очдог юм бэ? Англи эр Вильям Хазлитт энэ мэдрэмжийг атаархал хэмээн нэрлэжээ. "Бид азтай тэр хүнд уур хүрдэг юм биш. Харин хожоогүйдээ уур хүрдэг". Жек Пот хожсон нэг нөхөр хоёр ширхэг радио станц худалдан авчээ. Гэтэл түүний мөрий хожсоныг радиогоор сонссон ажилтнууд нь хонжворыг нь бүх ажилтанд тэнцүү хуваахыг шаардан улмаар ажлаасаа халагдсан байдаг. Энэ мөнгө түүн дээр гэнэт асгарсан болохоор бусад хүмүүсийн оролцоо ч бас байгаа гэж тэр ойлгожээ. 2,8 сая доллар хожсон өөр нэг эмэгтэй сугалаанд орохын өмнө хүүгийнхээ найз залууг өөрийнх нь төлөө залбир хэмээн гуйсан байжээ. Гэтэл тэр залуу бас хожилд хамаатай гэж үзсэн байна. [Танай найз саятан шоунд хожсон гэж бодъё. Та утсаар түүнд зөв хариулт хэлж өгсөн байна. Тэгвэл та түүний хожилд өөрийгөө хамаатай гэж үзэх үү? Хожсон мөнгөний хэдэн хэсэг нь таных вэ?]

Сугалаанд хожсон хүмүүсийн нэгэн адил интернет тоглоомд хожсон хүмүүс ч атаархал төрүүлдэг. Бусад хүмүүсийг сугалаа сугалуулаад өөрсдөө мөнгө олдог залуусын тухай нийтлэл сониноор дүүрэн. Хэрэв тэд баяжиж чадаж байгаа юм бол та ийм гавьяагүй гэж үү?

Цуглуулга

Энэ нь эдийн шуналын нөгөө хэлбэр. Эд зүйлс цуглуулж дарах хачин хүсэл. Тэгээд цуглуулгаа нэмээд л байдаг. Таны цуглуулга даруухан |давс ба перецний цуглуулга гэх мэт| эсвэл маш баян |Жейри Сейфиндийн машины цуглуулга| байх нь хамаагүй та цуглуулгаа өргөжүүлсээр л байна.

Зарим цуглуулагчдын хувьд үйл явц өөрөө таалагддаг бол заримынх нь тухайд энэ нь эдийн шунал болон өсдөг. Эд зүйлст дурлах нь шунал болон хувирсан хүмүүс тухайн эд зүйлийнхээ

тухай маш ихийг мэддэг. Тийм хүмүүсийг бусдаас ялгахад тун амархан. Хэрэв цуглуулах дурлал тань эдийн шунал болсон аваас таны цуглуулга дууссан юмуу дүүрсэн гэж хэзээ ч ярихгүй. Жинхэнэ цуглуулагч хүрсэн газраа хэзээ ч зогсдоггүй.

Цуглуулагчийн бүх хүчийг та өөр урсгалд чиглүүлж болно. Та эд зүйл цуглуулахын оронд бүгдийг нь гаргаж чулуудаад жинхэнэ үнэтэй зүйл юмуу жинхэнэ олдворыг худалдан авч болно. Таны өмч хөрөнгө хангалттай болжээ. Мод юмуу цэцэгний цуглуулга тань өөрөө оршин тогтнож чадна. Хураах ба өсгөн үржүүлэхийн бахдалын оронд юмыг дуустал нь хийсэн гэсэн мэдрэмжээр таашаал авч үр дүнг нь бахдаж болно.

xxx

Эдийн шунал нь ховор тохиолддог. Харин харамч хахир хураах хүсэл бол илүүтэй. Олонхи хүмүүс ямар нэг юмыг нөөцлөх хүсэлтэй байдаг. Хүн болгонд өөрийн гэсэн нөөц бий. Гэвч нөөцлөх дур хүсэл цааш өсөн томорч өөрийг тань боомилж мэднэ.

Арав дугаар бүлэг

Мөнгө ба зoorь

"Би бол мөнгөө банкинд байршуулна. Хэсэг хугацааны дараа тийшээ утасдаад миний сая саяын тухай надад хэлэхэд таашаалтай сонсох болно".

Мөнгө нөөцлөх нь мөнгийг хадгалах хүсэл ба мөнгийг хайрлах явдал

юм. Хэрэв та мөнгөө хадгалах дуртай, үе үе тоолдог бол мөнгөний нөөцөө бүрдүүлэх ихэсгэх бүх боломж танд байна гэсэн үг. Олонхи хүмүүст нөөцлөх хүсэл байдаг ч зорилго болон өсөх нь ховор.

Мөнгө цуглуулах хүсэл ямар ч хэлбэрээр байж болно. Мөнгөө банкинд байршуулаад компьютерийн дэлгэц дээр гарч ирэх тооцоогоо харан сууж болно. Үнэт эдлэл, эд зүйлс юмуу үл хөдлөх хөрөнгө худалдан авах замаар мөнгийг эргэлтэнд оруулаад баярлаж болно. Хэрэв баян хүн мөнгө хурааж хадгалаад байвал таавар мэт хачин сонин санагдахгүй гэж үү? Тэдэнд хэмнэх ямар ч хэрэггүй шүү дээ. Тэгэхээр мөнгө хураах хүсэл нь хүний орлогоос үл хамаардаг бололтой.

Эд баялгийн бүх хэлбэрээс хамгийн шилдэг нь алт эзэмших явдал. Алт бол бүх үлгэрийн баатар, бүх хаад ба хан хөвгүүдийн түүхэнд өгүүлэгддэг зүйл. Алт энэ хорвоогийн хамгийн баян хүмүүст харьяалагддаг. Энэ нь эд баялгаа гайхуулах давтагдашгүй арга. Хураах зөн совиндоо хөтлөгдөн алтыг хамгийн санаанд оромгүй аргаар ашиглана. Нэрт загвар зохион бүтээгч Бриони алтан утсаар оёсон эрэгтэй костюм заржээ. Харахад зүгээр энгийн мэт боловч үнэн хэрэгтэй алтан утсаар оёсон байна. Тэгээд 14 мянган долларын үнэтэй. Та эд баялагт дуртай гээд ийм мөнгө үрж чадах уу? Тэгвэл "Шарвета" зангиа худалдан аваарай. 24 кратын цэвэр алттай 185 долларын үнэтэй зангиа.

Үнэт эдлэлүүд ч хүний тэвчээрийг бардаг. Тэд хүндлэх бишрэх мэдрэмжийг төрүүлнэ. Нэгэн рестораны зальтай эзэн ресторанд нь ирэх хүн болгонд алмааз бэлэглэнэ гэж амалжээ. Гэхдээ шагнал нь үзүүр дээр нь бяцхан алмааз суулгасан мянган ширхэг чигчлүүр гэдгийг хэлээгүй. Арван өдрийн дотор энэ ресторанд 10 дахин иххүн үйлчлүүлжээ. 5 кратын алмааз авсан үйлчлүүлэгчид сэтгэл хангалуун байсан гэдэг.

Мөнгө аль ч цаг үед ямар ч хэлбэрээр үргэлж үнэ цэнэтэй байсан.

"Калигула атга дүүрэн мөнгийг шунамхай шүүрэн авлаа. Мөнгө түүнийг дарж, жингээрээ дарж байв. Эцэстээ түүнд өвчин тусчээ. Тэр мөнгийг мэдрэхээ болив. Тэр мөнгийг дээш нь цацаж мөнгөөр усан оргилуур хийлээ. Тэр мөнгөн дээгүүр хөл нүцгэн алхаж алтан зоосон дээр өнхрөв". Тэр цагаас хойш юу ч өөрчлөгдсөнгүй. 100 жилийн дараа Энди Уорхолын найз нар төрсөн өдрөөр нь түүнийг мөнгөөр булсан. Манхэттений "Студи 54" шөнийн клубыг үндэслэгч Стив Рубелл мөнгө харахаар бэлгийн хүсэл төрдөг байжээ. Мөнгө хүнийг өдөөн хатгаж сэтгэлийн тэнцвэрийг алдуулдаг.



Сальвадор Дали зочид буудлын цонхоор мөнгө атган цацаж "сая дахин өсөөд эргээд ирнэ" хэмээн хашгирч байв

Хүмүүс мөнгийг биеэрээ мэдэрч болно. Тиймээс мөнгө ашиглах өөр нэг арга байдаг нь түүнийг устгах явдал. 10 жилийн өмнө Лонг-Айлендын нэгэн саятан 100 доллараар боосон навчин тамхи үйлдвэрлэжээ. Хеир Стюарт Хоулзман түүний авга ах нь түүнд хэрэв 35 нас хүрэхээсээ өмнө тогтмол ажил олж хийх юм бол 50 сая долларын өв хөрөнгөө залгамжлуулна гэж болзол тавьсныг сонсоод 100 долларын өрийн картуудаа усан онгоц руу чулуудаж орхисон гэдэг. |тэрбээр Нью-Жерсид автобус жолооддог байжээ|.

Бүх хүн л ямар нэг юм хурааж дадсан байдаг. Гэхдээ жинхэнэ арвич хүмүүс л нөөцөө нэмэгдүүлэхийн тулд санаанд багтамгүй хүчлэл гаргаж, зайлшгүй хэрэгцээгээ хүртэл хязгаарладаг. Олон жилийн өмнө "Вашингтон пост" сонины сэтгүүлч

Катрин Грэхем тэрбумтан Уоррен Баффеттай нисэх буудал руу хамт явж байхдаа утсаар ярих 10 цент гуйжээ. Тэрбумтан 25 цент гаргаж ирснээ задлуулахаар явахыг харсан сэтгүүлч би задлаад өгч чадна гэсэн гэдэг. Дэлхийн хамгийн баян хүн Рокфеллерын хүүхдүүд дундаа ганцхан унадаг дугуйтай байжээ. Том хүү Жонн нь 8 нас хүртлээ ердөө ганцхан хувцас солиогүй өмсдөг байв. Ингэхэд 10 цент авахын тулд жорлон руу гараа дүрдэг хүний тухай та юу хэлэх вэ? Тэр мөнгөний хажуугаар амгалан өнгөрч чадсангүй.

Мөнгийг хойш нь хийх хүсэл их зовиуртай болж мэднэ. Та мөнгөнөөсөө ханамж авмаар байдаг ч түүнийг гараасаа гаргаж огт чадахгүй. Хэмнэснээс болоод таны эд баялаг гараас чинь гулсана. Хэрэв таны мөнгө хаалганы цаана юмуу цайзад байсан бол яг л таны хэмнэж байгаа шиг гар хүрэх аргагүй байхсан билээ.

xxx

Өөр хүслээ биелэл болгох, өөр зүйл сонирхоход мөнгийг ашиглаж болно. Мөнгө алдар нэртэй болоход тусалдаг. Алдар нэр ч бас мөнгийг дагуулдаг.

Мөнгөөр эрх мэдэл ба алдар нэрийг худалдаж авах

Эрх мэдэл ба алдар нэр олохын тулд мөнгийг хэрхэн ашиглах талаар та энэ сэдвээс уншаарай. Харин эрх мэдэл ба алдар нэрийн тухай илүү тодорхой мэдэхийг хүсвэл энэ номны тухайн бүлгүүдийг уншина уу?

Эрх мэдэл

"Би мөнгөө хэд хэдэн улс төрчдөд хуваан өгөх байсан. Тэдний хэн нэг нь намайг санаж засгийн газарт өндөр албан тушаал санал болгоно гэж би найдна".

Хэрэв та мөнгийг эрх мэдэл ийн төлөө ашиглах аваас та эрх мэдэлд тэмүүлэгч бөгөөд мөнгө таны хувьд эрх мэдлийн эх сурвалж төдий.

Юуны өмнө мөнгө танд өөрийн материаллаг тал дээр эрх мэдэлтэй болоход тусална. Та амин чухал хэрэгцээт зүйлсэд санаа зовохгүй. Хүүхдийн боловсрол, эмнэлгийн үйлчилгээ, байр сав, хувцас, хоолны төлбөрт санаа зовохгүй болно. Бизнес коллежид оюутнуудыг шууд л мөнгө хураахад сургаж эхэлдэг. Хүндрэлтэй нөхцөлөөс гарахад сургаж байгаа нь тэр. Зөвхөн мөнгөтэй үед л хүндрэлтэй асуудлыг тоохгүй байж болно.

Мөнгө бусдын дээр сүндэрлэх эрх мэдлийг өгнө. Мөнгөө хэрхэн үрэх вэ гэсэн сонголтын өмнө тулгарах үед мөнгө ямар их эрх мэдэл өгдөг нь илүү тодорхой болдог. Та дөнгөж үүсч байгаа компанийг санхүүжүүлэх юмуу эсвэл шүүхэд төлбөр хийх тухай шийдэх ба таны шийдвэр хорвоог өөрчилнө. Тэрбумтан Жорж Сорос ардчилал тогтоох төслүүдийг санхүүжүүлэх замаар засгийн газруудын бодлогод нөлөөлөхөд мөнгөө ашигладаг.

Гэр бүлийн хүрээнд эрх мэдлээ бататгахын тулд мөнгийг ашиглаж өв залгамжлагчдаа "Удирдаарай". Өмч хөрөнгө төлөвлөлтийн системд сүүлд оруулсан залруулга танай хүүхдүүдийн өв хөрөнгөд халдах боломжийг хязгаарлаж байна. [Баян эцэг эхчүүд хүүхдүүддээ өв хөрөнгө шилжүүлэхдээ тухайн мөнгийг ашиггүй зүйлд зарах юмуу үрж болохооргүй болзол тавьдаг]. Хэрэв таны өв залгамжлагчид энэ дүрмийг зөвшөөрөх юм бол таны байгуулсан Итгэлийн сангаас мөнгө авч болно. Та өв залгамжлагчиддаа мансууруулах бодис хэрэглэдэг эсэх талаар шинжилгээ өгөх хүртэл төлбөрийг нь хийхгүй байж болно. Эсвэл та гэртээ сууж байгаа ээжид нь шагнал өгч болно. Аль эсвэл хүүхдүүд ажил хэргээ эхлэхэд нь зориулж нэмэлт мөнгө салгаж өгч болох юм. Та тэднийг өөр дээрээ авах юмуу эсвэл хэн нь таны өв залгамжлагч болж мөнгийг яаж ашиглах ёстойг шийдэж болно.

Та эрх мэдлийг зүгээр худалдаад авч болно. Сонгуулийн өмнөх ажилд сая саяар нь үрж зараад улс төрийн эрх мэдлийг худалдан авч болно. Өнөөдөр засгийн эрхэнд орохын тулд санхүүжилт хийн хамаг мөнгөө үрж байгаа хичнээн нэр дэвшигч байдаг билээ дээ. Стивен Форбс зөвхөн ерөнхийлөгч болохын төлөө өөрийн бүх хөрөнгө зоорийг үрэхэд бэлэн байлаа. Толдмен Сакс" компанийн ерөнхий захирал Жон Корзине өөрт нь 350 сая доллар бэлэн байгаагүй бол сенатад нэрээ дэвшүүлэх байсан уу? Хэрэв та өөрөө хүсэхгүй бол нэр

дэвшигчдэд мөнгө цутгах замаар улс төрийн эрх мэдэл ба нөлөөг худалдан авч болно. 1996 онд ардчилсан намын төлөөлөгчид асар их мөнгө хуримтлуулсан бөгөөд хожим их мөнгө цуглуулсан хүмүүс нь оруулсан мөнгөнийхээ хэрээр шагнагдсан юм. 10-25 мянган доллар цуглуулсан хүмүүс ерөнхийлөгчтэй хамт том зоогт уригдсан. 50-100 мянган доллар цуглуулсан төлөөлөгчид цөөхөн хүнтэй тусгай зоогт багтах юмуу ерөнхийлөгчтэй аяга кофе хамт уусан. Харин 500 мянган доллараас дээш мөнгө цуглуулсан хүмүүс Клинтонтой гольф тоглохын тулд ерөнхийлөгчийн хувийн онгоцоор нисч, Цагаан ордонд шөнийг өнгөрүүлсэн. Их мөнгө цуглуулахын хэрээр та ерөнхийлөгчийн цагаас ихийг худалдан авна. Ерөнхийлөгчийг тойрсон бялдуучидтай харьцаж, тэднээс сэтгэл хөдлөм олон түүхийг мэдэж авах ба цаашаа найз нөхөддөө ярих болно.

Ашигтай хандив буян хийх замаар нийгмийн эрх мэдэл худалдан аваарай. Хэрэгтэй байгууллагад хэрэгтэй хэмжээний мөнгө бэлэглэвэл та удирдлагад нь багтана. Ингэснээр чухал асуудлын шийдэлд оролцох болж, улмаар хэрэгтэй хүмүүстэй нөхөрлөж, хаан шиг хүндлүүлж сонинд гарсан зургаа дуртайяа харах болно. [Хандив буян танд хэрэгтэй нэр төрийг бий болгоно]. Билл Гейтс засгийн газартай харгалдах үедээ онцгой өгөөмөр болсон. Бүх сонинууд энэ эелдэг өгөөмөр хүн их хөрөнгийнхөө ачаар буян хандив хийж гайхамшигийг бүтээж байна хэмээн бичиж байлаа. Музей, балетын бүлэг юмуу дуурийн театрыг удирдахын тулд тодорхой мөнгө оруулах хэрэгтэй. 1999 онд дуурийн "Метрополитен" театрын эзэд жилд 75 мянган долларын хөрөнгө оруулж байсан бол Лос-Анжелесын урлагийн музейн эзэд 50 мянган доллар оруулж байжээ. Жижиг хотод тооцоо мэдээж жижиг. Хьюстоны балетын багт жилд ердөө 5 мянган доллар хэрэгтэй.

Хэвлэл мэдээлэлд өөрийн албан тушаалыг худалдан аваарай. Ерөнхий редакторын албан тушаалыг шаард. Руперт Мердок "Нью Йорк пост" ба "Фокс ньос канал"-тай, Лорри Тиш "CB5"-тэй, Морт Цукерман "Ньюс энд ворлд репорт" ба "Нью Йорк дэйли ньос"-тэй, Жим Краммер THez1gee1.com-той ингэж л харьцсан. Ийм хэлбэрийн эрх мэдэл нэр төрийг дагуулж явдаг. Бизнес эрхлэгчид өөрийн мөрөөдлийн зах зээл дээр албан тушаал эзлэхийн тулд цаг үргэлж мөнгө үрэх хэрэгтэй болно. Си Ньюхаус цагтаа "Нью Йоркер"-тэй хийсэнтэй адил.

Мөнгийг алдар нэр болгохын тулд та өөрөө баян байх ёстой гэж бүү бод. Мэдээж үгүй. Мөнгөний урсгалыг хянах, хаашаа явж байгааг нь мэдэхэд л хангалттай. Эрх мэдэл баян юмуу ядуу ямар ч байж болно. Гэхдээ үргэлж нөлөөтэй байдаг. Учир нь эдийн засгийн хоёр үндсэн багана болох санхүүжилт ба татварыг удирдаж байдаг. Засгийн газрын эрх мэдэл эдгээр салбар хэр амжилттай хөгжиж байгаагаас хамаардаг. Мөн пи-ар хэрэгслүүдийн дэмжлэгээс хамаарах бөгөөд үүний төлөө удирдагчид төлбөр хийх ёстой. Тэр бүү хэл мөнгийг дам удирдах юмуу хянаж байсан ч энэ нь эрх мэдлийн эх сурвалж болдог. Коллежийн багш захирлууд шилдэг сургуулиудад суралцаж байгаа оюутнуудын өмнө өндөр орлоготой салбарт гайхамшигт амжилт олох боломж нээгдэж байгаад хөл алдана.

Энэ талаархи хоёрдугаар санамж

Хүмүүс инээмсэглэл илэн далангүй ба найрсаг байдлын баг өмсч нуугддаг. Гэхдээ тэд зөвхөн мөнгийг хүндэлж толгой бөхийхөөс биш эздийг нь бол үгүй. Эд баялаг танд яравгар байхыг зөвшөөрдөг. Үүний адил эрх мэдэл бялдуучлалыг хүлээж авахыг зөвшөөрч байдаг.

Баян хүмүүстэй ойртож мөнгөтэй нь харьцахын тулд тэдэнд долигонох явдал бий. Баячууд ч бас мөнгө саахгүй байгаа хүмүүст анхаарал хандуулж, зөвхөн эд баялаг мөнгө биш харин эзнийг нь хүндэлдэг хүмүүсийг анхаардаг. Зохиолч Энтони Пауэлл өөрийн зохиолын баатар Стрингхемийн тухай бичихдээ: "Тэр өөрийн хүрээллийн хүмүүсээс илүү баян байгаагүй. Гэхдээ мөнгөтэй чөлөөтэй харьцдаг байлаа. Тийм учраас мөнгө байнга дутагдана. Гэвч насан залуу хүнийг ч согтоох чадвартай алт мөнгөний үнэр түүнийг үргэлжхүрээлдэг. Ийм байдлыг сэтгэл алдам үнэрийг эсэргүүцэх шаргуу ба хэзээ ч үл мохох эсэргүүцэл, мөн аливаад огт үл гомдох зэрэг нь тэр, өөрөөр хэлбэл Стрингхэм үлгэрийн мэт баян эмэгтэйн хүү байсныг байнга сануулна".

Алдар нэр

"Би бол мөнгийгховор үзмэрээ сэргээхэд нь зориулж музейд бэлэглэх байсан. Гэхдээ миний нэр бүх сонин хэвлэлээр гарна гэсэн болзолтойгоор".

Хэрэв та мөнгийг алдар нэр худалдан авахад чиглүүлэх юм бол яг өөрийн мөрөөдөж байсан тэр алдар нэрийг авна.

Алдартай хүмүүсийн хэн нэгтэй харьцаж, ховор болоод нэртэй эд зүйл худалдан авч түүний хамт олны нүдэнд өртөөрэй. Хэрэв та Ван Гог-ийн "Наранцэцэг" зургийн эзэн юмуу Мар-Лаго эдлэн газрын эзэн, эсвэл "Найдварын олимпиад" зочид буудлын эзэн болох аваас алдар нэр адаглаад л таныг шүргэх нь гарцаагүй. Гэвч энэ бүхний төлөө төлбөр хийх хэрэгтэй. Алдар нэр хүслийг үнэхээр татах учир түүний төлөө асар их мөнгө төлдөг. Марк Макгвайерын өмчлөлийн 17-р зууны үеийн байшин дуудлага худалдаагаар 3 сая долларт хүрчээ.

Та арай энгийн алхам хийх тухайлбал ивээн тэтгэх замаар алдар нэрийг худалдан авч болно. Тэрбумтан Стив Форбс ерөнхийлөгчийн сунгаанд эфирийн цаг худалдан авахын тулд хэдэн арван сая доллар зарцуулсан. Тэр ерөнхийлөгч болж чадсангүй. Гэвч алдар нэр нь түгжээ. Таны гэрэл зургийг замын уулзварууд дээр байрлуулах юм бол тун удалгүй жолооч бүхэн таны царайг мэддэг болно.

Хэрэв та чадалтай бол олон нийтийн анхаарлыг тан руу татах мэргэжилтнүүдийг хөлсөлж бас өөрийн имижийг хянаарай. Таны гайхалтай залуу гэдгийг бүгд мэддэг болохыг хүсч байна уу? Таны пи-арчин амжилтыг тань мэдүүлээд өгнө. Тэгвэл таны нэрний өмнө үргэлж "гайхалтай" гэсэн угтвар явдаг болно. Таныг ажлаасаа гарлаа гэхэд танд ашигтай талаас нь танилцуулна.

Танд олон нийтийн зүтгэлтний алдар нэр хэрэгтэй юу? Ямар дэлгүүрийг ивээлдээ авах, ямар үдэшлэг цэнгүүнд очих, зуны байшин хаана худалдан авч, хэзээ тийш очих зэргийг таны зөвлөгч зөвлөнө. Мөн хэлж өгсөн бүхнийг нь хэрхэн биелүүлэхийг тэр хянаана. Гэхдээ зөвлөгчийн тусламж авсан гэдгээ нууцлах ёстойгоо мартуузай. Таны алдар нэр зохиомол гэдгийг хүмүүс мэдэх шаардлагагүй. Таны

алдар нэрийн дур булаам байдал яг л эрх мэдэл шиг байгалиас заяасан аятай байх учиртай. Олон алдартнууд алдар хүнд түүнд гэнэт хүрээд ирсэн хэмээн худал ярьдаг. Олон түмэн л

түүнийг сонирхосноор үл танихуйн харанхуйгаас татан гаргасан гэж ярина. Та мөнгөө өгч алдар нэрийг худалдан авч болно. Гэхдээ таны бэлэгийг олон нийт болоод хэвлэл мэдээллийн хэрэгслүүд анзаарна гэдэгт итгэлтэй байгаарай. Өөртөө зориулан зоог, хүлээн авалт хийвэл таны нэрийг хүмүүс мэддэг болохын баталгаа. Илүү үр дүнтэй боловч үнэтэй тусах нэг арга бий. Ямар нэгэн компани юмуу дээд сургуульд байнгын орлого хангаж өгөх. Таны нэр барилгын хаалга дээр өлгөгдөн байнга уншигдаж байхыг хүсэх үү? Бэлэг түгээгч болохыг өөртөө зөвшөөр. Тэгээд олон түмэн Гуттенхейм, Карнеги юмуу Геттигийн нэрийг цээжилсэн шигээ таны нэрийг цээжлэг. Жозеф Хиршхорныг санаж байна уу? Тэрбээр уран зургийн цуглуулгаа засгийн газарт гэрээслэхдээ зургуудад зориулан байр барих ёстой гэсэн болзол тавьжээ. Харин одоо Вашингтонд Хиршхорны музей сүндэрлэж байна. Түүний нэр Америкийн түүхэнд Вашингтон, Линкольн, Жефферсон нарын хамт бичигддэг.

Санамж: Та мөнгөөр сексийг ч худалдан авч болно. Гэхдээ энэ тохиолдолд асар их мөнгө оруулаад ч бүрэн амжилт олох баталгаа байхгүй. Энэ асуудлын тухай ихийг мэдэхийг хүсвэл "Секс" бүлгийг уншаарай.

xxx

Хэдийгээр мөнгөний тусламжтай хүслээ биелүүлж ханамж худалдан авч болох боловч энд ч бас гай хөө бий. Хэрэв та нэг удаа таашаалын төлөө төлбөр хийж, түүний үнэ цэнийг мэддэг болсон бол, таашаал нь мөнгө хүрэхээргүй тийм зайд үлдэх болно. Та огт өөрчлөгдсөнгүй.

Арван хоёрдугаар бүлэг

Мөнгөний гай

Та дөнгөж мөнгө хуримтлуулж эхлэх үед түүний нөлөө бахдан бишрэхэд хүргэнэ. Хүүхдийн сургалтын төлбөр, шүдний эмчийн төлбөр юмуу байрны түрээсийн төлбөрийн тухай цаашид бодох хэрэггүй болжээ. Та зоос бүрээ тоололгүйгээр шинэ цамц худалдан авах юмуу амралтанд явж чадна. Гэвч тун удалгүй энэ бүхэн бага санагдана. Та дэндүү ихийг хүлээж байсан шалтгаанаар мөнгөнд урам хугарна. Танд их юм хэрэггүй. Та зүгээр л нэг шат ахихыг хүссэн. Гэвч та алхам хийхийн өмнө зог тусч эргэн хараарай. Та яг юуг өөрийн болгосон бэ? Хэн нэгэн том байшинтай, тэр таниас их юмтай. Мөнгө үл ханамжийн мэдрэмжийг авчирна. Та өөрийг тань бүрэн сэтгэл хангах тийм байр сууринд очиж амжаагүй. "Майкрософт"-ын эзэн дэлхийн хамгийн баян хүн Билл Гейтст ямар хүсэл үлдсэн бэ? Гэтэл тэр хаалттай Үндэсний гольф клубын гишүүн болох хүсэлд шатаж явдаг ажээ. Тэр тийшээ орж чадах болов уу?

Мөнгөний өгдөг эрх чөлөөний үнэ цэнийг та ойлгож байгаа. Заримдаа бүлэг зарц нарыг удирдахын оронд өөрөө хийчихсэн нь амар байдаг. Та хэзээ ч ганцаараа байхгүй. Та үргэлж олны нүдэнд байна. Бүгд таныг хараад байгаад та дургүйцнэ.



Бритни Спирс хар тамхинд донтож шуугиан тарьсан ч алдар нэр нь бөхсөнгүй

Та ихийг төлөхийн хэрээр ихийг хүлээх атал таны амьдрал төгс төгөлдөр биш хэвээр. Хэрэгцээ шаардлага өсөхийн хэрээр хүрээлэн байгаа бүхэн таны цухлыг хүргэнэ. Хөшиг буруу татагдсан, жолооч хоцорсон, өндгийг буруу шарсан. Таны араас сэжиг бүхий этгээдүүд байнга ангуучлана. Биеэ сул тавихад хэцүү. Одоо та хөвөн даавуун цамц өмсч, шинэхэн шахсан амтат жүржийн жүүс ууж дассан учраас зөвхөн өөрийн өөлөх аргагүй унтлагын өрөө юмуу үнэтэй зочид буудалд л тухтай байж чадна.

Та ямар нэг чухал зүйлийг алджээ. Хэрэгцээ шаардлагын мэдрэмж. Уг нь та яг энэ мэдрэмжээс салахын тулд шаргуу ажилласан. Та ингэж явахдаа эсрэгээр энэ нь танд хичнээн

хэрэгтэй болохыг ухаарсангүй. Магадгүй та хэрэгцээг мэдэрсэн хэвээр байгаа гэж төсөөлж болно. Гэхдээ таны мөнгө бол хэзээ ч мэдрэхгүй.

Хэрэв та мөнгөө үрж дохио өгч эхэлсэн бол энэ тойргоосхэзээ ч мултрахгүй. Дохионоос салах ямар ч арга байхгүй. Та бодит ертөнцийн энэ урхинд чихэгдэн орсноо мэдэрнэ.


Та огт өөрчлөгдөөгүй. Та мөнгөний тусламжтайгаар хэрхэн дээш ахих тухай зөвлөгөө, шударга санаа бодол, гайхам сайхан сеттер нохой худалдан авна гэж бодсон. Гэвч та франц хэл сурах гэж оролдсонгүй, хөлгийн ахмад болохыг хичээсэнгүй, та буруу ярьдаг, цэцэн мэргэн биш, хээ шаагүй. Та 15 фунт жин хасах шаардлагатай. Та мөнгөний тусламжтайгаар эд зүйлс, байр суурь худалдан авч болох ба мөнгө таныг дээш ахихад туслах боловч таныг өөрийг чинь хэзээ ч төгс төгөлдөр болгохгүй, танд аз жаргал авчрахгүй, гэр бүлийн аз жаргалыг худалдан авч болохгүй ба амьдралын утга учрыг ч худалдан авч болохгүй гэдгийг ойлгоод айдас төрнө.

Том мөнгийг хэрхэн ашигласан нь


Том сүүлийн долоон жилийн турш бизнесээ өргөтгөв. Спорт барааны нэгэн хэвийн олон дэлгүүрийг өөртөө нэгтгэв. Одоо тэр ганц эзэн нь болжээ. Ийнхүү ахихын өмнөхөн Том урьд нь найз нөхөдтэйгөө хамт амьдардаг байсан харанхуй тоостой байрнаасаа сайн дүүргийн сайхан байшинд шилжжээ. Хөршүүд хэрхэн зүлэг засч байгааг харсан Том өөрийн цэцэрлэгтээ хэдэн мянган доллар зарцуулна гэж шийдлээ. Тэр өөрөө цэцэрлэгээ арчилж чадахгүй. Гэвч түүнд хангалттай мөнгө байгаа учир гурван цэцэрлэгч наранд шарагдаж байхад мань хүн гэртээ сууж телевизор үзэж, пиво шимэх болно.

Хөршийн ноход Томдтаалагддаг. Харин одоо өндөр ханаарт тусгаарлагдсан арын хашаатай болсон тул аль эртнээс хүссэн нохдыг авахаар шийдлээ. Түүнд хамгийн шилдэг, ухаалаг, эрүүл саруул, үүлдэр сайтай ноход хэрэгтэй. Тэгээд боссынх шигээ анч нохой худалдан авав. Тэрбээр хамгийн шилдэг нохойны мэргэжилтэн Жонсоос худалдан авсан. Жонс нохойнуудаа ерөнхийлөгч, Мадонна, Уилл Смит нарт зардаг. Том түүний сайн түншээс магтуу захидал барьж ирэх хүртэл мань нохойны мэргэжилтэн түүнтэй уулзахгүй зугтаад байж билээ. Дараа нь Том хэд хэдэн нохойн шоуны шагнал хүртсэн хөөрхөн гөлөг сонгон авав. Том өөрийн "хэппи" нохойндоо тун хайртай учир нохойн үүр биш ер бусын жинхэнэ байшин, бас суран хүзүүвч худалдан авлаа. Гэхдээ тэр хэппи нохойгоо унтлагын өрөөнийхөө шалан дээр нойрсохыг зөвшөөрдөг. Том нохойгоо гальбираа алдахаас сэргийлж тохирох цагт нь үржүүлэг явуулна.

Том үргэлж сайхан хувцаслаж ирсэн. Гэвч одоо урьд нь хэзээ ч орж байгаагүй тийм дэлгүүрүүдэд худалдаа хийх болжээ. Хувцас бол түүний сул тал. Хэдхэн сарын дотор тэр цайвар цув, дулаан пальто, моодны пиджак, өвлийн пальто зэргийг худалдан аваад зогсохгүй бас нэг пиджак захиалчихаад байгаа. Дүүрэг, байшин, нохой, хувцас гээд бүгд зөвхөн мөнгөний хүчээр боломжтой болсон. Түүнд мебель худалдан авах мөнгө байгаагүй учир жилийн турш байшин нь тавилгагүй шахам байлаа. Гэвч тэр цэцэрлэг, нохой ба хувцастаа туйлын сэтгэл ханамжтай байсан тул орон байр нь ямар байдалд байгааг бараг анзаарсангүй. Эцсийн эцэст хооллох өрөө юмуу зочдод зориулсан оргүйгээр байж болохгүй гэж үү гэж тэр өөрөө өөртөө уурсан хэлэв.



АЛДАР НЭР



Алдар нэр ба бүхний танил хүн

Алдар нэр. Та хэзээ нэгэн цагт олны танил байх хүсэл мэдэрч байсан уу? Таны танихгүй хүмүүс таны нэрийг мэддэг гэдгийг мэдэх хүсэл төрж байв уу? Таныг гэнэт гарч ирэхийг хараад таньсан хүмүүсийн нүүрэн дээр гайхшрал илрэхийг харахыг та хэзээ нэгэн цагт хүсч байсан уу? Энэ бол бидний алдар нэр гээд байгаа зүйл юм. Таныг бүгд танина. Тэд намайг анзаарсан болов уу?



Стив Жовс хорт хавдар өвчинд нэрвэгдсэн ч I Phone шинэ бүтээлээ тайзан дээр инээмсэглэн танилцуулж чадсан

Ингэхэд танд үнэхээр алдар нэрийн бүх сайхан тал, сэтгэл алдрам бүхнийг эдлэх хүсэл төрөхгүй байна уу? Таныг бүрэн ханамжтай байлгах анхаарал хүндэтгэл шүү дээ. Уиллиам Халит алдар нэрийн тухай ингэж хэлжээ. "Энэ бол хүнд байгалиас заяасан хүсэл юм. Бид хэн нэгний үзэл санаанд нийцэх, байнгын анхаарлын бай болохыг хүсэх ба биднийг сонирхох сонирхол эрс нэмэгдэх явдал" гэжээ. Та энэ тухай мөрөөддөг. Та биеэ хэрхэн авч явах, хэрхэн өгөөмрөөр гарын үсэг тараах, ням гаригийн өглөөний шоуны үеэр хэрхэн цэцэн мэргэн бодож сэтгэх, нийтээрээ таныг сонсох, таны дүрс дэлгэцэнд гарахад л сэтгэл алдрах хүмүүсийг мөрөөднө.

Гэвч 15 минут ч алдар нэртэй байх нь амаргүй хэрэг. Хүмүүс энэ зорилгод хүрэхийн тулд хичнээн хүч хөдөлмөр зориулдагийг бодож үзээрэй. Хэдэн зуун хүн "Өглөө" хөтөлбөрийн студид дугаарлан зогсдог. Тэд дуранд өртөх, гар даллах, Катти, Мэтт, Эл ба Энн нартай ярилцахын тулд ингэж зогсоно. Алдар нэр хайгч хэдэн мянган хүн МТВ-гийн сорилтонд орох гэж хичээнэ. Тэдний зарим нэг нь сорилго заасан өдрийн урьд шөнийг гудамжинд, асгарах бороон дор өнгөрөөж байдаг. Алдарт "Бүхний тухай яриач" шоуны хөтлөгч Женни Жонс "Хайрын эх" нэрээр алдаршсан бөгөөд түүн дээр ирэх зочны хөл үл тасарна. Эдгээр хүмүүс дэлгэцэнд гарахын тулд өөрийн амьдралын хамгийн ариун нандин нууц бүхнийг дэлгэхэд бэлэн.

Магадгүй та алдар нэр гэж юу болохыг аль хэдийн мэддэг байж болно. Та алдартай хүмүүсийн уран гоёор биеэ авч явах байдалд аль хэдийн суралцсан. Юунд ч санаа зовохгүй,

хөнгөн, биеэ албадахгүй дохио зангаа, цагаан шүд гялалзуулан инээх энэ бүхэн таны стильд тохирдог уу? Түүхчид таны гэр бүл салалтын тухай хэрхэн бичихийг төсөөлж үзсэн үү?

Алдар нэр энэ бүхнийг авахад туслана. Алдар нэр таны ололтыг өсгөж, жин дарж, та анхааралд орж, олны танил болох ба ийм байх гавьяаг та хийсэн. Эрх мэдэл ба хүч чадал танд агуу ихэмсэгийг авчирдаг. Мөнгө ба алдар нэр таныг бүхний танил болгоно. Харин секс ба алдар нэр дур булаам амьдралыг бэлэглэнэ.

Таны алдар нэр бусад хүмүүсээс хамааралтай. Алдар нэр гэдэг нь тэдний ухамсарт амьдарч байгаа зүйл. Та бол шүтэн бишрэгчдийн бүтээл. Гэхдээ танд ямар алдар нэр хэрэгтэй юм бэ?

Сонжоо.

Та ямар алдар нэрийг мөрөөддөг вэ?

Доорх баталгаануудаас танд хамгийн их тохирохыг нь сонгоорой.

64. Би өөрөө юмуу миний нэр сонинд гарсан эсэх нь ямар ч хамаагүй. Гол нь манай ажлынхан намайг анзаарч хүндлэх ёстой.

65. Хүмүүс миний нэрийг таньдаг. Миний хийснийг үнэлдэг байхыг би хүснэ. Гэхдээ гудамжинд үл таних хүмүүс намайг зогсоохыг хүсэхгүй.

66. Үл таних хүмүүс миний нэрийг мэддэг, намайг хажуугаар нь гарахад эргэж хардаг байхыг би хүснэ.

67. Хүмүүс миний хийсэн ажлыг олон жилийн турш судлах тийм алдар нэрийг би хүсдэг.

Хэрэв та нэгдүгээр баталгааг сонгосон бол та "Жижиг цөөрмийн том загас" алдарыг хүсдэг.

Хэрэв хоёрдугаар баталгааг сонгосон бол "Танил нэр" алдарыг мөрөөддөг.

Гуравдугаар хариултыг сонгосон бол та Одын алдар нэрийг мөрөөддөг.

Хэрэв дөрөвдүгээр баталгааг сонгосон бол та Шүтээний алдар нэрийг мөрөөддөг.

"Жижиг цөөрмийн том загас"

Хэрэв та үүнийг сонгосон бол танд найз нөхөд, хамтран зүтгэгчид ба хамт ажиллагсадын хүндэтгэл хэрэгтэй. Харин бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдөхийг хүсдэггүй. Шатахуун түгээгүүрийн ажилтан таныг хараад танихгүй. Өсвөр насны хүүхдүүд таны нэрийг сонсонгуутаа баярлан үсрэхгүй. Гэхдээ хэрэв та бага хурал дээр нэрээ хэлэх юмуу өөрийн ажилладаг байгууллагад ороод ирлээ гэхэд хүмүүс таны дэргэд суухын тулд бие биенээ унатал түлхэн зүтгэх болно.

Энэ тохиолдолд хүртэл үйлчилж байгаа харьцангуйн зарчим энэхүү алдар нэр хязгаарлагдмал боловч асар их таашаал авчирч байгааг харуулаад өгнө. Та алдар нэр асар их ач холбогдолтой

тэр жижигхэн нүхийг аль хэдийн эзэлжээ. Яагаад гэвэл энэ тохиолдолд та сэтгэгдэл төрүүлэхийг хүссэн тэр хүмүүстэй уулзалдах болно. Энэ төрлийн алдар нэр ямар боломжууд өгөх вэ? Та энэ хүрээний дотор юу хийж чадах вэ? Таныг нийгмийн асуудлын шийдэлд татан оролцуулж болно. Та сургуулийн удирдлага, бодлого ба буян хандиваар оролдсон ч болно. Та мэргэжлийн холбоог өөрийн нэрээр нэрлэж болно. Та өөрийн хотдоо юмуу ажилтнуудын хүрээнд алдартай. Ямар ч тохиолдолд ийм "Том загаснууд" сонирхсон хүнийхээ хүндэтгэлийг байлдан дагуулахад их анхаардаг. Тэд яг л хими юмуу шатрын мэдлэгтнүүд шиг мэргэжлийн алдар нэр хайна. Илүү өргөн, гэхдээ өнгөц алдар нэр тэдний анхаарлыг нэг их татахгүй.

Том загаснууд өөрийн цөөрөм дотроо бол олон хүний анхаарлын төвд байдаг. Харин цөөрмөөс цааш бол танил биш. Энэ төрлийн нэрийг олон түмэн мэдэхгүй.

Хэрэв та ийм хүмүүсийн тоонд багтдаг бол алдар нэрээ хэтрүүлж бүү үнэлээрэй. Таны байр суурь таатай төөрөгдөлд хөтөлж мэднэ. Энэ нь төрөлх цөөрмөөсөө цааш ч алдартай гэж төөрөлдөх явдал. Гэвч тийм биш. Таны хүрээнийхний ханддаг шиг анхаарал дотно байдлаар хаа сайгүй хандана гэж бүү хүлээ. Тэгээд ч таны өндөр байр суурь ба албан тушаалын тухай бүх цуу яриа танай ажилтнуудын хэн нэгний хөх инээдийг хүргэж мэднэ гэдгийг сана. Нэгэн шүүгч хэлэхдээ Би Нью-Йоркт хайртай. Энэ хот таныг алдар нэртэй байхыг зөвшөөрдөггүй. Би холбооны шүүгч. Гэвч Нью-Йоркийн төв гудамжаар алхахад намайг хэн ч танихгүй гэжээ. Эсвэл ажил хэрэгч компанийн нэгэн ажилтан өөрийн туслахад хандсан яриаг танд өгүүлье. "Хүү маань төрөхөд би үйлчлүүлэгчдийн өрөөнд сууж байсан. Гэтэл миний хэн болохыг мэдэнгүүтээ тэд өндөр зочдын өрөө рүү намайг урьсан". Харин туслах нь түүнд доорх асуултыг тавьж гэнэн алдаа хийжээ. "Яагаад тэгсэн юм бол? Та хэн болоод тэгсэн юм бэ?"

"Алдартай нэр"



Лютэр Мартин

Ийм алдар нэр таныг олон түмэнд танил болгоно. Гэхдээ энэ нь таны нэрний алдар болохоос биш таны өөрийн алдар нэр биш. Иймэрхүү алдар нэр хэд хэдэн төрөл байдаг. Бид тэднийг

"царай төрхгүй нэр", "нийгмийн өсөлт", "харваж байгаа од" гэх мэтээр нэрлэнэ.

Хэрэв та "царай төрхгүй нэр" хэмээх алдартай бол энэ тохиолдолд таны нэр л их алдартай. Яагаад энэ нэр хүн болгонд сонсогдсон нь тодорхой. Гэвч хэрэв та гудамжинд гарлаа гэхэд таныг нэг ч хүн танихгүй. К.Роулинг, найруулагч Жеймс

Кэмерон, доктор Бенжамин Спок нар яг ийм алдар нэртэй. Хэрэв та "алдартай нэр" хэмээх алдар нэрийн эзэн бол олон нийтийн хүлээн зөвшөөрөх шуугиан танд танил. Заримдаа таны нүүр царайг хүмүүс танина. Гэхдээ ийм алдар нэр царай төрхийг мэддэг тэр алдар нэр шиг олон нийтийг шатааж чадахгүй.

Алдар нэрийн өөр нэгхэлбэр нь "нийгмийн алдар" юм. Хүмүүс сонсонгуутаа таны нэрийг танихгүй байж болно. Гэхдээ тэд таныг алдартай гэр бүлийн гишүүн гэдгийг ойлгоно. Жинхэнэ Рокфеллер юмуу Астор, Каботын удамтай уулзана гэж бодохдоо хүмүүс салгалан чичирдэг. Та амжилт олж байгаа "нахиа" байж болно. Та өөрийн алдар нэрэнд хүрч, олонд хүлээн зөвшөөрөгдсөн байж мэднэ. Таны тухай тусгай сэтгүүлүүдэд бичдэг. Та үе үе хүмүүсийн сонирхон асууж байгааг сонсоно. "Гэхдээ энэ хүн чинь эгч дүү Миллерүүдийн нэг нь биш биз дээ?".

Энэ төрлийн алдар нэрний сүүлчийн хэлбэр нь "харваж байгаа од"-ын алдар нэр юм. Та цаашид од биш, гэхдээ таны нэр одын алдараа хадгалсаар байх болно. Таны нэр ба нүүр царайг хүмүүс мартаж амжаагүй. Гэхдээ их бүдэг бадаг санана. Хүмүүс харвасан оддын тухай асуухдаа "Тэр хаачсан бэ? Тэр амьд байгаа гэж үү?" гэх мэтээр ярьдаг. [Трой Донахью, Жон Линдсэй, Арт Гарфункель, Ли Якокка]. Ийм гашуун алдар нэрийг давж гарахад амаргүй. Хуучин одод хүмүүс тэдний тухай санаж байгаа ба алдар нэрийн үлдэгдлийнхээ төлөө тэмцэх ёстой гэдгээс болж ихэд зовж шаналдаг. Та уналтыг зогсоож эргэн ирж чадах эсэхээ мэдэхийг хүснэ.

Дүрэм

Хэн нэгэн байх нь хэн ч биш байхаас хавьгүй хэцүү.

Од

Хэрэв та од мөн бол танилцуулах шаардлагагүй хүн. Таны хэн болох ба юу хийдгийг хүмүүс бүгд мэднэ. Тэд таныг шууд таньж, яг одноос нүдээ салгаж чаддаггүй шигээ танаас харц салгаж чадахгүй. Та энд байгаагаараа хүмүүсийг ховсдоно. Хэрэв хүмүүс таныг салахгүй ажиглаж байвал та од мөн. Та шүтэн бишрэгчдийнхээ итгэлийг үл хөсөрдүүлэх, бас алдар нэрээ зөвтгөхийн тулд ямар нэг юм хийх ёстой. Ингэхгүйгээр таны одын байр суурь баталгаажихгүй. Гэхдээ бас ингээд ч болчихдог юм биш. Хэрэв та өөрийн одын цагийг хүсч байгаа бол шүү дээ. Бид Барбара Уолтерс, Харрисон Форд, Мадлен Олбрайт, Спайк Ли, Марта Стюарт, Алан Гринспен зэрэгхүмүүсийг гэж нэрлэдэг. [Гринспенний алдар нэр нь кабелийн телевиз таны төлөө, таны алдар нэрийн төлөө юу хийж чадахыг харуулж байгаа юм. Түүний тусламжтай холбооны захиргааны ажилтан од болсон. Пол Волкер "том загас" болж чадсан ч од болох хэмжээнд хүртэл өөрийгөө чанга зарлаж чадсангүй].

Одын байр суурь өөрийнхөө төлөө ажилладаг. Худалдааны компанийн эзэд ба наймаачид таны дүрийг ашиглах аливаа боломжийг үл алдах бөгөөд түүний тусламжтай худалдан авагчдыг татахыг оролдоно. Тэд бараан дээрээ таны дүрийг нааж, тэдний зохиох арга хэмжээнд таныг оролцохыг гуйж, дэмжсэний төлөө танд их мөнгө төлж, таны түүх, бичсэн шүлэг, тэр бүү хэл хоолны жорыг хүртэл хэвлэн нийтэлнэ. Тэд таныг улам нэртэй болгохын төлөө байдгаараа хичээж, өөрийн зорилгодоо таны хөргийг ашиглана. Тун удалгүй үгийн сүлжээний асуултанд хүртэл таны нэр хариулт болж, онцгой төрлийн хавчуургатай талханд хүртэл таны нэрийг өгнө. Эрдэмтэд шинэ нээсэн няндаа таны нэрийг хайрлана. [жишээ нь Майкл Жорданы нэрийг Залпелла пгуогдап хэмээх бактерид хайрлаж хүндэтгэл үзүүлэв]. Хатагтай Тюссо өөрийн лааны тосон музейд таныг мөнхжүүлнэ. Одын байр суурь нь маргашгүй үнэ цэнэт зүйлийн хэлбэрээр дандаа шагналд хөтөлдөг юм биш. Алдарт Зрюе дИЗ хамтлагийг санаарай.

Одын тухай ойлголтонд, үзүүлбэр нүд хуурах алдар нэр бас багтдаг. Та супер танил болж өөрийн агуу байдлаар гялалзана. Гэвч энэ нь ганцхан шөнө үргэлжлэх ба дараа нь та унтардаг. Өнөөдөр Жон Буттафуоко, Луиза Вудвад, Миа Хамм зэрэг нэр ба царайг хүмүүс аль хэдийн мартжээ. Гэтэл сонин бүрийн эхний нийтлэл, сэтгүүл бүрийн хавтас, шоу болгонд тэд гарч байсан үе бий.

Та олонхи "харвасан од"-дын адил алдар нэрийг богино хугацаанд эдэлнэ. Гэвч таны алдар нэр санаснаас илүү урт наслах нь бас бий. 16 дахь минут дээр та ердийн амьдрал руу аажмаар буцаж байгаага мэдэрнэ. Гэхдээ сонинд гарсан нийтлэлийн зузаан хайчилбар, банкин дахь том хадгаламж, өөрийн байгуулсан гавьяанд дүйцэх хүндэтгэл ба сайн талуудтайгаа буцна.

Шүтээн

Хэрэв та шүтээний алдар нэрийг хүсч байгаа бол эрин зуунд орших алдар нэрийг эзэмдэх ёстой. Ийм алдарт хүрсэн хүн цөөхөн. Луи Армстронг, Анна Франк, Диана гүнж, Элеонора Рузвельт, Жеки Робинсон - 20-р зууны шүтээнүүд бол эд.

Од хэзээ шүтээн болон хувирдагийг хэлэхэд хэцүү. Ийнхүү хувирах нь боломжтой зүйл. Хэрэв түүх өөрөө таныг сонговол, эсвэл та энэ дүрд бусад хэн бүхнээс илүү тохирч байвал, эсвэл та манлайлагч бөгөөд өөрийн биеэ авч явах байдлаар цаг үеэ илэрхийлж бас мэдэрч чадаж байвал ийнхүү хувирах боломжтой.

Хэрэв түүхэн дэх таны үүргийг ойлгож үнэлэхэд хялбар байх юм бол та шүтээн болно. Дипломат болохоос шүтээн болох нь ихэнхидээ хялбар байдаг гэдэг. Альберт Эйнштейний харьцангуйн онолыг маш цөөхөн хүн ойлгодог. Гэхдээ түүний алдарт E=mc² томъёог бараг бүх хүн хялбархан хэлдэг.

Одоос шүтээнд шилжиххамгийн найдвартай боловч эмгэнэлтэй арга нь үхэх юм. Гэнэтийн үхэл, халдлага, аллага. Абрахам Линкольн, Жон Кеннеди, Мартин Лютер Кинг, Жон Леннон нарын амь насанд халдсан, эсвэл Жеймс Диам, Амели Эрхарт нарын азгүй тохиолдол юмуу харгис хэрцгий үхэл, Мерилон Монрогийн амиа хорлосон зэргийг дурьдаж болно. Үхэл таны сайн талуудыг хадгалан үлдээж, шүүмжлэгчдийн амыг таглаж, улмаар таныг алдар нэртэй

болгоно. Та хорвоогийн алдар нэрийн харанхуйгаас ангижирч, үхлийн үл мэдэх ертөнц рүү оджээ. Холливудын нэгэн бараан домогт өгүүлснээр нэг хүн нөгөөдөө "Эльвис Пресли үхсэн" гэхэд нөгөө нь "Үгүй тэр бүр их алдартай боллоо" гэж хариулжээ.

Шүтээн нь амьдралаас илүү утга учиртай байхыг нийгэм хүлээдэг. Тиймээс шүтээнүүд хүнд баймгүй зан чанаруудыг өөртөө байгаа мэтээр ойлгуулна. Мартин Лютер Кинг дотор нь чанга яригч байрлуулсан хийн камер дахь цаазаар авах үйл явцын тухай ийнхүү дүрсэлжээ. "Хамгийн эхний цаазлуулагч залуухан негр байлаа. Бөглөөс саванд унаж, хий камер руу нэвчих үед камерт байгаа микрофоны тусламжтайгаар тэр залуу хэрхэн залбирч байгааг бид сонссон. Тэр "Жо Луис намайг авраач, Жо Луис намайг авраач.." гэж үглэж байв. Түүний сүүлчийн залбирал хүнд жингийн дэлхийн аварга алдарт боксчинд зориулагджээ".

Та шүтээний хувьд таны музейг нээж таны дүрстэй эд зүйлсийг цуглуулахад нийгмийг хөдөлгөж болно. Хүмүүс танд гар хүрэхийг хичээж, тэгэж чадахгүй аваас ядаж эд зүйлд нь хүрэхийг хичээнэ. Уинстон Черчилль бөмбөгдөлтийн үеэр Лондон хот ба дүүргүүдээр явсан тухайгаа дурсахдаа: "Хүмүүс биднийг хүрээлж, инээх юмуу бусад бүх аргаар хайр анхаарлаа илэрхийлж байв. Тэд миний хувцасанд хүрэх гэж хичээж байсан" гэжээ. Ерөнхийлөгч хууль цааз юмуу төрийн бусад бичиг баримтыг хэд хэдэн үзгээр гарын үсэг зурж баталгаажуулдаг. Ерөнхийлөгчид бараалхсан хүн бүхэн энэхүү түүхэн эд зүйлсийг, агуу хүний гар хүрсэн эд зүйлсийг гэртээ аваад харьж болно. [Ерөнхийлөгч үүргээ гүйцэтгэж эхэлмэгцээ автоматаар шүтээний зэрэглэлд очдог. Түүний хөшөөг ордонд босгоно. Гэвч тэр шүтээний зиндааг гавьяагаараа баталгаажуулах ёстой]. Домогт нисгэгч Чарльз Линдберг чекээ солих юмуу хувцасаа угаалгын газарт хүргэж огт чаддаггүй байжээ. Яагаад гэвэл хүмүүс түүний эд зүйлсийг хэт өндөр шүтэж бараг онгон шүтээн гэж үзэж байв.

Таны шүтэн бишрэгчид таныг шүтэх газраа бий болгож, Грейслэнд рүү мөргөлийн аян хийж, Жон Кеннеди ба Диана гүнжийн бишрэгчид шиг цэцэг тавина. [Тэд Британий элчин сайдын яамны барилгад цэцгээ авчирч байв].

Шүтээний байр суурийн үнэн төрхийг цаг хугацаа баталж өгнө. Таны алдар нэр зөвхөн шүтэн бишрэгчдийн сэтгэлийн ухаангүй оргилолт байсан уу, аль эсвэл хүмүүсийн зүрх сэтгэлд бат суурьшиж цаашид олон арван жил амьдрах тийм алдар нэр үү гэдгийг цаг хугацаа харуулна. Гэсэн хэдий ч алдар нэр хэр удаан настай нь ойлгомжгүй. Тиймээс орчин цагийн бүх шүтээнүүд алдар нэрийнхээ үндсийг үүсгэж бэхжүүлж байдаг. Энэ нь шүтэн бишрэгчид шүтэж байгаа зүйлтэйгээ үргэлж аль болох ойр байгаа гэдгээ мэдрэхийн тулд хийгдэнэ. Жорж Вашингтоныг авч үзье. АНУ-ын түүхэнд түүнээс илүү алдартай хүн үгүй. Гэхдээ тэр энэ алдар нэрийг нэгэнт тогтоосон хил хязгаарыг зөрчиж байгаагүй гэдгээрээ бас олж авсан.

Тэр өөрийн нэрний эргэн тойронд хэзээ ч шуугиан гаргадаггүй. Түүний дүр төрх нууцлаг бөгөөд таавар мэт үйлээр бүрхэгдсэн. Дэлавэрийг огтлон гарсан түүхэн агуу үйл явдал, интоорын мод ба хүйтэн инээмсэглэл - хүмүүсийн ухамсарт хурц үлдсэн бүхэн бол энэ. Вашингтон эргэлзээгүй шүтээн байх заяатай.

Маш сайн. Одоо танд ямар алдар нэр хэрэгтэйг та мэддэг боллоо. Энэ асуултанд хариулахад

амархан байсан. Гэхдээ алдар нэрд ямар замаар яажхүрэх тухай асуултанд хариулахад хавьгүй хэцүү. Цаашаа уншина уу?

Алдар нэртэй болох арга замууд

Хэрэв таны үл таних хүмүүс таныг таниж байвал та алдар нэртэй болжээ. Хэрэв таны зургийг татаж, танаас ярилцлага авч байвал, эсвэл та өөрөө ярилцлага авч байвал, таны тухай бичих юмуу эсвэл та өөрөө хэн нэгний тухай бичиж байвал, та хүндэлдэг хүмүүсийнхээ оюун санаанд амьдрах болно. Тэгэхээр та аль болох том алдар нэрд хүрэх ба бүхний хүлээн зөвшөөрсөн хүн болохыг хүсч байгаа бол ерөнхий нэг зорилго бий. Энэ нь таны нүүр царайг нийгмийн аль болох өргөн хүрээнд үзэж харж байх явдал.

Танд шалгарсан арга хэрэгтэй. Энэ зорилгод яаж хүрэх вэ? Зурагтаар сайн гар. Өнөөдөр хааяа ч гэсэн зурагтаар гарахгүйгээр үнэхээр нэртэй хүн болох тухай бодохын ч хэрэггүй. Хэн, эсвэл юу энэ цагт хамгийн чухал вэ гэдгийг шийддэг шүүгч нь телевиз болжээ. Түүний хажуугаар таны нэр хэвлэлд байнга гарах талаар хичээх ёстой.

Орчин цагийн телевизийн их хүч чадлыг мэдрэхийн тулд Ховард Стерн ба Дон Имус нар зурагтаар хичнээн ойр ойрхон гарч, тэд хэрхэн улам олны танил болж байгааг санахад хангалттай. Эрдэмтэн Карл Саган "Өнөө орой" шоунд тоглохын зэрэгцээ зурагтаар 26 удаа гараад нэртэй хүн болсон. Түүнийг сая сая үзэгчид харж, энэ нь шинжлэх ухааны салбарт өсөн дэвжихэд нь түлхэц өгсөн юм. Бичдэг сэтгүүлчдийн хэн нь ч ням гаригийн өглөөний нэвтрүүлэгт оролцон чөлөөтэй ярьж болно. Энэ тохиолдолд тэр сэтгүүлч зөвхөн бичдэг сэтгүүлчээс хавьгүй илүү анхааралд өртөнө. "Та 25 жилийн хугацаанд бүх хуруугаа элэгдтэл бичиж болно. Гэлээ гээд долоо хоногт нэг удаа хагас цаг телевизийн дэлгэцээр ярьсан шиг хүмүүст хүрэхгүй" гэж "Маклауф" группийн ажилтан асан сэтгүүлч Жек Жермонд ярьжээ. Левинскигийн телевиз "Ньюсвик" сэтгүүлийн ажилтан Майкл Изиков, Ховард Финеман, "Нэшнл журнал"-ын Стюарт Тейлор нарыг дэмжсэн. Эдгээр зохиолчид сэтгүүлийн янз бүрийн шагнал ихээр авч байсан боловч зөвхөн телевиз л тэднийг жинхэнэ алдартан болгосон.

Телевиз бол од бүтээгч юм. Өөртөө имиж бий болгох ба нэр хүндээ нэмэхийн тулд дэлгэцээр ердөө ганц удаа гарахад ч хангалттай. Ванна Уйат зөвхөн "Азын хүрд" шоуны үзэгчдийн өмнө алга таших ба захидлуудыг нээх ажил хийсээр нэрд гарчээ. Алдартай болоход ердөө 30 секунд хангалттай гэдэг. Дэйв Томас мөнгөний тусламжтай эх орон даяар алдаршсан.

Телевиз хачирхалтай нөлөө үзүүлдэг. Дэлгэцээр танил царай гарахад жирийн хүмүүс хагас ухаантай болдог байна. Хамт өглөөний цай уусан хүн нь дэлгэцээр гарахад хүмүүс шоконд ордог байж магадгүй. Хэрэв "Өглөөний шоу"-ны зочин Брайант Гамбел гадаа гарч зам дээр очоод ногоон гэрэл асахыг хүлээн зогсох аваас бид тэр яг мөн эсэхийг шалгахаар гүйлдэн очиж, бас энэхүү одын сүүдэрт зогсохыг хичээдэг. Өнгөрсөн үед ерөнхийлөгч, гүнж юмуу бусад алдартай хүмүүсийг зөвхөн сонгомол цөөн хүн харж болдог байлаа. Харин өнөөдөр бид тэднийг харж сонсох учир мэддэг болжээ. Роза Донелл ба Дэвид Леттерн нарыг өдөр бүр харж сонсдог тул танина.

Тэдэн шиг хүмүүс үргэлж дагалдагчдаар хүрээлүүлсэн байдаг. Селли Квин бол "Вашингтон

пост" сонины сэтгүүлч гэдгээрээ нэртэй. Гэхдээ телевиз түүнийг алдар нэрийн шинэ оргилд хүргэсэн. Дэлгэцээр гарч эхэлсэн тэр цагаас хойш мэдээний хадаас болсон гэж тэр дурсдаг байна. "Хүмүүс над руу хуруугаар зааж, гарын үсэг гуйж, намайг телевизээр харсан гэж намуун дуугаар хэлдэг. Гэхдээ тэд Чарли Мэнсон, Синкью юмуу ер нь дэлгэцээр харсан хэнийг ч болов ингэж хүрээлнэ гэдгийг би мэднэ" хэмээн хуурайдуухан нэмж хэлэв. Хүмүүс гайхан бахдах мөртлөө голж шилдэггүй. Дэлгэцийн дүр төрхөөс бодит байдал руу хийх үсрэлт нь амжилтын зам мөр бөгөөд аль ч нэртэй хүний нүүрэн дээр ил бичээстэй харагдана.



Опра Уинфри ганц удаа рекламдахад 6800 ширхэг зарагдаад байсан ном 750 мянган хувь борлогдож бестселлер болжээ

Үзэгчид жил ирэх тутам улам ихийг шаардана. Тэд жинхэнэ түүхийг хүлээж байна. Тэр шагнал гардуулах ёслол дээр ямар хувцас өмсөх гэж байна вэ? Тэр эхнэртэйгээ ямар харьцаатай вэ? Дэлгэцийн баатруудын тухай тодорхой мэдээлэл шаардах маргашгүй эрх үзэгчдэд бий. Үүнийг ерөнхийлөгч Клинтон 1994 оны 4 дүгээр сард хэлсэн үгээрээ баталсан. Тэр сонгуулийн өмнөх амлалтаа биелүүлж MTV сувгаар гарч билээ. Тэгэхэд нэг оюутан түүнээс "Ноён ерөнхийлөгч өө, таныг ямар дотуур хувцас өмсдөгийг мэдэх хүсэлдээ хорвоо шатаж байна?" гэж асуухад Клинтон огтхон ч тэвдэлгүйгээр "голдуу сайныг" гэж хариулжээ.


Гайхалтай нь алдар нэрийн хүч түүнийг өөр өөр салбарт хэрэглэснээр өсдөггүй. Голдуу энэ нь телевизийн ачаар л явагддаг. Өнөөдөр олны танил хүмүүсийн тоо өмнөх үеэс хавьгүй их болжээ. Алдартай хүмүүсийн амьдралын хэв маягийг сурталчлах, тэдний хувийн түүхийн тоо өсч, бас ганц удаа дэлгэцээр гарах шүүмжлэгчдийн санал бодол ч нэмэгдлээ. Алдар нэр өссөөр байхад түүний хүч тулгамдсан чанараа алдахгүй. Шинэ од ассантай холбоотой сүрлэг баяр түүнийг зурагтаар гарсны дараа зохиогдоно. Хэдийгээр ийм одод улам олон болсоор байгаа ба энэ од хэдхэн сарын өмнө Техаст сэтгүүлч байсан зэрэг нь огт хамаагүй.

Дүрэм

Алдар нэр бол хоосон чимээ биш.

Хэвлэл нь уншигчдад шүтээнтэйгээ ойртох мэдрэмжийг бий болгож чаддаггүй. Тийм учраас

телевиз шиг шүтэн бишрэх өдөөгдсөн хүсэлд дуудахгүй. Гэхдээ хэвлэл таныг үзэгчид ба хүмүүст танилцуулж, телевиз рүү үсрэх тавцанг бэлдэж өгдөг. Хэрэв та телевизээр гарч чадахгүй байх аваас таны нэр хэвлэлд байнга гарч байхаар зохицуулах хэрэгтэй. Хэн ч таны тухай бичих хүсэлгүй бол та сонины редакторт өөрөө захидал бичээрэй. Түүнийг нийтэлнэ. Эсвэл сонины редакцийг худалдан аваад өөрийн үзэл бодлыг сурталчилна.



Мухаммед Али боксчин биш алдарт жүжигчин юмуу суут улс төрч шиг санагддаг байв

Хэдийгээр телевизийн нэр хүнд хэвлэлийг дарж байгаа ч та телевизээр амжилт олохоос сонин ба сэтгүүлийн гялалзсан алдар нэрийг илүүд үзэж мэдэх юм. Сэлли Квин хүмүүст ингэтлээ сонирхогдож байгаадаа тун дургүй байдаг. Тэр ярихдаа "Хэн нэгэн чиний хувийн амьдралд дайран орж, чиний хүсээгүйгээр биеэ авч явах нь үнэхээр аймшигтай. Хэн нэгэн өөртэйгөө адил хүмүүсийн дунд алдар нэртэй ба хүндтэй байхыг хүсдэг. Гэвч миний бодлоор хамгийн шилдэг алдар нэр нь чиний тухай бүгд мэддэг, чиний нэрийг бишрэн хэлдэг мөртлөө чиний царайг таньдаггүй байвал дээр. Зохиолч нар ийм алдар нэртэй, харин телевизийн тухайд энэ боломжгүй" гэжээ. Гэвч та алдар нэрийг ухаант амьдралын үнэт зүйл гэж түүний төлөө тэмцдэг бол харин телевиз олонхийн санаа бодолд таацуулахыг хүсдэг учир таны өндөр соёлтой дүр төрхийг арчин хаяж ч мэднэ. [Харолд Блум, Кэтрин Маккинон зэрэг сэхээтэн одод хэрэв тэднийг телевизэд урих юм бол баярлах болно. Артур Миллерийг санаж байгаа биз дээ].

Хэрэв телевиз ба хэвлэл танд өөрийгөө сурталчлахад тохирч байгаа бол тэдний ололт амжилт бүхнийг ашиглаарай. Дэлхийн хамгийн баян хүн Брунейн султаныг дэлгүүрт орж ирэхэд нь биеийн байцаалтаа үзүүлэхийг шаардсан байна. Түүнд өөрт нь албан ёсны ямар ч баримт байсангүй. Гэтэл түүний арваад бие хамгаалагчдын нэг нь хааныхаа гэгээн дүр бүхий энгэрийн тэмдэгээ даллан харуулжээ. Мэдээж хэн бүхэн өөрийгөө сурталчлах ийм арга хэрэглэж чадахгүй.

Одоо та алдар нэртэй болохын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслийн дэмжлэг амин чухал

гэдгийг ойлгосон учраас сонголтын асуудалтай нүүр тулгарна. Боломжит бүх аргыг ашиглаарай. Өөрийгөө харуулах нэг шилдэг арга бол маш алдар нэртэй хэн нэгэн хүн юмуу ямар нэг юмтай харьцах явдал. Арай хэцүү боловч бас л үр дүнтэй аргын нэг нь ажил мэргэжилдээ өндөр албан тушаалтай болох. Эсвэл танай мэргэжлийн чиглэлээр ямар нэг агуу зүйл дээр ажиллаж эхлэх зэрэг юм. Хэрэв эдгээр арга болж өгөхгүй бол шуугиан тарих хэрэгтэй. Бас нэг өөр зам ч бий. Хэрэв та мөнгөтэй бол алдар нэрийг зүгээр худалдаад авчихаж бас болно. За тэгээд арга зам сонгосон байлаа ч гэсэн хамгийн гол нь та хүмүүсийн анхааралд нийцэх, хурц гялалзах гял цал хувь хүн байх ёстой.

68. Алдар нэртэй хавиралцах аргыг ашигла. [Хэн нэгэн юмуу ямар нэгэн алдар нэртэй зүйлийн ойр орчим үргэлж эргэлдэх]

69. Өндөр албан тушаалд суух

70. Мэргэжлийн сонирхлын салбартаа нээлт хийх

71. Хаа сайгүй үзэгдэх

72. Алдар нэрийг худалдаж авах

73. Хурц хувь хүн байх

1. Алдар нэртэй хавиралцах

Энэ тохиолдолд хавиралцах гэсэн үг нь бусдын нүдэнд өртөх дүр төрх бүтээхийн тулд хүч хөдөлмөр гаргахыг хэлж байна. Алдар нэрийн хавиралцал гэдэг нь таны хэн нэгэн хүний дэргэд үргэлж байхыг хүмүүс харах үед та тухайн хүний нэр алдарт үзүүлж буй эсэргүүцэл л билээ. Энэ нь алдар нэр яг таны дэргэд байх бөгөөд хавирч шүргэж байгааг хэлнэ. Ийм хавиралтыг хэрхэн ашиглах вэ?

Хавиралтыг ашиглах хамгийн хүртээмжтэй арга нь телевизээр хэн нэгэн алдар нэртэй хүнээс ярицлага авах явдал юм. Иймэрхүү ярилцлага авч алдар нэрд гарсан хүмүүсийг санацгаая. Ларри Кинг, Барбара Уолтерс, Чарли Роуз. Өөрийн хөтөлбөртөө алдар нэртэй зочдыг урих тэдний чадвар өөрсдийнх нь нэр хүндийг өсгөсөн билээ.

Бас нэг шалгарсан арга нь нэртэй түншүүдийн жагсаалтыгбий болгох явдал. Таны хэн байх нь хамаагүй. Мэс засалч, салалтын асуудал хариуцсан өмгөөлөгч, үсчин, загвар зохион бүтээгч байж болно. Та үйлчилж байгаа хүмүүсийнхээ алдар нэрийг ашигла. Алдар нэрийг ингэж ашиглах чадвар өөрийг тань алдар нэртэй болгоно. Бүхий л алдар нэртэй хүмүүсийг шүтэн бишрэгчид нь маш их хүндэлдэг учраас тэдний дадал зуршил, сул тал, бас багшийг нь хүртэл биширдэг. Дэлхийн нэг номерын гольфчин Тайгер Вудс өмнөх алдартан Кованы бөмбөг дөхүүлэгч байжээ. Алдар нэр алдар нэрийг төрүүлдэг. Гэнэт Опра Уинфри таны үйлчлүүлэгч болчих юм бол та хэрхэн нэрд гарахаа төсөөлж байна уу? Түүнтэй хавиралцсан хэн бүхэн алдар нэртэй болдог. Түүний дасгалжуулагч Боб Грин, тогооч Роза Дайли, хамтран зүтгэгч Стедман Гредем, зөвлөгч Филипп Макгро гээд л. Опра ч энэ хүмүүсийн тухай өөрийн номондоо бичсэн байдаг.

Өөрийн нэрийг ямар нэг алдар нэртэнтэй холбо. Нэр алдарт дуртай боловч хараахан нэрд гарч амжаагүй эрдэмтэн нийтлэлээсээ олсон орлогыг аль хэдийн алдар нэрд гарсан нэгэнтэй хуваалцахдаа хичнээн баяртай байхыг төсөөл. Цаадах нь түүний нийтлэлд хуруу хөдөлгөх төдийхөн оролцсон

Мухаммед Али боксчин биш алдарт жужигчин юмуу суут улс төрч шиг санагддаг байв

байлаа ч ялгаагүй. Гол нь түүний сүртэй нэр хувь нэмэр болж байна. Хэрэв та алдартай хөрөнгөтөн, телепродюссер юмуу улс төрчийн тухай түүхэн ном бичих аваас телевизийн олон шоу танаас ярилцлага авах гэж зүтгэх болно. Хэрэв та хэн нэгэн нэртэй хүнтэй хамт байгууллага удирдах юм бол таны өмнө асар их боломж, нэр хүндтэй ажил ба том амжилт шууд нээгдэнэ.

Цөөн тооны азтай хүмүүсийн хувьд угсаа гарал нь алдар нэр болж өгдөг. Кеннедигийн удам бүгд алдартай. Генри Фордын нэр алдар Жейн, Питер, Брижит нарын ирээдүйг нээж өгсөн. Мартин Шиний алдар нэр Чарли ба Эмилио Эстевезам нарт мөн тусалсан. Техасын амбан захирагч Жорж Бушийн хувьд эцэг нь Америкийн ерөнхийлөгч байсны ачаар маш богино хугацаанд Бүгд Найрамдахчуудын удирдагч болж, ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх кампанит ажлаа эхлүүлсэн.

Хэрэв танай гэр бүл алдар нэртэй биш бол тийм гэр бүлийн гишүүдтэй хань ижил болох зам бас бий. Диана Спенсер ба Каролина Бессет нар од болох замаа ингэж л эхэлсэн. Памела Дигби Черчилль Хэйвад Харриман гурван удаа гэрлэх явцдаа хүүхэд насны овог болох Дигби мөн Хэйвад нэрээ алдахад хүрсэн ч Черчилль гэж овоглох эрхтэй болж авсан билээ. Хэдийгээр тэр Уинстон Черчиллийн хүү Рэндольфтой удаан амьдарч чадалгүй салж сарнисан ч овгийг нь авч чадсан юм. Эмэгтэй хүн түүний тусламжтай алдартай болдог тухай Дональд Трамп ингэж хэлжээ. "Би од бүтээгч. Би эмэгтэй хүнд алдар нэртэй болох асар том боломж өгдөг гэсэн утгаар ярьж байна. Харамсалтай нь тэд од болонгуут миний хувьд ямарч сонирхолгүй болчихдог. Энэ бол урлагийн бүтээл бүтээхтэй л адил юм. Бас их гунигтай" гэжээ.

Алдар нэртэй хавиралцах нь нэр алдартай хүмүүсийн зүгээс тан руу анхаарал хандуулахаас аргагүй болгохыг хэлнэ. Ерөнхийлөгч Клинтон ба Моника Левински нарийн секс шуугианыг ашиглан телевиз хэвлэл мэдээлэлд өртөн чансаагаа өсгөсөн тоо томшгүй олон конгрессын гишүүд ба сэтгүүлчдийн үйл хөдөлгөөнийг үнэлж цэгнэх оролдлого хийгээрэй. Бельгийн баргар анархист Билл Гейтсийн нүүр рүү хэрхэн бялуу чулуудсан тухайгаа нийтлэл бичээд бүх сонинд явуулж орхижээ. Арван жилийн өмнө сэтгүүлч Жесси Жексон нэг өглөө сэрэхдээ л олны танил болсон. Учир нь Мартин Лютер Кингийг алсны маргааш өглөөний шоунд тэр түүний цусан толботой хувцсыг өмссөөр орж ирсэн билээ. Хэдийгээр ийм үйлдэл асар их эсэргүүцэл дагуулсан ч тэр нэрд гарсан юм.

Аливаа байгууллага ч алдартай хавиралцах техникийг ашиглаж болно. Энэ тохиолдолд байгууллага нь хүмүүс ба үйл явдлыг шударга шүүдэг шүүгчийн үүргийг өөртөө авах хэрэгтэй. Америкийн телевизийн урлагийн хүрээлэн хорьдугаар зууны гайхамшигт зуун киноны нэрийг зарласнаар олны анхаарлыг өөртөө татаж чадав. Хамгийн үсрэнгүй компаниудын нэрсийн жагсаалтанд "Аз" хэмээх сонины нэрийг өгөх замаар энэ сонины

нэрийг олон түмний ухамсарт суулгасан байна. Нэгэн нууцлаг сэтгүүлч Нью-Йоркийн интернет сүлжээний хамгийн нөлөө бүхий 100 хүний нэрсийн жагсаалтыг "Силикон гудамж 100" нэртэйгээр хэвлэнгээ өөрөө Нью-Йоркийн түүхэнд нэрд гарав. |Ер нь ийм жагсаалтууд өөр өөр үзэл бодол ба маргааныг байнга дагуулдаг. Магадгүй түүгээрээ бас нэрд гарах үр дагавартай юм|.

2.Өндөр албан тушаал

Алдар нэрд хүрэх хэцүү бөгөөд урт замын нэг нь өндөр албан тушаал эзлэх явдал. Энэ тохиолдолд та зөвхөн нэр хүндтэй албан тушаал эзлэхээс гадна нөлөө бүхий албан тушаалд суух ёстой.

Дүрэм

Таны алдар нэр хүмүүс таныг хэр ойр ойрхон харахаар үнэлэгддэг.

Нэртэй албан газрыг хараандаа авч, тийшээ багтахын тулд болох бүхнийг хий. Далласын ковбой асан нэгэн туулсан замаа дүгнэн бичихдээ: "Би Далласын хөл бөмбөгийн багийн дүрэмт хувцасыг өмссөн тэр цагаас хаан болон хувирсан. Нууцлаг уур амьсгал биднийг хучив. Биднийг хаана ч ирсэн хүмүүс бахдан биширч угтдаг байлаа. Хүмүүс хөл бөмбөгийн багийг стадион руу дагуулан ордог 18 настай бүсгүйн гарын үсгийг авах гэж 3-4 цаг наранд зогсч дугаарлаж байсан. Гэтэл тэр бүсгүй ердөө хоёрхон хоногийн өмнө зоогийн газар үйлчлэгч байсан ба "Хонгор минь, франц шарсан төмс бэлдээрэй" хэмээн хашгирч өөрсдөд нь үйлчилж байсан бүсгүйн төлөө ингэтлээ дугаарлан зогсч байв" гэжээ.

Хэрэв шаардлага гарвал өөртөө нөлөө бүхий албан тушаал ба байр суурийг бодож олоорой. Хоёр мянган солигдох тэр шөнө буюу 12 сарын 31-нээс 1 сарын 1-ний шөнө төрөх хүүхдүүдэд энэ үйл явдалтай холбоотойгоор асар их ивээл хайр ирэх нь баталгаатай байв. Дональд Фезерстоун эхнэр Нэнсигийнхээ оёсон хувцасыг 15 жилийн турш тасралтгүй өмссөн гэсээр нэрд гарсан. Тэднийг телевизийн нэвтрүүлгүүдээр харуулж, гэрэл зураг нь АНУ ба гадаадын сэтгүүлүүд дээр гарлаа.

Харин та? Та өдөр бүр цэцэрлэгт хүрээлэнд шувуу хооллодог Тагтааны хорхойтон хэмээн нэрд гарч болох юм. Эсвэл хүүхдүүддээ "Цасан гоо ба долоон одой" зохиолын одойнуудын нэрийг өгснөөр нэрд гарч бас болно. Оскарын шагнал гардуулах ёслолын үеэр дуранд өртөх юмуу хөл бөмбөгийн тэмцээний үеэр талбай дээр гарч гүйж бас болно. Танд өчүүхэн аз дайрвал орон нутгийн чанартай алдартан болно.

Гэхдээ таны ажиллаж байгаа байгууллагаас илүүтэй зөвхөн та хувь хүний хувьд алдартай болсон гэж эндүүрэх хэрэггүй. Танай албаны нэр хүнд таны алдар нэртэй хамт өснө. Хэрэв та алдар нэрийг танд авчирсан тэр албан тушаалаас гэнэт буулаа гэхэд алдар нэр өөрөө тэсч үлдэх нь ховор. "Тойм"-ын редактор Норманн Подхорец ярихдаа, тэрбээр хүмүүст хувь хүнийхээ хувьд огт сонирхолгүй байсан бөгөөд тэд зүгээр л "Тойм"-ын редактортай уулзаж ажиллахыг хүсдэг байв. Энэ албан тушаалд хэн байх нь огт хамаагүй. Тэд байгууллагынх нь нэр төрийг өргөх хүнтэй харьцаа тогтоохыг хүсч байжээ. Хэрэв таны эргэн тойронд таныг хүндэтгэн өргөмжлөхөд бэлэн хүмүүс байх аваас тэд таны зүгээс ач буян хайж байгаа биш ба

гагцхүү танай байгууллагатай холбоо тогтоох замыг эрж хайж байгаа гэдгийг санаарай. Та өөрөө гялалзсан удирдагч юмуу гүйцэтгэгч байх нь тэдэнд сонин биш.

3. Мэргэжлийн салбартаатом нээлт хийх

Энэ нь албан тушаал эзлэхээс ч хэцүү. Гэвч хэрэв та нээлт хийж чадсан бол түүнийг даган өндөр албан тушаал ирнэ. Гэхдээ та юу хийх ёстой юм бэ? Шинжлэх ухааны нээлт хий. Усанд сэлэлтийн дэлхийн дээд амжилтыг эвдэх юмуу дэлхийн

хамгийн том хавчуургатай талх хийсэн гэж Гиннесийн номонд ороорой. Хамгийн тансаг төрсөн өдрийн баяр зохион байгуул. Хамгийн шилдэг борлуулалттай ном бич. Дэлхийд хамгийн анхны бөхийн дунд сургуулийн эмэгтэйчүүдийн багийг үүсгэ. Аливаа юмыг анхалж хийсний хэрээр алдар нэртэй болох боломж их байдаг. Арга ядахад бусдаас хурдан хий.

Алдар нэр таны шинэ бүтээлээс шууд хамаарахгүй. Энэ нь зөвхөн алдар нэртэй болох арга зам л юм. Английн зохиолч Вильям Хезлитт бичихдээ: "Ганц хүний алдар нэрийн зам нь байж болох бүх замуудаас хамгийн нарийн, хамгийн урт болоод хамгийн хүнд хэцүү байдаг" гэжээ. Ямар ч байлаа гэсэн ийм маягийн алдар нэр сүртэй тод байдаг. Энэ алдар нэр зөвхөн танд харьяалагдана. Алдар нэрд гарахын тулд хамгийн их хүч хөдөлмөр зарсан тэр хүнд харьяалагдана. Та одоо өөр хэний ч алдар нэрээс хамаарахгүй. Түүний алдар нэр таныг олны нүдэнд өртөхөд туслаагүй. Харин таны хийж бүтээснийг өөр хэн ч булаан авч чадахгүй. Та өөр хэн нэгэн худалдан авах юмуу тантай гэрээ хэлцэл хийж өөрийн болгох аргагүй тийм хэлбэрийн алдар нэртэй болжээ.

Хэрэв та гайхалтай нээлт хийсэн бол энэ эхэлснээ цааш үргэлжлүүлж хүрсэн дээрээ зогсохгүй байх, эсвэл эрдэмтний алдар нэр дээрээ өөр төрлүүдийн алдар нэрийг нэмж чадвал бүр их алдар нэр цуурайтна. Мухаммед Али өөрийгөө алдарт боксчин гэхээс гадна бас хурц ухаантай, сэтгэлгээ сайтай гэдгээрээ алдартай болохоо ойлгосон. Тэр нэг удаа хэлэхдээ "Хэрэв би бусдын анхаарлыг татахуйц хашгирч шуугиж чаддаггүй бол долоо хоногийн дараа хаана байх байсан гэж та нар бодож байна. Би төрөлх хотдоо очоод машины шил арчиж, цахилгаан шатны харуул хийх байх. Тэнд би өөрийн байр сууриа эзлэх байсан" гэжээ.

4. Алдар нэрийн төлөөх гэмт хэрэг

Танд мөнгө, хэлхээ холбоо, авьяас чадвар аль аль нь байхгүй мөртлөө алдар хүндтэй болохыг хүсдэг байж мэдэх юм. Та хэний ч үл таних хүн байсан дор ядахдаа муу талаар ч гэсэн алдар нэртэй болохыг хүсвэл хэрүүл шуугиан өдөөж, бусдын санаанд ч орохгүй зүйлийг хийж, энэ тухайгаа бүх хүмүүст яриарай. Тэгвэл та хүссэн үр дүндээ хүрнэ. Энэ нь таны зорилго руу түлхэц өгнө. Та яг л оготно шиг газар сайгүй гүйж, таны тухай хаа сайгүй ярих болно.

Дүрэм

Шуугиант амжилт ямар ч амжилтгүй байснаас дээр.

Та хэрхэн "Нэшионал Энквайер"-ын азгүй хохирогч болсон тухай түүхээ худалдаарай. Эсвэл нууц давхар амьдралынхаа тухай бусдыг шоконд оруулам түүхийг сэтгүүлчдэд ярьж болно.

Сексийн бохир заваан явдлуудаа дэлгэрэнгүй бичиж ч болох юм.

Хэрүүл шуугианаар нэрд гарсан Донна Раис, Паола Жонс, Марла Мэйплс нарын жишээг дагаж болно. Тэд жинс үйлдвэрлэгч компанийн рекламанд оролцоод дараа нь өөрсдийгөө рекламдсан байдаг. Жон Уайны эхнэр уур хилэндээ автан нөхрийнхөө бэлиг эрхтэнийг тас хэрчиж орхисноор нөхрөө алдар нэртэй болгосон.

Жон Уайн энэ үйл явдалд зориулан бүхэл бүтэн кино хийсэн бөгөөд сенсаацид дуртай үзэгчид баяртай худалдан авчээ.

Мэдээж алдар нэрийн төлөө гэмт хэрэг үйлдэх нь байж болшгүй зүйл. Гэвч энэ шалтгаан гэмт хэрэг гарах хамгийн түгээмэл шалтгаануудын нэг байдаг. Зарим гэмт хэрэгтнүүд хэвлэл мэдээллийнхэн түүний хийсэн хэргийн тухай мэдээг шүүрэн авч, "алдар нэр" нь хаа сайгүй цуурайтахыг хүлээж суудаг. Алдар нэрд гарах мөрөөдөл нь Колумбын коллежийн 17 настай сурагч Дилан Клеболд ба 18 настай Эрик Харрис нарыг бараг залгисан бөгөөд тэд 1999 онд 13 хүн алж нэрд гараад дараа нь амиа егүүтгэсэн. Дунд сургуулийн нийтийгхамарсан аллагын төлөвлөгөөг тэд гэртээ сайтар бодож боловсруулсан байдаг. Холливудын өндөр орлоготой нэгэн кинонд гардаг шиг Клеболд "Найруулагчид энэ түүхийг сонсоод цочин дагжих болно" гэж байв. Захирлыг сонгох эсэх дээр багагүй маргаан дэгджээ. Ингэхэд захиралд Квентин Тарантино ба Стивен Спилберг хоёрын хэн нь таалагддаг вэ? Харрис: "Аливаа аллагыг гоёмсог бэлэг тэмдэг ба түгшүүртэй егөөгөөр чимэх ёстой" гэж санал болгосон байна.

Жиан Люги Ферри 1993 онд 8 хүнийг буудан хороожээ. Тэрбээр үхэхийнхээ өмнө захидал үлдээсэн ба түүндээ Опра Уинфри, Фил Донахью, Жералдо Ривьера нарыг буудан алмаар байна гэж бичжээ. Канзасын цуврал алуурчин цагдаагийн газарт бичсэн захидалдаа "Миний нэр сонинд гарахын тулд би өөр хичнээн хүнийг алах хэрэгтэй вэ?" гэж бичиж байв.

Алдар нэрд гарахын тулд гэмт хэрэгтэн туйлын увайгүй гэмт хэрэг үйлдэхэд хүрдэг. Алдар нэртэй хүмүүсийн эсрэг бохир завхай үйлдэл хийх гэх мэт. Тэгэх юм бол гэмт хэрэгтнийг яг л од шиг өргөмжилж, мотоциклийн цуваа түүнийг дагалдаж, тэдний дурсамж номнууд санаанд багтамгүй үнээр зарагддаг. Иймэрхүү түүхийг одод өөрсдөө ярих байх. Норман Мейлер, Трумен Капоте, Жо Макгиннис, Эрол Морис нарын хийсэн шиг.

Үнэн хэрэгтээ улс төрчид ба одод руу дайрахын шалтгаан нь алдар нэрд шунах шунал байдаг. Гэмт хэрэгтнүүд өөрт нь алдар нэр авчрах нэртэй байг сонгодог. Ерөнхийлөгч Рональд Рейганыг алсанаар хорин таван настай Жон Хинклигийн тухай сонинуудын тэргүүн нүүрэнд бичиж, улмаар тэр жүжигчин Жоди Фостерын хүндэтгэлийг байлдан дагуулах байсан гэнэ. Түүний халдлага алдар нэр авчирна гэж үзсэн тухайгаа Хинкли хүлээн зөвшөөрсөн байдаг. Халдлагаас хойш 5 цагийн дараа мань эр энэ тухай телевизээр гарсан эсэхийг нууц албаныхнаас асууж байв.

Хэдийгээр энэ нь тун үр дүнтэй арга боловч хууль ёсных биш юм.

Хэрэв та зарим нэг талаар алдартай бол олби оготно шиг хаа сайгүй үзэгдэх нь алдар нэрийг улам өргөж өгнө. Тэр тусмаа та ад үзэгдсэн нэгэн гэсэн алдартай бол бүр илүү. "Бэд бой

энтертаймент" компанийн нүүр царай болсон Шон Комбс жинхэнэ дуулиан шуугиан тарьсан. Тэрбээр фонограммаа устгаж, Манхеттэний шөнийн клубын тайзан дээрээс шүтэн бишрэгчиддээ, залхах боломж олгохгүй гэж хашгираад зугтсан юм. Шүтэн бишрэгчид ч түүнийг хүндэлж, түүний нэр ба дүр төрхийг санасаар л байна.

5. Алдар нэрийг худалдаж авах

Хэрэв дээр дурдсан аргуудаас аль нь ч танд тохирохгүй байвал алдар нэрийг зүгээр л худалдан ав. Гэхдээ танд мөнгө хангалттай бол шүү дээ. Та "Мөнгө" сэдвийн 11 дүгээр бүлгийг уншаарай.

6. Хурц тод хувь хүн

Аль замаар явах нь чухал биш. Гэхдээ алдар нэрд хүрэхийн тулд таныг хүмүүс аль болох олон удаа үзэж харах ёстой. Та нөлөө бүхий ивээн тэтгэгчийг яаж олох вэ? Хурц тод хувь хүн бай. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тэдний хүсээд байгаа зүйлийг нь өгч сур. Хурц шүүмжлэл хурдан хариулт, айдас төрүүлэм үгс, зураг.

Дүрэм

Зурагт ба хэвлэлийн алинд ч бай энэ нь үргэлж хүчтэй үйлчилдэг.

Хэвлэл мэдээллийн бүх хэрэгслийг ашигла. Гарчиг нь сэтгэл догдлом байх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэмнэлээр амьдар. Тэдний тоохгүй байгаа хүмүүсийг үл тоож, хамгийн тулгамдсан асуудлын талаар ярь. Коммунистуудыг мөрдсөн сенатч Жозеф Маккарти хэвлэлийг жолоодох талаар мастер байсан. Тэр эсрэг тэсрэг үзлийн эх сурвалж байсан ба үе үе чанга дуугаар мэдэгдэл хийдэг байв. Тэр хэвлэлд мэдээ мэдээллээ маш түргэн нийтэлдэг байсан учир уншигчид энэ мэдээллийг шалгаж ч амждаггүй байжээ.

Өнөөдөр энэ давуу талыг барьж тогтоох нь хамаагүй хэцүү. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэдэггүй хүн олон болсон. Хэвлэл мэдээллийн хэрэгслийг жолоодох ба хөдөлгөх нь бүхэл бүтэн бизнес болжээ. Асуулт бүр дээр зөвлөгч, яриа бэлтгэх зохиолчдыг татан оролцуулдаг болсон байна. Рональд Рейганы хэвлэлийн нарийн бичгийн дарга Майкл Дивер төрийн тэргүүнд зориулсан гэрэл зургийн шинэ хэлбэрийг бодожолсноор ерөнхийлөгчийн амьдралыг тэрчигээр нь өөрчилсөн гэдэг. Энэ нь сүүлийн үеийн мэдээ гэдгээс хавьгүй илүү хүчтэй сэтгэгдэл төрүүлж байв. Өнөөдөр жижиг хот бүрт түүний зарчмыг ашиглах болжээ. Тэр бүү хэл хэний ч үл таних хүмүүс хүртэл ням гаригийн шоунд орохын тулд яриагаа хэрхэн чимэглэхийг мэддэг болж. Өнөөгийн ертөнцөд алдар нэрийн төлөө тэмүүлэгчид нулимс асгарам түүх ярьж гэрэл зураг харуулах үед тоймчид тэдний ярианы даацийг дарж өгдөг болж. Гэхдээ тэдний тэр арга нь үргэлж үр нөлөө өгдөг сайн арга л даа.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэзээ ч таныг тойрон өнгөрөхгүй байхын тулд хичээ. Хэрэв та тодорхой нэр алдартай болсон бол бүх давуу талаа ашигла. Олны анхаарлын төвд байгаа давуу талуудаа ашиглаж чадвал үзэгчдийн сонирхолыг татна. Анхаарал улам их анхаарлыг дагуулдаг. Өөрийн эрчээр хөдлөх энэ хүчийг та зорилгодоо ашигла. Та дэлхий даяар аль болох

их анхаарал татахын хэрээр улам нэр алдартай хүн болно. Та аль хэдийн хүлээн зөвшөөрөгдсөн. Гэхдээ яаж? Та доорх сайтар боловсруулагдсан аргуудыг ашиглаж болно.

Яриан дундаа онцгой үгхэллэгхэрэглэ. Энэ нь хүмүүсийн цээжинд үлдэх хурц хэллэг байх ёстой. Жишээ нь Жонни Кокран "Хэрэв бээлий чинь багадаад байвал зүгээр л тайлчихаач" гэж хэлсэн байдаг. Харин Росс Перо Мексикт явуулсан эрэл хайгуулын үеэр "...гайхалтай сорох дуу чимээ" гэж хэлэн нэрд гарсан. Ллойд

Бентсен "Би Кеннедиг мэддэг байсан. Тэр миний найз байлаа. Сенатч аа, та бол Кеннеди биш шүү" гэж хэлдэг байжээ. Хэрэв таны сэтгэлгээ хүрэхгүй бол кино болон рекламн нэрд гарсан хэллэгүүдийг ашиглаарай. Жишээ нь "Үхрийн мах хаана байна?" гэсэн хэллэг ямар вэ?

Хүмүүсийн нүдэнд торохын тулд хайр дурлалыг ашигла.

Янаг амрагийн явдлыг бүү март. Холливудын одод Гвинет Пэлтроу ба Бен Аффлек нар яг ийм алхам хийсэн. Сэжгийг дарахын тулд Барбара Стрейзанд шиг эсвэл нөхөрт гар, эсвэл эхнэр ав. Магадгүй та яаралтай Лайл Ловеттын эхнэр болсон Жулия Робертсын жишээг дагаарай. Аль хэдийн алдар нэртэй болсон Мадонна Шон Пенн хоёр сүй тавьсан тухайгаа зарлаж байв. Сенатч Альфонс Дамато ба Клаудия Кохен нар хайр дурлалаа зарлах гэж бүхэл бүтэн хэвлэлийн бага хурал хийсэн. [Гэхдээ энэ нь түүний зүгээс тун бодлогогүй алхам болсон. Учир нь сенатч тэгэхэд эхнэртэй байсан аж]. Хэрэв хуримын тухай таны мэдээ хүмүүсийг шоконд оруулахгүй байх юм бол энэ тухай ер бусын нөхцөл байдалд зарлаад үз. Усан дор, спортын талбай дээрх завсарлагын үеэр, эсвэл сансарын "Шатл" хөлөг дээрээс. Хэрэв та аль хэдийн эхнэр юмуу нөхөртэй бол салах замаар алдар нэрд гарч болно. Шуугиантай салалт хийж алдар нэрд хүрсэн тэрбумтнуудын эхнэр асан хатагтай Трамп, Рональд Перелмэн, ба Ларри Фортенски нар байна.

Хэрэв танд хайр дурлалын адал явдал тохирохгүй бол хэрүүл шуугиан өдөөх юмуу дур алдарч болно. Яг л Фрэнк Синатра, Ричард Прайер, Мадонна нар шиг. Хүмүүсийн сэтгэлийг донсолгохын тулд нүцгэн шалдан харагдаж ч болно. Лил Ким ийм алхам хийсэн. Харамсалтай нь түүнд хүний нүд татах юу ч байсангүй.

Идэвхитэй бай. Тэгвэл таны алдар нэр бүр өснө. Ричард Гир Түвдээр аяласныхаа хүчинд одоо байгаа тэр хүн болж чадсан. Харин Уоррен Битти ерөнхийлөгчтэй сээтэгнэсний дараа олны танил болов. Хэрэв та улс төрөөр оролдож байгаа бол шалтаг гарах болгонд өөрийн үзэл бодлыг хэлж байгаарай. Ер бусын үзэл баримтлал уншигч ба үзэгчдийн сонирхолыг онцгой татдаг учраас хамгийн санаанд оромгүй байр суурийг эзэлж бай.

Хэрүүл маргаан өдөө. Та олонд танигдаагүй үзэл баримтлалыг дэмждэг хүн бол нууцыг нээ, урьд нь ил гараагүй цоо шинэ дээдсийн хүрээний хов яриаг дэлгэ. Ингэснээр та олны нийтийн анхаарлыг өөртөө татна. Дэгсдүүлэх айдас, түгшүүр. Саятан Жон Феэчайлд эцгийнхээ сонины дампуу худалдаанд хүмүүсийн анхаарлыг татахын тулд моодны шинэ урсгалыг сурталчилж, мөн "Эмэгтэйчүүдийн өдөр тутмын хувцас" сониндоо хорвоогийн хамаг хов живийг тавьдаг байв. Танаас огт хүлээгээгүй тийм юмыг хий. Хэрэв та хуучинсаг үзэл баримтлалаараа алдартай нэгэн бол эрчүүдийг хамгаалсан ном бич. Хэрэв та нэртэй

банкир бол баян хүмүүсийн ёс суртахууны ялзралын тухай бичээрэй.

Өрсөлдөөн. Хүмүүс өрсөлдөөнийг ажиглах, өөрийн дэмжиж байгаа хүнийхээ төлөө зовних дуртай. Марк Макгвайр ба Сэмми Соса нар бейсболд, Анна Винтур ба Кейт Бесс нар загварын ертөнцөд өрсөлдөнө. Чанга дуутай спикер Ньют Гингрич нөгөө танхимын эсрэг сүрлэг үг хэлсэнээр ардчилагчдын танхимын нэрийг хүмүүсийн нүдэнд өндөр өргөж өгсөн. Бритни Спирс ба Кристина Агилера нарын поп хөгжмийн тухай ихийг бичиж болно. Гэхдээ тэдний ширүүн өрсөлдөөн хүмүүсийг өөр талаасхарахад хүргэсэн. Галзуу өрсөлдөөн таны нэрийг засч янзлан хүмүүсийн ой тойнд он удаан жил суулгаж өгдөг. Жишээ болгон Николаус ба Палмер, Мантле ба Мэйс, Эверт ба Навратилова нарыг санахад хангалттай.

Хүмүүс таныг ой тойндоо үлдээх ба та өөрөө тэдэнд тааламжтай байхын тулд наргианы мэдрэмжийг мартаж болохгүй. Түүнийг ашиглаж сураарай. Йога Бера зөвхөн дасгалжуулагч, баг болоод азын хүчээр бейсболын домог болсон юм биш. Тэрбээр "Миний хэлсэн зүйлсээс үнэн хэрэгтээ би юуг ч хэлээгүй" гэж хэлээд нэрд гарчээ. Түүнээс амьдралын ямар сургаалыг дагадаг тухай асуухад "Хэрэв та замын уулзвар дээр ирэх юм бол замаараа л гар" гэж хэлсэн юм. Харин дараагийн удаа цаг хугацааны тухай түүнээс асуухад тэр "Та яг одоо гэсэн утга агуулж байна уу?" гэсэн байдаг.

Гэнэтийн үйл явдлыг төлөвлө. Энэ үйл явдлын төвд та орж, таны зургийг байршуулж, бүх сонин хэвлэл энэ тухай бичнэ. Захиргаанаас халагдахыг эсэргүүцэн өөрийгөө төмөр хашаатай гинжлэх юмуу шударга бусаар буруутгагдсан хүний эрхийг хамгаалаарай. Нэрт теннисчин Жон Макинрой түүний алдар нэр бол шүүгчидтэй дандаа хэрэлдэж, цохиураа шиддэг байсантай холбоотой болхи алдар нэр гэжхүлээн зөвшөөрсөн байдаг. Гэвч энэ бүхэн үзэгчдийн сонирхол ба сэтгэлийг тоглолтонд татахын тулд сайтар бодож хийсэн жүжиг гэсэн байна.

Хүлээн зөвшөөрөгдөх бас нэг арга байдаг нь танигдахгүй үлдэх гэвэл та гайхна. Та үргэлж нуугдаж, үнэн байдлаа нуух аваас хүмүүсийн сонирхолыг татаж, тэд таны тухай маргалдаж, яриа хэлц үүсгэдэг. Зохиолч Жо Кляйн өөрийн улс төрийн "Үндсэн өнгө" номондоо хүмүүсийн анхаарлыг ихээр татаж, бас нэр хүндээ овжин өргөсөн юм. Тэрбээр нүүр царайгаа нууж, үзэгчдээс нуугдаж байлаа. Өөр үед бол энэ номыг гартаа ч барьж үзэхгүй байсан олон олон хүмүүс харин одоо номыг бүхэлд нь уншаад зогсохгүй түүний тухай маргаанд оролцож байна. "Вэнити Феэр" сонины "Миний анхны Гольфстрим" нийтлэлд тийрэлтэт хөдөлгүүрийн нэгэн эзэн ахан дүүсийн холбоонд ороод баяр хөөр болж байгааг дүрслэн бичжээ. Нэр нь үл мэдэгдэх зохиогч мэдээлэл сайтай бизнесмен гэсэн нэрээр гарчээ. Хэрэв энэ нийтлэлийн дор "Майкрософт" компанийн техникийн захирал нэрээ тавьсан бол нэг их сонирхол татахгүй л байсан. Тэгсэн бол цуу яриа дэгдэх боломжгүй байсан. "Нью-Йорк таймс" сонины рестораны тоймч Рут Рейчел зургийг нь авах үед үргэлж амны хаалт зүүдэг байжээ. Тиймээс рестораны бүх ажилтнууд түүнийг дандаа таньдаг байв. Гэвч түүний хаалт зүүж явдаг нь бусдын зүгээс ихээхэн сонирхол төрөхөд хүргэсэн. Гэхдээ хэрэв та оньсого шиг байхыг хүсэхгүй бол...

Өөрийн нэрийг ашигла-н хүлээн зөвшөөрөгдөнө. Малком Икс гэсэн овог нэрийг мартаж боломжгүй. Сэтгүүлч Женнифер Ли хамгийн түгээмэл нэртэй хүн. Овог нь бас тун түгээмэл хятад овог. Тэгэхээр нь тэр "8" гэсэн нэр өөртөө өгчээ. Тэгээд өөрийгөө Женнифер 8 Ли гэж

нэрлэх болсон. Нүдэнд шууд тусах мартагдашгүй нэр, мөн ийм шинэлэг байдал нь сонины шинэхэн дугаар бүрт хоёр багана нийтлэл нь амжилттай уншигдахын баталгаа болсон. Боломжтой газар бүрт нэрээ байршуул. Бүтээгдэхүүн дээр, шинэ бүтээл дээр нэрээ тавь. Өөрийн компанийн үйчилгээтэй хамт нэрээ сурталчил. Санхүүч Майкл Блумбергийн хувьд санхүүгийн мэдээллийн терминалдаа "Блумберг" нэр өгсөнөөр айл бүхэнд түүний нэр танил болжээ. Нью-Йоркийн ресторануудад үндэслэгч эзэд нь өөрсдийн нэрийг өгсөнөөр алдартай болдог. Б.Смит гэхэд "У.Б.Смит", Даниэль Боло гэхэд "Даниэль" болон "Кафе Боло" нэрүүдээр ойлгогдох болж.

Гадаад төрхийг өөрчилж болно. Жишээ нь Хиллари Клинтон, Диана гүнж юмуу холливудын од Гвинет Пэлтроу нар үе үе үс засалтаа өөрчилж хэвлэлд шуугиан тарьдаг. Та олны анхаарлыг татахын тулд ер бусын бэлэг тэмдгийн шивээс хийлгэж болно.

Хэрэв та санаанд оромгүй аюул юмуу эмгэнэлт байдалтай нүүр тулах аваас алдар нэрд хүрэх найдвартай замаар алхаж явна. Рок од Курт Кобейн амиа хорлосны дараа түүний бэлбэсэн эхнэр Кортни Лав шууд анхаарлын төвд орсон.

Бас бүлэг хүн ганц хүнийг бодвол анхаарлын төвд орох нь хурдан байдгийг санаарай. Хамгийн найдвартай арга нь бүлгийн нэр хүмүүсийн ой тойнд түргэн сэргэх явдал. Жишээ нь "Младотурки" гэдэгтэй төстэй, тиймэрхүү. Хэрэв та бүлгийн дотор байгаа тааламжгүй санал зөрөлдөөн, бэлгийн эрх чөлөө болон ухаангүй явдлуудын тухай цуурхал дэгдээх юмуу зохион ярьж эхэлбэл бүх хүнд асар их таашаал өгнө. Цогц стратеги хамгийн сайн үр дүнтэй. Алдартай жүжигчид, дуучдын бүлэг алдар нэрд хүрдэг. Фрэнк Синатра, Дин Мартин, Сэмми Дэвис, Питер Лауфорд гэх мэт. Наяад оны дундуур Шон Пэнн, Роб Лоу нарын хамтлаг байв. Бүх л супер загвар өмсөгчдийн амьдрал, найз нөхөд болон өрсөлдөгчдийг нь хүмүүс сонирхож байдаг. Наоми Кемпбелл, Кристи Терлингтон, Линда Евангелиста гээд л.

Өөрийгөө бусад хүмүүсээс тусгаарлахын тулд таны имиж нүдэнд тусахаар байх хэрэгтэй. Энэ нь танаас хувь хүнийг олж харахад тусална. Тэгээд таны нэр шар хэвлэлийн бохир хуудаснаа гарч ирэхийн цагт таны имиж л өөрийг тань бусад хүмүүсээс ялгарахад тусална. Энэ бүхэн Гомерын туульсыг санагдуулдаг. Саарал нүдэн Афина, ягаан хуруут Эос. Мэтт Драж зөөлөн хилэн бүрх малгайгүйгээр олны нүдэнд үзэгдэж чаддаггүй. Зохиолч Том Вульф үргэлж зөвхөн цагаан костюм өмсч явдаг. "Плейбой"-гийн гэрэл зурагчин Хуг Хефнер үргэлж л өөрийн пижамтайгаа нүдэнд өртөнө. Нэртэй өмгөөлөгч Гарри Спенсер цацагтай костюмтай. Архитекторч Филипп Жонсон, холливудын төлөөлөгч Ирвинг Лазар, дуучин Элтон Жон, Лео Вассерман нар бариу бөгөөд гальбирыг нь зааж өгсөн хувцас өмсдөг.

Үс засалт үргэлж хүмүүсийн анхаарлыг татдаг зүйлийн нэг. Боксын менежер Донна Кингсийн үс дандаа өрвийн боссон байдаг. Денис Родман үсээ солонгын долоон өнгөөр будна. Шинед О Коннор халзалж хусдаг бол эгч дүү теннисчин Венера Сирена нар гээг сүлжиж тууз зүүдэг учир хялбар танигдана. Зураач Сальвадор Далиг бага мэдлэгтэй хүн хүртэл туранхай гальбир мушгирсан сахлаар нь танидаг.

Хэрэв та эмэгтэй хүн бол ямар нэг зүйлээрээ ялгарахад хэцүү байж болох юм. Эмэгтэй моод маш түргэн солигдож байдаг. Жоселин Вилдешгайн ["Сүйт бүсгүй Вилдешгайн" буюу "Арслангуудын хатан хаан"] энэ асуудлыг ганцаараа байж шийддэг. Хувцсаараа ялгарахын

оронд тэрбээр өөрийн муур шиг давгагдашгүй төрхөө тодруулах, товойсон шанаагаа ялгаруулах, зөөлөн арьс ба тэгш бус хэмтэй онигор нүдээ тодотгохын тулд гоо сайхны мэс засал хийлгэдэг. Тэргүүн хатагтай Нэнси Рейган их гаж бөгөөд нарийн мэдрэмжтэй нэгэн байсан. АНУ-ын бэлэг тэмдэгтэй хувцас өмсөхийг хуульчлахын оронд тэрбээр улаан өнгийн хувцасыг илүүд үздэг байв. Мөн төрийн албаны бусад эрчүүдийн эхнэрүүдэд зөвхөн тэргүүн хатагтай л ийм өнгөтэй хувцас өмсөх эрхтэй гэдгийг ойлгуулсан.

Хэрэв та бусдаас ялгарахаар шийдсэн бол маягтай нэгэн болохыг хичээ. Ламар Александр 2000 оны ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээр шийдэхдээ шотланд бүтээлгээсээ татгалзсан нь тун мэргэн санаа байсан. Тэрбээр энэ бүтээлгийг 1996 оны уралдаанд хожсон хэдий ч энэ шинэлэг байдал маргааны сэдэв болсон юм.

Ивээл хүртэж эхэлсэн бол таны дэргэд гэрэл зурагчид байх тал дээр анхаар. Таны царайг олон түмэн нэрний адил сайтар тогтоох ёстой. Сонин сэтгүүлүүд нийтлэлдээ илүү анхаарал татахын тулд хөргөөр чимдэг. "Уолл-стрит журнал"-ын түүх даацаараа арван тиймэрхүү түүхийг ч нам дарна. Гэхдээ энэ бол дүр төрх нь сонин хэвлэлийн хуудаснаа амьдарсаар байгаа хүмүүсийн түүх билээ. Хэрэв та нийгмийн амьдралд нэртэй болохыг хүсвэл гэрэл зургаа сонин хэвлэлд нийтлэхийг хүсэх биш бүр амин чухал хэрэгтэй байна. Таны нийгмийн зориулалттай гэрэл зураг яг Патрика Макмалланых шиг олон байх тусмаа сайн. Хэвлэл таныг "Харперс базар", "Квеста" юмуу "Нью-Йорк"-ийн хуудаснаа нийгмийн ямар ч дүр төрхөөр танилцуулж чадна.

Алдар нэр-тийм

Олон түмнээс дайжиж ямар нэгэн эзэнгүй арал руу зугтаад тэндээ гэр бүлийн харьцаа зохиох.

Сэтгүүлчдийг зөөдөг машин хөлсөл.

Экологийн гэмт хэргийн эсрэг шагнал гардуулах ёслол дээр шуугиантай эсэргүүцэл өдөөх

Хэрэв та эмэгтэй хүн бол өөрийгөө бисекс гэсэн цуу тараа

Хэрэв та эр хүн бол гурвуулаа хийх сексэд дуртай гэсэн цуу тараа.

Алдар нэр-үгүй

Та нэртэй шүүгчтэй гэр бүлээ батлуулах ёстой ба энэ үед хотын захиргаа үл таних хүмүүсээр дүүрсэн бол бүү оч

Сэтгүүлчдийг зөөх машин хөлслөхийг өөртөө бүү зөвшөөр.

Экологийн гэмт хэргийн эсрэг шагнал олгох ёслол дээр ямар нэг мэдэгдэл хийх хэрэггүй.

Хэрэв та эмэгтэй хүн бол бисекс гэсэн цуу бүү тараа

Хэрэв та эрэгтэй хүн бол танд гурвуулаа хийх секс таалагддаг гэж бүү ярь.

Хэрэв та хичнээн хичээгээд ч алдар нэр танд ирэхгүй байх аваас алдар нэрийн шуналаа жүжигчний ажлаар дар. Кино продюссер Дон Симпсон Францаас Девиллийн кино наадамд ирэхдээ түүнийг шүтэн бишрэгчид бүчин авч шүүрээсэй гэж мөрөөдөж байсан тухайгаа хэвлэлийн төлөөлөгчдөө ярьсан байдаг. Хэрэв танд хувийн хэвлэлийн төлөөлөгч байхгүй бол та Тинселтоун студийн Анагейм паркад нэвтрэхийн тулд 45 доллар төлөх хэрэгтэй. Ийш орохын өмнө таны хөлд улаан хивс дэвсэж, гэрэл зургийн аппаратууд гялсхийж, шүтэн бишрэгч залуучууд гарын үсэг авахаар дайрч, сэтгүүлчид сониндоо ярилцлага авахаар гуйж, папарацци нар таны зургийг зогсоо чөлөөгүй дарах болно. Та нэг шөнө алдар нэртэй хүн болно. Хэрэв та гэртээ ойрхон байхыг хүсдэг бол бар юмуу караоке ороод дуулж эхэлсэнээр эндхийн нэртэй хүн болно. Энэ нь алдар нэрд хүрэх хамгийн хүртээмжтэй арга.

Интернет-провайдерууд хамгийн тансаг хүслийг ч хангах чадвартай, алдар нэрд хүрэх шинэ замыг нээлээ. Таны нэр тавигдаж бас хүн бүр уншина гэж бодохоос өвдөг чичрэлтийг мэдрэхийн тулд өөрийн сайтыг нээгээрэй. Та өөрийн гараар веб хуудсаа бүтээж нээгээд, түүнийг ердөө тавхан хүн орж сонирхох үед яг ингэж өвдөг чичрэхийг мэдэрнэ. Та вэб хуудас дээрээ аливаа сэдвээр өөрийн бодол санааг бичиж тавихаас гадна видео аудио материал мөн гэрэл зургаа байрлуулна. Хэрэв таны вэб хуудас танд аль хэдийн нэрд гарчихсан мэт мэдрэмж өгч байвал үнэхээр тэгсэн гэж бүү бод. Өвөрмөц кино сонирхогч Гари Ноулз өөрийн сайтыгхолливудаас алс хол нээсэн билээ. Тэр өөрөө Техаст амьдарч байсан ч түүний сайт бүх сонин хэвлэлийг өөрийнх нь тухай дуугарахад хүргэсэн. Хэдийгээр сайтыг хийхдээ их содон бахадмаар хийсэн боловч маш олон хүн сайтад морилж түүний хуудсуудыг уншиж эхэлжээ. Энэ бол танд өгөх сайн хичээл мөн үү? Эргэлзэх хэрэггүй. Товойн гарахын тулд боломж бүхнийг ашигла. Хэрэв та алдар нэрийг байлдан дагуулах замд аль хэдийн гарахаар шийдсэн бол дараах зөвлөгөөнүүдийг уншаарай.

1. Алдар нэртэй хавиралцах, хэн нэгэн алдар нэртэй хүнтэй харилцах

Бидний санал:

Та байрныхаа урьдах зүлэг цэцэрлэгийг өөрийн үзэмжээр ашиглах эрхийг алдартай хүнд өгөөрэй. Тун удалгүй тэнд дахин хэд хэдэн алдартан гарч ирнэ.

Таны танил тэднийг татан авчирна. Удалгүй таныг маш сайн цэцэрлэгч хэмээн ярьж эхлэх бөгөөд таны харъяаны нуга хөндийг түрээслэх тухай ярина.

Тансаг үдэшлэг зохиож, зөвхөн алдар нэртэй хүмүүсийг урина. Таныг онцгой содон хүлээн авалт хийсэн тухай хот даяараа мэдэх болно.

2. Нүдэнд торохуйц байрлал эзлэх.

Санал:

Зул сарын баярын чимэглэл нь хамгийн ер бусын гэх тийм хүн болоорой. Хотын бүх хүмүүс харахаар яарах бөгөөд удалгүй та болон танай гэр сонин хэвлэлд гарна.

Хамгийн хурц маргаантай сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, энэ тал дээр өөрийн

өвөрмөц үзэл бодлыг олоорой. Тун удалгүй танаас бүгд ярилцлага өгөхийг гуйж, бас аливаа асуудлыг шийдэх түлхүүрийг эрж хайж эхэлнэ.

3. Нээлт хий.

Санал:

Өөрийн хооббиг туршлага болго. Түүх сонирхогч биш харин энэ салбарын мэргэжилтэн бол. Орон нутгийн түүхийн мэргэжилтэн гэдэг утгаар бүгд танаас зөвлөгөө авах болно.

4. Хэрүүл шуугианд оролцох.

Танай компанийн жил тутмын баяраар болдог даруу бус үдэшлэг ба архидалтанд оролц. Тун удалгүй 5 мянган ажилтан таны тухай ярих болно.

5. Алдар нэрийг худалдаж ав.

Рестораны эзэнд аядуу дуугаар ямар нэг зөвлөгөө өг. Үр дүнд нь тэр хүн үдэш бүр таны эзлэх хамгийн шилдэг ширээг санал болгох ёстой.

Хүмүүс таныг хамгийн шилдэг байрлалд хардаг байх ёстой. Тэгвэл тэдний хэл таны тухай мэдээллийг түгээнэ.

Алдар нэрд суралц: Марсиа кларк алдар нэрийн тухай шүүххурал: симпсоны хүн амины хэргийгхөтөлж буй яллагч шүүхэд үг хэлнэ.

Кларк алдар нэртэй болох боломж байгааг мэджээ. Тэгээд тухайн нөхцөлд байж болох бүхнийг ашигласан байна.

Хэвлэлийнхэн 9 сарын турш Симпсоны хэргийн талаар тасралтгүй ажиглаж байсан нь түүний нэрд гарахад тусалсан. Энэхүү хэрэгт өндөр албан тушаалын хүмүүс хурлын эхнээс дуустал татагдан орж байсан нь Кларк телевизийн дуранд өртөхөд хүргэсэн. Жүжигчин, хөл бөмбөгийн од Симпсон нийгэмд алдар нэртэй хүн байсан учраас аргагүй. Түүний алдар нэр шүүхэд оролцсон ба тухайн хэрэгт татагдсан бүх хүнийг өөрийн тойрог замд хамсан юм. | Алдар нэртэй хавиралцах|. Улсын яллагч нь Марсиа Кларк байлаа. Энэ эмэгтэйд олон түмэн нэг л удаа харсан ба удалгүй түүний тухай аль болох ихийг мэдэх хүсэлд авгжээ. Түүний хувцас юмуу үс засалтдаа хийсэн аливаа өөрчлөлт шинэ мэдээ болон хувирч, сэтгүүлчид түүний араас ангуучилж байв. [Нэг эрхэм түүнд үсчинээ зээлдүүлжээ. -Алдар нэр алдар нэрийг төрүүлдэг]. Кларкийн алдар нэрийг хэвлэл мэдээллийнхэний өдөөсөн шүүх ажиллагаанд ямар ч хамаагүй шуугиан бүдгэрүүлж байв. Түүний хүүхдүүддээ хэрхэн санаа тавьдаг талаар сонинд тоо томшгүй олон нийтлэл гарч, улмаар ажил хэрэгч ээжүүдийн талаар бөөн маргаан дэгджээ. Түүний Кристофер Дардентай уулзаж учирдаг байсан тухай цуурхалаас үүдээд олон нийт тэр хоёрын тухай маргалдаж гарав. Дарден тус хэргийн хоёрдугаар яллагч бас негр байлаа. Харин Кларк бол цагаан арьстан. Олон нийтэд энэ бүхэн багадаа байв. Эцсийн эцэст Кларкийн их ололт нь эргээд алдагдал болсон юм. Тэрбээр энэ хэрэг дээр ажиллахдаа "буруугүй" гэсэн маргаантай дүгнэлт хийснээр хэвлэлийн зүгээс улам

их анхааралд өртөв.

Хэрэв эхний удаа хувь заяа түүнийг алдар нэртэй болгосон бол харин цаашдаа сүүдэрт уначихгүйн тулд өөрөө асар их хүч гаргахад хүрлээ. Шүүх хурал дууссаны дараа тэрбээр орон даяар аялан явж үг хэлдэг болов. Тэр ном бичсэн бөгөөд номын эрхийг нь 4 сая доллараар авчээ. Тэр зурагтаар үе үе гарч өөрийн хөтөлбөртэй болов.

Гэвч түүний түүхийн төгсгөл алдар нэрийг барьж байхад хичнээн хэцүүг харуулсан. Тэр од хэвээр байхыг хичнээн хичээсэн ч түүний гэрэл унтарч эхэллээ. Хурц гялалзах од биш харин "харваж байгаа од" болсноо тэр ойлгов. Ингэхэд хатагтай Кларк одоо хаана явна вэ?

Алдар нэрийн талаархи төөрөгдөлүүд

Та жинхэнэ алдартан уу, эсвэл жижиг цөөрмийн том загас уу гэдэг нь чухал биш. Хэрэв та од шүтээн юмуу эсвэл алдар нэрийн замаар алхаж яваа нэгэн бол алдар нэрийн тухай төөрөгдөлд хууртаж замаасаа гарч болохгүй.

Төөрөгдөл: Та өөрийнхөө тухай зөвхөн үнэнийг ярих ёстой ба тэгэх аваас алдаршина.

Бодит байдал: Өөрийн түүхийг зохиож ярихаас битгий ай. Жишээ нь хүүхэд нас хичнээн хэцүү байсан тухай яриа таны амжилтанд ашигтай. Стив Флорио амьдралынхаа тухай нэг бус удаа илэн далангүй зохион ярьсан. "Би нийгмийн доод ангийн хүүхдүүдтэй хамт сурдаг байлаа" гэх мэт. Түүний энэ мэдэгдэлд үнэний дусал ч байхгүй. Лео Хиндер 13 настайдаа гэрээ орхин явж өөрийгөө хайж эхэлсэн ба 16 настайдаа худалдааны хөлөг онгоц дээр сэлж явсан гэж ярьдаг. Гэвч үүнийг нь санадаг хүн нэг ч үгүй. Продюсор Жеффри Папоус бизнесээ дээшлүүлэх ба ажилтнуудаа идэвхжүүлэхийн тулд цэрэг армийн шатаар толгой эргэм амжилт үзүүлсэн хэмээн худал ярьдаг. Гэтэл тэнгисийн цэргийн архивыг ухаж үзэхэд мань хүн онгоцны шалгагч байснаас хэтэрсэнгүй. Түүний ажилтнуудын нэг нь дурсан ярихдаа тэнгисийн цэрэгт байх үедээ онгоцоор нисч яваад осолд орсны дараа Папоус сэтгэл санаа хүнд байдалтай ажилдаа ирсэн гэж дурсдаг. Гэтэл энэ үйл явдал Том Крузийн "Шилдэгбууч" кинонд гардагосол сүйрлийгягдавтдаг нь үнэхээр сонин. "Оракул"-ын үндэслэгч Ларри Дэллисон физикийн ухааны эрдмийн зэрэгтэй гэж хүмүүсийг удтал төөрөгдүүлж байжээ. Үнэн хэрэгтээ тэр коллеж ч төгсөөгүй.

Гэр бүлийнхээ түүхийг өөрчилж ярихдаа чөлөөтэй байж сур. Хэдийгээр ээж нь амьд байсаар атал Мерилин Монро өөрийгөө өнчин жаахан охин гэж ярьдаг байв. Папоус ч бас өөрийгөө өнчин гэдэг. Трумен Капотегийн ээж орон нутгийн гоо сайхны олон тэмцээнд ялж байсан. Харин Капоте үнэнийг нээж энэ хүн түүний эх болохыг хэлсний дараа ээж нь "Алабамагийн мисс" тэмцээнд түрүүлж алдараа мандуулсан. Түүний алхам илүү сайн болжээ.

Хэрэв хүмүүс шүтээндээ хайртай бол нас нь ямар хамаатай юм бэ? 32 настай телевизийн жүжигчин зохиолч Риле Вестон холливудыг өөрийн 19 насанд итгүүлж чадсан юм. 1946 онд төрсөн найруулагч Стивен Спильберг олны нүдэнд өөрийн урлаж бүтээсэн дүр төрхийг үзүүлэхийн тулд амьдралынхаа хэдэн жилийг хасч, насаа дарсан байдаг. Тэргүүн хатагтай Рейган 1923 оны 7 дугаар сарын 6-нд төрсөн ба энэ тухай нь түүх бичсэний төлөө бөөн хэрүүл шуугиан тарьжээ.

Төөрөгдөл: Алдар нэрийн тал дээр бол та даруу загнах хэрэгтэй.

Бодит байдал: Алдар нэрийн мөч бүхэн ид шидтэй байдаг. Хэрэв та азын тэнгэрт санаа тавьдаг бол түүний үндэст мөн санаа тавих хэрэгтэй. Хэрэв та шударга бус худалдаа эрхэлж эхэлсэн усан цэрэг байлаа гэхэд бүх найз нөхөд ба ажилтнууддаа барааны эх загварын хуулбараа илгээх хэрэгтэй. Гэмт хэрэгтнүүд хүртэл үхсэн хойноо хүлээн зөвшөөрөгдөх үүднээс салалтын захидал бичиж түүндээ жинхэнэ нэр ба дуудлага нэрээ дурдсан байдаг.

Та нэг л удаа даруу загнаж болно. Гэвч олны нүдэнд ил байхыг хүсвэл өөрийгөө сурталчлахаас аргагүй. Хоёр баатрыг харьцуулж үз. Холбооны армийн удирдагч Роберт дурсамж бичихээс татгалзсан. Яагаад гэвэл тэр ийм юм хийвэл "Цэргүүдийн цусаар мөнгө олсон хэрэг" гэжхэлжээ. Гэтэл булангийн дайнд холбооны армийг удирдсан генерал Норманн Шварцкопф хожим 50 мянган долларын лекц уншиж, хувийн түүхээ бичин 6 сая доллараар зарсан.

Мэдээж энд санаанд оромгүй байдлын зарчим нөлөөлжээ. Хэн нэгэн хүн сэтгүүлд зориулан будлиу үйл явдалтай найруулга бичих юмуу түүний нэрийг Лиза Смит дурдаасай хэмээн хичээж байхад харин өөр нэг хүн өөрийн нэрийг сонинд гаргахгүйн төлөө бүх хүчээ зарцуулдаг.

Төөрөгдөл: Өөрийн түүх өөрийнхөө тухай ярихаар байх ёстой.

Бодит байдал: Та алдарт хүрсэн зам ба хэрхэн ахиж дэвшсэн тухай сэтгэл хөдлөм түүхийг өөрөө зохиож бас өөрөө ярьдаг байх хэрэгтэй. Та хожим сайхан хун болж хувирсан нугасны муухай дэгдээхэй мөн үү? Эсвэл та үлгэрт гардаг яст мэлхийтэй адил бөгөөд хэнд ч үл танигдах он жилүүд хөвөрсөөр байх уу? Магадгүй таныг аль нэгэн кафед тоглож байтал алдартай хүн олж анзаараад харанхуйгаас суга татан гаргаснаар ахин дэвшиж эхэлсэн "Олз" алдартан болохыг хүсч мэднэ. Эсвэл ямар нэгэн дуулиантай түүх ба салалтын дараа алдарын гэрэлд эргэн ирсэн золбин хүү. Хамгийн түгээмэл домог нь америк мөрөөдөл юм. Түүгээр бол та алдар нэр, эд баялгийг эзлэн авахын тулд бөглүү хөдөөнөөс хотод ирсэн хүн. Гэхдээ та байгалиас авьяаслаг заяагдсан. Та Давид ба Голиаф хоёрынх шиг түүх зохиож, таны алдар нэр гайхалтай гялалзаж ч мэднэ.

Төөрөгдөл: Хэрэв таны алдар нэр үндэстэй бол хэр их нэр алдартай болох тал дээр санаа зовох учиргүй.

Бодит байдал: Энэ буруу. Үнэхээр нэртэй болохын тулд танд алдар нэрийн баталгаа хэрэгтэй. Та өөрөө зарласан тэр үед л олонхи хүмүүс таны алдар нэрийг хүлээн зөвшөөрдөг. Алдар нэр өөрөө таныг нөлөө ба эрх мэдэл бүхий хүн болгон хувиргадаг. Олон хүн таныг мэддэг гэсэн ганц тэр зүйл хүртэл таны амжилтанд туйлын ашигтай. Алдар нэртэй болсон хүмүүсийн хийсэн үйлдэл бүхнийг давгаарай. Гэрэлд гарч, хэвлэлийн анхаарлын төвд орох цаг хугацаа танд хэрэгтэй.

Өөрийн имиж дээр үргэлжлүүлэн ажиллахын зэрэгцээ тойрон хүрээлэгсдэд өөрийгөө зориул. Та бусад хүмүүсийн тусламжгүй байж чадна. Та доорх зүйлсийн аль нэгийг хийдэг үү?

4- Төлбөрийн картаа өдөрт хэд хэдэн удаа хармаанаасаа гаргахад хүрдэг.

+ Бусад алдартай хүмүүстэй уулзах арга чарга хайж, боломж гарвал тэдэнтэй зургаа авхуулдаг.

+ Үдийн зоогонд сайн суудал эзлэхийн тулд урилгаа байн байн үздэг.

+ Таныг чиглүүлж өгөх хүмүүстэй харьцдаг.

+ Хэн нэгнийг зоогонд урьдаг. Тэгээд өөрийн төлөвлөгөөг танилцуулна.

+ Бараг танихгүй хүмүүст ч бэлэг өгдөг. Ялангуяа таны мэргэжлийн тухай ярьж, хувь хүний хувьд тодруулж өгдөг хүмүүст. Энэ нь таны боловсруулсан эд зүйл, бүтээсэн юм, бичсэн нийтлэл, ном, диск байж болно|.

+ Танд ашиг авчрах хүмүүстэй танил цах аргыг хайдаг. Та ч тэдэнд ашигтай байж мэднэ. Тэгэхээр тэд танилцах санаачлага гаргасны тань төлөө талархана.

+ Та зөвлөх багтай ойр дөт.

+ Та вэб сайтыг бий болгоно. |Хүмүүс таны тухай бүхнийг мэднэ. Таны ажил ном гэх мэт.

+ Та алдартай хүмүүсийг гэртээ үдэшлэг цэнгүүнд урьдаг уу?

+ Олны дундаас тодрохоор хувцасладаг уу? Нөхцөл байдал шаардаж байгаагаас илүү нягт юмуу заримдаа хэт хурц задгай хувцасладаг.

+ Бусад хүмүүсээс өөрийгөө нэрээр биш харин зан чанарыг тань тодорхойлох, түүний тусламжаар алдар нэрд гарах гэж байгаа тэр хочоор дуудахыг гуйдаг уу? Өөртөө "бух", "цайвар үст" гэх мэт нэр бодож олсон уу? Та өөрийнхөө авьяас чадварын ачаар нэрд гарах гэж оролдож байна уу? "Түүний хоолой гайхамшиг". Эсвэл "тэр бүхнийг мэднэ".

+ Таныг хурим юмуу оршуулганд урихыг хүсдэг үү?

+ Та хэн нэгний зөвлөмжийг сонирхдог шиг хэрэгтэй хүмүүсийг сонирхож ойртохыг хичээдэг үү?

+ Үдэшлэг цэнгүүн дээр та зочин бүртэй ярьж чадна.

+ Хэн нэгний анхаарлыг эзэмдэхийг хүссэн тэр хүнийгээ өөрийнхөө найз нөхөр болтол нь цөхрөлтгүй дагаж байсан уу?

Хэрэв та гурваас олон удаа "тийм" гэсэн хариулт өгсөн бол жинхэнэ өөрийгөө сурталчлагч. Та гадны тусламжгүй өөрөө товойно. Гэхдээ үүнийг хүмүүс тэр болгон таашаадаггүйг анхаар. Учир нь хүмүүс таныг зөвхөн гялалзахыг хүсэхээс биш алдар нэрд буурь суурьтай хандах хүн биш гэж бодох учраас тэр. Энэ өнцгөөс авч үзэх юм бол таны урагш ахиж байгаа нь тэдэнд цухал төрүүлнэ. Харин таны хөдөлгөөн хүмүүст тэвчихийн аргагүй болох тэр

тохиолдолд таны хичээл зүтгэл бүхэн, үйл хөдөлгөөн танд ашигтайгаар эргэж, товойход туслана.

Төөрөгдөл: Та зөвхөн хувь хүнийхээ чанаруудын ачаар алдар нэртэй болох ёстой.

Бодит байдал: Алдар нэр өсөхийн хэрээр та өөрийн имиж ба дүр төрхийг улам их хянах шаардлагатай. Энэ бүхэн таны хувь хүний зан араншинг тусгах ёстой. Имиж цаг хугацааны эрхээр солигдож байдаг. Жозеф Кеннеди хэлэхдээ: "Та үнэнээсээ байгаа тэр хүн биш. Та бол хүмүүсийн бодож байгаа тэр хүн" гэжээ.

Сонин сэтгүүлийн хуудаснаа зөвхөн таны сайшаасан мэдээллийг гаргахыг шаардах ёстой. Өөрийгөө өөрчил. Опра Уинфри ба Битлз гэх мэт алдартнууд өөрийгөө өөрчилж, дүр төрхөө хэд хэдэн хувиргасан. Мадонна нэгэн клиптээ нүдний будаг нь урссан, хуруу цоорхой бээлийтэй ба загалмай барьсан дүртэйгээр Мерилинтэй төстэй цагаан алтан бүсгүй дээр ирдэг. Туранхай гэнэн тэнүүлч охин шашны "Ргогеп" найрлын гэрэл дор тэнгэрийн сахиус болон хувирч байна. Хэрэв та олонд алдартай нэгэн болсон бол сөрөг дүр төрхөөс зайлсхий. Муу алдар нэр таныг дайрахгүй байх талаар хичээ. Бага ч гэсэн алдартай хүн бүхэн өөрийн гэсэн дүр төрх ба давтагдашгүй имиж бий болгохыг хичээдэг.

Таны алдар нэр өсөхийн хэрээр таны үг бүрийг анхааралтай сонсох, танд үйлчлэхийг хүссэн хүмүүс хүрээлж эхэлнэ. Таны алдар нэрнээс тэд таашаал авна. Таны алдар нэрний туяа тэдэн дээр тусахад тэд дулаацдаг. Хэдийгээр тэд өөрсдийгөө таны тухай мэддэг ойлгодог гэж боддог ч та тэднээс үүнийг харин бүү хүлээ. Та алдар нэрээ ойроос харах боломжийг тэдэнд олгосон учраас тэд танд хүндэтгэлээр хариу барьж байгаа нь тэр.

Алдарт сэтгэл судлаач Эрик Эриксоны охин Сью Эриксон Блоланд хүмүүс эцгийнх нь өмнө хэрхэн сөхөрдөг тухай бичихдээ: "Түүнд хандах хандлага хэрхэн өөрчлөгдөхийн гэрч нь би байлаа. Тэр мэргэжлийн салбарын бүх уулзалт ба хурал дээр анхаарлын төв, гэрлийн эх үүсвэр болж байв. Түүнийг хамтран зүтгэгчид болон зүгээр л түүнтэй ярил цахыг хүсч дугаар ээлжээ хүлээх шүтэн бишрэгчид нь хүрээлдэг байсан. Түүнийг ороод ирэхэд хүмүүс бүгд хүүхэд болчихдог. Сэтгэл догдолцгоож, түүний анхаарлыг өөртөө татахыг хичээж, түүний талархалыг хүлээхийг хичээдэг байв" гэжээ. Ийм маягийн бүх шүтэн бишрэгчид ба талархагчдад та өөрийгөө үнэн хэрэгтээ хэн болохоо харуулах шаардлага үгүй. Тэд үргэлж таны дэргэд хамт байх ба бэлэн байсныхаа төлөө асар их төлбөр шаардсан ч хэрэггүй.

xxx

Хэрэв та алдар нэр гэж юу болохыг нэг л удаа таньж мэдсэн бол цаашдын үйл хөдөлгөөнөө үүн дээр үндэслэн зохиох ёстой. Өөрийн агуу зорилгод хүрэхдээ он цагийн олон шүтээнүүдийн хэрэглэж байсан аргыг хэрэглэж, тэдний үйлдлийг зээлдэж, тэдний хийсэн бүхнийг хийх аваас та сая зорилгодоо хүрнэ. Та өөртөө зориулан ирээдүйн дүр төрхөө бүтээж сүндэрлүүл. Тэгээд түүнийхээ онцлог шинжүүдийг одоо байгаа болон ирээдүйн дүрийнхээ онцлогтой харьцуулан хэмж.

Дүр бүтээх

Хэрэв та алдар нэрд хүрэхийг хичээж, түүний төлөө тэмцэж байгаа бол төлөвлөгөөнийхөө ядаж өчүүхэн хэсгийг урьдчилан хийх нь танд тустай. Алдар нэр нь байр суурь, дээд зэргийн албан тушаал ба эрх дархыг авчирдаг. Хэрэв та зорилгоо тунхаглах аваас үүгээрээ та өөрийгөө алдар нэртэй болон эрх дархтай хүмүүсийн зиндаанд аваачдаг.



Диана бол үзэсгэлэнт хун болон хувирсан нугасны муухай дэгдээхэй, эсвэл Ханхүүтэй суусан Үнсгэлжин байлаа

Алдартай рок хөгжимчдийн менежер Шер Гордон нэгэн хамтлагийн тухай ярихдаа: "Хэрэв би түлхэх л юм бол тэд бүх цаг үеийн одод болно гэж би өөртөө итгэн ажилласан. Хорвоогийн бүх алдартай хүмүүсийг хүсэн хүлээдэг шиг тэднийг ч хүсэн хүлээх ёстой. Олон түмэн энэ хамтлагийг мэдэхгүй байж болно. Гэвч тэд алдартай саятнуудыг талархдаг шигээ энэ хамтлагт талархах болно. Ийм тохиолдолд хэн нэг нь хамтлагийн тухай ямар нэг зүйл мэдэхийг хүсвэл ододтой харьцаж байгаа гэдгээ мэдрэх ёстой. Харин хөгжимчид өөрсдөө аль хэдийн шүтээн болсон гэдэгтээ итгэх ёстой. Тэгвэл ярилцлага авч байгаа сэтгүүлчид ба хэвлэл мэдээллийнхэн үүнийг шүүрэн авна. Тэднийг харж байгаа хүн бүхэн үүнийг мэдрэх болно" гэсэн байдаг.

Ингээд хэрэв таныг алдар нэр шүргэсэн бол та яг л од шиг, алдар нэртэй хүн шиг цаашид биеэ авч яваарай.

75. И м ижээ уд и рдах

76. Илүү алдар нэртэй хүмүүстэй харьцах

77. Зургаа зөвхөн хэрэгтэй бараа бүтээгдэхүүн дээр байршуулах

78. Алдар нэрийн соронзон давалгаа цацруулах 1.Том ярь

Бүх алдар нэртэй хүмүүс ам нээх л юм бол хүссэнээ авч байдаг. Тийм учраас үргэлж ихийг шаард. Бусад оддын юу нь хүмүүст таалагдаж байгаад онцгой анхаарал хандуулж түүнийг нь нэх.

Танд болон таны ажилд тохирох өөрийн гэсэн дүр төрхийг бүтээ. ^Ц^лЛ Хэвлэлийнхэнд зориулсан автобус, таны яриаг бэлтгэх нарийн бичиг, үсчин, жолооч, зурхайч, бие хамгаалагч ба дасгалжуулагч.

Хамгийн хурдан бөгөөд тохь тухтай тээврийн хэрэгслийг шаардана. Дэми Мур "Дисней"-н хүүхэлдэйнүүдэд дуу оруулахдаа өрсөлдөгч компанийн ажлын дуу авиануудыг авчрахыг шаарддаг байжээ. Дуу бичлэгийн студи түүнийг өөрийн унаагаар компанидаа хүргэх санал тавив. Тэрунаа нь лимузин болохыгмэдээд Мур ихэд цочирдсон гэдэг. Энэ компани бол "Идахо" байлаа. Дуу бичлэгийн студи хувийн автомашин хөлслөхөд хүрсэн ба түүний төлөө 4500 доллар төлжээ.

Ододод заяадаг хэзээ ч зайлж чадахгүй хувь тавилан нь үргэлж бүхний нүдэнд ил байх юм. Гэвч та эсрэгээр шаардаж болно. Жулия Робертс холливудын зочид буудлын цогцолборт тусгай өрөөндөө буух үед буудлын бусад зочдыг түүнтэй уулзахгүй байх, хэрэв санаандгүй таарвал түүн рүү харахгүй байхыг хүсдэг. Мадонна ч бас шүтэн бишрэгчидтэйгээ таарахаас зугтдаг. Түүний бие хамгаалагчид буудлын ажилтнуудад Мадоннагийн нэрийг хэлэх, түүний тухай ярих ба харахыг хүртэл хориглодог байна. Холливудын од Сигурни Уиверыг спорт танхимд дасгал хийж байх аваас түүний дасгалыг хэн ч дууриах ёсгүй хэмээн хориглодог.

Шаардлага зохиохдоо сэтгэмжтэй байж үз. Хувь хүний зан араншингаа харуулахаас бүү ай. Ийм уран сэтгэлгээний зарим нэг жишээг толилуулъя. Супер загвар өмсөгч Клаудия Шиффер рашаан уух бас зөвхөн улаан толбогүй "Скиттлз" чихэр идэхийгхүсчээ. Тэрэнэ санаагрокхөгжмийн од ВанХаленаасавсан бололтой. Цаадахь нь хүрэн өнгө ороогүй М&М*3 чихрээр хийсэн хоол захиалсан байдаг. "Доктор Квин-эмэгтэй эмч" цуврал киноны гол дүр, телевизийн од Жейн Сеймур үсээ угаахын тулд Их Британиас борооны ус авчрахыг шаарддаг байв. Зөвхөн нэг удаа үс угаах үсний өртөг 1200 доллар болж байлаа. Нэрт гэрэл зурагчин Патрик Демаршелер жүжигчин Эшли Жадын зургийг авах үед тэрбээр онгоц дахь усны дулаан яг 72 хэм байхыг шаардсан юм. Бөмбөг шидэгч Рэнди Жонсон "Аризоны алмазны уурхай" компанитай дөрвөн жилийн хугацаатай 52 саяын гэрээ хийхдээ бас нэг юм нэмж шаардсан нь түүнийг гольф-клубт багтаах мөн 10 жилийн турш нэгдүгээр эгнээнд "Феникс Сан" сагсан бөмбөгийн багийнхантай зэрэгцэн суух явдал байв.

Таны хамгийн даруухан хүсэл нь шүтэн бишрэгчдийн гайхан магтахыг сонсох хүсэл. Ерөнхийлөгчийн тангараг өргөх хоёр дахь ёслолоос долоо хоногийн өмнө Вашингтон хотын

"Жефферсон" зочид буудлын гуравдугаар давхарт А ба Б хэмээх хоёр нөлөө бүхий хүний хооронд доорх яриа болсныг тэмдэглэжээ. Тэдний нэг нь ковбой гутал өмсч, цув нөмөрсөн байв.

А: -Та Хар зангиа ба Пүүзийг дагах байлгүй гэж хэлэхдээ нэгэн намыг дэмжих гэсэн утга агуулжээ.

Б: -Ягтийм.

А: -Тэгвэл надад урилгын тасалбар хэрэгтэй. Надад өгөөгүй байгаа нь хачирхалтай.

Б: -Надад бүр 6 ширхэг илүү байгаа. Танд нэг хэрэгтэй юмуу? |билетийн үнэ 100-200 доллар аж|

А: -Тэгвэл сайн л байна. Намайг Карл Бернштейн гэдэг гээд гараа сунгав.

Б: -Би таныг таньсан ноён Бернштейн. Би Майкл Изиковын бүлэгт байх болно.

А: -Би билетээ яаж авах вэ? Хэнийг асуух вэ?

Б: -Намайг л асуугаарай гэж хэлээд хаалга хаагдав.

Тэр хоёр илүү тодорхой ярилцахаар өрөөнд орцгоожээ. Эхний хүний хүсэл хангагдав. Энэ нь гуравдугаар давхраас хоёрдугаар давхарт буух тийм хугацааг л эзэлжээ.

Мэдээж та алдар нэрийн тодорхой түвшинд хүрсэн бол энэ нь танд тангараг өргөх ёслолын урилга түгээгээд байна гэсэн үг биш. Тэгвэл та юу шаардаж чадах вэ? Хэрэв таныг уулзалтанд урилаа гэхэд цаг нь тохирохгүй бол өөрчлөхийг шаард, эсвэл зохион байгуулагчид хамгийн орчин цагийн видео ба аудио хэрэгсэл ашиглахыг шаардаж болно. Таныг орон нутгийн телевиз урилаа гэхэд та тусгай жолоочтой машинаар очих, эсвэл таны уух дуртай ус үргэлж бэлэн байхыг шаардаж болно. Нэг алтан дүрэм бий. Ихийг шаардсан хүн л ихийг авдаг.

2.Имижээ удирд

Өөрийн имижийг бүтээ. Моодны хувцас, зангиа, үс засалтыг сонго. Скотти Пиппений жишээг дагаарай. Тэрбээр залуудаа домогт "Буллз" багт тоглож байхдаа илүү буурь суурьтай харагдахын тулд ердийн шиллэгээ бүхий нүдний шил зүүдэг байв. Ийм жижиг сажиг зүйлсийн тухай битгий март. 100 удаа сонссоноос нэг удаа харах нь дээр гэдгийг сана. Тиймээс танд таалагдах дүр төрхийг бүтээ.

Гэвч зөвхөн дур татам гадаад төрх бүтээх хангалттай биш. Таны хувь хүний зан чанарыг агуулсан бүхэл бүтэн имиж бүтээхэд хэвлэл туслана. Энэ нь таны ажлыг хөнгөвчилж, имижээ дээшлүүлэх ба хэвлэлийн талаарх үзэл бодлоо өөрчлөхөд тусална. "Би"-гээ улам хурц тод болгож, урагш зүтгэх хүчээ нэмэгдүүл. Олон нийтийн байгууллага удирддаг гэж мэдэгд. Капитализмыг сүйтгэж буй онолын үндэс, эсвэл амьдралын өндөр өртөг, эсвэл ахуйн үйлчилгээний үнэ өндөр байх гэх мэт асуудлаар үглэж яншихын оронд хөлсөө дуслуулан

ажиллаж байгаа эцэг эхийгээ тэтгэж өргөснөөр америк маягийн үнэ цэнэт зүйлсийг та улам хөгжүүлнэ. Жек Кеннедиг нас барсны дараа эхнэр нь түүний хэлсэн үгнүүдийг ой тойнд хоногштол давтан хэлэх, сонинд хамгийн түгээмэл гэрэл зургуудыг нь байрлуулах замаар хүмүүсийн оюун санаанд дүр төрхийг нь бэхжүүлсэн. Жишээ нь тэр эцгийнхээ шарилын өмнө толгой гудайн зогсох хүү Жонны гэрэл зургийг дэлгэж Теодор Уайтын зохиолын баатар "Камелот" гэсэн нэрийг өгсөн.

Олон нийтээс багны ард нуугдаж, хувь хүний зан араншингаа хоч нэр, бэлэг тэмдгээр нуугаарай. Яг Кеннеди шиг. Эсвэл танд баг олох ажлыг өөр хүнд даатга. Цагаан ордны ажилтнууд ширээн дээгүүр самартай ваарнууд зулж тавьдаг байсан ба энэ нь тэдний бэлэг тэмдэг байв. Таны дүр төрх жирийн хүмүүст ойрхон байх ёстой. Учир нь та хүнээс гаж биш. Самарны нухашт дэндүү дуртай юмуу буржгар байцаанд дургүй гэх зэргээр тоглож наргиж чаддаг бай. Ийм зүйлс нийгмийн ямар нэг бүлгийн анхаарлын төвд байгаа хүн бүхэнд амин чухал. Хүмүүс таныг мэдэхийг хүсч байна. Харин та ямар хувь хүн болохоо илүү сайн мэдүүлэхэд туслах учиртай. Тэд таны пепси-колагийн дэглэм юмуу морин уралдаанд дуртай талаар тоглон ярилцах үедээ танд их ойр дотно мэт өөрсдийгөө мэдэрдэг.

Хэрэв та дахин давташгүй зөвхөн өөрийн гэсэн дохио зангаатай бол хүмүүсийн ой тойнд үлдэхүйц хий. Тэрбумтан Жон Рокфеллер том хүмүүст 10 цент, хүүхдүүдэд 5 цент гардуулж өгөхдөө аль болох сайн ажиллахыг уриалсан ба үүгээрээ дэндүү харамч хахир гэсэн дүр төрхөө зөөллөх оролдлого хийв.

Гэхдээ болгоомжтой бай. Нийтлэгдсэн зургийг үгүйсгэх юмуу онигоо амтархан ярих зэргээр нэр төрөө бүү унагаа. Линдон Жонсоны алдаан дээр суралцаарай. Хоёр хайртай тайган нохойнхоо чихнээс татаж буй гэрэл зураг нь нийтлэгдсэний дараа нохой сонирхогчид түүнийг шүүмжлэл зэмлэлээр булсан билээ. Хүмүүс таны дэвшлийг үнэлнэ гэж бүү бод. Та өөрөө л урагшилж байгаагаа харуулах ёстой. Бие хамгаалагчдаар өөрийгөө хүрээлүүл. Ядахдаа онцгой тохиолдолд зориулан нэг бие хамгаалагч хөлсөл. Танд заналхийлж байгаа гэсэн ойлголт өгсөнөөр анхаарлын төвд байгаагаа тунхаглана. Олон нийтийн анхаарлын төвд байхын тулд ямар ч боломжийг ашигла. Таны тухай бичих хүнийг хөлсөлж ав. Эсвэл газар сайгүй таныг даган явах камертай зураглаачийг худалдаж ав. Таны үг үйлдэл бүрийг бичих дагалдагсадын тоо хүмүүсийн сэтгэгдэлд хүчтэй нөлөөлдөг.

Хэрүүл маргаан өдөө. Өдөн дуудсан байртай хувцаслаж, танхайдуу байж сур. Гэхдээ энэ нь таны имижд тохирч байвал шүү дээ. Хэрэв ийм зоримог байхыг хүсэхгүй бол гэм хоргүй хүний төрхийг өөртөө өг. Нямбай костюм өмссөн ажил хэрэгч хүний дадсан имижээ саравчтай малгай ноосон цамц өмссөн спортын хүний имижээр соль. Мэргэжилтнүүдийн туслалцааг ашиглаарай. Хэвлэлийн төлөөлөгч таны тухай бичиж, хэвлэлд зориулан түүх зохиож, нийтлэлийн утгыг засч, таны гэрэл зургийг хэвлэлээр аль болох түргэн тараахыг шаардах болно.

3. Илүү алдартай хүмүүстэй харьц

Та зөвхөн сайн нэр төртэй хүмүүстэй хамт харагдах ёстой. Учир нь таныг харсан хүн бүхэн, таны удирдлаганд байгаа бүх хүмүүс таны тухай ярилцана. Та сонинд хооббиныхоо тухай ярих юмуу жил тутам зохиогддог үйлдвэрлэгчдийн бага хуралд оролцох гэж байлаа гэхэд үүнд

өөр хэн хэн оролцохыг заавал сонирх. Хэрэв тэнд алдартай хүн байхгүй бол оролцохоос зайлсхий. Та алдар нэргүй хүмүүстэй харьцах ёсгүй.

Хэрэв яагаад ч юм оролцохоор шийдлээ гэхэд танд дүйцэх суудал гаргаж өгөхийг шаард. Даргын дэргэд хэн суух вэ? Зоогт өөр хэнийг урьсан бэ? Жей

Лено юмуу Дэвид Леттерманыг гарч ирэхээс бүр өмнө алдар нэртнүүд шинэ одын анхны гаралтыг тэвчиж ядан хүлээдэг байв. Өөрийн байр суурийг хамгаал.



Кеннеди яриандаа хараал зүхлийг завсар зайгүй урсгадаг зуршилтай байлаа

Хэрэв та ододтой танилцаж чадсан бол тэднээс авч болох бүхнийг аваарай. Яриан дундаа алдар нэртэй хүмүүсийн нэрийг хавчуулах нь үүнийг гүйцэлдүүлэх хялбар зам. Энэ нь та тэдэнтэй хэлхээ холбоотой гэсэн үг. Энэ нь та амжилтанд хүрсэн гэсэн үг бөгөөд алдар нэртэй болохын тулд танд яг энэ хэрэгтэй. Ийм арга ихээхэн үр дүнтэй ч бас аюултай. Нэг ярианд хэт олон хүний нэрийг бүү оруул. [Та тэр хүмүүсийг үнэхээр мэддэг бол энэ тухай ярих хэрэгцээгүй]. Ярьж байгаа зүйлээ аль болох нууцлах, хамгийн гол нь нэрийг зөв хэлэх ёстой. Кеннедияриандаахараал зүхлийг

Хэрэв хэрэгтэй бол алдар нэртэй хүмүүсийг завсар зайгүй урсгадаг зуршилтай нууц нэр юмуу товчилсон нэрээр нь хэлээрэй. байлаа

Инри Льюис Гэйтсийг Скит гэж дууддагийг бүгд мэднэ. Далд нэрийг хольж хутгаж болохгүй.

Лазарыг супер тагнуулч Ирвингийн хоч нэрээр дуудчихдаг тэр хүмүүстэй бүү адил болчихоорой. Жонсон "Свифт"-ийг зөвхөн түүхчид юмуу шүтэн бишрэгчид нь бурханлиг гэж дууддаг. Харин түүнтэй танил хүмүүс бол түүнийг Эрвин хэмээн жинхэнэ нэрээр нь дууддаг байна. Харин ойр дотны хүмүүс, өдөр тутмын зочид нь түүнийг Бак гэж дуудна. Жон Кеннедигийн ойрын хүмүүс түүнийг хэзээ ч Жо гэж дууддаггүй. Гэр бүлийн хүрээний яриаг нь огт сонсоогүй нэгэн сэтгүүлч энэ нэрийг бодож олжээ.

[Таны алдар нэртэй болох үед хэн нэгэн хүн таны нэрээр тоглож байгааг сонсоход сонин байдаг. Санамсаргүй танилцсан хүн тантай нөхөрлөдөг хэмээн гайхуулна. Тэд та хоёрын хооронд бат бөх харьцаа байгаа гэж мэдрэх юм. Алдар нэртэй байхад зөвхөн нэг тал л ойр дөт

гэсэн мэдрэмж төрүүлдэг. Холын тасалгаанд таны нэр нэгярианаасаа нөгөө рүү нисч байх юм. "Тэр өөрийгөө Пит гэж дуудаарай гэснийг та мэдэх үү?" Тэд онигоо ярьцгааж байна. Цард Жастын романд энэ тухай ийнхүү дүрсэлжээ. "Та бүхэн цаг үргэлж Жекийн түүхийг сонсдог. Тэр юу идэж уух дуртай, ямар хурц яриатай, гольф янзын тоглодог тухай яриа, түүний зовлон шаналал болоод бусад мянга мянган түүх. Гэвч эдгээрт үнэний дусал ч үгүй. Пап лам ба дарга Мао ч ийм л байсан байх. Эхлээд харахад доромжлоод байгаа ч юм шиг яриа нь үнэн хэрэгтээ хичнээн хүнлэг болохыг нь харуулж өгдөг таавар мэт хүмүүс. Тэдний үнэнийг тогтооход ойрын найзууд нь тусалдаг".

Алдар нэртэй хүнтэй танилцахын тулд өөрийн бүх уран сэтгэмжийг ашиглаарай. Хэрэв та хэнтэй ч танил биш бол танил юм шиг дүр исгээрэй. Виктор Гуд өөрөө олны танил хүн биш бөгөөд хуримандаа мөн л танихгүй хүмүүсийг урьжээ. Тэр өмнөө ганцхан зорилго тавьсан нь тэдний ажиллаж буй компанид тааламж төрүүлэх явдал байв. Энэ нь "Майкрософт" компани ба түүний ерөнхийлөгч Билл Гейтс, тэрбумтан Роберт Аллен, гүйцэтгэх захирлууд ба өөр олон тооны компани корпорациуд. Гуд өөрийн алхамыгтайлбарлахдаа би сонирхолтой хүмүүстэй уулзах дуртай гэжээ. Түүний алдарын хором нь "Уолл-Стрит" сэтгүүлд гарсан нийтлэл ба хуримын бэлэг, захидал, талархалууд байв.

4.Зөвхөн хэрэгтэй бараа бүтээгдэхүүн дээр зургаа байршуул

Алдар нэр моодыг төрүүлдэг. Алдар нэртэй хүмүүс ямар нэг юм ярих юмуу ямар нэг зүйл худалдан авахад тэдний үг ба үйлдэл моодонд ордог. Эмэгтэй хүн бүрт байгалаас заяасан хэвийн зүйл болох жирэмслэлт хүртэл моодны салхи татуулна. Хэрэв Синди Кроуфорд юмуу Эрин Лаудер Зинтколет зэрэг одод жирэмсэн боллоо гэхэд бүх сонин сэтгүүл энэ тухай шуугидаг. Хэрэв Мадонна, Гвинет Пэлтроу юмуу Майкл Жексон сурталчлах юм бол еврейн мистик ч моодонд орж таарна. |хэрэв түүнийг Марла Мейплз сурталчилж эхэлбэл энэ нь гэнэтийн бэлэг болж чадахгүй шүү.|

Нэгэнт алдар нэр моодтой хамт явдаг тул та еерийгөө хамгийн моодны, хамгийн давтагдашгүй бүхнээр хүрээлэх хэрэгтэй. Бусад олонхийн адил таны тухай Лос-Анжелест нэр алдартай хүн гэдгээ харуулах гэж байна гэж яриг л дээ. Та таарч тохирох салондоо сэтгэлд нийцтэй хүмүүстэйгээ уулзалт зохиож, гайхалтай сайхан үсээ зассан ирнэ. Та салонд суух зуураа нэр хүндтэй дүүрэгт газар худалдан авах гэж байгаа тухайгаа ярих болно. Та Беверли-Хиллсийн тансаг байшингуудын дундуур дайран ирнэ. Хэдийгээр энэ газар гаднаа ямар нэг хаяггүй бөгөөд гуравдугаар давхарт байрлаж байлаа ч та хаана очихоо мэднэ. Та зөвхөн хамгийн үнэтэй дэлгүүрээс цэцэг худалдаж авна. Та энэ онд хамгийн их моодонд ороод байгаа дасгалжуулагчтай долоо хоногт гурван удаа хичээллэх болно.

Мэдээж та моодны биш санагдсан зүйлийг ч моодонд оруулж чадна. Магадгүй та Силикон хөндийн алдартан болохыг хүснэ. Орлогоо нэмэгдүүлэхийн тулд та Сэмп-Хилл-Роуд дахь компаниудтай уулзаж учирдаг гэж сануулна.

Та урт насгүй хөтөлбөрүүд зохион байгуулах ба эрх дархаа ашиглан дахин сэргээнэ. |та үүгээрээ эрх дархаа ашиглаж чадна гэдгээ өрсөлдөгчиддөө харуулдаг|. Та ердөө ганц костюмтай бөгөөд түүнийгээ 5 жил өмсөж байна. Та заримдаа ажлаа тасалдаг ба энэ нь Тарогийн картын цуглуулгаа нэмэгдүүлэхийн тулд юм. Таны ярианд дараах хэллэгүүд олон

таарна. "Бид энэ түвшинд байгаа", "Бид хүмүүсийн анхаарлыг сайтдаа яаж татах вэ?", "Аль болох их боломж ба үйлдэл байх хэрэгтэй байна". Та хамгийн сүүлийн үеийн тоон камерыг тэр дор нь худалдан авна. |эсвэл компани танд танилцуулах загварыг бэлэглэвэл бүр сайн|

5. Алдар нэрийн соронзон долгионыг цацруул

Ямар ч тохиолдолд алдар нэр танд өөрөө хүрээд ирсэн мэт, таны зүгээс ямар ч хүч хөдөлмөр зараагүй мэт байгаарай. Та зүгээр л гэрэлд гарсан хэрэг.

Ирж байгаа боломжуудаас зайлсхийх, ядахдаа зайлсхийж буй дүр эсгэх хэрэгтэй. Ингэснээр та сонголт хийж байгаа мэтээр өөрийгөө харуулна. Таны хичнээн их хүч хөдөлмөр зарцуулсныг хүмүүс бүү мэдэг.

Тахэээ ч маклер шигбиеэ бүүавч яв. Бусад хүмүүс л ингэвэл таарна. Амбан захирагчаас өндөр албан тушаал авахыг хичээ. Танд ажил хэрэгтэй. Өөрийгөө урагшлуулах нэг ч боломжийг алдаж болохгүй. Түүний оронд танай ажилтнууд ба найз нөхөд таны тухай ямар нэг юм ярихыг хүс. Сэтгүүлчдийг хөлслөх тухайгаа

бод. Тэр зөвхөн таны тулгуур болоод зогсохгүй юу хийх, юу хийхгүй байх, ямар нийтлэл эрж олох, ямрыг нь тоохгүй орхихыг шийдэх болно.

Та хэвлэлд гарсан бүхнээ нууцаар уншдаг байлаа ч моодны од байхыг хичээдгээ хэзээ ч бүү харуул.

Та бүхний тухай мэддэг мэт сэтгэгдэл төрүүл. Дэлхийн эдийн засаг, тогтвортой байдал, кофены бар, Бүгд Найрамдах намаас ерөнхийлөгчид нэр дэвшигч.

Та алдар нэрээ ихэд хайрладгаа хэзээ ч бүү сануул. Хью Хефнер сонины хайчилбараар цомог хийсэн нь хэнд ч нууц биш болжээ. Уг нь тэр энэ хоббигоо нууцалж байсан бол илүү дээр байх байсан. Та хүмүүсийн анхааралд өртөхгүй байхыг байнга хичээдэг ч яаж ч чадахгүй байгаа тийм нэртэй хүн шиг л санагдах ёстой. Хүршгүй бай. Ресторанд орвол тамхины утаагаар халхлагдсан алсын ширээнд суух, байшин дотор ч нарны хар шил зүүж аль болох анзаарагдахгүй байхыг хичээ. Олны дунд уусах, амжилтгүй оролдлого хийх, бие хамгаалагчдаар өөрийгөө хүрээлүүл. Танай сэтгүүлч таны нэрийг нийтлэлээс авах оролдлого хийж байгаа тухай хэвлэлээр мэдээл. Таны санааг маш олон хүн сонирхдог тул компаниа нууцаар удирдахад хүрдэг гэж бүхэнд мэдээл. Амьдралын бүх баримтаа нарийн бичигтэйгээ зөвшилц. Тэгвэл одоо танд нууц бий болсон ба хэн нэгэн энэ нууцыг тайлахыг хүсэх учир таныг цаг алдалгүй сонирхож эхэлнэ.

xxx

Иймэрхүү алхамууд танд алдар нэр авчирна. Энэ алдар нэрийг та өөрөө хүсвэл мөнгө ба сексийн нэгэн адил алдар нэрээ улам өсгөхөд хэрэглэж болно.

Арван Зургаадугаар бүлэг

Алдар нэр- улам их алдар нэр, эрх мэдэл, мөнгө ба сексийн эх сурвалж

Хүмүүс алдар нэрийг маш өндөр үнэлж, түүнийг болгоомжтой удирддаг. Яагаад гэвэл алдар нэр өөрөө улам их алдар нэр, мөнгө, эрх мэдэл ба сексийн эх үүсвэр болж өгдөг. Энэ бол бүх юмны эх үүсвэр.

Алдар нэрийг улам өсгөхийн тулд ашигла

Ямар нэг юм ажил үйлс бүтээж байгаа хүн бусдын нүдэнд өртөхдөө өөрийг нь таниасай гэж хүсдэг ба танигдах ч гавьяатай. Та кино од бөгөөд одоо улс төрчийн замналаа эхлэх гэж байж болно. Эсвэл та эрдэмтэн бөгөөд таны гарын үсгийг гуйх шүтэн бишрэгчдээ хүлээж байж мэднэ. Хүмүүсийн хүлээлт таныг алдар нэрээ өөр чиглэлд хандуулахаас аргагүй болгодог. Үүнийг хийхэд амархан. Нэг салбарт амжилт олсон бол нөгөө салбарт дэм болдог.

Бүү хулчий. Таны алдар нэр бол таны шүүгч. Та түүнийг өөрөө бүтээсэн. Цуутай хүн амины хэрэг дээр Жонни Кохран сэжигтэн Симпсоныг хамгаалсныхаа төлөө маш олон хүнээс шүүмжлэл авсан. Гэвч ингэлээ гээд Кохран телевизийн алдартай шинжээч ба тоймч хэвээр үлдсэн юм.

Мөрөөдлөө хэрэгжүүлж алдар нэрээ шинэ тавцан дээр өсгө. Та хэн бэ, жүжигчин үү, тамирчин уу гэдгээ шийд. Хэрэв та өөрийгөө улс төрд сорихыг хүсч байвал Рональд Рейган, Фред Гранди, Сонни Боно, Жек Кемп, Билл Брэдли, Алек Болдуин нарын жишээг дага. Харин урлагийн хүн хэмээн танигдахыг хүсвэл урлагаар хөөцөлд. Силвестер Сталлоне ба Донна Саммер нар уран зургаа үзэсгэлэнд тавьж байлаа. Жерри Гарсиа зангианы загвар бүтээсэн. Микки Рурк афишийн хэмжээтэй хуудас дээр хэвлэсэн яруу найраг тус бүрээ 2000 доллараар зарав. Билл Гэйтс, Мадонна, Жин Хекман, Майкл Ишер, Жемми Ли Кертис, Фержи нар ном бичсэн. Дуучин Глория Эстефан, Марайя Керри нар кино од болсон. Эсвэл та жүжигчин Гвинет Пэлтроу ба Сьюзан Сарадон нар шиг сэтгүүлийн редактор болох уу? Магадгүй та олон нийтийн нууц ажлын тусламжтай гялалзсан нэр төртэй болмоор байна уу? Өөрсдөдөө "015HE3" хэмээх нэр бодож олсон бүлэг загвар өмсөгчдийг үнэлээрэй.

Таны дүр төрхийг бусад алдар нэртэй хүмүүсийн хамт санаж аваг. Өөр тавцанд алдар нэртэй болсон хүнтэй өөрийгөө холбо. Жүжигчин Уоррен Битти холливудын алдар нэрээ улс төрч Гэрри Хартсын алдар нэртэй холбосон. Зохиолч Труман Капоте оюун ухааны түвшин өндөр гэсэн алдар нэрийнхээ хүчээр дээдсийн хүрээлэлд орох замаа тавьсан. Хоёр алдартны аль алины ололтыг ашиглаарай.



Дэлхийн хамгийн баян хүн Рокфеллвр хүүхдүүддээ огт мөнгө өгдөггүй учир тэдгээр нь 8 нас хүртлээ ганц ээлжийн хувцастай байлаа

Хос од гялалзах нь хурц. Та нэгэнт аль нэг салбарт хүлээн зөвшөөрөгдсөн учир бусад салбарын оддын дунд байраа эзлэх бүрэн эрхтэй. Загвар өмсөгчид Нобелийн шагналтнуудтай хослох нь элбэг. Ид цэцэглэж яваа үйлдвэрлэгчид кино найруулагчдыг дэмждэг. Телерман "Оддын сурвалжитнуудын дотор надад танихгүй хүн үгүй" гэж мэдэгджээ. Алдар нэртэй хүмүүс бие биенээ сайн мэддэг. [Эсвэл мэдэж байгаа дүр эсгэдэг.] Тэд хэрхэн хүлээн зөвшөөрөгдсөн нь чухал биш. Тийм ч учраас одод урьд нь нэг ч уулзаагүй байлаа ч бие биенээ зоогт эргэлзээгүй урьдаг.

Гэхдээ үргэлж ийм байсан юм биш. 1966 оны 11 дүгээр сард "Плаза" зочид буудалд зохиолч Труман Капоте ба "Вашингтон пост" сонины сэтгүүлч Катерина Грэхам нарт хүндэтгэл үзүүлэх ёслолд цэвэр цусны сурвалжитнууд цуглаагүй. Тэнд дээдсийн хүрээлэнгийн 540 төлөөлөгч байв. Харвардын профессор Артур Шлезингер загвар зохион бүтээгч Оскар де ла Рентатай ирэв. Одоо бүх одод холилдлоо. "Цагаан ордны сэтгүүлчдийн нийгэмлэгийн" сэтгүүлчид Шон Пенн, Мелани Гриффит ба Пула Жонс зэрэг дуулиантай кино ододтой холилджээ. "Таймс"-ын 75 жилийн ойн баярт жүжигчид, сэтгүүлчид, эрдэмтэд, яруу найрагчид ба улс төрчид бүгд цугласан байлаа. Хип хопын од Комбс 29 насны ой дээрээ Марта Стюартаас эхлээд "Неагу 0"-гийн рэпчин хүртэл бүх оддыг урьсан байх юм. Щонна Каран, Мухаммед Али ба Сара Фергюсон нар цагдаагийн хамгаалалттай|.

Алдар нэрийн гэгээ эрх мэдэл авчирна

Алдар нэр таны ярьж хийж байгаа бүхэнд болон бас танд өөрт хүмүүсийг анхаарлаа хандуулахад хүргэдэг. Харин энэ бол эрх мэдэл юм. Тэгэхээр танд чухал бааз суурь үндэс нь байна. Бусдын анхаарлыг татах чадвар нь үнсийг алт болгон хувиргадаг тэрхүү гүн ухааны чулуу юм.

Улс төрийн тавцан дээр хамгийн санаанд оромгүй аргаар нэрээ алдаршуулдаг. Цуутай алдар нэртэй хүмүүс ба овгийнхон энд тун жинтэй байдаг учир ийм жүжигчин юмуу тамирчин асан хүмүүс эсвэл алдартай улс төрч асаны хамаатан саднууд алдар нэрээрээ хэний ч үл мэдэх хүмүүсийн улс төрийн өсөлтийг үүсгэж түлхэж өгдөг. Улс төрөөс гадна юу ч хийж чадаагүй хүн сонгуульд ялахад маш хүнд байдаг. "Их бие" хэмээх хоч нэрээрээ алдаршсан

мэргэжлийн бөх Жесси Вентурын гайхам амжилтыг санацгаая. Тэрбээр 1998 онд Миннесота муж улсын амбан захирагчид нэрээ дэвшүүлэхэд хүмүүс түүнийг шууд таньж "тийм" саналаа өгсөн байдаг. |одоо тэр хочоо "Ухаалаг" болгон өөрчлөх санаатай.|

Анхаарч хүлээн зөвшөөрсний дараа үйлдэл хийдэг. Холливудын од Кристофер Рив мориноос унаж биеийн зүүн хэсэг нь мэдээгүй болсон. Гэвч тэр өөрийн алдар нэрийн хүчээр олон нийтийн анхаарлыг нуруу нугасны гэмтлийн судалгаанд хандуулж чадсанаар санхүүжилт бий болгосон. Рив конгрессийн өмнө өөрөө үг хэлсэн ба үүний дараа гишүүдийн 16 хувь нь энэхүү асуудлын талаарх шинжлэх ухааны ажиллагааны санхүүжилтыг нэмэгдүүлэхийн төлөө санал өгсөн юм. Рив улам цаашилж ерөнхийлөгч Клинтонтой ярилцаж чадсан ба түүний дараа дээрх судалгаанд дахин 10 сая доллар нэмж олгогджээ. Рив Америкийн саажилттай хүмүүсийн нийгэмлэгт нэгдсэнээр нийгэмлэгийн орлого хоёр дахин өссөн нь тус нийгэмлэг байгуулагдсанаас хойшхи 13 жилд тохиогоогүй өсөлт ажээ. Алдар нэртэй ганц хүний азгүй тохиолдол тийм өвчнөөр өвчилсөн мянга мянган хүмүүсийн хувьд боломж болсон юм.

Хэрэв танд мэдлэг туршлага хангалтгүй бол бүү санаа зов. Таны цухал илүү үр дүнтэй. Яагаад гэвэл та залхам нэг хэвийн өнгө аястай хэргэм зэрэгтэй мэргэжилтнүүдээс хавьгүй илүү алдар нэртэй. Олонхи улс төрчид нэртэй өмгөөлөгчөөс илүү бейсболын одтой хамт зургаа тагуулах дуртай байдаг. Вашингтоны "Оддын холбоо" байгууллага алдартай хүмүүсийг нийгмийн амьдралд оролцоход дууддаг. Тэдний нэрийг ододтой ажилласныхаа төлөө сайн төлбөр төлдөг түншүүдтэй холбож өгдөг.

Та алдартай хүн үү? Алдар нэрийг өөртөө татахын тулд алдар нэртэнтэй нөхөрлө. Танай зочид үнэтэй дарс уухаасаа илүү танай ширээний ард сууж байгаа нэр хүндтэй зочдыг хараад догдлох болно. Мэдээж ийм хүмүүстэй танил байх нь таныг ч бас алдар нэртэй болгоход хүргэнэ. Тэгвэл эрх мэдэл авчирна гэсэн үг. Сенатч Жон Уорнер холливудын од Элизабет Тейлортой хурим хийснээр улс төрийн жин асар нэмэгдсэн. Түүний эхнэр нь олон нийтийн анхаарлыг сүй болгон дагуулж ирсэн юм. Энэ нь улс төрчийг гэрэлтүүлж түүнийг буурь суурьтай улс төрч мэтээр харахад хүргэж улмаар АНУ-ын сенатын сонгуульд тэр ялсан билээ.

Алдар нэр ба эд хөрөнгө

Алдар нэрхудалдагддаг. Таны алдар нэрийгкино, ном, концерт, билет, теле шоу, дэлгүүр, тоглоом, хувцас, хоолны дэглэм, видео хөтөлбөр, дасгалжуулагчид, улс төрчид, унтлагын хувцасны рекламанд ашиглана.

Дэмжлэг гэдэг том зүйл. Майкл Жордан сагсан бөмбөгөөс явахад түүнд КНке, Са*огасle, Вцап, МС1 \l/oglc1cot, Напез, Ball Рагк Ргапкз зэрэг алдартай компаниуд ба сая сая хүмүүсийн дэмжлэг байсан. Хэрэв та ийм дэмжлэгийн төлөө төлбөр хийгээгүй байлаа ч аль ч компанийн бүтээгдэхүүнийг сурталчилж өгнө гэж амлаад үйлчилгээг нь үнэ төлбөргүй авч болно. Нью-Йоркийн өндөр загварын шинэ улирлын үзүүлбэрийн долоо хоногт загвар зохион бүтээгч Жилл Стюарт жүжигчин Эшли Жадыг урьж "Карлайл" зочид буудалд тусгай өрөө гаргажээ. Жад түүний бүх үзүүлбэр дээр байх, тэр бүү хэл түүний цуглуулгаас дуртай арван даашинзаа авах эрхтэй байв. Холливудын одын баталгаатай дэмжлэг нь тэр хэдэн даашинзнаас хавьгүй илүү үнэтэй. Өөрийгөө "Үнэлэгч" болгоод хүмүүс ба тэдний үйл

ажиллагааны талаарх санаа бодлыг бүрдүүл. Магадгүй та тоймч, нөлөө бүхий удирдагч юмуу засгийн газрын гишүүн байж болно. Тэгвэл хэвлэлийнхээ эргэн тойронд шуугиан тарихыг хүссэн хэвлэн нийтлэгчдээс тань дээр номын бороо асгарна.

Та өөрийгөө ямар нэг юмны рекламны арга мэтээр хараарай. Хэрэв таны үс хумсыг сайхан хэв маягтай засч өгвөл хариуд нь энэ салон руу аль болох олон түнш чиглүүлнэ гэдгийг ойлгуул. Та ямар нэг шинэ ресторанд дэмжлэг үзүүлж долоо хоногт нэг удаа тэнд сууж харагдана гэж ойлгуул. Гэхдээ мэдээж та өөрөө энэ рестораны хоол ба дарсны үнийг төлөхгүйгээр үйлчлүүлбэл шүү дээ.

Таны алдар нэр өөрийн барааг борлуулахад тусалж байвал бүр сайн. Сусанна Лонштайн моодны шинэ чиглэлийг бий болгосон. Жүжигчин Пол Ньюман дэлгүүрээ байгуулж, тэнд өөрийнх нь нэртэй поп-корн, гоймон, ундаа зэргийг зарж эхэлжээ. Гэхдээ олсон бүх орлогоо буяны байгууллагад хандивлах гэнэ. Женнифер Флауэрс тамхи худалдаалж эхэлсэн бөгөөд гэхдээ тамхины зах зээлийн хатан хаан болжчадсангүй. Харин Моника Левинский өөрийн загварын түрийвчийгүйдвэрлэж бас хувцас хүргэх үйлчилгээ эрхэлжээ.

Од үйлдвэрлэдэг машин та хэрхэн алдар нэрд хүрсэнийг сонирхдоггүй. Түүнд зөвхөн үр дүн буюу алдар нэр л хэрэгтэй. "Дольче ба Габана"-гийн загвар зохион бүтээгчид холливудын Хейди Флейсс хатагтайн шүүх дээр өмсөх хувцасыг нь бүрэн бүтээж өгсөн байна. Ийм боломжийг алдаж яаж болох вэ дээ?

Хэрэв та бусад олонхи хүний нэгэн адил олны танил биш бол яах вэ? Тэгвэл амжихын тулд бүх боломжийг ашиглаарай. Бусдын алдар нэрийг мөлж. Хүмүүс алдартны нэртэй харьцахын тулд мөнгө төлдөг. Шинэ дэлгүүр, ресторан, үзэсгэлэн, дөнгөж эхэлж байгаа загвар бүтээгчдэд ийм реклам хэрэгтэй. Тэдэнд нэртэй хүний нэр амин чухал. Тэгэж байж л бусдын анхаарлыг татна. Алдартнуудыг уургалж сур. Нью-Йоркийн стилистүүд уулзалт болгонд алдар нэртэй хүмүүсийг урьсаныхаа төлөө цалин авч байдаг. Ийм маягаар зочдын анхаарлыг татдаг байна. Спортын багууд алдартай тоглогчдыг багтаа авахыг шаарддаг. Тэдний алдар бүх багт сайнаар нөлөөлдөг. Гялалзсан тоглогчид дараагийн улирлын тасалбараа худалдан авч амжаагүй, эсвэл шинэчилж амжаагүй шүтэн бишрэгчдээ өөрсдөө урьдаг байна.

Эсвэл алдар нэрийг өөрийнхөө төлөө ажиллуулах өөр аргууд танд хэрэгтэй юу? Хэрэв та дурантай харьцаж чаддаг бол гэрэл зургуудаа хэвлээд зарж эхлээрэй. Алдартнуудыг тойрон эргэлдэх гэрэл зурагчид ба папарацци нарыг хамгийн азтай хэрэглэгчид гэдэг. Тэднийг алдар нэрийн паразитууд ч гэдэг. Диана гүнжийн авгын осолд орж үхсэн нь олон нийтийг ийм гэрэл зурагчдын эсрэг хандуулсан. Гэвч тун удалгүй шүтээнийхээ зургийг харах хүсэл нь ухамсарыг давав. Бүх гэрэл зурагчид сая долларын үнэтэй зураг дарахыг хичээдэг. Нэгэн удаа гэрэл зурагчид Мерилин Монрог нягт хүрээлсэн ба энэ бужигнааны дунд папарацци нарын нэг нь микрофоноо түүний ам руу хэт ойртуулснаар шүдийг нь хугалж байсан. Урьд өмнө хатагтай Жаклин Онассисын эргэн тойронд эргэлдэж байсан папарацци гэрэл зурагчид өнөөдөр видео камераар зэвсэглэжээ. Тэд гайхамшигт дүр төрхийг хагас нууц үйл ажиллагаа явуулдаг аль нэгэн теле компанид зарахыг хүснэ. Тэдэнтэй нэгдээрэй. Тэр цагт аль нэгэн алдартны нүүрний будаггүй байгаа зураг юмуу давхар эрүүг буулгасан ганцхан кадр танд бүхэл бүтэн баялаг авчирна.

Өөр яах вэ? Санаачлагатай бай. "Ыайопа! Епдшег" сонин зөвхөн ганцхан удаа түүх бичиж хэвлэсэн ба түүнийгээ Мадонна ба Уоррен Битти нарын зургаар чимэглэсэн.

Магадгүй та одоо хэн ч танихгүй ирээдүйн одыг нээж, түүнийг энэ нэргүй ангалаас суга татаж мэднэ. Таны эргэн тойронд алдартай хүн их байхын хэрээр тань руу их мөнгө урсана. Твигги тайзан дээр гарах хүртэл хэн ч загвар өмсөгчид рүү тэгтлээ анхаардаггүй байлаа. Хэдийгээр одоо тэдний эрх мэдэл аажмаар унтарч байгаа ч тэд моодны сэтгүүлийн нүүрнээс кино юмуу телевиз рүү одож байна. 1980 онд алдар нэртнүүд гэнэт ихээр өссөн нь тэмдэглэгджээ. Тэдний алдар нэр гүйцэтгэх захирлуудад асар их хөрөнгө авчирав. Ид цэцэглэж байгаа спортын суваг нь алдартай тамирчид ба тэдний алдар нэрийн хүчээр амьдардаг. Ийм суваг спортын тэмцээнүүдийг байнга нэвтрүүлнэ. Харин энэ нь өөрийн хувь заяаг телевиз ба арилжаатай холбосон тамирчдын хувьд өвөрмөц, тогтмол, найдвартай дэмжлэг юм. Телевизээр моод үзүүлэх болсноор загвар зохион бүтээгчдийг дэлхий даяар алдартай од болгосон. Зохиолч сэтгүүлч нар ч ажил олгогчдынхоо хамт алдарт гарсан юм.

Бид алдартай хүмүүсийн үсчин, гэрэл зурагчин, түүх бичигч, менежер, продюссеруудын тухай танд сануулсан. Өөр хэн байж болох вэ? Алдартай хүний программч байж болох уу? Алдартай хүний нохойг салхинд гаргах уу? Шинэ боломж, шинэ дүр төрхийг эрж хайж болно. Урьд нь телевизийн үндэсний нийгэмлэгт ажиллаж байсан хүмүүс одоо өндөр моодын сувагт очиж өөрийгөө шинэ нэр ба баатруудад бүрэн зориулжээ. Хэрэв таны шинэ ажил таны сонирхолд бүрэн нийцэхгүй бол битгий санаа зов. Шүтээн болохын тулд хийх ёстой ганц ажил тань олны анхаарлын төвд байх явдал.

Хэрэв та алдартай хүмүүстэй танил гэдгээрээ бардамнасан бол одоо тэднийг ашиглаж сураарай. Ерөнхийлөгч Жек Кеннедиг буудаж алсан Ли Харви Освальдын ээж Маргарет алуурчны эхийн алдар түүний хүсч хүлээсэнд хүрээгүйн улмаас ихэд хямарчээ. Хүүгийнх нь зургийн төлөө түүний бодож байснаас хавьгүй бага төлбөр хийж байв. Хүүгийнх нь түүх ямар ч эрэлтгүй байлаа. Ярилцлага өглөө гэхэд бас л бага төлж байсан. Маргаретийн илтгэлийн сэдэв нь "Америк амьдралын хэв маяг" байсан юм. Энэ хэрэгт татагдан орсон бусад хүмүүс тухайлбал ерөнхийлөгчийн бэлэвсэн эхнэр, цагдаа Типпийн бэлэвсэн эхнэр, түүний бэр Марина нар хавьгүй давуу талтай байсан гэж тэр ярьдаг. Тэд бүгд л түүний хүүгийн ачаар хөрөнгө чинээтэй болсон атал харин ээж нь үгүй гэнэ. |10 жилийн өмнө тийм байжээ. Харин одоо Освальдын ээж байх нь хүндтэй бөгөөд орлоготой|.

Алдартай хүний дэргэд байх боломжийг үнэлж сур. Мерилин Монрогийн цогцос Вествудын цэцэрлэгт хүрээлэнд нойрсож байна. Гэтэл жүжигчний булшны хажуугийн талбайн төлөө 25 мянган доллар төлсөн байх ба үүний эзний сүүлчийн зогсоол Монрогийн дэргэд байснаар түүний шүтэн бишрэгчдэд үнэлэгдэнэ гэж найджээ. Мексикийн саятан Лас Вентанас ал Парайсо Оскар гардуулах ёслолыг зохион байгуулагчид зочид буудлын тансаг өрөөнд хоёр хонох бүх зардалыг төлсөн. Ямар сайхан хөрөнгө оруулалт вэ? Өндөр хэмжээний хэд хэдэн зочин түүнтэй хамт байх замаар түүнийг шагнах болно.

Та ийм төрлийн ажил хэргийг шүүмжилдэг байлаа ч алдартнуудыг ашиглаарай. 60 настай гоо үзэсгэлэнгийн хатан хааныг буудсан Жон Бенет Рэмсэй бүх мэдээ ба сонины гол сэдэв болж байв. Редактор энэ тухай захидалд тайлбарлахдаа: "Бид оддын алдар нэрийг хэвлэлд ашиглаж байгаа тухай бичиж байна. Тийм ч учраас нүүрэндээ Рэмсэйг байрлуулсан" гэж байв. Энэ

егөөтэй байрлал аль хэдийн гүйлгээнд оржээ. Далаад оны сүүлээр Фосет-Мейжорын ухаангүй явдлыг "Нью-Таймс" ашигласан байдаг. Түүний гэрэл зургийг дугаарынхаа хавтас дээр байрлуулаад дээр нь том гарчиг тавьжээ. "Энэ дугаарт Мейжорын тухай юу ч байхгүй" гэсэн байв. Сэтгүүл Мейжорыг худалдах давтагдашгүй аргыг хэрэглэсэн байна. Энэ дугаарт ямар нэг сонин юм юу ч байсангүй.

Алдартнуудыг ашиг олох зорилгоор ашиглаарай. Өөрийн хэрэгцээн дээр тулгуурлан мөнгө ол. Буян хандив түүгээр хичээллэдэг хүмүүсээс холдулдаг. Алдартны найзуудын дэмжлэгийг ашиглах хэрэгтэй. Ийм төлөвлөлт үргэлж үр дүнгээ өгдөг. Сайентологийн сүм эгнээндээ алдар нэртэй хүмүүсийгтатдаг. Цаадуул нь бусдыгаа дагуулна. Энэ шашны хүрээнд Жон Траволта, Кристи Элли, Том Круз, хөгжимчин Исаак Гейс, телевизийн тоймч Грета ван Састерен нар багтаж байна.

Алдар нэр ба секс

Алдар нэрийн зайлшгүй байх нөхцөлийн нэг нь шүтэн бишрэгчдийн бурханчлал юм. Тэд танд тэнэг захидлууд бичиж, шөнийн цагаар одын буусан зочид буудлын орчмоор эргэлддэг. Алдар нэр сексийн адал явдлын үүдийг нээнэ.



Ерөнхийлөгч Билл Клинтон дадлагажигч охинтой холбоотой секс дуулианы дараа Хиллари Клинтоны орны хөлд сөхрөн уучлалт гуйжээ

Сагсан бөмбөгийн нэгэн одын түүх бий. Тэрбээр тоглолтын үед үзэгчдийг сайтар судалдаг. Дараа нь хамгаалагчид хэд хэдэн бүсгүйг зааж өгөөд захидал дамжуулах ба тоглолтын дараа хувцас солих өрөөнд ирэхийг хүссэн байдаг. Тэмцээн дуусч тамирчин усны өрөөнд орж ирэхэд тэнд бүсгүйчүүд түүнийг хүлээж байдаг. Тэрбээр бүгдтэй нь ээлж дараалан секс хийнэ. Хажуугийн өрөөнд сэтгүүлчид хүлээж байх тул аль болох хурдан дуусгана. Сенатор асан нэгэн мөн ингэдэг байв. Тэрбээр олны өмнө лекц унших үедээ дур булаам бүсгүйчүүдийг өндөр дээрээс олж хараад туслахдаа заадаг байжээ.

Алдар нэртэй хүнтэй секс хийх тухай бодол хүслийг өдөөдөг. "Нью-Йорк Обсервер" сонинд алдартнуудын хичээллэдэг "Фитнесс ба зугаацал" клубт юу болдог талаар бичиж шуугиан тарьсан.

Зарим хүмүүсийн тухайд алдартантай харьцдаг хүнтэй учрах нь тэр алдартантай өөртэй нь секс хийсэнтэй бараг адил тооцогдоно. Холливудын эмсийн

хүрээлэнгийн алдарт эзэгтэй Адамс зарим үйлчлүүлэгч алдар нэртэй хүмүүсийн үйлчилгээнд гардаг хүүхнүүдийг тусгайлан захиалдаг гэжээ. 45 настай саятан Элиот олон алдартай хүнд үйлчилсэн эмэгтэйтэй энгэр зөрүүлдэгээ нуугаагүй. Тэдний тоонд бага Ж.Кеннеди, Дональд Трамп, Селинжер нар байна. Тэрбээр алдартнуудыг "оролцогчдын жагсаалт" гэж нэрлэсэн байдаг.

Алдар нэртэй хүн хүртэл өөр алдар нэртэй хүний хавьтагчтай секс хийвэл таашаал авдаг. Жек Кеннеди ерөнхийлөгч болсон хойноо хүртэл хагагтай Юдит Кемпбелл Экснертэй аюултай холбоогоо таслаагүй. Экснерийн дур татах салшгүй нэг шалтгаан нь тэрбээр Фрэнк Синатра болон Чикагогийн дээрэмчин Сэм Момо Жинкан нарын нууц амраг байсан явдал. |Нэгэн гүйлгээ сэтгэлгээтэй хуурамч эх алдар нэрийн капиталыг ашиглан мөнгө олох зорилгоор ийм зарлал тавьдаг байжээ. "Би алдар нэртэй хосын хүүхдийг гаргаж өгч өөрийгөө золиосолсон юм. Одоо таны хүүхдийг гаргаж өгч яагаад болохгүй гэж?" гэсэн байв. Энэ тэнэгдүү зарлал нь цаад утгаараа бол та энэ эмэгтэйгээр үйлчлүүлж хүүхэд гаргууллаа гэхэд танай хүүхэд ба тэрхүү алдар нэртэй хосын хүүхэд хоёр нэг цустай болно гэсэн далд утгыг агуулж байгаа нь бас л анхаарал их татсан байна.|

xxx

Та алдар нэртэй болохоор шийдэж, энэ зорилгодоо хүрэхийн тулд алиалагч шиг навсаганасан хойноо алдар нэр ч бас хүндхэн асуудлуудыг араасаа дагуулдаг болохыг ойлгоно. Та энэ асуудлуудаас салахын тулд алдар нэрээс ухрах уу? Үгүй. Гэвч ингэлээ гээд асуудлыг шийдэж чадахгүй.

Төгсгөлийн хэсэг

Алдар нэр ба зовлон

Хэрэв та анхаарлын төвд орсон ч аюулгүйн мэдрэмж үгүй байх аваас та хэнд ч танигдахгүй байхын амгаланг аль хэдийн алджээ. Танд анхаарал хүндэтгэл хэрэгтэй. Гэвч таны алдар нэр чанга цуурайтахын хэрээр аюулгүй байдал хайлан урсч эхэлнэ. "Би" гэх юм үгүй болно. Үүнийг өөрчлөх аргагүй.



Стиввн Спилбөрг Оскарын шагнал авна гэдэгт бат итгэлтэй байжхэлэх үгээ хүртэл бэлдсэн ч нуран унав

Таны алдар нэр бусдын сэтгэл хөдлөлийг шатаана. Таны нөлөө таны зорилгоос давж гарна. Таны үгээр улс орон ярина. Таны үс засалтыг мянга мянган залуус дууриана. Дэлгүүр таны нэрийн хуудсыг тооцоо хийхээр банк руу илгээхгүй. Яагаад гэвэл тэд таны гарын үсгийг хадгалж үлдэхийг хичээнэ. Эрдэмтэй эрчүүд таны үг алхам бүрийг шинжиж бүх баримтыг буруугаар эргүүлнэ. Хэрэв та хүсвэл улс орон дахь хууль тогтоох чиглэлд нөлөөлж чадна. Эсвэл бүх далд явдлыг өгүүлсэн шуугиант ном нийтэлж дөнгөнө. Та өөрийн ажил хэргийг эхлүүлж чадна. Та солиотой ертөнцийн анхаарлын төв. Хүмүүс таны яаж харагддаг, юу хийдэг, ямар хувцасладгийг мэдэхийг хүснэ. Таныг ресторанд ороход хүмүүс эргэн харж харцаараа үднэ. Таны үг бүрийг шүүрнэ. Таны хамгийн энгийн анхааруулгыг гүнзгий утга агуулгатай ишлэл мэт хүлээн авна. Хүмүүс танд хүндэтгэл үзүүлж байгаа нь тэр.

Ийнхүү салахгүй сонирхох нь таныг үргэлж ил байлгаж, хамгаалалтгүй болгодог. Цэвэрлэгчид таны тухай бүхнийг мэдэхийг хүснэ. Таны нууц бүхнийг. Таны гэрийн эргэн тойронд юу болоод байгаа, таны ямар ном уншдаг, ээжтэйгээ ямар харьцаатайг хүртэл мэдэхийг хүснэ. Тэд бүхнийг мэдэх ба харахыг хүснэ.

Олон нийтийн сонирхолын хүч таны эргэн тойронд байгаа хүмүүст тодорхой эрх олгодог. Та бас тэдний тухай сонсож мэдэж байхыг тэд хүснэ. Нэгэн алдартай



Фрэнк Синатра ерөнхийлөгч Кеннедид зориулсан нисдэг тэрэгний талбайг эвдэж сүйтгэжээ

хөгжимчин ийм нөхцөл байдлыг ядарсан дуугаар тайлбарлахдаа: "Бүлэг сексээс аль хэдийн залхсан. Шөнө болгон хийсэн ч болно. Хүүхнүүд хангалттай. Гэтэл тэдний хэн нэгэнтэй шөнийг өнгөрөөхийг хүсвэл түүний бүхий л амьдралын түүхийг сонсохоос аргагүй болдог. Харин би цаашид хэний ч түүхийг сонсох хүсэлгүй байна" гэжээ. Хүмүүст таны анхаарал хэрэгтэй.

Түүний хажуугаар хүмүүс таны нөлөөний хүчийг анзаарч байдаг. Хэрэв тэдний шинэд тэмүүлэх тэмүүлэл ба халуун сэтгэлийг нь ямар нэг байдлаар хангахгүй бол сөнөөх аюултай. Тэгээд ч алдар нэр атаархал ба дургүйцлийг бас өдөөж байдаг. Таны эргэн тойронд байгаа хүмүүс хамтран зүтгэгчид ба өрсөлдөгчид танд өөрийн тухай сайн бодол төрүүлэх юмуу таны анхаарлыг татахын тулд хоорондоо өрсөлдөнө. Хүүхдүүд ба ойр дотны хүмүүс нь таны бусадтай өнгөрүүлсэн цагийг агаархангуй тоолж суудаг. Хүн бүр таны анхаарлыг нэхэх ба хэрэв та анхаарал хандуулаагүй бол цөхрөлд автана.

Үнэн хэрэгтээ энэ бүхэн яагаад ингэж байна гэвэл та бусад хүмүүсийн хувьд, тэд таны хувьд хэн байхаас хавьгүй жинтэй хүн. Тэдний хувьд та бүх үнэт зүйлсийн хэмжүүр. Си Шонагон өөрийн "Зүүдний тайлал" номондоо өнгөрсөн болоод өнөөдөр анхаарал маргааны бай болж байгаа хүмүүс болон эд юмсыг багтаасан үнэт зүйлсийн жагсаалтыг дурьджээ. Ийм хүнийг хүмүүс тойрдог. Харин өнөөх шүтээн маань ярих үедээ зөвхөн нэг хүн рүү харж ярьдаг.

Хүмүүс таныг зугаацуулах эрхийн төлөө тэмцэлдэнэ. Танд бодол санаагаа хэлж, хурц үгээр булна. Алдар нэрийн нэг гашуун жишээ: бага Ж.Кеннеди ба түүний эхнэрийг үхсэний дараа хэн нэгэн хүн тэдний онгоцоор нисэхдээ хэрэглэсэн тасалбарыг дуудлага худалдаагаар заржээ. "Энэ билетийг Жон Кеннеди ба Каролина Бессет нар онгоцноос буунгуутаа надад өгсөн юм. Тэд Маямигаас Нью-Йорк хүрэхдээ яг миний ард сууж ниссэн. Би энэ нислэгийг хэзээ ч мартажгүй". Энэ уулзалтын үнэ цэнийг мэдмээр байна уу? 4850 доллар.

Та тэдний шуналаас залхаж гүйцээд дахин дахин гуйж байгаа хүмүүсийг орхино. Алдар нэртэй хүмүүс хүртэл таагүй мэдрэмж болоод оддын асуудлаас ихэд зовдог. Фрэнк Синатра ерөнхийлөгч Жек Кеннедигийн нөхөрлөлийг олж авч чадсан. Тэрбээр ерөнхийлөгчид нэр дэвшихэд нь цуцалтгүй дэмжиж байсан бөгөөд өөрийн хит дууны "Асар их найдвар" гэсэн хувилбарыг түүнд зориулж хариуд нь өөрийг нь хэзээ ч мартажгүй байхыг Кеннедигээс гуйдаг байжээ. Энэ бага юм гэж үү? Мэдээж энэ бол их зүйл. Синатра Кеннедиг хүндэлдэг байсан.

Ерөнхийлөгчийн хамгийн энгийн таталбар бичгийг хүртэл жаазалж тавьдаг байв. Өндөр хэмжээний зочин ирснийг мөнхжүүлэхийн тулд түүний нэртэй дурсгалын пайзыг гэрийнхээ унтлагын өрөөний хаалга дээр хадаж байлаа. Тэр бүү хэл гэр нь Цагаан ордонтой адил байх ёстой гэж шийджээ. Тэгээд гэртээ яг Цагаан ордных шиг холбооны сүлжээ байршуулж, 40 хүний багтаамжтай хооллох өрөө тохижуулж, ширээн дээр ерөнхийлөгчийн дарцагийг байрлуулсан бөгөөд зочдод зориулсан жижиг байшин, нисдэг тэрэгний талбай хүртэл бүтээжээ. Гэвч Синатра зохион байгуулалттай гэмт хэргийн ертөнцийн төлөөлөгчидтэй холбоотой нь анзаарагдсан тул Кеннеди ах Робертын зөвлөгөөг дагаж тэднийд очихоос татгалзжээ. Синатра маш их уурлаж, нисдэг тэрэгний тавцангаа эвдсэн бөгөөд ийнхүү татгалзсаныг нь хэзээ ч мартаж чадаагүй.

Тэгсэн мөртлөө та өөрийгөө одын хувиар биш харин хүн гэдэг утгаар нь үнэлүүлж хайрлуулахыг хүснэ. Гэвч та жинхэнэ байгаагаараа тэдний шаардлагад нийцэх үү? Тэд амжилтыг хүндэлж байна уу эсвэл зүгээр л дүр төрхөд бөхийж байна уу? Домогт захирал Ли Якокка өөрийн түүхийн номонд бичихдээ: "Миний үйлдлээр намайг таньдаг нь надад таалагддаг. Гэхдээ миний алдар нэр бол өөрийн минь жижигхэн хэсэг гэдгийг үргэлж сануулдаг юм. Би алдар нэрийн төлөө их бага юм хийжээ. Би өөрийн унадаг "Мустанг" машинаараа алдарт хүрсэн гэж үү? Эсвэл Фордын алдар нэр ид мандаж явахад түүний дэргэд байснаараа хүрсэн үү? Яагаад гэвэл Крайслерын дэргэд байснаараа тэгсэн гэж үү? Хэдийгээр аймшигтай боловч би телевизэд явуулсан арилжааны үйл ажиллагааныхаа ачаар алдар нэрд хүрсэн гэсэн мэдрэмж надад төрөөд байдаг юм" гэжээ.

Таны нийгмийн имижүнэн нүүр царайнаас таньсалшгүй. Таныгзохих ёсоор үнэлж хүндлэхгүй байгаага мэдэрдэг. Таныг мэдэхгүй байна. Алдарт зохиолч Энди Уорхол алдар нэрийн иймэрхүү сохор байдлыг тайлбарлажээ. Тэрбээр жүжигчин Мижетийг хөлсөлж ийш тийш явах юмуу лекцэнд суух шаардлага гарвал өөрийгөө орлуулдаг байна. Хар шил зүүж, хар арьсан пиджак, өмсч нүүрээ будаж, буурал хиймэл үс зүүсэн Мижет түүний дүрд гайхамшигтай тоглодог байлаа. Яагаад нэрт зохиолч жүжигчинийг хөлсөлсөн юм бэ? Өөрийнхөө дүрд тоглуулах гэж үү? "Тэр миний дүрд надаас хавьгүй илүү байсан".

Та хувь хүнийхээ тухайд шүтэн бишрэгчдийн нүдэнд гандаж гундана. Та тэдний хувьд үнэлж дүгнэж цэгнэн ярьж болох энгийн хүн. Та тэдний бүтээл болж хувирна. Та өөрийгөө тайлшгүй оньсого мэт боддог байсан ч хамаагүй. Элвис Пресли нэгэн удаа хэлэхдээ "Ямар нэг үл үзэгдэх гар намайг удирдаад байгааг би үргэлж мэдэрдэг. Энэ нь би Элвис Пресли болж хувирсанд ямар нэг шалтгаан ба зорилго байх ёстойг хэлээд байна" гэжээ. Дуурийн од Аделина Патти өөрийнхөө дууны бичлэгийг анх удаа сонсонгуут дуу алдав. "Бурхан минь би яагаад Патти чигээрээ байгааг одоо ойлголоо. Ямар гээчийн дуу хоолой вэ?". Нэрт дипломатч Генри Киссинжер эрт урьд болж өнгөрсөн үйл явдлын тухай, тухайлбал Харвардын их сургуулийн багш байсан тухайгаа ярих үедээ тэгэхэд би Киссинжер болоогүй байсан гэж ярьдаг.

Мартин Лютер Кинг хэлэхдээ би бол зөвхөн түүхийн жүжигчин юм. Түүхийн аль нэг хоромд хувь хүн хэрэг болсон. Харин би тэр хувь хүн нь болсон юм гэдэг. Та бол бусад хүмүүсийн бүтээл. Та бол тэдний харж байгаа, таны тухай бичиж байгаа, танаас хүсээд байгаа тэр хүн.

Таны нэр төр олон хүнд танигдаж эхэлдэг. Улам олон хүн таны дүр төрхийг таньдаг болно.

Тун удалгүй таны жинхэнэ "би" жижигрэн жижгэрсээр дүр төрхийн цаагуур үзэгдэхгүй болно. Ихийг хүсэх хөшигний ард та өөрөө бол хэний ч танил биш хүн хэвээр үлдсэн гэсэн бүдэг бадаг мэдрэмж танд байсаар байна. Та бол та биш гэдгээ ойлгоно. Та хүмүүсийг татаад байгаа юм биш. Таны тухай мөрөөдөх мөрөөдөлдөө тэд татагдаж байна.

Хэдийгээр ийм дутагдал байсаар атал алдар нэрийн тухай мөрөөдөл хэзээ ч багасч байсангүй. Та улам өсч буй хүлээлтийн урхинд оржээ. Продюссер Жулия Филипс түүний "Стинг" кино Оскарын шагналын арван ангилалд нэр дэвшсэн учир шагнал гардуулах ёслолд одох үедээ алдар нэрийн зорилгыг сая ойлгожээ. Тэр бодохдоо "Хаалт, саад, цагдаа, шүтэн бишрэгчид, гэрэл зурагчид. Газар сайгүй. Бид одоо гэрэл зургийн аппарат гялсхийхийг анзаарахаа больжээ. Алдар нэртэй хүмүүсийн дунд байгаа хэний ч үл таних ганц хүн нь та гэдгийг мэдрэх нь алдар нэртэй хүн хэний ч үл таних хүмүүсийн дунд ганцаараа байгаа байдалтай харьцуулж болохуйц" гэсэн байдаг. Гэрэл зурагчид, шүтэн бишрэгчид, түүний дэргэд зогсох алдарт нэртнүүдийг тойрон шахцалдах мөртлөө харин түүнийг хэн ч анзаараагүй гэдэг. "Хэн ч бидэнд хүрч чадахгүй. Нэг юмуу хоёр жилийн өмнө бол би тэдний дунд байхыг хүсч байсан. Харин одоо би зорьсондоо хүрлээ. Ийм цэнгүүнд орох цорын ганц арга нь өөрөө од болох явдал аж" гэжээ. Алга ташилтаас авах мансуурал таны махбодь руу нэг удаа нэвтрэх аваас та хүлээн зөвшөөрөгдлөө гэсэн үг. Та бахдан бишрэхийг тэднээс нэхэж, тэдний хүлээн зөвшөөрөлтийг заавал авахыг хүснэ.

Та өөрийгөө нэрээ дөвийлгөгч хэмээн мэдэрнэ. Таны амжилт бол ердийн сохор аз болохоос биш гавьяа биш. Та од, та үлгэрийн мэт баян болсон, үлгэрийн ертөнцөд амьдардаг, газар сайгүй өөрийн дүр төрхийг олж харна, гэхдээ таны ийнхүү сонгогдсон нь яагаад ийм өндөр үнэтэй юм бэ? Нэг л тохирохгүй байгаа, нэг л юм дутагдаад байгаа мэдрэмж алдар нэрээр зөөлөрдөггүй.

Тэгээд юу гэж? Их муугаар бодоход та диваажинд очихгүй гэж үү? Улс төрч Ньют Гринвич алдарын оргилд байх үедээ ингэж хэлжээ. "Надад нэр төрийн аварга том төлөвлөгөө бий. Би бүх ертөнцийн анхаарлын төв болмоор байна. Би үүнийг хийнэ. Одоо би алдар нэртэй" гэжээ.

Норманн Майлер өөрийн хэрхэн доош орсон тухай дурсахдаа "Миний байдал муудсаар байлаа. Америк их тэмүүлэмтгий орон. Харин миний "Би" надад үүнийг ойлгох боломж өгөөгүй. Би бусдаас дээр биш, надаас илүү алдар нэртэй хүмүүс байгаа гэдгийг ойлгохын тулд би зовлонт он жилүүдийг туулсан юм. Би өөрийгөө үргэлж хэт үнэлдэг байж. Бүдүүлгээр хэлэх юм бол би хүмүүсийг мартаад байна гэж бодсон чинь хүмүүс намайг мартсан байжээ" гэсэн байдаг юм. Та дургүй байна уу? Та хүмүүсээс "Би хэн юм бэ?" гэсэн асуултын хариуг нэхэж байна уу? Тэд хариуг нь мэдэхгүй.

Шигтгээ: Бет алдар нэрийг хэрхэн ашиглав.

Бет саяхан "Эрээн тахь" ресторанаа нээжээ. Тэр аюултай бизнест орж байгаагаа мэдэжбайв. Гэвч тэрамжилтолохзоригдүүрэн байлаа. Түүний ресторанд хүмүүс зөвхөн орохыг тэр хүсээгүй. Харин ресторан нь гайхамшигтай нэр хүндтэй байж, хотын хамгийн шилдэг нь болж, бас өөрийг нь хүмүүс таньдаг болоосой гэж тэр хүснэ.

Бет эрээн тахины өнгө будагт дуртай байсан тул ресторанаа ингэж нэрлэжээ. Тэр бүх ширээгээ эрээн тахины хээтэй бүтээлгээр хучиж бүх ажилтандаа ийм хээтэй хувцас өмсгөв. Тэр өөрөө ч банзал, цамц, цүнх гээд ийм хээтэйг хэрэглэнэ. Тэр ресторан руугаа юмуу эсвэл өөр тийш явж байгаагаас үл хамааран үргэлж ингэж хувцаслана.

Бетийн хамгийн анхны алхам нь рестораны тухай магтан дуулах сэтгүүлч

хөлслөх шийдвэр байв. Бас тэр буян хандивын үйлсийн тухай боджээ.

Моодонд ороод буй нэртэй гүн ухаантан Тис Сити Кэрес жил бүр хандивын баяр зохиож мөнгө цуглуулдаг. Бет түүнтэй танилцаад шоуны өмнө түүнийг ресторандаа урив. Энэ зоог Бетийн хувьд ялалт байлаа.

Хэдэн сарын дараа Кэрес жил бүр зохиодог цэнгүүнээ түүний ресторанд хийхээр сонгожээ. Тэгэхээр нь Бет зочдоос энэ үдшийн төлөө төлбөр авахгүй гэж шууд хэлэв. Цэнгүүний тухай радиогоор шууд нэвтрүүлж, сэтгүүлчид маш их ярьсан нь баярын чимэг болов. "Эрээн тахь" гэсэн нэр хүмүүсийн амнаас салахаа больж, нүдэнд шууд тусах хээ нь хүмүүсийн ой тойнд үлджээ. Тун удалгүй бусад байгууллагууд өөрийн арга хэмжээг зохиож эхэллээ.

Бет бизнест хөл тавиад ганц жил болох гэж байхад түүний ресторан нь олон нийтийн дунд өргөн нэртэй болжээ. "Эрээн тахь" гэсэн нэр хүмүүсийн ой тойнд шигдэн үлдэв.



CEKC



Арван наймдугаар бүлэг

Секс ба далд зорилго

Дур тачаал татам байдлыг үр дүнтэй ашиглах нь туйлын амаргүй. Секс бол хүч тамир, мөнгө юмуу алдар нэртэй адилгүй. Энэ бол байнга байх мөртлөө жолоонд ордоггүй. Энэ бол хүмүүсийн бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн биеэ авч явах байдлын хэм хэмжээ дээгүүр хөндлөн алхахад хүргэдэг зүйл.

Дур тачаал татам байдлыг ашиглах нь цаанаа тодорхой зорилгыг агуулдаг. Санаатай санаагүй алин болох нь хамаагүй. Энэ нь эрх мэдлийг булаах, мөнгөнд хүрэх, эсвэл алдар нэртэй болох буюу сэтгэлийн ойртолт зэргийг өөртөө агуулна. Түүнээс гадна мэдрэмжийн таашаалыг бас агуулдаг.

Тэр бүүхэл эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийг ямар нэг зорилгоор ашиглахад эргэлзээ төрдөггүй атал сексийг ашиглах тухай бодоход л эвгүй болоод явчихдаг. Зул сарын үдэшлэг дээр ялалт байгуулах хүсэл, гэр бүлийн хангамж хүрэлцээг сайжруулах тэмүүлэл, үдшийг гэрийн амьтдын хүрээлэлд өнгөрөөх, эсвэл Аспены урилга гуйххүсэл зэрэг дээр үндэслэсэн хоёр биений харьцааны тухай бодол санаа шууд айдас төрүүлдэг. Дараах бүлгүүдэд авч үзэх сексийн холбогдолтой төсөөлөл ба төлөвлөлтүүд бидний дасч сурсан хүлээлтүүдтэй сүлэлдэх болно. Энэ нь чин сэтгэлээс татагдах буюу ойртох, бүр багаар бодоход харилцан таашаал авах зэрэг хүлээлт билээ.

Ямар ч нөхцөл байдалд цаашид өргөжих боломжгүй тохиолдолд ч цөөхөн тооны хүн л сексийн тал дээр шинэ төлөвлөлт шугам гаргаж чаддаг. Тэд эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийн тухайд ч ингэх л байсан. Мэдээж тэдний үйлдэл хөндлөнгийн ажиглагчдын зүгээс маш их таагүй уур амьсгал ба дургүйцлийг өдөөдөг.

Хэдийгээр та энд хэлэлцэж байгаа зарчмуудыг хэрэглэх тухай хэзээ ч бодоогүй байсан ч уншлагаа үргэлжлүүлээрэй. Энэ нь бусад хүмүүсийн үйл хөдлөлийг ойлгоход хэрэгтэй. Сексэд ашигладаг эдгээр төлөвлөлт үнэхээр дур гутам байж мэднэ. [Эрчүүд сексэд хүрэхийн тулд эрх мэдэл, мөнгө ба алдар нэрээ ашигладаг уу? Эсвэл эмэгтэйчүүд эрх мэдэл мөнгө ба алдар нэрд хүрэхийн тулд сексийг ашигладаг уу?] Гэвч энэ нь тэдгээр төлөвлөлтийг үр дүнгүй хэрэг гэж байгаа биш. Та өөрөө хэрэглэхгүй байлаа ч гэсэн цаад утга учрыг нь ойлгох ёстой.

Мэдээж та махбодийн таашаал авахын тулд бэлгийн харьцаанд ордог гэж ойлгож болно. Энд хэцүү зүйл үгүй. Хэрэв тийм бол та үнэхээр харьцагчтайгаа

сэтгэлийн ойртолт авах хүсэлд хөтлөгдөөгүй гэдэгтээ итгэлтэй байхын тулд шалтгааныг сайтар судлаарай. Энэ бол ялагдлын төлөвлөлт.

Хамгийн аймшиггүй хүмүүсийг эс тооцвол бэлгийн харьцааг тун цөөн хүн хянаж чаддаг. Таны хүсэл ба сэтгэл хөдлөл өөрийн тань сонирхолтой мөргөлддөг. Хэрэв та ямартаа ч гэсэн ийм харьцаанд орохоор зүрхэлсэн бол ухаан санаагаа булингартуулалгүй хадгалаарай.

Сонжоо:

Та бэлгийн дур булаам байдлаа ашигладаг уу?

Та өөрөө ч мэдэлгүйгээр бэлгийн дур булаам байдлаа ашиглаж болно. Дараах асуултуудад "тийм" эсвэл "үгүй" гэсэн хариулт өгөөрэй.

79. Та ямар нэг үдэшлэг дээр бусдын анхаарлыг өөртөө татахын тулд дур булаам тонгойж байсан уу?

80. Та дур булаам харьцагчтайгаа албаар хүмүүсийн өмнө гардаг уу?

81. Та хань юмуу харьцагчийнхаа эд хөрөнгө, зиндаа, нас ба гадаад төрхийг бусдын харьцагчтай харьцуулдаг уу?

82. Та хэзээ нэг цагт таны бэлиг эрхтэн бусад эрчүүдийнхээс том гэсэн бодлоор сэтгэлээ тайтгаруулж байсан уу?

83. Та хэзээ нэг цагт өөрийн нас, өндөр ба биеийн бусад үзүүлэлтийг худлаа хэлж байсан уу?

84. Хэрэв таны шинэ танил Жулия Робертсын төрсөн өдөрт уригддаг, эсвэл "Нью-Йорк таймс" сэтгүүлд ажилладаг, эсвэл "мерседес" унадаг бол түүнтэй уулзахдаа сэтгэл догдолж нууцхан дэвэрдэг үү?

85. Харьцагчаа үнэлэхдээ энэ хүн гэр бүл үүсгэх ба үргэлжлүүлэхэд хамгийн тохиромжтой гэж бодож байсан уу?

86. Та эхний ба хоёр дахь удаагаа уулзахдаа хүсэл байсан эсэх шалтгаанаар бус харин цаашид уулзаж учирах боломжийг ихэсгэх найдварт автан бэлгийн харьцаанд орохоос татгалзаж байсан уу?

Хэрэв та эдгээр асуултуудын аль нэгэнд "тийм" гэж хариулсан бол бэлгийн дур булаам байдлыг далд зорилгоор аль хэдийн ашигласан гэсэн үг.

Щараагийн бүлгүүдэд гетеросекс харьцааг авч үзэх болно. Харин гомосекс харьцаа нь үндсэн ялгаатай бөгөөд тусгай үнэлэмж дүгнэлт шаарддаг учир энэ номонд авч үзэхгүй|

xxx

Дараагийн бүлгүүдэд эрэгтэй ба эмэгтэй хүмүүс сексийг өөр өөрөөр ашигладаг болохыг үзүүлнэ. Гэхдээ та эсрэг хүйснийхэнд зориулсан бүлгийг уншихгүй өнгөрөөх хэрэггүй. Доор бичсэн бүх аргыг ойлгох нь маш чухал.

Эрчүүд сексийг юунд ашигладаг вэ?

Ямар нэг зорилгод хүрэхийн тулд эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийг бодвол сексийг ашиглах нь харьцангуй цөөн гэдгийг өмнө дурьдсан. Гэвч энэ нь үр дүнгүй арга гэсэн үг биш. Сексийг эмэгтэйчүүд болон бусад эрчүүдэд өгөх дохио болгон ашиглаж, өөрийн эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийг зарлана. Эмэгтэй хүмүүс ч бас сексийг ашигладаг болохоор эр хүний тухайд хэр их эрх мэдэл, мөнгө ба алдар нэртэй болохын хэрээр эмэгтэйчүүдийн сэтгэлийг булаах магадлал өндөр. Харин эмэгтэй хүний анхаарал нь таны ололтыг ажиглаж буй хүмүүсийн хувьд дохио болж өгнө. Эсвэл та бусад олонхи хүмүүсийн адил зөвхөн махбодийн таашаалын төлөө сексийг ашиглахыг хүсдэг байж болно. Сексийн төлөө секс. Бусад тохиолдолд та ганган хүүхний гараас хөтлөн алхаж яваагаа харуулснаас авах таашаал түүнтэй бэлгийн харьцаанд орох таашаалаас хүчтэй ялгарна. Эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийн хэр хэмжээ таныг зорилгодоо хүрэхэд тусалж байгааг та олж мэднэ.

Нийгмийн өндөр байр суурьтай эрчүүд нийгэмд доогуур байр суурьтайг бодвол эмэгтэйчүүдийн сэтгэлийг хавьгүй их татдаг болохыг хүмүүс таамагладаг. Үүнийг судалгаа ч баталж өгсөн. Тэгэхээр эмэгтэй хүн үнэлэмжийн шалгуур маягийн үүрэг гүйцэтгэж байна. Судалгааны явцад судлаачид гэр бүлтэй хосуудын гэрэл зургуудыг судалж үзээд эрэгтэй хүнийг доорх байдлаар дүгнэжээ. Хэрэв эрэгтэй хүний хажууд дур булаам эмэгтэй байх юм бол тэр эрийг их азтай ба ухаалаг гэж хүлээн авдаг байна. Харин царай муутай эхнэр байвал өсрэгээр. Иймэрхүү үнэлэмжүүдэд үндэс бий. Царайлаг биш залуухан эр сайхан эмэгтэйн анхаарлыг татахын тулд эсвэл баян, эсвэл хүчирхэг, эсвэл алдар нэртэй байх ёстой. Таны амжилтыг дагадаг сексийн харьцаа нь хүнд хэцүү хөдөлмөрийн сайн шагнал юм. Хүрсэн амжилтаа бусдад харуулах тааламжтай бөгөөд эвгэй арга. Амжилтанд хүрээгүй хүн таны эзэмдэж байгаа эмэгтэйн анхаарлыг татна гэж найдах ч хэрэггүй.

Бэлгийн эзэмдэлт таныг нэг үгээр өмчтөн болгох ба таны алдар нэрийг өсгөнө. Ялангуяа бусад эрчүүдийн шүлсээ гоожуулдаг эмэгтэйд эзэмшиж байвал бүр өснө. Тэд таны таашаалд атаархана. Бусад хүмүүсийн хүлээн авч байгаа байдал нь бодит байдлыг хэвшүүлдэг. Тиймээс хүмүүсийн нүдэнд өсөхийн хэрээр таны нийгмийн байдал өсөхөд нөлөөлнө.

Та хавьтагчаа бардамнан гайхуулах замаар бусад эрчүүдэд сэтгэгдэл төрүүлнэ. Энэ нь загвар өмсөгч, жүжигчин юмуу баян удмын эмэгтэй байж болно. Гэхдээ сексийг ийм талаар ашигладаг эрчүүд эмэгтэй хүний сайн талууд гэхээсээ илүү гадаад үзэмжинд гол дүн өгдөг. Өрсөлдөөн ил тод бөгөөд хожилгүй байж

болно. Александрын их дэлгүүрийн эзэн Жонатан Фаркас 50 гарсан хойноо залуу насаа ийнхүү дурсжээ. "Та загвар өмсөгчидтэй хамт ил тод харагдах ёстой. Учир нь энэ бол жинхэнэ үнэтэй эд. Залуус бидний дунд бие биенээ давах хүсэл байх ба байнга өрсөлдөөн явагддаг. 3 мянга юмуу 4 мянган долларын загвар өмсөгч чамтай явалдсан уу?", "Плейбой" сэтгүүлийг үндэслэгч Дональд Трамп нэгэн эмэгтэйн тухай онгирон ярихдаа: "Би түүнтэй хамт ресторанд ороход бусад эрчүүд эхэр татан уйлдаг байсан" гэжээ. Хүмүүс түүний эмэгтэйд биш харин тэдний болзоог харан ийм байдалд орж байхыг тэр анзаарчээ.

Харин танд ямар эмэгтэй хамгийн их таарах вэ? Хөөрхөн бөгөөд үдэшлэг цэнгүүн сайн зохиодог телевизийн хөтлөгч эсвэл гэрээсээ анх удаа гарсан том хөхтэй хөдөөний хөөрхөн бүсгүй, англисакс юмуу протестант шашинтан эмэгтэй юу? |Энэ бол хоосон тооцоо биш гэжта бодно. Ийм эмэгтэй илүүхөгжилтэй, түүнтэй секс хийхэд гайхалтай.|

Өөрөө өөрийгөө сексийн тодорхой түвшинд хүргэхэд түлх. Жишээ ньхамгийн түгээмэл зорилгуудын нэг нь олон хамтрагчтай байх явдал. Ерөнхийлөгч Жек Кеннеди дандаа "Би эмэгтэй хүнийг нэг л удаа эзэмдсэн бол дахиж сонирхдоггүй" гэдэг байв. Тэрбээр цаашдын харьцаа биш харин цаашдын эзэмдэлтэд тэмүүлдэг. Тэр дээд амжилт тогтоож түүнийгээ эвдэнэ. Хүмүүс өмнөх ерөнхийлөгч нараа хол хаясан Кеннедигийн олон тооны эмэгтэйчүүдийн тухай түүхийг ярихад Жонсон ширээ тасхийтэл алгадаад: "Чөтгөр гэж би бүр олон эмэгтэйтэй явалдсан. Ямар нэг урьдчилсан зорилгогүйгээр" хэмээн дуу алджээ. |Сенатын олонхи удирдагчдын адилаар Жонсон Капитолид хууль бус дурлалын харьцаандаа зориулан даруухан булан гаргаж авсан байдаг|. Жүжигчин Дастин Хоффман дуу алдан: "Хэрэв Жек Николсон бид хоёр хамт байхаасаа өмнө Уоррен Биттигээс цөөн хавьтагч үзсэн гэвэл алдаж байгаа хэрэг" гэжээ. Сагсан бөмбөгийн од Уилт Чемберлен амьдралдаа 20 мянган эмэгтэйтэй бэлгийн харьцаанд орсон гэж тоолжээ. Харин МэжикЖонсон 2 мянган эмэгтэй гэсэн нь бас л сэтгэгдэл төрүүлж байна. |Сексийн тал дээр эмэгтэйчүүд тоолох нэг их дуртай биш. Гэвч тийм хүмүүс байна. Кино од Эннабел Чонг 1995 онд нэг өдрийн дотор 251 эртэй бэлгийн харьцаанд орж дээд амжилт тогтоожээ.|

Эсвэл та нэгэн хөрөнгө оруулагч банкир шиг Пентхаузын өндөр үнэтэй охидтой бэлгийн харьцаанд орох гэж оролдож болно. Эсвэл янз бүрийн улсаас ирсэн хүүхнүүдтэй хурьцаж болно. Энэ нь ялангуяа оюутнуудын дунд түгээмэл байдаг. Зарим хүн хэд хэдэн эмэгтэйтэй зэрэг явалдах, эсвэл зарим нь зөвхөн залуу охидыг ангуучилдаг.

Хэрэв танд эмэгтэй хүнтэй харьцаагаа төгсгөлд нь хүргэх хангалттай цаг хүч ба энерги үгүй бол сэтгэл бүү зов. Энэ чухал биш. Та бэлгийн харьцаанд оролгүйгээр бусад эрчүүдэд сэтгэгдэл төрүүлж чадна. Генри Киссинжер бусад эрчүүдэд сэтгэгдэл төрүүлэх, тэднийг өдөөн хатгахын тулд өөртөө толгой эргэм имижийг бодож олсон. Тэр хүмүүсийн нүдэнд өөрийгөө маш тачаангуй хүн мэт харагдуулдаг. Эмэгтэй хүний тухай мэдлэгтээ тулгуурласан янз бүрийн наргиан үе үе хэлнэ. Амралтын өдөр бүр гял цал хүүхэнтэй Цагаан ордонд харагдаж сэтгэгдэл төрүүлдэг байсан. Гэтэл Киссинжер хамт яваа хүүхнүүдтэйгээ бэлгийн харьцаанд бараг ордоггүй байжээ. Түүний хувьд энэ чухал биш. Тэр сэтгүүлчдэд тайлбарлахдаа бүхнийг чадагч хүчирхэг залуугийн дүр төрх нь сэтгэгдэл төрүүлэхийн тулд л хийгдсэн гэжээ. "Миний хүүхэмсэг эр гэсэн нэр надад чамгүй ашиг өгсөн. Одоо ч хэрэг болсоор байна. Учир нь түүний тусламжтайгаар би хүмүүст өөрийгөө ямар нэг музейн үзмэр биш гэж батлахад амархан байдаг" гэжээ. Цочирдом имиж бүтээхийн тулд "Дур булаам чихэр" хөлсөлнө. Бусад эрчүүд атаархсандаа ухаанаа гээж, харин эмэгтэйчүүд өдөөгдөнө. Танд бүгд атаархана. Романтикхарьцааны үед зайлшгүй тохиолддог хэрүүл маргаан ба ам мурийлтаас болж та хохирохгүй.

Гэвч сексийг ашиглах нь зөвхөн хүмүүст өөрийгөө гайхуулах зүйл биш. Энэ бол нэг төрлийн байлдан дагуулалт, тэгэхээр өөрийн хүчиндээ итгэхэд тусална. Та одоо өөрийн хүсэлд нийцүүлэх гавьяатай. Учир нь та хүчирхэг, баян ба алдар нэртэй бөгөөд танд олон олон

боломжууд бий.

Яг одоо энэ бүхнийг хийсний дараа танд сексийн бүх эрх чухал гэж бодогдохгүй байна уу? Та өөрийн өсөн нэмэгдэж байгаа хүслийн гарт байна. Та бүх юманд манлайлахыг хүснэ. Та өөрийгөө гял цал бүсгүйтэй агуу секс хийх гавьяатай гэж тооцно. Та юу ч авахгүй гэдэг нь худлаа. Та бүхнийг олж авна. Нью-Йоркийн салалтын асуудлаарх алдарт өмгөөлөгч Рауль Фелдер өөрийн ажиглалтаас дараах дүгнэлтийг хийжээ. Нууц амраг гэдэг нь эдийн засагтай шууд холбоотой үйл явц. Хэрэв эр хүнд мөнгө их байвал нууц амрагтай болох магадлал өсдөг.

Хэрэв та анхаарлыг нь татах гавьяатай гэж үзсээр атал эмэгтэй хүн огт анзаарахгүй бол та өөрийгөө баян, чухал, алдар нэртэй гэж харуулбал үйлчилж эхэлнэ. Бас хамтран зүтгэгчид таныг ямар их атаархлын нүдээр харахыг та олж харна.

Эрх мэдлээ үзүүл. Генри Киссинжерийн хэлсэн үг бий. Бид байнга ишилдэг. "Хүч - анхдагч өдөөгч эхлэл". Гэхдээ эрх мэдлээ харуулах шилдэг аргуудыг олох хэрэгтэй. Жишээ нь ерөнхийлөгч Никсоны өмгөөлөгч Жон Дин нэгэн бүсгүйг сонирхсон ч өнөөх нь түүнд утасны дугаараа өгөхөөс таггалжээ. Тэгэхээр нь Цагаан ордны нэртэй операторуудыг ашиглан түүний дугаарыг хайлгаад дараа нь түүнд утасдаж үүгээрээ эрх мэдлээ гайхуулах боломж гаргажээ.

Мөнгөө мэдүүл. Гэр, машин, хувцас гээд өдөр тутмын зардалд их мөнгө зарцуул. Гажхачин алхам үйлд. Сэтгэгдэл төрүүлэхийн тулд түүнд зориулан үнэтэй бэлэг ав. [Та хамтдаа таашаал авах тийм бэлэг өгч болно.] Найруулагч Скотт "Том хөхтэй" харьцах дуртайгаараа нэрд гарчээ. Тэрбээр өнөөх үнэт том эдтэй эмэгтэйчүүдээ гайхуулах үзүүлбэрүүд зохиодог байв. Тэр бүү хэл заримынх нь хөхийг томсгох мэс заслын төлбөрийг хийж байсан бөгөөд үүнийгээ зөвхөн тэдний төлөө биш бас өөрийнхөө төлөө ч хийдэг байлаа. Төлбөрийн картаа биширч байгаа эмэгтэйдээ өгөөд хэрэглэх бүрэн эрхийг олгоорой. Сагс дүүрэн сарнай түүнд худалдан ав. Гэхдээ дэлгүүрээс биш ресторанд бааранд зардаг сарнай шүү дээ.

Алдар нэрээ мэдүүл. Жүжигчин Бен Аффлек энэ талаар "Алдар нэрд гарсан хүн эвдэрдэг. Гэхдээ эмэгтэйчүүдийн тухайд бол та дур булаам хэвээр" гэжээ. Жүжигчин Эндрю Маккарти 1980 онд түүнд ирсэн алдар нэр нэг л зүйлээс бусдыг өөрчлөөгүй гэжээ. Өөрчлөгдсөн зүйлийнхээ талаар: "Улам олон дэгдээхэйнүүд надтай ойр харьцаанд орохыг хүсдэг болсон" гэсэн байдаг. Алдар нэрээс авч болох бүхнийг ав. Таны шүтэн бишрэгчид танихуйц тийм газраар яв. Тэгвэл ямар чухал хүнтэй яваагаа найз бүсгүй чинь ойлгоно. Сексэд нэртэй болохын тулд үндэсний баатар байх шаардлагагүй. Таны алдар нэр таныг жижиг цөөрөмд хүлээж байгаа. Тодорхой хэдэн рестораны байнгын үйлчлүүлэгч бол. Тэд танд хамгийн үнэ цэнэтэй түнш хэмээн хандах болно. Эзэн нь таныг нэрээр дуудаж, танд үргэлж хамгийн сайн ширээг бэлдэж, үйлчлэгчид таны нүдэн дээр дуртай коктейлийг тань найруулна.

Мэдээж энэ бүхэн нь бодит байдалд та зарим нэг эрх мэдэл, мөнгө ба алдар нэртэйг өгүүлнэ. Хэрэв үгүй бол... Өөрийн гадаад төрх дээр, мөн дээд зиндааныхны үг хэллэгээр ярилцаж сурах чадвар дээр ажилла. Хэрэв та мөнгө, хүч ба алдар нэрийг сексийн зорилгоор ашиглах юм бол таныг хүний тань хувьд үнэлнэ гэж бүү хүлээ.

Хэдийгээр эмэгтэйчүүдээс цөөн боловч эрчүүд ч бас алдар нэр, мөнгө ба эрх мэдэлд

хүрэхийн тулд сексийг ашигладаг. Нью-Йоркийн жинхэнэ барон Морт Цукерман нь Бетти Роллинс, Глория Стиман, Гора Эфрон, Диана фон Фурштенберг зэрэг алдар нэртэй олон олон бүсгүйтэй явалдаж байв. Америкийн сенатч Бод Торричели нь Патриция Дафф, Бьянка Жеггер нартай явалддаг байсан. Виржини муж улсын сенатч Жон Уорнер Вашингтоны Ли их сургуулийн оюутан байхдаа Свит Брайер ба Мэри Балдвин болон нэгдүгээр дамжааны бусад оюутан охидын нэртэй хавтасыг байнга шагайдаг байсан бөгөөд хожим тэдний нийгмийн зиндааг ч шалгадаг байв. Тэгээд хэнтэй гэрлэсэн бэ? Ивээн тэтгэгч мультисаятан Пол Меллоны охинтой. Түүний өвөө нь нефтийн аварга компаний эзэн Эндрю Меллон гэдгийг бүгд мэднэ. Уорнер эхнэрээсээ салсаны дараа телевизийн хөтлөгч Барбара Уолтерс, нефтийн компанийн өв залгамжлагч Пейж Ли Хафтн нартай явалдаж байгаад Элизабет Тейлортой гэрлэсэн байдаг.

Та гэр бүл зохиох хүсэлгүй байсан ч нэртэй үйл явдал юмуу агуу хүмүүст хүрэхийн тулд эмэгтэйчүүдийг ашиглаж болно. Арга ядлаа гэхэд нөхөр нь ирээгүй хонгорхон хатагтайг дагалдах замаар хөдөлж болно. Жерри Ципкин бол тэргүүн хатагтай Нэнси Рейган болоод дээдсийн хүрээний бусад эмэгтэйчүүдийг хаа сайгүй дагалдаж явдгаараа нэртэй.

Алдар нэртэй эмэгтэйн хүрээлэлд багтахад холимог мэдрэмж төрнө. Нэг талаас та олонхи эрчүүдийн адилаар эмэгтэй хүний сүүдэрт дарагдах нь таалагдахгүй. Та өөрөө анхаарлын төвд байхыг хүсч байгаа шүү дээ. "Секс ба хот" номын зохиогч Кэндас Пушпел өөрийгөө "нэг их нэртэй хүн биш" хэмээн нэрлэхдээ өөрийн туршлага дээр олон зүйлийг мэдэж авчээ. "Юу үнэн бэ гэвэл эрэгтэй хүнд бусдын анхаарлыг өөрөөс нь илүүтэй татдаг эмэгтэйн дэргэд байх нь таалагддаггүй" гэжээ. Нөгөө талаас алдар нэртэй эмэгтэй бол таны ангын олз. Тэр хамаг нэр төрөө чирэн ирж таныг сонгожээ. Тэр эмэгтэй алдар нэртэйн хэрээр бусад эрчүүд таны ялалтыг өндөр үнэлэх болно. Энэ нь хүндэтгэл төрүүлж, таны алдар нэрийг түшиж тулна.

Сексийн сүйрэл

Секс таны хүч чадлын тухай дохио өгч тулж дэмжихээс гадна бас сүйтгэж мэднэ. Олон эзэрхэг эрчүүд хүч чадал ба секс гэсэн ойлголтыг хольж хутгадаг. Тэд дур булаах ба ялалт байгуулахад тэмүүлдэг. Хэрэв энэ тодорхойлолт танд тохирч байвал болгоомжтой байгаарай. Секс таныг урхиндаа оруулж мэднэ. Хэрэв хэрүүл шуугианы үндэс болох аваас таны хүч чадлыг үгүй хийнэ. Ингэснээр та бэлгийн харьцаанаас татгалзахад хүрдэг.

Улс төрчид эрх мэдэл ба бэлгийн харьцааг холих аваас ноцтой аюул нүүрлэнэ. Улс төрчид жирийн хүүхэмсэг эрчүүдийг бодвол сексийн тал дээр илүү боломжтой байдгаасаа болоод түүнд татагдан ордог. Эсвэл тэд олон нийтийн хүчтэй хяналтан дор байдаг уу? Магадгүй улс төр дэх эрх мэдлийн төлөө шунал нь сексийн тал дээр ч ханаж цаддаггүй өлсгөлөн байхтай нь дүйцдэг үү? Зарим нэг хүмүүс улс төрийн амжилт ба сексийн оргилсон эрчтэй идэвхи хоёрын хооронд нягт харилцаа байгааг олж хардаг. Судалгаанаас үзвэл улс төрд амжилт олсон эрчүүд хотын дундаж иргэдийг бодвол бэлгийн шунал тачаал их байдаг ажээ.

Ялангуяа Тэр бүлийн үнэт зүйлс"-ийг дэмждэг улс төрчид сексээс болж эрх мэдлээ алдах аюул тун их. Өрсөлдөгчид өндөр ёс суртахуунд үл нийцэх ямар нэг үйлдэл хийхийг тань онцгой анхааралтай ажиглаж байдаг. Ерөнхийлөгч Клинтоньг ёс суртахуунгүй харьцааных нь

төлөө хагуу шүүмжилсэн конгрессийн гишүүд хожим өөрсдийнх нь нүгэл ил болоход хоёр нүүртнүүд хэмээн шившигийн баганад хадагдсан. Дээрэнгүй спикер Ньют Жингрич 56 настайдаа ерөнхийлөгчийгхамгийн хатуу шүүмжилдэг нэгэн болжээ. Гэтэл түүний 33 настай туслах бүсгүйтэйгээ явалдаж эхнэрээ араар тавьдаг нь ил болоход үг ба үйлдлийн зөрөө нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтай нийтийн хүртээл боллоо. Гэхдээ энэ нь гэр бүлийн үнэ цэнийн тухай сурталчилдаг хүмүүсийн хуаранд өгсөн эцсийн цохилт биш байв. Ливингстон "Заримдаа үнэний замаас хазайдаг" хэмээн хүлээснийхээ дараа бүх эрх мэдлээ алдсан. Гэр бүлээс гадуур явдал нь хэвлэлд дэлгэгдэх аюулд өртсөн Ливингстон ерөнхийлөгч Клинтонд итгэл үзүүлэх эсэх тухай маргааны үеэр өндөр индэр дээрээс мэдэгдэхдээ, ирэх сонгуульд өөрийн нэрийг дэвшүүлэхээс татгалзаад зогсохгүй конгрессийг ч тун удахгүй орхино гэжээ.

Улс төрчид ийм алхамаа юу гэж зөвтгөдөг вэ? Итгэхэд бэрх боловч тэдний хэлдэг зөвтгөлүүдийн нэг нь секс эрүүл мэндэд амин чухал гэнэ. Ерөнхийлөгч Кеннеди ардчилсан намын улс төрч Бобби Беймерт ярихдаа: "Хэрэв ямар нэг сонирхолтой зүйлгүй ганцхан өдөр өнгөрөх юм бол миний толгой хатгаж өвддөг" гэжээ. [Тэр энэ тухайгаа Английн ерөнхий сайд Гарольд Макмилланд хүртэл ярьдаг байв]. Домогт Мартин Лютер Кингийн хүү байнга олны анхаарлын төвд байдаг ба түгшүүрээ намжаахын тулд сексийг ашигладаг байсан гэнэ. Тэр хэлэхдээ "Секс бол тавгүйтлийг багасгах арга" гэдэг байлаа. Гэвч түүний энэ арга өөрийг нь холбооны мөрдөх товчооны захирал Эдгар Гуверийн гарт оруулсан байна. Мөрдөх товчоо түүний зочид буудлын өрөөнд чагнах төхөөрөмж байрлуулж өдөөн хатгалгын бичлэгүүд хийдэг байжээ.

Хэрэв бэлгийн замбараагүй явдал таны эрх мэдэлд заналхийлж эхлэх юм бол араас нь мөрдлөг тандалт ба тачаангуй сонирхол бас гарцаагүй дагалдана. Антоний ба Клеопатра нарыг сана. Бүгд Найрамдах намын сенатч Боб Пэквуд секс явдлынхаа төлөө цөлөгдсөн. Тэрбээр багаар бодоход 17 эмэгтэйг мөшгиж, хүчээр секс тулгаж байжээ. Мэдээж Клинтон ба түүнд итгэл үзүүлэх эсэх тухай асуудал, 23 настай даруулгагүй жолоогүй тачаангуй оюутан хүүхэнтэй харьцсаных нь төлөө Жей Лено, Морен Дауд, Дон Имусаас эхлээд "Үзэл бодол" хөтөлбөрийн тоймчид хүртэл бүх хүмүүсийн зүгээс бүтэн жилийн турш ирсэн байнгын шалгалт ба доромжлол.

Иймэрхүү алхам дэлгэгдэх нь таны өөрийгөө эзэмдэх чадвар хангалтгүйг харуулдаг. Алдах зүйл ямар их, тэр бүү хэл бүхнийг алдаж мэдэхээр байсан ч хүслээ хянаж чадахгүй байна гэсэн үг. Ийм ухаангүй байдал таны улс төрд тохирохгүйг харуулж байна. Таны ийм үйлдэл нь улс төрд тохирохгүй гэдэгтээ та өөрөө ч итгэдгийг харуулдаг. Мөн хуулийн дээр гэж өөрийгөө боддог бөгөөд бас шүүмжлэлийг хүлээн авах чадваргүй гэдэгтээ итгэдгийг харуулж байна. 1987 оны ерөнхийлөгчийн сонгуулийн өмнөх кампанит ажлын үеэр Гэри Харт түүний бэлгийн харьцааг мөрдөж байсан сэтгүүлчдэд: "Хэрэв хэн нэгэн цаашид намайг мөрдөхийг хүсч байгаа бол их залхах болно доо" гэжхэлж байжээ. Гэвч хэн ч залхсангүй. Донна Райс бүсгүйтэй тогтоосон харьцааг нь сэтгүүлчид мөрдөхөд саад тавьсангүй. "Энэ хүн одоо ерөнхийлөгч болох гээд байгаа гэж үү?" гэж хүмүүс дуу алджээ.

Дүрэм

Секс таны боломжид цохилт өгөхийг хэзээ ч бүү зөвшөөр.

Олон нийтийн санаа бодолд аливаа дуулиан шуугиан хүнийг тодорхой имижтэй холбож байдаг. Шуугиант алхамуудыг түүнийг үйлдсэн хүмүүстэй холбоорой.

Гардуулсан хүн

Үйлдэл

А. Нью-Йоркийн шүүгч Сол Уолчлер Б. Спортын тоймч Марв Алберт В. Телевизийн номлогч Жим Бэккер Г. Улс төрч Нельсон Рокфеллер Д. Жүжигчин Пи-ви Герман Е. Дуучин Майкл Жексон Ж. Улс төрийн зөвлөх Дин Моррис З. Найруулагч Вуди Аллен

87. Дээдэс сурвалжтнуудын театр дотор бэлиг эрхтэнээ гаргаж хүмүүст үзүүлсэн.

88. Янхантай амаар секс хийх харьцаанд орсон.

89. Насанд хүрээгүй хүүхдүүдтэй бэлгийн харьцаанд орсон сэжигт өртсөн.

90. Урлагийн ном дээр ажиллаж байхдаа залуухан найз бүсгүйнхээ гар дээр үхсэн.

91. 21 настай сүмийн нарийн бичгийн дарга бүсгүйтэй бэлгийн харьцаанд орсон.

92. Цус ойртолтонд орооцолдсон.

93. Түүнийг хүлээн аваагүй эмэгтэйн охинд нь заналхийлсэн.

94. Эмэгтэй хүний дотуур хувцсыг шүтээний чанараар авч явдаг.

Зөв хариулт: а-7, б-8, в-5, г-4, д-1, е-3, ж-2, з-6

Сексийн голлох шинж тэмдэгүүд

Бэлиг эрхтэний хэмжээ

Үс

Өндөр

Бэлиг эрхтэний хэмжээ

Олонхи эрчүүд бэлиг эрхтэний хэмжээг бэлгийн хүч чадал болоод хорвоогийн эрх мэдэлтэй холбож үздэг. Энэ нь бэлиг эрхтэний урт, бүдүүн ба хөдлөх чадвартай холбогддог.

Гайхалтай нь бэлиг эрхтэндээ санаа зовдог эрчүүд эмэгтэйчүүд биш харин эрчүүд түүний тухай юу гэж бодох бол гэж зовдог ажээ. Нэгэн судалгаанд орсон 300 эр бэлиг эрхтэнээ томруулах мэс заслыг сайшаасан ба тэд шийдвэрээ тайлбарлахдаа "Хаалттай орчны айдас" гэжхэлсэн, өөрөөр хэлбэл бусад эрчүүдийн өмнө таагүй байдалд орох мэдрэмжээр тайлбарлажээ. Харин гуравны нэгээс цөөн хүн нь бүсгүйчүүдийн зүгээс ирж байгаа

гомдолоос болж ийм шийдвэрт хүрсэн гэжээ.

Та ч бас бэлиг эрхтэнээ томруулахыг хүсдэг үү? Энэ бол хамгийн сүүлийн үеийн гоо сайхны мэс заслуудын нэг. Эсвэл та илүү сүртэй аргууд тухайлбал бэлиг эрхтэнээ уртасгахын тулд хүнд жинтэй юм зүүх аргыг ил үүд үзэх үү? Хийж эхлэхээсээ өмнө таны хүлээлт зөвдөх эсэхийг сайн бодоорой. Эрчүүд бодохдоо сэрэл хөдөлсөн үеийн бэлиг эрхтэний дундаж урт 25,4 см гэдэг бол харин эмэгтэйчүүд 10 см гэж л боддог. Харин үнэн хэрэгтээ дундаж урт нь 14 см байдаг ажээ.

Зарим эрчүүд тэдний бэлиг эрхтэн том байвал сэтгэл санаа нь их өргөгддөг. Нэгэн эр энэ тухай ярихдаа "Би ажил хэргийн уулзалтанд очихдоо дотроо ингэж

боддог. Хэрэв энд байгаа залуу миний эрхтэний ядаж тал шиг эрхтэнтэй бол ч" гэжээ.

Гэвч хэрэв та эрхтэнээ бусдад гайхуулах хурц хэрэгцээг мэдэрч байвал дотроо дарах гэж хичээгээрэй. Үүнийг ашиглах нь тун найдваргүй. Компьютерийн "Apple" компанийн ерөнхийлөгч Стив Догсобо залуухан бүсгүйчүүдийг ажилд авахаар ярилцлага хийх үедээ албаар дотуур өмдгүй зөвхөн шорттой ирдэг байжээ. Тэгээд хөлөө ачин сууж эмэгтэйчүүдийг шоконд оруулдаг байна. Эр хүний бэлиг эрхтэний гайхуулах тал нь зөвхөн бэлиг эрхтэний хэмжээгээр хязгаарлагдахгүй. Грекийн тэрбумтан Онассис бэлиг эрхтэндээ халимны гуурны арьс угладаг байжээ.

Үс

Олонхи эрчүүд үсэндээ ихэд санаа зовж, үс унавал түгшдэг. Үс нь залуу нас ба хүч чадалтай адилтгагдана. Судлаачид халзан эрчүүд ба өтгөн үстэй эрчүүдийг судалжээ. Халзан эрчүүд их сул дорой ба сэтгэл татах увидасгүйд тооцогддог болох нь тогтоогдсон. Эрчүүд ингэж мэдэрдэг. Халзан эрчүүдээс асуулга авахад тэдний 75 хувь нь үүнээс болж эвгүй мэдрэмж төрөхөд хүрдэг гэжээ. Энэ ч шинэ зүйл биш л дээ. Наполеон Оросын хаан Александртай уулзах үеэрээ улс төрийн чухал сэдвүүдээ хаячихаад халзралтыг хэрхэн эмчлэх тухай ярилцаж байжээ.

Өндөр

Магадгүй та өөрийнхөө өндөрт санаа зовдог байх. Хэрэв та намхан бол сэтгэл амгалан биш болно. Өндөр эрчүүд өндөр албан тушаал эзлэх магадлал өндөр. Тэд илүү сайн ажилд орж, их мөнгө олдог. 11990 оны судалгаагаар нэг дюймд харьцах цалингийн дундаж өсөлт жилд 1300 доллар|. Түүнээс гадна сайхан эмэгтэйчүүдийн анхаарлыг илүүтэй татдаг.

Биеийн өндөр нь мөнгө, эрх мэдэл ба сексийн тал дээр ч их утга учиртай. Мөнгөний тухай авч үзье. Америкийн 500 шилдэг компанийн гүйцэтгэх захирлуудын 50 хувь нь 6 футээс дээш 1183 см| нуруутай байхад зөвхөн 3 хувь нь 5 фут |152 см| ба түүнээс доош байжээ. Сексийн тал дээр. Эмэгтэйчүүд доод тал нь өөрөөсөө 6 дюйм |15см| өндөрэрчүүдийгсайшаадагбайна. Эрх мэдэл: 70жилийнтурш АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд аль өндөр нуруутай нь ялсаар иржээ. Ганцхан Ричард Никсон энэ хуулийг эвдэж чадсан байдаг. 1976 онд Жимми Картер ба Жеральд Форд нар ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөх үеэр Картерын талынхан өөрийн нэр

дэвшигчийг бодлоготойгоор байрлуулж байжээ. 185 см өндөртэй түүнийг заавал ерөнхийлөгчийн ард зогсоодог байв. Харин телевизийн халз ярилцлагын үеэр нэр дэвшигчид заавал суух ёстой гэхэд Картерын хамаг төлөвлөгөө нурсан гэдэг. Удтал маргасны эцэст мань хоёр зогсох, гэхдээ бие биенээсээ хангалттай хол зогсох гэдэг дээр санал нэгджээ. Фордын талынхан ийм буулт хийснийхээ хариуд арын дэвсгэрийн төлөвлөлтийг өөрчлөх шаардлага тавьсан ба энэ нь нэр дэвшигчийнхээ халзанг нуух зорилготой байв. 1998 оны ерөнхийлөгчийн сонгуулийн халз тулааны үеэр Жорж Буш намхан нуруутай Майкл Дукакисын хажууд зогссоноор сонгогчдын нүдэнд таатай харагдсан гэдэг. Тэрбээр өндөрөө харьцуулахын тулд ингэжээ. Тэгээд бараг бүх халз мэтгэлцээнд өндөр нуруутай нь ялж байсан.


Тиймээс намхан нуруугаа нуух арга хэмжээ аваарай. Мэдээжхамгийн энгийн арга нь өсгөж ярих. Үнэн хэрэгтээ хүмүүс өөрийн нурууг хэт үнэлэх нь түгээмэл байдаг. Гэхдээ та арай бусдаас онцгой зүйл бодож олоорой. Холбооны мөрдөх товчооны дарга Эдгар Гувер 6 фут 1182 см| хүрэхгүй өндөртэй байсан. Гэхдээ хүмүүс түүнийг дандаа доороос өлийж харахаар байрлал эзэлдэг. Тэр хүмүүсийг намхан буйдан дээр суулгаад харин өөрийнхөө ширээ сандалыг өндөрлөг дээр тавьдаг. Хувиарлалтын Дээд Танхимын дарга Фрэнк Яблонс намхан нуруутай. Тэрбээр ширээгээ шалнаас 6 дюйм |15 см| өргөгдсөн тавцан дээр тавьдаг. Энэ нь зочдыг өндрөөс харах боломжийг олгодог байлаа.

Нөгөө талаар намхан нуруу хүнийг баатарлаг алхам хийхэд хүргэдэг. Тэрбээр гадаад дутагдлаа ингэж нөхөхийг оролддог байна. Энэ нь ердөө 5 фут 2 дюйм |157 см| нуруутай хэдий ч европыг байлдан дагуулсан эзэрхэг хүний нэрээр "Наполеон өвчин" гэж нэрлэгджээ.

Хэдийгээр та гадаад төрхийнхөө зарим нэг асуудалд сэтгэл зовж явдаг байлаа ч соронзон давалгааны чухлыг бүү мартаарай. Өөрийн сэтгэл зовнилыг хэзээ ч хүмүүст бүү харуул. Сенатч Пэнвуд 1992 онд түүний өдрийн тэмдэглэл ил болсноос хойш байнгын шоглоомын бай болжээ. "Би гель огт хэрэглээгүй. Би үсээ халуун сэнсээр үлээлгэдэг боловч шууд хатдаггүй. Хэрэв миний хүссэнээр болохгүй бол самнадаг. Миний үс хэт ширүүн болохоор халуун агаараар үлээлгэхэд багахан хэсэг л налдаг. Би өөртөө итгэлтэй байдаг. Одоо бид улс төрийн өрсөлдөгчөө дарж чадна гэж бодож байна". Уг нь олон нийт бодохдоо сенатч хүн улс орондоо санаа зовнидог гэж бодсон болохоос биш үсний сэнсэнд ингэтлээ анхаарна чинээ санасангүй. Түүний гадаад төрхдөө хэт их зовних байдал нь олон нийтийн нүдэнд түүнийг сул дорой харяадуулжээ.

Сексийн төлөө секс

"Таны бодож байгаа шиг толгой эргэм тэр зорилгууд миний сонирхолыг хэзээ ч татаж байгаагүй. Би таашаал авахын төлөө л секс хийдэг". Үнэн хэрэг дээрээ таны мөнгө эрх мэдэл ба алдар нэртэй болох хүслийн үндсэн шалтгаан нь секс байж мэднэ. Яагаад гэвэл эмэгтэйчүүд эрх мэдэл, мөнгө ба алдар нэрэнд маш татагддаг бөгөөд танд энэ бүхэн их байхын хэрээр тохиолдлын бэлгийн харьцаа амархан болно. Ирээдүйтэй захирал, реп дуучин, улс төрийн зүтгэлтэн, гүйцэтгэх захирал, хөл бөмбөгчин гээд хэн бүхэн өөрийн гэсэн хүсэл таашаалтай ба сексийн тал дээр хавьтагчаа сонгох эрхтэй.



Чемберлен амьдралдаа 20 мянган бүсгүйтэй энгэр зврүүлсэн гэж мэдэгджээ

Гэвч олонхи эрчүүдийн хувьд тохиолдлын бэлгийн харьцаанд ороход бэрхшээлтэй байдаг. Яагаад гэвэл хэдийгээр эрчүүд үүнийг хүсдэг боловч ийм хүсэлтэй эмэгтэйчүүд цөөн. Эмэгтэйчүүд хөнгөн сээтэгнэлээс хүртэл байнгын харьцаанаас нэхдэг шигээ их зүйлийг шаардаж байдаг.

Хэрэв та эрх мэдэл мөнгө ба алдар нэрийн тусламжтай хөнгөн ялалт байгуулах боломжгүй ердийн нэг залуу бол тохиолдлын хавьтагч хайх эрэлд яаж амжилт олох вэ? Дараах сэдвүүдэд анхаарал хандуул.

Гадаад төрх

Хэдийгээр эмэгтэйчүүд эрчүүд шиг гадаад төрхөд онц их анхаарал хандуулдаггүй боловч өндөр нурууг бол үнэхээр үнэлдэг. Аль болох өндөр харагдахыг хичээ.

Эмэгтэйчүүд хангалуун амьдралын шинж тэмдгийг хайдаг учраас ажилдаа явсан ч, бааранд суусан ч үргэлж сайн хувцасла. Таны хувцас сайн материалаар оёсон, цэвэр ба чөлөөтэй байх ёстой.

Үргэлж хүчтэй харагдахыг хичээ. Бие махбодийн тэнхээгээ тодруулж бай. Өдрийн ажлын хувиар ямар хатуу хүнд болох тухай санаандгүй мэт ярь. Эсвэл эмэгтэйчүүдэд тавилгын байрлалаа солиход нь тусал. Гэхдээ эмэгтэй хүмүүс уул овоо шиг булчин зангирсан эрийг биш чавхайсан эрчүүдэд дуртай байдаг.

Дуу хоолойнхоо өнгөнд анхаар. Намхан, аядуу, уянгалаг дуу эмэгтэй хүнийг татдаг.

Нүүрний тэгш хэм нь тэгш бусаас илүү сэтгэл татна. Хэрэв таны хамар баруун тийш бага зэрэг мурий бол зүүн тийш үсээ хагал. Ингэснээр тэнцвэртэй байдал үүсгэдэг. Мөн таны хоёр хөмсөг ижил өтгөн байх ёстой.

Толгойн үс их бол сайн, харин бусад хэсгийн үс онцгүй гэж үздэг. Тиймээс хамар, чихнээс цухуйсан үсийг хайчилж, хөмсөг унжиж ургах аваас хайчилж байгаарай.

Хараа муутай бол мэс засал хийлгэх, эвсэл контакт линз зүүх хэрэгтэй. Хэдийгээр нүдний шилтэй эрчүүд илүү ухаалаг, сэтгэл зөөлөн мэт харагддаг ч эмэгтэй хүнд бие галбирын талаасаа таалагддаггүй. Нэг шилийг олон жил зүүх хэрэггүй. Шинийг авч байгаарай. Нарны шил зүүж бай. Ийм шил нь эр хүнийг такси харагдуулахаас гадна дутагдлыг нууж өгнө. Жишээ нь хоёр нүд дэндүү ойрхон бол нарны шил зүүгээрэй.

Үйлдэл

Бэлэг, ундаа худалдан авах юмуу гар цайлгах мөнгө өгөх зэргээр өгөөмөр болоод санхүүгийн боломжтой гэдгээ харуул.

Өөртөө итгэлтэй байх нь амжилтын дохио. Олон түмэнд үйлчил. Модонд авирах, жонглёр хийх юмуу цанаар гулгах гэх мэт зарим нэг сурсан зүйлээ улам сайжруулах замаар өөртөө хүмүүсийн анхаарлыг хандуул. Наргианч зангаа заавал хөгжүүл. Эмэгтэйчүүд наргианч эрчүүдэд тун дуртай.

Хүүхэд сонирхдог ба хүүхдэд хайртай гэдгээ харуул. Ингэхэд улс төрчид яагаад хүүхэд үнсэх дуртай вэ? Халамжтай хүн, анхааралтай эцэг гэдгээ харуул.

Хүний далд ухамсарт нөлөөлдөг бараг үл анзаарагдам санамсаргүй шүргэлтийг ашигла. Судалгаанаас үзвэл иймэрхүү шүргэлт таны талаар эерэг мэдрэмж ба сайн талын сэтгэл хөдлөл үүсгэж байдаг. Гэхдээ бараг мэдрэгдэхгүй байх ёстой. Үл таних хүмүүс биед нь хүрэхийг эмэгтэй хүн тэвчиж чаддаггүй.

Хамгаалагч шиг хөдөл. Хатагтайг машинд нь хүргэж өгнө гэж зүтгэ. Хэрэв ресторанд хүйтэн бол пиджакаа нөмрүүл. Хэрэв хэн нэгэн түүнтэй маргах юм бол эмэгтэйн үзэл бодлыг дэмж.

Харилцаа

Эмэгтэй хүнийг хөдөлмөрч, чармайлттай ба нэр төртэй эр хүн татдаг. Өөрийн олон тооны ололт амжилтын тухай сануулж бай. Өөрийн амьдралын зорилгыг ярьж бай.

Үргэлж соронзон давалгаа цацруул. Таны үйлдэл өөртөө итгэх итгэл, хүч чадал ба бэлгийн дур булаам байдалдаа итгэлтэй гэдгийг дамжуулах ёстой.

Анхааралтай хандах нь амжилт татахын нэг нууц. Нүдээр илэрхийлэх ба харцаар дамжуулан хэлхээ холбоо тогтоо.

Тоймч Элизабет Дрю тэмдэглэхдээ: "Ерөнхийлөгч Клинтон тохиолдлын танил ч бай, зочин ч бай, яриаг нь сонсож анхаарлаа төвлөрүүлдэг. Тэр ярилцагчаа анхааралтай харж, түүний ярьж байгаа зүйлд бүрэн автсан байдаг гэжээ.

Эмэгтэйчүүд найдвартай байдлыг үнэлдэг. Тийм учраас үргэлж уужуу тайван бай. Унхиагүйтэх нь стрессийг давж чадахгүй гэдгийг харуулна. Эелдэг байдал нь эр хүнийг дур булаам болгох давтагдашгүй хэрэгсэл.

Та "Би энэ бүхнийг бүгдийг нь оролдож үзсэн" гэж бодож мэднэ. Өөр ямар нэмэлт заалт өгөх

вэ? Домогт хүүхэмсэг эр Казановагийн жишээг дагахыг хичээ. Түүний секс байлдан дагуулалтын зарчмуудыг өнөөдөр ч хэрэглэж болно.

Бэлгээр бороо оруулж хүслийг өдөө

Гоёмсог цаг худалдан авсны дараа би ээмэг зүүлт гээд бусад жижиг чамин зүйлсийн талаар бодож эхэллээ. Мэдээж би бүгдийг нь шууд худалдаж аваагүй. Хайр, энхрийлэл, эелдэг зан шингээн сонгосон бэлгүүдийг тэр хүлээн авсан нь намайг ч бас их баярлуулав.

Өрсөлдөх чадвараа үнэл

Тэр бүсгүйг харж хандаж байгаа хүн нь нөхөр, амраг, хамаатан юмуу асрагчийн алин болохыг мэдэх ёстой. Ер нь энэ удаад ямар гээчийн адал явдалд татагдан орж байгаагаа мэдэх хэрэгтэй.

Гэрлэнэ гэж амал

Би түүнийг өөрөөсөө илүү хайрлаж байх үедээ |секс хийхээс өмнө| гэрлэнэ гэж бодож байлаа. Гэвч түүнийг эзэмдсэн хойно тэнцвэрийн цэг миний тал руу хазайв. Миний өөрийгөө хайрлах сэтгэл Кристинад өгсөн хайраас хүчтэй байжээ.

Секс боломжгүй бол цааш хөдөл

Хэрэв тохирох тэжээл авахгүй бол хайр дурлал нь завхай эрийн зүрхэнд үндсээрээ үхдэг гэдгийг бага зэрэг туршлагатай эмэгтэй бүр мэднэ.

xxx

Эмэгтэйчүүд ч бас эрчүүдийн нэгэн адил сексийг ашигладаг. Гэхдээ тэдний зорилго ба арга эрс ялгаатай.

Эмэгтэйчүүд сексийг юунд ашигладаг вэ?

Та сексийг төлөвлөгөөндөө багтааж болно. Ингэхэд та олз шүүрэхийг хүсч байна уу? Энэ олз нь таныг эрх мэдэл мөнгө ба алдар нэрд хүргэх эр хүн байж болно. Эсвэл та сексээс ердөө л таашаал хайдаг уу? Гэвч секс хоёр хүнийг ойртуулж харьцааг бэхжүүлдэг гэж бодон алдаа бүү хийгээрэй.

Жек Потийн төлөөх секс

Эмэгтэйчүүдээс тун цөөхөн нь олз шүүрэхийн тулд, тухайлбал эрх мэдэл, мөнгө ба алдар нэрд хүргэх эрийн төлөө сексийг ашигладаг.



Кино од Эннабел Чанг нэг өдөрт 251 эртэй энгэр зөрүүлж дээд амжилт тогтоов

Харин та олонхид багтаж байгаа бол эрэгтэй хүнээс гарч буй тушаал заавар, тэдний өндөр цалин хангамж, бусад хүмүүс түүнийг хүндлэх байдал үндэсний онцлог зэрэг нь зөвхөн ухамсрын далд түвшинд эмэгтэй хүнийг өдөөдөг. Вашингтоны нэгэн эр хэлэхдээ "АНУ-ын сенатчийн хөлд ямар олон эмэгтэй сөхрөн унадгийг мэдвэл та гайхах болно. Гэтэл дипломтай эдийн засагчийн хөлд ч дутуугүй тооны эмэгтэй унаж өгдөг юм" гэжээ. Ингэхэд эр хүн ажлаасаа халагдчихвал таны сонирхол хамт халагдах уу? Таны оргилуун сэтгэл бүдгэрэх үү?

Эрт дээр цагаас эмэгтэйчүүд эрх мэдэл, мөнгө ба алдар нэрд хүрэх боломжгүй байсан учир тэдгээрийг хүчирхэг, баян ба алдартай эрийн тусламжтай олж авахыг хичээдэг байсан гэж нийгэм судлаачид тайлбарладаг.

Харин хувьслын онолын сэтгэл судлаачид эмэгтэй хүний хангамж сайтай эр хайдаг гол шалтгаан нь хүүхдүүдээ дээд зэргээр хангах явдал гэжээ. Өөрийг нь болоод хүүхдүүдийг нь нийгмийн тодорхой зиндаа, байнгын хамгаалалт, анхаарал халамж ба орлогоор хангаж чадах

тийм эрд эмэгтэйчүүд татагддаг. Ер нь амьдрал ба амжилтанд амин чухал бүхнийг хангах эр хүнийг хүсдэг.

Шалтгаан ямар ч байж болох хэдий ч эмэгтэй хүн мөнгө, эрх мэдэл ба алдар нэр, мөн тэдэнтэй дүйх чанарууд болох нэр төр, сайхан сэтгэл, нийгмийн өндөр албан тушаал зэрэгт татагддаг нь үнэн.

(Энэ бүхнийг өөртөө шингээсэн эрийг Жек Пот хэмээн нэрлэх болно.)

Та Жек Потод тэмүүлэхдээ энэ нь таны туйлын зорилго болчихдог тэр цөөхөн эмэгтэйн нэг байж болно. Энэ тохиолдолд танд түүний хувийн чанар ба зан араншин огт чухал биш. Гэхдээ түүнийг урьж залдаг хүмүүс |хамтад нь таныг ч бас| юмуу банкин дахь дансанд нь нөлөөлөхгүй тохиолдолд шүү дээ. Та өөртөө шударга байж, зөвхөн тодорхой зиндааны эрчүүдийг сонирхдог болохоо ухаарна. Сургуулийн багш юмуу төрийн албан хаагч таны утасны дугаарыг асууж өөрийгөө зовоох ямар ч шаардлагагүй. "Мисс Мэйфлауэр" хэмээх Сидни Бидл Бэрроз Жек Потод тэмүүлж буй бүсгүйчүүдэд зориулан бичихдээ: "Баян, хүч чадалтай эр хүнийг өөрийн болгох тэмүүлэл асар их хөдөлмөр, гүргэр ба цөхрөлтгүй занг шаардана. Энэ өндөр бооцоог бүх хүчээ нэг зүгт төвлөрүүлж чаддаг тийм эмэгтэй л хожих боломжтой. Мэдээж ийм харьцаанд өөрийгөө золиослох шийдэмгий, дүүрэн хүсэлтэй, тэвчээртэй эмэгтэй ховор. Гэхдээ энэ нь боломжтой зүйл. Эмэгтэй хүн үлгэрийн мэт баян эрчүүдийг өөрийн болгож мөрөөдөл нь бодит болсон хэдэн зуун жишээ түүхэнд бий".

Гэхдээ та Жек Потын араас хэт шунаж байгаага ил хүлээн зөвшөөрч огт болохгүй. Романтик дурлал харуулж нүд хуурах ёстой. Учир нь нэг ч эр хүн хэрэв өөрийнх нь амжилт байгаагүй бол өөрөө хэн ч биш гэдгээ хүлээн зөвшөөрөх дургүй байдаг. Үнэн үг ярих, үнэн үйлдэл хийх гэж бүү биеэ чилээ. Харин өөрийгөө үнэн сэтгэлээсээ гээд л бай. 27 настай бүжигчин Анна Николь Смит 80 настай саятан Ховард Маршалыг үнэн дурлалдаа хялбархан итгүүлж чадсан. [Тэр хүний 500 сая долларын хөрөнгө хайртай нь ямар ч холбоогүй гэнэ.] Түүнийг тооцоогоор нөхөрт гарсан гэхэд тэр эрс эсэргүүцдэг байв. Мэдээж олз шүүрэх тэмүүлэлтэй л бол жинхэнэ сэтгэл ба мэдрэмжгүй хүн гэсэн үг биш л дээ. Та сэтгэлтэй ч байж болно, үгүй ч байж болно.

Үргэлж өөрийн Жек Потыг олж нөхөрт гарахыг хичээж бай. Эрх мэдэл, мөнгө ба алдар нэрд хүрэх зам гэр бүлийн баталгаагаар гагнагдвал бүр найдвартай. [Саллаа гэхэд хуримын өмнө байснаас илүү хангамжтай хоцордог].

Мөнгөний Жек Пот

Өөрийн Жек Потыг эрж хайж буй эмэгтэйчүүдэд өгөх зөвлөгөө байдаг уу? Тийм ээ. Энэ тал дээр ямар нэг хуурамч өнгө аясгүй, шулуун шударга бичсэн олон ном зохиол бий.

Жини Поло Сейлз "Романтик харьцаа, нөхөрсөг ба ажил хэрэгч зорилгын төлөө баян эртэй хэрхэн танилцах вэ? 1999, "Баян эрийн эхнэр болох арга" 1991 он.

Лиза Жонсон "Саятаныг хэрхэн урхидах вэ?" 1995

Сьюзан Райт "Хөрөнгийн төлөө хэрхэн нөхөрт гарах тухай: баян эр хэн нэгэнтэй гэрлэх ёстой, яагаад тантай биш гэж?" 1995

Дорис Лили "Саятантай хэрхэн гэрлэх вэ?" 1951, сайжруулсан хэвлэл "Тэрбумтантай хэрхэн гэрлэх вэ?" 1984

"Космополитен" сэтгүүл энэ бүх сэдвийг дэлгэрэнгүй авч үздэг.

Керт Пелаке "Мянганы бүсгүй" 1999 он. Энэ номонд саятантай суух байнга оролдлого хийж буй залуу бүсгүйн амьдралыг дэлгэрэнгүй харуулдаг

Хэрэв та дээр дурьдсан номнуудад цаг үрэхийг үл хүсвэл бид танд эхнэр нөхрийн харьцаанд хэрхэн орох талаар хэд хэдэн зөвлөмжийг санал болгож байна.

Хэн

Хязгаарлагдмал боломжтой эмэгтэй асар их мөнгөтэй эрэгтэйг олж авахыг хүснэ. Гэхдээ удам дамжсан мөнгө үү эсвэл цоо шинэ баяны мөнгө үү? Хуучин мөнгө их алдар нэртэй байдаг. Шинэ мөнгө таны хүслийг илүү өөгшүүлнэ. Таны хамгийн шилдэг сонголт бол саяхан бэлэвсэрсэн эр. Түргэн хөдөл. Эхнэрийнх нь үхлийн өвчтэй байх үе ба гашуудлын эхний өдрүүдэд хүртэл анхаарал түшиг үзүүл.

Хаана

Үйл явдал болж байгаа тэр газарт бай. Хүний эрхийн бага хурал, оршуулга, үнэ хаялцуулах худалдаа, музей, уран зургийн галерейн нээлт, онгоцны нэгдүгээр зэргийн суудал. Ганц бие, нүдэнд торохуйц эрчүүдийн цуглардаг газрууд руу оч. Хэрэгтэй спортоор хичээллэ. Теннис, агаарын теннис, цана, хамгийн шилдэг дасгалжуулалтын танхимд хичээллэх. Амралтаа хэрэгтэй газарт өнгөрөөнө. Бриж, блэк Жек, баккара зэрэг мөрийтэй тоглоомын урлагт суралц. Та бөгс эргэх зайгүй байр хөлсөлж ч болно. Хамгийн гол нь эргэн тойрны хөршүүд хэрэгтэй хүмүүс байх ёстой. Та юун дээр ч хэмнэлт хийж болно. Гэхдээ хүүхдүүдээ хамгийн шилдэг хувийн сургуульд явуул. Энд та эхнэрээсээ салсан баян аавуудтай учрах шилдэг газар.

Яаж?

Их уран сэтгэлгээтэй шаргуу байх хэрэгтэй. Нэгэн залуу сэргэлэн бүсгүй Нью-Йоркийн хамгийн баян эрчүүдийн нэгэн дээр нүд унагажээ. Тэгээд тэдний гэрт зохион байгуулагдсан үдэшлэгийн урилгыг олж авсан байна. Дараа нь ширээн дээр тавьсан нэрнүүдийг сольж, өнөөх эрийн зүүн бөөрөнд сууж авчээ. Харин ердөө сарын дараа тэр эр сая долларын үнэтэй хуримын бөгжийг бүсгүйн гарт зүүсэн байх юм. Марла Мэйплс тэрбумтан Дональд Трампын ажилладаг байшингийн орчим нэгэн удаа "санамсаргүй" мөргөлдөх хүртлээ удтал эргэлдсэн бөгөөд ингэсэн гэдэг.

Мөрдлөг

Та ирээдүйн Жек Потынхоо тухай бүхнийг мэдэж аваарай. Тэр танд хэрэгтэй хүн яг мөн

гэдгийг багтай тогтоохын тулд зөвхөн түүний үгэн дээр бүү тулгуурла. Интернет ашиглан компанийг нь шалга. Амралтаа өнгөрөөдөг газар, оршин суугаа газар, хөршүүд, машин, хувцасыг нь үнэл. Түүний найз нөхөд бахамтран зүтгэгчдийг нь үнэл. Нийгэмд эзэлж буй байр суурийг нь илтгэх нийгмийн хүрээллийг нь үнэл.

Таны сонгосон хүнийг Жек Пот болгосон тэдгээр чанарууд түүнийг тааламжтай хань ижил болохын баталгаа биш гэдийг санаарай. Ялалт бүр өөрийн үнэ цэнэтэй байдаг гэдэгт итгээрэй.

Дүрэм

Хэн мөнгөний төлөө нөхөрт гарч байнав тэр хүн зоос нэг бүрийг хөлсөө урсган олж авах болно.

Секс ба биеэ үнэлэлт

Биеэ үнэлэх нь сексийн тусламжтай мөнгө олох хамгийн ил тод арга хэлбэр. Гэхдээ биеэ үнэлсэнээс биеэ үнэлэлтийг зуучилж зохион байгуулах нь илүү ашиг авчирдаг.

Олон нийт эрэгтэй зуучлагчдыг жигшдэг мөртлөө эмэгтэй зуучлагчдад илүү зөөлөн ханддаг байна. Эмэгтэй хүн шаардлагатай бэлтгэл хийх тохиолдолд мөнгөний төлөө секс нь хүлээн зөвшөөрч болохуйц илүү элэгсэг дотно, тэр бүү хэл наргиантай санагддаг. "Мадам Мейфлауэр" хэмээн алдаршсан Сидни Бидл Бэрроуз өөрийн бизнесийн үндсийн тухай ярихдаа, хамгийн гол нь биеийг нь үнэлүүлж байгаа охид бүсгүйчүүдтэйгээ ойр дотно байх ёстой хэмээн онцолсон байдаг. Тэрбээр өөрийн оффист бүсгүйчүүдтэй уулздаг тухай дүрслэн бичихдээ, тэд ажлаа хүлээн суухдаа хэрхэн поп корн бэлдэж иддэг болон хэн нэгнийх нь төрсөн өдөр болоход үдэшлэг зохиодог тухайгаа өгүүлжээ. "Азтай загасчин" хоч нэртэй Ксавьера Холандер, Алекс Адамс, Хейди Флейс, Эдна Милтон зэрэг нэрд гарсан зуучлагчид байдаг. Тэдний нэгнийх нь тухай Бродвейн "Техасын хамгийн шилдэг жижигхэн янхны газар" гэсэн мюзикл бүтээгдэж нэрийг нь мөнхөлсөн.

(Янхан болоод түүний зуучлагчдын хувьд ер нь бизнесийн аль ч салбарт байдгийн адил алдар нэртнүүдэд үйлчлэх нь эд баялаг ба алдар нэрийн замыг хурдасгаж өгдөг. Флейсийн алдар нэртэй үйлчлүүлэгчдийн нэрс шар сонинууд дээр хөвөрсний дараа тэр жинхэнэ алдартан болсон билээ.)

Сексийг мөнгөөр солих хүсэлгүй бөгөөд мөн биеэ үнэлэх, түүнийг зуучлах сонирхолгүй бол хүүхэдтэй болоход анхаарч болно. Эр хүн маш олон гэрээ хэлцлийг тасчин хаяхад бэлэн байдаг ч төрсөн үрдээ туслахаас хэзээ ч татгалздаггүй. Баян эртэй өнгөрүүлсэн азтай ганц шөнө танд 18 жилийн турш тогтмол орлогын баталгаа болно. Эцэг байж магадгүй гэсэн магадлал хүртэл мөнгөний муугүй хангамжийг дагуулдаг. Ялангуяа болзошгүй баян эцэг нь эхнэр хүүхэддээ хангалттай нэр хүндтэй хүн байх аваас энэ мэдээ гадагш өчүүхэн төдий алдагдлаа гэхэд алдах юм их бий.

Энэ тал дээр тамирчид дур булаам бай болдог. Мэргэжлийн тамирчдын хүслээ чөлөөтэй тавих, хорхойдоо автах нь элбэг. Бие хамгаалагч Гейри Пейтон хоёр хүүтэй бөгөөд ердөө 4

сарын зайтай төржээ. Эхний хүүг нь ирээдүйн эхнэр нь төрүүлсэн бол харин хоёр дахь хүүг өөр эмэгтэй гаргасан байдаг. Бейсболын тэргүүн тоглогч Стив Гарби нууц амрагийнхаа буянаар эцэг болон хувирсан. Гэтэл дахин хоёр эмэгтэй түүний хүүхдийг нууцаар гаргаад байсан нь ил болсон бөгөөд хуучин эхнэр нь бас хоёр хүүхэдтэй. Тамирчин Ларри Жонсон дөрвөн хүүхнээс төрсөн таван хүүхдийг тэжээхэд хүрч байв.

Мэргэжлийн спортын баг тамирчид, тэр тусмаа сагсан бөмбөгчид энэ талаар нэртэй. Тэд чөлөөт цагийнхаа ихэнхийг аян замд өнгөрөөдөг. Бусад спортын тамирчдыг бодвол айлчилж тоглох нь 5 дахин их байдаг. Тэд өндөр цалин авдаг. Үндэсний сагсан бөмбөгийн холбоо тамирчиддаа бусад спортын төрлийг бодвол хэдэн сая доллар илүү төлдөг. Энэ тамирчдыг тогтооход ч амархан. Тэд бүх хүмүүсийн дээгүүр сүндэрлэх бөгөөд зурагтаар байнга гардгийн ачаар тэдний царайг бид танина. Домогт "Чикаго булз"-ын од Деннис Родман ярихдаа "Сагсан бөмбөгчдийн амьдралын 50 хувийг секс, үлдсэн 50 хувийг мөнгө эзэлдэг" гэжээ.

Та үүнийг худлаа гэж бодож байна уу? Хэн, тэр тусмаа шууд ямар нэгэн сагсчинаас жирэмсэн болохыг хүсэх юм бэ? гэжта бодно. Гэвч хүүхдийн хангамжийг өөртөө орлого оруулах хангалттай аюулгүй арга болгон ашигласаар байна. Тэрбумтан Рональд Перелмен 4 настай Патриция Дафф охиныхоо асрамжинд 38 мянган доллар зарцуулдаг байна.

Эрх мэдэлтэй Жек Пот

Магадгүй та эрх мэдлээр хангах эр олж авахыг хүсч болно. Бусдын эрх мэдэл бусдын мөнгөнөөс найдвар багатай гэдгийг санаарай. Таны Жек Пот мөнгөө танд хялбархан шилжүүлж болох ч эрх мэдлээсээ салахад тун хэцүү байдаг. Мэдээж Кейт Кэпшуо нь Стивен Спильбергийн эхнэр байгаагүй бол холливудад эрх мэдэлтэй болохгүй, илүү олон дүр авахгүй байсан. Гэвч түүний эхнэрийн зиндаа нь түүнд Жодди Фостер юмуу Мадонна шиг эрх мэдлийг хангаж чадахгүй. [Түүнээс гадна байшин, гоёл чимэглэл юмуу, орлоготой үнэт цаасыг өөрийн нэр дээр болгож болно. Харин түүний эрх мэдэл Жек Поттой хамт алга болдог. Хэрэв тэр үхэх, албан тушаалаа алдах юмуу салах юм бол дуусаа].

Хүмүүс сексийн тусламжтай олж авсан хүч чадалд сэжигтэй ханддаг. Тэр бүү хэл сексийн харьцаа нь эрх мэдэлд хүрэхээс хавьгүй өмнө болсон явдал байлаа ч ялгаагүй. Тэргүүн хатагтай ерөнхийлөгчийнхтэй дүйцэхүйц эрх мэдэлтэй. Тиймээс түшмэдийн хувьд аюул занал учруулдаг бөгөөд эрх мэдэл нь нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн болзол нөхцөлүүдээр хязгаарлагдаж байдаг. Засгийн газрын кабинетад зөвлөгөө явагдахад заавал оролцоно хэмээн зүтгэсэн тэргүүн хатагтай Розалин Картерын маргааныг санаарай. Эсвэл нөхрийнхөө багийн тэргүүлэгчийг халах өдөөн хатгалга хийсэн тэргүүн хатагтай Нэнси Рейган бас байна. Нийгмийн дунд илүү их эрх мэдэлтэй тэргүүн хатагтай нар болох Хиллари Клинтон, Элеонора Рузвельт нар байнгын тэмцэл дунд амьдарсан. Гэхдээ иймэрхүү эрх мэдлийг хууль ёсны бус бөгөөд айдастай гэж үздэг.

Хууль бус эрх мэдлийн асуудлаар нэмж хэлэхэд эзэрхэг эмэгтэйчүүд сул дорой нөхрийнхөө оронд нийгмийг удирдах явдал цөөнгүй. 1994 оны Калифорнид явагдсан сенатын сонгуулийн үеэр хатагтай Арианна Хаффингтоны сэргэлт илт байсан бөгөөд хүмүүс тэрбээр өөрийн нөхрийг нэр төрд дурлах сэтгэлдээ зэвсэг болгон ашиглаж байна хэмээн ярих болжээ. Эхнэр

нь ялалтанд нөхрөөсөө илүү сонирхолтой байх шиг санагдаж байв. Эхнэрийнх нь эрх мэдэл ба хүч чадал нөхрийнх нь өчүүхэн шаардлага болон дутагдлыг тодотгож өгч байлаа.

Өнөөдөр эмэгтэй хүн бэлгийн харьцаанд оролгүйгээр эрх мэдэлд хүрч болно гэж үздэг. Тиймээс та иймэрхүү аргад тааламжгүй ханддаг эр эм хүмүүсийн уур хилэнг төрүүлнэ.

Хэдийгээр ийм олон дутагдал байгаа ч Жек Пот таныг эрх мэдэлд хүрэхэд туслана. Гэхдээ нэг зүйлийг санах хэрэгтэй. Та түүнийг оршин буй хүчний тулгуур болгон ашиглахаас биш эрх мэдлийг бүр эхнээс нь бий болгоход ашиглах хэрэггүй.

[Алсын хараагүй зарим нэгэн хүн шиг алдаа бүү гаргаарай. Тэд бодохдоо баян Жек Пот бол эрх мэдэл ба зиндаатай гэдэг. Тэр их том хүн. Тэр баян мөртлөө том биш байж болно гэж үү?]

Алдар нэрийн Жек Пот

Мэдээжалдар нэртэй эртэй сексхийснээртанд алдар нэр ирнэ. Ерөнхийлөгч Клинтонтай нэр нь холбогдохоос өмнө Моника Левинскийн тухай хэн нэгэн сонссон уу? Эсвэл Жерри Зайнфелдтай нэр холбогдохоос өмнө Сюзанна Лопштайны тухай хэн нэгэн сонссон уу? Алдар нэрийн Жек Пот мөн эрх мэдэл ба мөнгийг авчирдаг. Шинээр олж авсан алдар нэр таны шинэ ажилд олны анхаарлыг татаж, ашигтай гэрээ хэлцэл хийх юмуу телевизийн ток шоунд оролцоход туслана. Ийм талын жагсаалт дуусахгүй. Гэхдээ та хүмүүсийн сонирхлыг өөр дээрээ болгож эс чадвал урт наслахгүй.

"Дүр хувиарлах дасгалжуулагч" гэдэг нь голливудын хоч нэр [Энд эрх мэдэл ба алдар нэр салшгүй холбоотой] бөгөөд залуу жүжигчид эрх мэдлийн юмуу алдар нэрийн Жек Потыг хүчирхэг найруулагч, алдартай жүжигчин ба гүйцэтгэх продюсерын өчүүхэн анхаарлын шинж тэмдэг юмуу мөнгөний тусламжтай олж авахыг хичээдэг. Найруулагч Жон Сингелтон кинонд тоглох жүжигчид ба орлон тоглогчдыг өөрөө сонгодог байв. [Түүний туслагч нь хэн нэгэнд хандаж "Ноён найруулагч тантай фургон машиндаа уулзмаар байна" гэжхэлдэг байжээ]. Тэрбээр сонирхсон хүн рүүгээ дуран хандуулсанаар орлон тоглогчийг хөнгөхөнөөр од болгодог байлаа. Тиймээс эмэгтэйчүүд түүний хүссэн бүхнийг ямар ч эргэлзээгүй зөвшөөрдөг байсан бөгөөд түүний тааллыг ямар ч хамаагүй аргаар олж авахыг хичээдэг.

Та өөрийн Жек Потыг олж авахын төлөө секс ашиглахыг хүсэх боловч бас гар хүрэхээргүй байхыг давхар хүсч мэднэ. Ийм байж болох уу? Болно. Бодит амьдрал дээр халдашгүй байдал нь эрчүүдийн хувьд маш хүчтэй үйлчилгээтэй урхи занга болдог. Нэрт сэтгэгч Ларошфуко "Эмэгтэй хүний хувьд хүйтэн хөндий байдал нь гялгар цалгар бүрхүүл шиг. Түүнийг дур булаам ба сэтгэл татам байдлыг тодотгохын тулд өмсдөг" гэжээ.

Дүрэм

Сексийг ашиглахын тулд түүнээс татгалз.

Сексийн тухай бяцхан дохио таны эргэн тойронд сонирхолын бүрхүүл үүсгэнэ. Хүмүүсийн анхаарал ба сайшаалыг татахын тулд бараг үл анзаарагдам дохионууд өгч сур. Ажлын байран дээрээ та доорх секс дохионуудыг өгч болно.

Биеийн галбиртаа бусдын анхаарлыг татахын тулд суниах юмуу тонгойно. |Өнөөдөр өглөөнөөс хойш бүх бие хөшөөд байна|

Дээд ангиллын хүмүүстэй биеэ барилгүй харьцах |Дэд ерөнхийлөгч өнөөдөр түүнтэй хамт дарс шимэхийг хүсч байгаа эсэхийг асуулаа. Тэгэхдээ таны ажлын Жоныг бол уриагүй шүү|

Эрчүүдийн дундаас зөвхөн цөөн тооны эрийг сонгож тэдэнтэй дотно харьцаатай гэдгээ онцолно. |Чихэнд нь шивнэх, зурвас дамжуулах, хоол ундаагаа хуваалцах, хувцас зээлдэх юмуу машиныг нь хэрэглэх|

Өөрийн найз залуу юмуу нөхөртөө, тэр тусмаа баян, эрх мэдэлтэй юмуу алдар нэртэй бол түүний таашаал сонирхол ба өрсөлдөх мэдрэмжийг нь сэргээхийн тулд үл анзаарагдам дохио өгөх юмуу сануулга хэлэх.

Өөрийгөө гайхуулах нүдэнд аятайхан шалтаг олох, дасгалын танхим руу явж байна гээд хувцасаа задгайлан оффисын голоор өнгөрөх, эсвэл торгон нарийн хөхний даруулгаа бүсгүйчүүдэд үзүүлж байна гэх шалтгаар цамцаа тайлах.

Олон нийтийн санаа бодлоор бол эмэгтэйчүүд баян, хүч чадалтай ба алдар нэртэй эрчүүдэд хүрэхийн тулд сексийг ашигладаг бөгөөд цаадуул нь ч энэхүү өдөлтөнд амархан автдаг. Эмэгтэй хүний секс байдал дээр үндэслэсэн зарчмуудад эм хүний биеэ авч явах байдлыг дүрслэн бичихийг хичээдэг. Гэхдээ эдгээр дүрэм зарчмууд эмэгтэй хүнийг цохохын тулд хийгдсэн гэж бодон хууртах хэрэггүй. Ихэнхидээ тэд өөр зорилго агуулдаг. Энэ нь эр хүнийг занганд орохоос хамгаалах, бас эмэгтэй хүний үл халдам байдлаа ашиглан эр хүнийг өөрийн болгох зэрэг юм.

Сексийн төлөө секс

"Жек Пот миний өдрийн хувиарт байхгүй. Жек Пот хэнд хэрэгтэй юм бэ? Би сексийн төлөө л секс хийхийг хүсдэг" гэж та боддог байж болох юм. Эмэгтэй хүний тухайд эрчүүдийг бодвол түр зуурын хавьтагч болох нь амархан. Гэхдээ эмэгтэйчүүд ерөнхийдөө урт хугацааны харилцаанд сонирхолтой байдаг. Гэвч та түрхэн зуур сээтэгнэхийг хүссэн бол доорх зүйлсэд анхаарна уу?

Гадаад төрх

Эмэгтэй хүнд буцалж байгаа эрүүл саруул байдал ба залуу нас эрчүүдийг татдаг учраас гадаад төрхөндөө онцгой анхаар.

Хүн бүрийн таашаал өөр хэдий ч олонхи эрчүүд урт үстэй, том хөхтэй ба өндөр эмэгтэйг таашаадаг.

Таны хувцас заавал моодны байх албагүй боловч хамгийн гол нь танд сайхан зохисон байх ёстой.

Бие барьсан бөгөөд таны биеийн давуу талуудыг харуулсан задгай хувцас өмсөх.

Үйлдэл

Эрчүүд таны сонирхолын тэмдгийг тэвчиж ядан хүлээдэг. Тиймээс өдөн дуудах дохио зангаа хий. Гуурсыг дур булаам сорох, хэлээ долоох, өөрийн гар хөлийг илэх зэрэг. Түүний нүд рүү эгц ширтэж, таны энэ харцыг тогтооход нь тусал. Таны бие галбирын сайн талуудыг тодотгох зогсолтоор зогс.

Нарны шил зүү. Нарны шил зүүсэн үед эмэгтэй хүн өөртөө итгэлтэй болохоос гадна дур булаам болдогийг судалгаа харуулжээ. Түүнээс гадна зориг орж урьд нь хийж чадахгүй байсан зүйлээ хийдэг. Жишээ нь наранд шарлагын газар нүцгэн хэвтэх гэх мэт. Мөн нарны шилийг хамрынхаа үзүүр дээр тохож нүдээ гаргах замаар сээтгэнэхэд ашиглаж болно. Эсвэл танилцахыг хүсч байгаагийн тэмдэг болгон шилээ аажмаар авах юмуу шил рүүгээ үлээх үйлдэл хийнэ.

Өмнөх бүлэгт өгүүлсэн шиг үл анзаарагдам шүргэлтийг ашиглах ёстой. Энэ нь түүнд халуун дулааныг ба ханамж мэдрэхэд нь тусална. Эсвэл илүү илэн далангүй шүргэлтийг ашигла. Эрчүүдийн тухайд шүргэлтэнд эмэгтэйчүүд шиг хатуу чанга ханддаггүй.

Харилцаа

Эрэгтэй хүнийг яриа өдөхөд хялбар байхаар болго. Өвөрмөц гоёл чимэглэл зүүх, эвдэрхий машин унах юмуу шуугиан тариад байгаа ном барьж яв.

Өдөөн дуудсан сэдвээр яриа өдөхөд эрэгтэй ухаангүй дуртай. Хэрэв та онгоцонд нисч яваа бол дээдсийн хүрээний "Мисс" клубт багтах нууц хүсэлтэй гэдгээ санамсаргүй мэт хэл. Хэрэв та үдэшлэг цэнгүүн дээр байгаа бол гартаа оргилуун дарстай хундага бариад энэ ундаа таныг увайгүй алхамд түлхдэг гэж хүлээн ярь.

Дур таталтын соронзон долгиог цацруул. Юунд ч үл санаа зовж байгаа нэг үйлдэл хий.

Эрч хүч эрчүүдийн дурыг үргэлж татдаг. Тиймээс сэтгэл өдөөгдсөн байдалтай ярьж, гарын зангааг их хэрэглэ.

Түүний үг болгонд анхааралтай ханд. Ийнхүү анхаарал төвлөрүүлэх нь эр хүнийг өөрийгөө дур булаам ба секси байна гэж бодоход хүргэдэг. Памела Хэрримен өөрийн хүсч явдаг баян ба эрх мэдэлтэй эрчүүдэд ерийн бус анхаарал тавьдгаараа алдартай болсон.

Эрчүүд эмэгтэйчүүд бүгд эелдэг зөөлөн байдалд адилхан ханддаг.

Дүрэм

Секс танд бэлэглэдэг ердийн таашаалыг өөрчлөхийг хүсвэл зөвшөөрөгдсөн хил хязгаарыг нэвгэрч, хориотой бүс рүү ор.

Бие барьсан цамц юмуу сээтэгнэсэн харц гэх мэт дур булаах аргуудыг та дэндүү сонирхолгүй гэж боддог уу? Тэгвэл түүний хамгийн нууц мөрөөдөл ба тачаангуй хүслийг нь амьдралд нэвтрүүлнэ гэж амлан ухаан алдуулж болно. Та яагаад сэрэл төрсөн ба хичнээн их хүсч

байгаагаа түүний чихэнд шивнээрэй. Нэрт секс судлаач Зигмунд Фрейдийн бичсэн "Хориотой зүйлсийн увидас" аргыгхэрэглээрэй.

Нүцгэн биеэ бусдад харуулж таашаал авагч. Өдөөн дуудсан маягаар хувцаслаж, бас тийм хөдөлгөөн хий. Нүцгэн бие дээрээ хэлхгэр цув нөмөр. Дотуур хувцасгүйгээр ажил хэрэгч костюм өмс. Хөшиггүй цонх дээр секс хийх санал тавь.

Шинэлэг зүйлс. Нэг хэвийн байдал уйтгар гуниг төрүүлдэг. Сексийн үед өвөрмөц байрлал санал болго. Хавьтагчаа харилцан солих үдэшлэг цэнгүүн зохиож болно. Хавьтагчаа солих ба шинэ нөхцөл байдлаас үүсдэг сэрэл нь дур булаах байдлаа хэзээ ч алдаагүй.

Гурван хүн оролцсон бүлэг секс цэнгүүн. Энэ нь эксгибиционизм буюу бусдад нүцгэн биеэ харуулж таашаал авах, вуляризм бусдын нүцгэн явдлыг харж таашаал авах ба шинэлэг гэсэн гурван зүйлээс авах таашаалыг нэгтгэдэг. Нэг дор хэд хэдэн хүнтэй зэрэг явалдахад үүсэх таашаал.

Аз туршилт. Рестораны цэвэрлэгээний өрөөнд юмуу зам дээр, машин, эсвэл хурлын танхимын ширээн дээр секс үйлдэх. Конгрессийн нэгэн гишүүн эхнэрээ конгрессийн хуралд урихад цаадах нь нүцгэн биен дээрээ булган шуба нөмөрч өндөр өсгийтэй гуталнаас өөр хувцасгүй иржээ. Тэд өндөрт байрлах тавцангийн баганууд дунд доор цэлийх хотыг харан секс хийсэн байдаг.

Ярихаас бүү ич. Үйлдсэн сексээ дэлгэрэнгүй дүрслэн ярих юмуу ухаангүй мөрөөдлөө хуваалц. Моника Левинский ерөнхийлөгчтэй утсаар секс ярьдаг байснаа хүлээмэгц энэ төрлийн секс олны анхаарлын төвд орсон. Үнэн хэрэг дээрээ Моника Бейкерийн утасны сексийн тухай "Дуу хоолой" номыг түүнд зориулан худалдан авсан байжээ. |Энэ баримт ил болмогц дээрх номны борлуулалт эрс дээшилсэн|

Садомазохизм. Энэ талын зарим туршлагатай гэж хэлсэнээр харьцагчаа өдөөж болно. |Гэхдээ үүнийг өдөөдөг харгислалтай бүү андуур. Садомазохизмын шинжтэмдэг юу вэ? Эзэн ба боол, ноёлогч ба дагалдагчийн дүрийг зөвшилцөн хуваах|

Дээр дурьдсан аргууд их аюултай. Казанова анхааруулахдаа "Хөнгөн ялалт нь ихэнхидээ тухайн хүний завхай зайданг харуулдаг. Энэ нь эрчүүдэд таалагддаггүй. Эр хүн өөрөө хичнээн завхай байх нь энд огт хамаагүй" гэжээ.

Хэрэв та сексийн төлөө секс хийх сонирхолгүй ба өөр ямар нэг зорилготой байлаа ч, эр хүнд бол таны хүсч байгаа ганцхан зүйл нь секс гэж ойлгуулахыг хичээ.

Секс ба сэтгэлийн ойртолт

Танд хэзээ нэгэн цагт яг хайртай эсэхэд нь бүрэн итгэж чадаагүй хүндээ таашаал өгөх зорилгоор, эсвэл ер нь харьцаа эхлээд дөнгөж эхний шатандаа явж байхад л бэлгийн харьцаанд орох хүсэл төрж байсан уу? Хэрэв тийм бол энэ нь махбодийн ойртолтын тусламжтайгаар сэтгэл санааны хувьд ойртох оролдлого юм. Та хоёр биеийн харьцаандаа найдвартай ба аюулгүй байдлыг хүсч байна. Түүнийгээ хувцас худалдан авах, ээж аавтайгаа

хооллох, төрсөн өдрөөр гэнэтийн бэлэг хийх, кино юмуу оройн хоолонд урих, эсвэл чихэнд сонсголонтой амлалт зэргээр чимэхийг хүсдэг. Тиймээс сексийг хэрэглэж байна.

Энэ бол том бөгөөд бүрэн дүүрэн алдаа. Ийм төлөвлөлт сүйрэх жамтай. Ашиггүйгээр зогсохгүй эсрэг үр дагавар авчирна. Өөрийгөө харьцагчийнхаа бүрэн эрхэнд өгч, өөрийн байр суурийг тавьж өгснөөр түүнтэй илүү ойр дотно болно гэж бодох хэрэггүй. Хэрэв та илүү туршлага хуримтлуулахын тулд ингэдэг юм бол тохиолдлын хүн бүртэй хөнжилд орвол яасан юм бэ? Гэхдээ тэр өглөө босонгуутаа дурласан эр шиг загнана гэж хүлээсний гарз.

Сэтгэл санааны ойртолтгүй харьцаанд секс нь хүчний хувиарлалтыг эмгэнэлтэй өөрчлөлтөнд оруулна. Секс хийх хүртэл хүч эмэгтэй хүний талд байдаг бол сексээс хойш эрэгтэй хүний талд шилждэг. Сэтгэлийн ойртолт сул байхын хэрээр эрх мэдлийн шилжилт огцом явагддаг. Гэтэл хүчтэй мэдрэмж байгаа цагт эрх мэдэл тэнцвэртэй байдалд байдаг. Та сэтгэлийн ойртолтгүй сексийг зөвшөөрснөөр эрх мэдлийнхээ тодорхой хэсгийг эргэлт буцалтгүй алдана. Таны тооцоолсоноос эсрэг эргэж, та сексийн оронд ямар нэгэн сэтгэл түүнээс огт авахгүй.

Учир нь сексийг сэтгэлийн ойртолт болгон ашиглах гэсэн эмэгтэйчүүдийн тоо томшгүй оролдлогыг харгалзахгүйгээр энэ үйлдэл нь ямар ч хүчгүй байдаг. Эсвэл түүний үйлчлэл зөвхөн нэг талд үйлчилдэг гэвэл илүү зохино. Сексээс хойш та илүү эмзэг болж, хайр дурлал, зөөлөн сэтгэлийг хүлээнэ. Гэтэл оронд нь түүний битүүлэг зэмлэлийн дарамтыг мэдэрдэг. Та өөрийгөө аз туршилтанд оруулж байна гэсэн үг. Нэг ч бэлгивч таныг жирэмслэх юмуу бэлгийн өвчнөөс бүрэн хамгаалж чадахгүй. Сэтгэл санааны тал дээр ч та өөрийгөө аюултай байдалд оруулсан. [Хэрэв тэр одоо таныг түлхэх юм бол энэ нь секс хийхээс өмнө түлхсэнээс хавьгүй хүнд тусна]. Түүнээс гадна танай хавьтагчийн сексийн талаарх мэдрэмж таныхаас бүр эсрэг байж болно. Таны хувьд одоо түүнээс хайр дурлалын үгс сонсох нь чухал байтал харин түүний хувьд санасандаа хүрсэн бөгөөд ялалтандаа сэтгэл ханажээ. Энэ үед та өөрийн хүлээлтийг ярьж, бодол сэтгэлээ дэлгэвэл тэр тун эвгүй байдалд орж болно. Та сексийг ойртоход хэрэглэдэг үү? Та сонголт хийх үедээ доор дурьдсан бодол санаануудын аль нэгэн дээр тулгуурлаж байсан уу?

"Би дур тачаалын давалгаанд автсан. Эцсийн эцэст эмэгтэй хүний дотор ч хүчтэй хүсэл шуургалдаг". [Энэ нь жинхэнэ махбодийн хүсэл байсан уу эсвэл таныг сексэд түлхэж байгаа романтик найдвар байсан уу?]

"Тэр үнэхээр секс хийхийг хүссэн. Миний хувьд сэтгэл догдолсон зүйлгүй. Гэвч би үүнээс том асуудал үүсгэхийг хүсээгүй". [Харин та долоо хоногийн дараа энэ талаар ямар бодолтой байх бол?]

"Тэр эрэгтэй надад маш их таалагдсан. Тиймээс би энэ үдэш төгс төгөлдөр үдэш болохыг мэдрүүлэхийг хүссэн юм". [Энэ үдэш төгс төгөлдөр биш байлаа гэхэд юу өөрчлөгдөх байсан бэ?]

"Тэр бидний болзоонд ийм их зардал гаргасны дараа түүнийг хаалтны цаана гаргаж хаях нь онцгүй санагдсан". [Түүний хичнээнийг зарсан нь яагаад таны санааг зовоох ёстой гэж].

"Эмэгтэй хүний тэвчээр тэсвэр ба цэцэн ухааны тухай итгэл үнэмшилд би автдаггүй. Би яг эрэгтэй хүн шиг зэрлэг огцом байж болно". [Та үнэхээр тэгэж харагдахыг хүсч байгаа шигээ юунд ч санаа зовдоггүй хүн үү?]

Секс шинж тэмдгүүд Хөх

Та олонхи эмэгтэйчүүдийн нэгэн адил эрэгтэй хүн эмэгтэй хүний хөхөнд ямар анхаарал хандуулж байгааг ухамсарласан. Та ч бас сэтгэгдэл төрүүлмээр байгаа.

Хэрэв та еерийн хөхний хэлбэрт еерчлелт оруулах нь чухал гэж бодож байгаа бол хөхний хэлбэрийн моод нь бусад бүх зүйлийн нэгэн адил еерчлөгдөж мэднэ гэдгийг битгий мартаарай. Силикон хөндийгөөс явуулдаг "том байх тусам сайн" гэсэн зар сурталчилгаанд бүү автаарай. Том бөмбөгөр хөх ба нарийн бэлхүүс нь 1900 он гэхэд даган дууриах үлгэр жишээ болж байв. 1920 онд байдал эсрэгээр эргэж хавтгай цээж хамгийн секси болж эхэлсэн. 1940 он гэхэд урагшаа шовгор хөх моодонд орлоо. 1960 онд дахиад л жижигхэн хөх моод болжээ. 1970-аад оны үед хөхний хэмжээ хэлбэр нь чухал биш болж, хамгийн гол нь хөхний даруулга зүүхгүй байх ба байгаагаар нь байлгах явдал болжээ. Эр хүн бүр өөрийн дуртай хэмжээний хөхийг сонгож байна. 1990-өөд онд өмнөд муж улсуудад том хөх моод болж байсан бол харин умард мужуудад байгалиас заяасан байдлаараа байх нь моод байв. Шинэ мянганд хөхний моод хичнээн өөрчлөгдөх нь дамжиггүй.

xxx

Сексийг ашиглах гэдэг нь жинхэнээс секс хийх гэсэн утга санааг агуулах албагүй. Заримдаа хорхой хөдөлгөм битүү дохио өгөхөд л хангалттай. Эсвэл та сексийг романтик харьцаа, сээтэгнэл ба болзоо зэрэгтэй хослуулан хэрэглэж болно. Зөвхөн байнгын бэлгийн харьцаанд орох буюугэр бүлийн амьдралл сексийн бүх сайн талыг ил гаргахад тусалдаг. Энэ нь эр эм хоёрын холбооны бусад ямар ч хэлбэрт боломжгүй байдаг. Гэр бүл нь харьцагчийнхаа нийгмийн байдал дээр тулгуурлан гэр бүлтэй болох, өөрийн үр удмыг үндэслэх боломж өгнө.

Хорин нэгдүгээр бүлэг

Гэр бүл ба бэлгийн тогтмол харьцаа

Мөнгө, эрх мэдэл ба алдар нэрд хорвоо бүрэн захирагддаг юм биш. Алдар нэр ба эд хөрөнгө нь хувийн ололт амжилт. Харин нийгэмд олох амжилт нь нийгмийн ба гэр бүлийн байдлаас хамаардаг. Гэр бүлийн харьцааг [бэлгийн байнгын харьцаа] өөрийн болоод хүүхдүүдийнхээ нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэхийн тулд ашиглаарай.

Гэр бүлийн амьдралтай болсноор та гэр бүлийн институтын нэг хэсэг болно. Эртнээс уламжилж ирсэн уламжлал байдаг нь баян хүн ба сурвалжит гаралтай хүмүүсийн хоорондох хурим юм. Нэгэн төрлийн солилцоо. Баян хүн нь үүгээр цэнхэр цусны хүмүүст үзүүлдэг хүндлэлийг авч байна. [Энэ нь хорвоо дээр зүгээр худалдаад авчихаж болдоггүй цөөхөн зүйлсийн нэг]. Харин сурвалжит гаралтай хүн нь түүний одоогийн байдалд хэрэгтэй мөнгийг олж авна.

Гэр бүлийн шинэ бэлэг тэмдэг бүтээх юмуу шинэ сүлд хийх зэрэг нь тэнэг явдал. Түүний оронд энэ бүх шинж тэмдгүүдийг эзэмшдэг гэр бүлийн гишүүн болж орсон нь дээр бөгөөд улмаар бүгд таны гарт ирнэ. Гэр бүлийн амьдрал иймэрхүү "Зөв" гэр бүлүүдтэй нэгдэж, нийгэмд хүлээгдсэн байр суурь эзлэх боломж өгдөг. Эцсийн эцэст та сайхан гэр оронтой [гэр бүлд харьяалагдана], ажил дээрх хүмүүстэйгээ найрсаг харьцаатай, клубт гишүүнчлэлтэй болно. Та нийгмийн өндөр хүрээнд багтан орох ба таныг тэнд хүлээн авах, бүр багаар бодоход тийшээ нэвтрүүлнэ.

Хэрэв та ашигтайгаар хуримлахыг хүсч байвал товойх тодрох юмгүй өнгөрсөн үеийнхээ тухай бүү бод. Гэр бүлийн амьдрал зохиох нь бүрэн боломжтой. Зохиосноос хойш өнгөрсөн дурсамж аажмаар тэнийнэ. Порно кинонд тоглож сэтгүүлийн "Секс" буланд түүний тухай мэдээ байнга гарч байсан нь Патрициа Клюг бүсгүйг тэрбумтан Жон Клюгийн эхнэр болоход нь саад болоогүй.

Нийгмийн зиндаагаа батжуулахад гэр бүлийн амьдрал амин чухал. Энэ нь нийгмийн байр суурины тогтворжилт болоод мөнгөний хангамжийн баталгаа болж өгдөг. Салж сарнилаа ч гэсэн та хоёр дундын хөрөнгийн эрхтэй.

Даргынхаа хүү юмуу охинтой суух нь бизнест хөл тавих маш сайн арга байдаг. Филип Грэхемийг хар ["Вашингтон пост"-ын эзэн Мейерын охинтой суусан] эсвэл Артур Салцбергийг хар ["Нью Йорк таймс"-ийн эзний охинтой суув].

Өнөөдөр эмэгтэй хүмүүс ажил дээрээ өндөр албан тушаалд хүрдэг болжээ. Тиймээс гэр бүлийн доторхи эрх мэдэл ч тэнцүү болж ирсэн. Гэр бүлийн амьдрал эхнэр нөхөр хоёрын аль алиных нь ахин дэвшихэд түшиг тулгуур болдог. Гарольд Эванс ба Тина Браун, Боб ба Элизабет Доул, Дейвид Келли ба Мишель Пфайффер, Жон Грегори Дюн ба Жоан Дидион, Жеймс Рубин ба Кристина Эманпур, Майк Николс ба Пиана Сэйер, Ричард Филипс ба Дана Хойе, Бэн Брэдли ба Сэлли Квин, Кеп Аулетта ба Аманда Урбан зэрэг хосуудыг санаарай. Нийлбэр нь хоёр нэмэгдэхүүний дүнгээс үргэлж илүү. [Хүчирхэг хосуудад маш олон давуу тал

байдаг ч дутагдалтай талууд бас бий. Учир нь хос хоёр нэг салбарт ажилладгийн улмаас үе үе сонирхолын зөрчил үүсч өрсөлдөөн бий болдог. Тэдний хэн хэн нь компанийн нууцыг эзэмших, удирдах албан тушаалд очих гэх мэтийг хүснэ|.

Гэр бүлийн хэлхээ холбоо нь алдар нэрийг холбох ба нэмэгдүүлэх хамгийн үр дүнтэй арга юм. Шерон Стоун "Төрөлх зөн совин" кинонд тоглосныхоо дараа од болж нэрд гарсан бөгөөд гэтэл "Сан-Франциско эксперт" сонины редактор Фил Бронштейнтай гэрлэснийхээ дараа бүр ч хүндлэлтэй болжээ. Мэрилин Монро ба бейсболын домог Жо Ди Мажо, дараа нь Монро ба кино зохиолч Артур Миллер, жүжигчин Жейн Фонда ба улс төрч Том Хейден, дараа нь Фонда ба санхүүгийн магнат Тед Тернер нарын хувьд эхнэр нөхөр хоёрын алдар нэр гагнагдаж нэгэн цул болж байв. Улс төрийн зөвлөгч Жеймс Карвил |ардчилсан нам| ба Мэри Маталин |Бүгд Найрамдах нам| нар хамтдаа байхдаа нэг нэгээрээ байснаас хавьгүй хүчтэй болжээ.

xxx

Олон нийтийн өмнө хамгийн ил тод байдаг гэр бүлийн холбоо бол ерөнхийлөгч ба тэргүүн хатагтай юм. Энэ хос улс төрийн зорилготой цэвэр ажил хэргийн зөвшилцөл үү эсвэл хайр дурлал ба романтикийг агуулсан холбоо юу гэдэг тал дээр үргэлж хүчтэй сониучлал явж байдаг. Энэ гэр бүлүүдээс аль нь үргэлжхамт амьдарч байсан бэ?Хэрэгтэй газарт хэрээс тавихзамаар мэдлэгээ шалгаарай.

Ерөнхийлөгч ба Тэргүүн хатагтай

А.Билл ба Хиллари Клинтон

Б.Жорж ба Барбара Буш

В.Рональд ба Нэнси Рейган

Г.Жимми ба Розалин Картер

Д.Жеральд ба Бетти Форд

Е.Ричард ба Пет Никсон

Ж.Линдон ба Бед Жонсон

З.Жек ба Жеки Кеннеди

И.Дуайт ба Мэми Эйзенхауэр

Зөв хариулт: Билл ба Хиллари Клинтон нар чадаагүй, Жорж ба Барбара Буш нар нар чадсан, Рональд ба Нэнси Рейган нар чадсан, Жимми ба Розалин картер нар чадсан, Жеральд ба Бетти Форд нар чадсан, Ричард ба Пет Никсон нар чадаагүй, Линдон ба Бед Жонсон нар чадаагүй, Жек ба Жеки Кеннеди нар чадаагүй, Дуайт ба Мэми Эйзенхауэр нар чадсан.

Угсаа

Эрх мэдэл, алдар нэр ба материаллаг хангамжийн тал дээр тодорхой түвшинд хүрсэн хүн өөрийн болон үр удмынхаа аюулгүй байдлыг хангах, товойж тодорсон байр сууриа өөрөөсөө хойш ч баталгаажуулахын тулд үндэс угсаа үүсгэх шаардлага заавал тулгардаг. Үүний тулд гэр бүлийн харьцаанд заавал орох шаардлагатай. Өөр юу хэрэгтэй юм бэ? Америкийн хамгийн алдартай угсаа гарлууд тухайлбал Рокфеллер, Кеннеди, Форд ба Буш нарыг авч үзэхэд ерөнхий нэг жам байгаа нь ажиглагддаг.

Их хөрөнгө.

Хөрөнгөө угаах. Хэрэв шаардлагатай бол олон нийтийн байгууллага ба буян хандивыг ашиглах.

Нүдэнд ил ба хүндтэй байр суурь. [Нэг салбар юмуу компанийн хүрээнд] Энэ байр суурь угсаа дамжин үеэс үед уламжлагдана.

Нэрийн давталт. Энэ нь хүмүүсийн ой тойнд гүн орохын тулд эцэг өвгөдийн нэрийг хүүхэддээ давган өгөх ба "том", "бага", "хоёр", "гурав", "дөрөвдүгээр" гэх мэт тодотгол хэрэглэдэг.

Өөрийгөө гаргуунд гаргахад бэлэн үнэнч зүтгэлтэй, авьяаслаг хүмүүсийг хөлслөх замаар эрх мэдлээ улам өсгөх, чин сэтгэлээсээ их ажиллах хүсэлтэй байдаг.

Хүмүүсийн сонирхолыг байнга татахын тулд үе үе санхүүгийн болоод бэлгийн дуулиан шуугианд орооцолдох.

Хүмүүст үргэлж дуурсахын тулд нэртэй байгууллагад өөрийн нэрийг хадах.

Угсаа гарлыг үүсгэхэд ердөө гурван үе хангалттай гэдгийг анхаар. Олонхи угсаа дөрөв дэх үеэсээ задран сүйрдэг.

Харин та өөрөө бол бусдаас ондоо мэт царайлж, хэд хэдэн үе дамжина хэмээн хүлээж, итгэлтэй байгаа мэт дүр эсгэх ёстой. Мөнгө ба алдар нэрийн бэлэглэдэг, харьцуулах аргагүй, сэтгэл зовох ч аргагүй их эд хөрөнгө ба өмчийн мэдрэмжийг та биш таны үр удам л эдэлж таашаана шүү дээ. [Нэгэн цагт таны эд хөрөнгө урсаж дуусах бөгөөд тэр үед таны үр удам тансагласан цагийнхаа дурсамжтай зууралдан удтал амьдарна].

Угсааны дүр төрх маш хүчирхэг учраас гэр бүлийн уламжлалд ямар нэг хүндлэл үзүүлэх тун дургүй олон нийтийн байгууллагууд хүртэл бууж өгдөг. "Сигрэм" ба Бромфмен, "Ньюс" корпораци ба Мердокийн угсаа, Форд ба Фордын удам гэх мэт. Гэвч компанийн ерөнхийлөгч бүр өөрийнхөө хүүг өв залгамжлагчаар томилох боломжгүй. Энэ тал дээр амжилт олохын тулд өөрийн талынхныг захирлуудын

зөвлөлд багтаах ёстой. Угсаа залгамжлах хүнээ маш болгоомжтой сонгоорой. Энэ нь хамгийн сайн нэрд дэвшигч биш байж болно. Гэхдээ заавал итгэл хүлээсэн хүн байх ёстой.

Санаанд оромгүйн зарчим

Бүрэн ялалтаа тэмдэглэхийн тулд санаанд оромгүйн зарчим хэрэглээрэй. Эрчүүд: хэрэв таны эргэн тойрны эрчүүд эхнэрүүдээ "шинэ модель"-оор сольж байвал та харин 25 настай эхнэртээ үнэнч үлдээрэй. Эмэгтэйчүүд: нийгмийн өндөр байр суурь эзэлж байгаа эрчүүдээс жирэмсэн болох хүсэлд бүү авт. Харин ч бусдын ийм тэмүүллийг шоолж инээ. Жоди Фостер юмуу Мадонна гэх мэтийн одод алдар нэртнүүдийн эхнэр болох тэднээс хүүхэд төрүүлэх гэж тэмүүлээгүй. Фостерын хамтрагчийг хэн ч мэдэхгүй. Харин Мадонна эхний хүүхдээ хэн ч үл таних хүнээс |хувийн дасгалжуулагч Карлос Леона гаргасан юм.

Дүрэм

Даруу ба энгийн байдал нь бүрэн ялалтаа илэрхийлэх шилдэг арга байж болно.

xxx

Сексийг эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийн зорилгоор ашиглах явдал нь нэг л зүйлээр арай хөнгөрдөг. Энэ нь дээрх бүх зүйлс эзэндээ эротик төрх олгодог явдал билээ. Эрх мэдэл, мөнгө ба алдар нэр нь эр эмийн хоорондын харьцааг онцгой хурц болгож өгдөг. Нөлөөг нь таашгүй учир түүнд сөрж зогсох боломжгүй.

Хорин хоёрдугаар бүлэг

Эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийн эротик төрх

Эрх мэдэл, мөнгө ба алдар нэр онцгой гялбаатай. Тэр нь шүтэн бишрэгчдийг татаж байдаг. Мэдээж хувь заяаны эдгээр шагналыг бие даан олж авах чадваргүйн улмаас ядаж сексийн хавьтагчаараа дамжуулан түүнд хүрэх хүслээс заримдаа энэ бүхэн болдог. Тэвчих аргагүй дур булаана. Энэ нь шуналын илрэл юм. Мөнгө эрх мэдэл ба алдар нэр нь үнэхээр эротик гял цал өнгө аястай бөгөөд түүнээс болж таны бүх бие салгалдаг.

Баян, эрх мэдэлтэй, алдар нэртэй хүмүүс үргэлж анхаарлын төвд байдаг. Энэ нь тэднийг сэтгэл алдам дур булаам болгодог. Хичнээн олон хүн тэднийг харж, тэдний тухай ярилцаж, тэдний санаа бодлыг тооцдог. Ийм их анхаарал нь тэдний дур тачаал төрүүлэм төрхийг улам нэмэгдүүлнэ. Түүний дэргэд байснаараа та ч бас анхаарлын төвд орж байгаа гэж бодоход хүртэл таатай. Тэдэнд ямар ч тус хүргэлээ гэхэд таашаал авах бөгөөд энэ нь хүчтэй мэдрэмжүүдийг төрүүлж байдаг.

Эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийг эзэмших тал дээрх тэгш бус байдал нь мөн эротик үр дүн дагуулна. Багш ба оюутан, дарга ба доод албан тушаалтан, эмч ба сувилагч гээд. Хэрэв тэд ердийн гэр бүлийн цэнгүүн дээр таарах юмуу бааранд танилцсан бол тэдний хэд нь хоорондоо амраглах байсан бол. Маш цөөн. Тэгш бус байдал нь хүнийг өдөөж салгалуулдаг бөгөөд энэ нь их дур тачаалыг төрүүлж байдаг.

Эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийн тухай мөрөөдөл, эрэгтэй эмэгтэй аль ч хүний толгойд үргэлж хадаастай. Үнэндээ бүх мөрөөдлийн цаана дагуулах, хамгаалах, эзэмдэх ба ялах хүсэл нуугдаж байдаг. Харин эмэгтэй хүний мөрөөдөл нь сэргээх, сэнхрүүлэх, сэтгэл догдлуулах, гарзанд гаргах ба хөтлөгдөх хүсэл дээр тулгуурладаг.

Дүрэм

Мөнгө, эрх мэдэл ба алдар нэр нь ердийн өдөөгчид.

Эрх мэдэл нь эротик өнгө аястай. Ялсан ялагдсан аль нь ч бай салгалан чичирдэг. Эр хүн шавхагдашгүй хүчтэй байх, түүнийхээ ачаар товойх, удирдах ба хамгаалах замаар цагаан морьтой ханхүү болж үзэсгэлэнт гүнжээ аврахыг мөрөөднө.

Таны хүсч байгаа эмэгтэйг анхаарал ба ээлээрээ дагуулахыг хүссэн шүтэн бишрэгчид хүрээлэх боловч тэр зөвхөн таныг хайрлана. Тэгээд та ялан дийлсэн байдалтай түүнийг авч одохыг бусад эрчүүд нүд үл салган ширтэнэ. Ленлли Мур өөрийн "Дурлалын техник" номонд бичихдээ "Эрчүүд өөр хэнд ч байхгүй зүйлийг өөрийн болгох гэж хүсдэг юм биш. Харин ч бусад эрчүүдийн хүсээд байгаа зүйлийг авахыг хичээдэг. Ялангуяа энэ нь эмэгтэйчүүдийн тал дээр хүчтэй. Тийм ч учраас таныг өөртөө дагуулах хүсэл нь улам их" гэжээ.

Эмэгтэй хүний тухайд олон эрчүүд эзэмдэн авахыг хүссэн ангын олз гэдгээ мэдрэх үедээ эрх мэдлийн оргилд хүрдэг. Эрчүүд таны гарыг хүсч, та тэдэнд атаархлын үрийг тарина. Тулж

түших хүчтэй эр хүний мэдрэмж ба түүнээс хамааралтай байх гэдэг нь их дур булаам санаа. "Эрх мэдэл гэдэг бол сэтгэл догдлуулж өдөөдөг зүйл. Яагаад гэвэл эрх мэдэл хамгаалж, гадаад ертөнцөөс хаацайлж байдаг. Эрх мэдэл их секс. Учир нь эрх мэдэлтэй хүн өөртөө итгэх асар их итгэлтэй байхад түүнд ойртох гэж оролдох хүмүүс боол шиг чичирч байдаг" гэж зохиолч Барбара Амиль бичжээ. Бусад хүмүүсийн дээр зогсох асар их эрх мэдэлтэй хүнийг удирдана гэдэг ямар их таашаал авчирдаг вэ?

Сэлли Квинн "Вашингтоны ажил үйлс"-дээ сексийн тухай дүгнэн бичиж: "Өөрөө асар их эрх мэдэлтэй эр хүнд нөлөөлж чадах нь амраг бүсгүйд маш их таашаал авчирдаг. Нийгмийн байр суурь ба мөнгөндөө хангалуун эр хүн шууд хоёр эмэгтэйд хэрэгтэй болсноор өөрийгөө дөвийлгөх сэтгэлээ хангадаг. Энэ нь бүх эрчүүдийн сэтгэл зүйг илэрхийлж байна" гэжээ.

Ийм жишээ зөвхөн Вашингтоны ажил хэргээр хязгаарлагдахгүй. Нэр алдарт дуртай хоёр удирдагчдыг авч үзье. Эрэгтэй нь нас ахимаг бөгөөд компанидаа тэргүүлэх байр суурьтай. Эмэгтэй нь тийм ч өндөр албан тушаалтай биш. Тэдний хооронд ямар нэг холбоо байгаа эсэхийг хэн ч итгэлтэй хэлж чадахгүй. Гэвч иймэрхүү яриа гарлаа гэхэд тэдэнд ашигтай. Эрэгтэй нь бүсгүйчүүдийн зүрхийг байлдан дагуулах чадвартай, идэвхитэй хүн болж харагдана. Харин эмэгтэй нь удирдлагад хүрэх чадвартай, нөлөөтэй гэж харагдана. Харин тэдний холбоо ололт амжилтынх нь илэрхийлэл болно.

Та мөнгө төлөх юмуу танд хүмүүс төлбөр хийх үед мөнгө их таашаал авчирдаг. Эр хүн ангын олзоо эмэгтэй хүний хөлд хаях үедээ бүрэн ханамж авдаг. Тэд бүсгүйн хүзүүнд бриллиант зүүгээд дараа нь түүнийгээ дагуулан олны өмнө гарах дуртай. Хатагтай Дейзи бол агуу Гэтсбигийн эд баялгийн өдөөгч нь болж өгсөн. Энэ их эд баялаг зөвхөн түүнийг баярлуулах ба нэрд гарахын төлөө байсан.

Нөгөө талаар эд баялгаа гайхуулах үедээ та олон нийтийн мэдэлд өөрийгөө өгдөг. Холливудын од Хью Грант 20 долларын янхантай орооцолдон олон нийтийг гайхшралд оруулсан. Гял цал дээдсийн хүрээний Лиз Херли бүсгүй түүний мэдэлд байхад, тэр тусмаа үнэгүй байхад яагаад тэр гудамжны хямд янханд төлбөр хийсэн юм бэ гэж бүгд гайхсан. Гэвч гол нь энд л байгаа юм. Ямар нэг юманд төлбөр хийх үед сэтгэл догдолж, бас их сайхан болдог. Дани Шапиро өөрийн дурсамжид баян амраг Леннигийн тухай бичихдээ: "Түүний үнэхээр хүсдэг ганц зүйл нь хаашаа ч юм гарч тансаг гоёлоо гайхуулах явдал байсан. Энэ нь миний гэр юмуу эсвэл зочид буудлын 300 долларын өрөө байх нь сонин биш. Магадгүй тэр зочид буудлыг илүү үздэг байсан. Яагаад гэвэл тэнд мөнгөний төлөө секс явагддаг" гэжээ.

Таны өмнөөс төлбөр хийхэд багагүй таашаал авна. Худалдан авалтад согтуурсан хүн цаад эрийгээ улам их мөнгө үрэхэд өдөөж эхэлдэг. Та үнэтэй таашаал учир өртөг өндөр байх ёстой. Та зөвхөн таны төлөө бүтээгдсэн эд баялгийг өөртөө татна.

Хэрэв та олонхи эмэгтэйн нэгэн бол мөнгө, эрх мэдэл ба алдар нэрэнд үнэн сэтгэлээс татагддаг. Таны энэ мэдрэмж хуурамч биш ч ганцхан танд байдаг зүйл бас биш. Энэ нь олон олон хүний шинж төрх. ["Хэрэв түүнд эрх мэдэл мөнгө ба алдар байгаагүй бол тэр миний чин сэтгэлээсээ хайрладаг тэр эр биш байх байсан. Энэ бүхэн ганцхан түүнд байдаг зүйлс"]. Жессика Склар хурим хийгээд ердөө хоёр сарын дараа Жерри Зайнфильдтай учирсан ба тун удалгүй янагийн харьцаанд орж, гэр бүлээ цуцалсан юм. Бүсгүй түүнийг чин сэтгэлээс

хайрласан байх. Гэвч Зайнфильд хамгийн алдартай хошин шогийн жүжигчин байгаагүй бол тэр бүсгүй тийм хурдан бууж өгөх үү? Эргэлзээтэй.

Секс үлгэрүүд

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн аль алины хувьд секс үлгэрүүд нь тэдний нууц, хэнд ч үл ярьдаг, дарагдсан хүсэл ба амьдралд хэрэгжүүлэх, ялах ба аврах мөрөөдлийн илэрхийлэл болдог. Та эдгээр түүхэд тоглосноор бүрэн таашаал авна. Та өөрийгөө ялан дийлсэн ханхүү юмуу аврагдсан гүнжийн дүрд хардаг. Та хоёр учралаа эдгээр даллан дуудах увидастай үлгэр домгийн бүрхүүлээр хучаарай. Эрэгтэй нь мангас дүрд хувирсан Жонон, эмэгтэй нь Гоо гүнж гэж төсөөл.

Гэвч үлгэрээ буруу сонгох юм бол ноцтой урам хугаралт дагуулахыг сана. Таны сонгосон эр хүн таныг нүдэнд өртөхгүй өндөрт гаргаж чадна гэдэгт та үнэхээр итгэж байна уу? Бааранд таарсан хүүхэнд туслах үед туулж гарсан тэр их хүндрэл бэрхшээлүүдийн дараа бүсгүй таныг хайр сэтгэлээр шагнах уу? Тийм ч байж болно, үгүй ч байж болно.

xxx

Та "Секстэй холбоотой энэ бүх зүйл надад ямар ч сонирхолгүй, би эрх мэдэл, алдар нэр ба менгийг сонирхдоггүй шигээ сексийг ч бас сонирхдоггүй гэж бодож болно. Сайн байна. Хэрэв секс таныг олзолдоггүй юмаа гэхэд бусдыг олзолж байдаг. Та үүнийг өөрийн зорилгод хүрэхэд ашиглаж бас болно.

Хорин гуравдугаар бүлэг

Секс мөлжлөг

Та өөрийнхөө нэг ч хувцасыг тайлалгүй, нэг алхам ч ухралгүйгээр сексийн зах хязгааргүй дур татам хүчийг мэдэрч болно. Тодорхой хүмүүстэй бэлгийн харьцаанд орохын оронд сексийн тухай бодол санаан дээр тулгуурлан ашиг олохыг хичээ.

Энэ тал ын хамгийн бүдүүлэгхэлбэр нь садар самуун бизнес бөгөөд худалдах ба зарах хэлбэрт шилжжээ. Томчуудад зориулсан энэ зугаа цэнгэл маш түргэн хурдацтай үйлдвэрлэл бөгөөд жилд 10 тэрбум долларын ашиг авчирдаг. Өнөөдөр энэ бизнест татагдан орох шилдэг арга нь юу вэ? Интернетэд сайт нээх, өөрийн дэлгүүрийг нээх. Та өөрийн үйлчлүүлэгчид ямар ч хязгаарлалтгүй хүртэмж ба бүрэн нууц байдлыг санал болгох бөгөөд энэ нь тэднийг маш түргэн татна. Интернетэд орж байгаа зургаан хүн бүрийн нэг нь томчуудад зориулсан зугаа цэнгэлийн сайтад ордог байна. Тэгэхээр танд тэднийг сонирхсон материалаар хангах боломж бий. Хүмүүс таатай мэдээллийн төлөө төлбөр хийдэг. Тэд торон дотуур өмд ба өндөр өсгийтэй гуталнаас өөр хувцасгүй эмэгтэйчүүдийг үзэх дуртай. Зарим сонирхогчид компьютерийн сексийг бодит сексээс ч илүү үздэг. Учир нь энд бүрэн хяналт тавих боломжтой. Таны саналыг хойшлуулах юмуу татгалзана гэж байхгүй. Ямар ч царай төрх ба биеийн галбир таны сонголтоор бий. Таны ямар ч галзуу юмуу гажиг хүсэл биелэгдэх болно.

Өвчтэй сонирхол ньэротикүзүүлбэрээрхангагдажбайдагхамгийн тачаангуй хүслийг ч интернет гайхамшигтай хөнгөн хангаж өгдөг. Вашингтоны 20 настай бүсгүй Женнифер Рингли өөрийн хувийн сайтаараа амьдралынхаа алхам бүрийг дамжуулдаг байна. Идэж уух, унтаж хэвтэх, хувцаслах, секс хийх гээд бүгдийг нь. Интернетэд орсон сая сая хүн үүнийг үзэх боломжтой. Удалгүй энэ сайтыг дууриан маш олон сайт бий болсон. Хэрэв та нүцгэн биеэ бусдад харуулан таашаал авдаг бөгөөд камер байрлуулахад хүрэлцэх мөнгөтэй бол та ч бас өөрийн сайтыг үүсгэж болно.

Гэхдээ та садар самууны нийлүүлэлтээр биш сексийг өөрөөр ашиглаж болох уу? Мэдээж. Венецийн худалдаачид савангаас эхлээд машин хүртэл бүх барааг худалдахдаа сексийг ашигладаг байсан.

Таны бараа садар самуунаас хол байсан ч та тийм хандлагыг хэрэглэж болно. Эмэгтэй хүний дотуур хувцасны "Викториягийн нууц" компани интернетэд хаврын моодны үзүүлбэр зохиосноор түмэнд нэртэй болжээ. Интернетийн бараг

сая гаруй хэрэглэгчид зөвхөн торгон дотуур хувцаснаас өөр өмсгөлгүй загвар өмсөгчдийг харахаар энэ сайт руу хошуурсан. Өөр нэгэн авхаалжтай вэб сайтыг эзэн түүний амжилтыг давгахын тулд өөрийн сайтдаа "Викториягийн нууц" моодны үзүүлбэр миний сайтад байхгүй гэсэн нэр өгч байжээ. Тэр өөрийн сайтад бичихдээ "Би сайтдаа анхаарал татах зовиурт хөдөлмөрийнхөө үр дүнд миний сайт Викториягийн нууцын моодны үзүүлбэртэй андуурагдахаар байх ёстой гэж шийдсэн. 1999 оны 2 дугаар сарын 3-нд тэр сайт руу хоёр сая хүн орж үзсэн байдаг" гэжээ.

Сексийг өөрийн барааг борлуулахад ашиглаарай. Битүү утгатай үг түүнд тохирох зураг зэргийг рекламдаа оруулна. "Багамын арал дээр ингэвэл илүү дээр", "Кэлвинс бид хоёрын хооронд юу ч болоогүй", "Үүнийг тайл, бүгдийг нь тайл" гэх мэт. Шампуний рекламанд эмэгтэй хүний уухилах дуу оруулж болно. Эсвэл үнэртэй усны рекламанд дур ханамжийн үеийн агшинг оруулдаг. Хувцас, машин, хүнс, диск гээд бүхнийг иймэрхүү байдлаар сурталчилж болно.

Сэтгүүлүүд сексийг ашигладаг талаар их ярьж болно. Зөвхөн "Плэйбой", "Пэнтхауз", "МахГ эсвэл "Ое^аНз" ийм хандлага барьдаг юм биш. Хамгийн улиг болсон уйтгартай сонинууд хүртэл нүүрэн дээрээ секстэй холбоотой элдэв гарчиг тавьдаг. "Миний үзсэн бүхнээс хамгийн шилдэг секс", "Сексээс сайхан бүхнийг ав, яг одоо эхэл", "Ганцаардалдаа цэг тавь, секс хий" гэх мэт. "Ездшге" сэтгүүл "Хөх бол орчин цагийн соёлын ялалт" гэсэн гарчигтай нийтлэл гаргаж нүүрэндээ холливудын од Памела Андерсоны зургийг байрлуулжээ. Хөхөө шахан барьж зургаа авхуулсан одын зурагтай энэ дугаарт садар самуун нь өнөөдөр худалдааны хамгийн чухал хөдөлгүүрийн нэг болсон тухай нийтлэл гарсан юм. "Vапйу Ра1г"-ийн эзэн Тина Браун сэтгүүлийнхээ нүүрэнд Деми Мурын бараг шалдан зургийг сонгож байв. Мэдээж спортын сэтгүүлүүд усны хувцас, мини бикини зэргийг байнга сурталчлах ба тэдгээр нь тухайн ондоо хамгийн сайн зарагддаг.

Сэтгүүлээ зарахын тулд сексийг ашиглая гэвэл ямар нэгэн бусдын хүршгүй эротик ба сонин хачин зүйл оруулах ёстой.

Сексийг бусад сэдэвтэй холбо |Секс ба спорт, секс ба хувцас, аялал, гимнастик, танилцах, нууц зөвлөмжүүд, сексийг аль нэг муу үр дагавартай аялалтай холбох, эсвэл сексээс болж гайхалтай жин хассан тухай гэх мэт|.

Хамгийн шилдэг сонин хачин байрлалуудыг санал болгох, дур тавих таван нууц, холливудын хамгийн секс таван залуу, бүсгүйг орондоо оруулах арван таван арга гэх мэт.

Дур алдам нүцгэн юмуу бараг нүцгэн биенүүдийн гэрэл зургийг байнга оруулах. Тэдгээр нь бие биетэйгээ ямар нэгэн байрлалд холбогдсон байх.

Сексийн тухай шинэ мэдээлэл өгөх, санаанд оромгүй байрлалууд, дур хөдөлгөх мэдэгдээгүй цэгүүд, анагаахын баримтууд.

Та сурвалжлагч бол таны мэргэжилд сексийг ашиглах хэлбэрүүдийг хэрэглэж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бараагаа зарахын тулд сексийг байнга хэрэглэдэг. Моника Левинский ба ерөнхийлөгч Клинтон нарын секс дуулиан тэдний хувьд алтан судал болсон. Сайн талын баатрууд, хорон санаатнууд, хоорондоо холбоотой хэд хэдэн дуулиант түүхүүд, гол дүрүүд бий болсон. Симпсоны шүүх

хурлаасхойш Америкт ийм дуулиан төрөөгүй байсан юм. Энэ түүхийн эргэн тойронд өрнөсөн хэрүүл маргаанаас болж Боснигийн дайн ба анагаахын шинэчлэл хүртэл мартагдсан. Түүний оронд амаар хийх секс нь секс мөн үү эсвэл тамхи татахтай адил юмуу гэх мэт сэдвээр маргаан явагдаж байв. Урьд өмнө сонин ба телевизээр огт гарч байгаагүй үг хэллэг ба үйлдлүүд харин одоо эрүүл сэтгэлгээтэй хүмүүсийн байнгын тайлбарлалт болж

хувирсан.

Хэрэв тухайн мэдээ нь үнэхээр дуулиантай бөгөөд маш сайн бэлтгэгдсэн байх юм бол хүмүүс шүүрэн залгидаг. 1996 онд 60 настай гоо сайхны хатан хаан Жон Бэна Рэмзаг алсны дараах тасралтгүй мэдээллийг сана. Түүний дур татам нүүр будалт, нойтон уруул ба өдөн дуудсан царай төрхтэй дүрсүүд телевиз ба сониноор тоо томшгүй хөвөрсөн. Хэрэв эдгээр секс зураг нь байгаагүй бол энэ аллага тийм их анхаарал татахгүй байсан юм.

Сэтгүүлч хүний хувьд таны толгойд ийм дуулиантай түүхийг нийтлэх эсэх, зөв эсэх, эсвэл нэр хүндтэй хэвлэл үүнээс болж шалдаа буух эсэх тухай ухаалаг асуулт орж мэднэ. Сэтгүүл бол сексийг ашигтайгаар ашигладаг зүйлсийн нэг. Өөр тоо томшгүй олон жишээ бий. Сексийг алдар нэрийн тулгуур болгон ашигладаг. Доктор Рут Вестхаймерын нэрийг нарийн хүрээнд мэднэ. Тэрбээр аялгатай яриагаа сексийн дохио болгон ашигладаг байв. Кендес Бушпель эхлээд хэвлэлд, дараа нь телевизэд өртөхийн тулд "секс ба хот" гэсэн хэллэгийг ашиглаж байв. [Нью-Йоркийн тухай түүний нийтлэл дээр үндэслэсэн телевизийн шоу тун муухай нэр зүүн үлдсэн]. Янхан Трэйси Квэн "Манхэттэний дуудлагын бүсгүйн өдрийн тэмдэглэл" бичсэн нь "Салон" сэтгүүлд нийтлэгджээ. Өөрийгөө сексийн шинжээч гэж зарлаарай. Энэ нь интернетэд сонирхол татаж амжилт олох чухал арга. Энэ сүлжээнд мэргэжилтэн ба хэрэглэгч байнга дутагдалтай байдаг.

xxx

Хэрэв та сексийг секс гэдэг утгаар нь ашиглахыг хүсч байгаа бол садар самуунаас зайлсхий. Секс таны хувьд сурталчилгааны зорилгоор ашиглах дүр төрх, өөр нэгэн хэрэгсэл, тохь тухийн нэг зүйл болж хувирна. Харин та сексийг байлдан дагуулалт ба таашаалын төлөө ашигладаг бол эрт орой хэзээ нэгэн цагт та садар самуунтай заавал нүүр тулна.

Садар самуун

Сексхурдан дуусдаг. Тэр урт бөгөөд тасралтгүй байх боломжгүй. Та хүрсэн дээрээ зогсч болохгүй. Эс тэгвэл өчигдрийн ялалт гайхамшигаа алдана. Тэгээд та үүрэг хариуцлага хязгаарлалтаар дүүрэн гэр бүлийн өдөр тутмын харьцаанд шигдсэнээ ойлгоно.

Та эрх мэдэлтэй, баян хөгшний эхнэр болжээ. Эхэндээ бүх юм таныг догдлон чичрэхэд хүргэнэ. Тансаг гэр орон, сайн идээ ундаа, гадаадад аялах гээд л, бас түүний найзууд ийм чухал хүмүүс байдаг гэдэгт итгэхгүй байсан. Харин одоо та яг түүний адил сайн дарсыг таньдаг болох үед тэр хүн таны мөрөөдсөнийг өгч чадахгүй болохыг ойлгоно. Түүний өвдөг суларч, тэр шатаар арай гэж өгсдөг.

Эсвэл та удтал хойноос нь гүйж эргүүлсэн сайхан эмэгтэйд өндөр нуруутай ах байдаг, эсвэл тэр бүсгүй самрыг тэвчдэггүй, эсвэл үргэлж өөртөө адреналин авч явдаг, эсвэл тэр амралтын өдрүүдээр таныг дагуулан алт мөнгөний дэлгүүрээр орох дуртай гэдгийг олж мэднэ. Тэр бүү хэл таны үс засалтыг өөрчлөх гэнэ.

Секс биднийг хайр дурлал ба дотно сэтгэлийн хүрээ рүү татан оруулдаг. Заримдаа зүгээр таашаал авчрах юмуу бидний өдөр тутмын уйтгартай амьдралыг өөрчилж өгдөг.

Шигтгээ: Жон сексийг хэрхэн ашиглав.

Компьютерийн бизнес олсон Жоны амжилт түүний хамгийн далд мөрөөдлөөс ч давжээ. Түүнийг хотын шинээр мандсан оддын нэгд тооцож сэтгүүлд нийтлэл хүртэл гарав.

Харин одоо Жон залуу, эрч хүчтэй, баян ба гүйлгээ ухаантай хүний дүр төрхөө байнга барьж байх ёстой гэж мэдрэх болов. Хэдийгээр Жон улам том төлөвлөгөөнд шатаж тасралтгүй ажиллаж байсан ч ажил хэрэгтээ нэг их цаг зардаггүй хүн царайлан аливаа баяр цэнгүүнд байнга ирнэ. Жон мөн л имиджээ барихын тулд 27 настай урт хөлтэй тачаангуй бүсгүйчүүдтэй ил тод харьцах бөгөөд цаадуул нь ч түүний найз бүсгүйн дүрд дуртайяа хувирах аж. Гэхдээ тэдний хэнтэй нь ч секс харьцаа байгаагүй. Түүнд ингэж явах цаг зав, эрч хүч ч байсангүй. Гэхдээ тэр олон түмэнд ганцаардмал харагдахыг хүссэнгүй.

Үе тэнгийнхэн нь түүн дээр атаархсан харц хаяхад ихэрхэг зан нь ханамж

авах аж. Үдэш бүр янз бүрийн ганган бүсгүйтэй явдагаас болоод сэтгүүлчид түүнийг гайхалтай донжуан хэмээн дүрсэлж гэрэл зураг нь сонин сэтгүүлийн хуудаснаас салахаа больжээ. Иймэрхүү нэр алдар Жоныг хэн нэгэн түнштэй харьцах үед хүйтэн уур амьсгал үгүй байхад тус болно. Учир нь тэд Жонтой уулзахаар явахаас бүр өмнө түүний тухай сонссон байдаг. Эмэгтэйчүүд түүнд байнга сонирхол төрнө.

Шигтгээ: Тина сексийг хэрхэн ашигласан бэ?

Тина Лос-Анжелесын Цаппи дахь нэгэн бааранд ажилладаг байлаа. Энэ бааранд рок од саятан Тор байнга суудаг. Тина үргэлж бие барьсан секс хувцас өмсөх бөгөөд Тор руу өдөн дуудсан харцыг шөнө бүр шиднэ. Саятан түүнийг эцсийн эцэст анзаарав. Тэд хэсэг хугацаанд уулзсан ч удалгүй холбоо тасарчээ. Тина жирэмсэн болоод зогсохгүй түүний хүслээр хийсвэр хийлгэхгүй гэдгийг Тор мэдсэн юм. Тина хэдийгээр жирэмслэх гэж зүтгээгүй ч хамгаалах гэж ч бас юу ч хийсэнгүй. Дрэгон хүүг мэндэлснээс хойш Тор эцэг гэдгээсээ татгалзаагүй бөгөөд одоо хүүхэддээ зориулан сар бүр 7 мянган долларыг Тинад төлдөг. Тина баарны ажлаа аль хэдийн хаяж одоо хүүгийн хамт далайн эрэгт ойрхон амьдрах болжээ.

Эрх мэдэл, алдар нэрд хүрэх зарчимууд

Ноён буюу эзнээс хэзээ ч давж гарч болохгүй. Өороор хэлбэл хамгийн гол хун тэрхуу дээрх байр суурин дээрээ тохитой сууж байх ёстой. Туунд сэтгэгдэл торуулэх юмуу тууний аяд нишцуулэх гэж хичээхдээ хэтрүүлж болохгүй. Ялангуяа авьяас чадвараа гаихуулахдаа болгоомжтой байгаараи. Эс тэгвэл эсрэг үр дүнд хүрдэг. Тэдэнд аидас юмуу үл итгэх байдал торуулж орхивол аюултай. Өороосоо дээш хумуусийг байгаагаасаа илуу гялалзахад нь туслаараи. Тэр цагт та оороо эрхмэдэл, алдар нэрийн оргилд хүрнэ.

Найз нохдод хэзээ ч хэмжээ хязгааргүй итгэж болохгүй. Даиснуудаа ашиглаж сур. Наиз нартайгаа болгоомжтой бай. Тэд атаа жотоонд амархан автах тул таныг худалдах нь хурдан. Ногоотэйгуур тэд даисан юмуу эрх танхи нэгэн болохдоо тургэн. Та оортоо зүтгүүлэхээр хуучин даиснаа дуудаарай. Тэд танд ямар нэг зүйл батлах хэрэгтэй учраас наиз нохдоос илуу уян байх болно. Үнэн хэрэгтээ та даиснаасаа илуу наиз нохдоосоо айх хэрэгтэй. Хэрэв та дайсангүй бол дайсантай болох аргыг бодож олоорой.

Зорилгоо нууж бай. Хумуусийг харанхуй байлга. Өорийн үйлдлийн далд зорилгыг хэзээ ч буу нээ. Хумуусийг тогтворгүй тэнцвэргүй байдалд байлга. Таны ямар алхам хиш хусэлтэй байгааг мэдэхгүйн улмаас тэд хамгаалалтаа хангаж чадахгүй. Тэднийг буруу мор хоолгож мананд тооруулж байгаараи. Таны жинхэнэ зорилгыг мэдэх үед бух юм ороитсон байх болно.

Хэрэгтэй гэснээсээ ургэлж багаярь. Хэл яриагаараа хумууст сэтгэгдэл торуулэх гэж хусэх үедээ их ярихын хэрээр хуч чадалгүй бусадтай адил мэт харагддаг гэдгийг санаж яваараи. Улиг болсон зуулийг ярихдаа хуртэл таашигуу, ямар нэг таилалгүй, тодорхой бус ярьж чадвал та бусдаас ондоо харагдана. Нолоо бухий хумуус юмыг дандаа дутуу ярьдагийн улмаас аидас тугээж, сэтгэгдэл торуулж байдаг. Та их ярихын хэрээр тэнэг юм хэлэх магадлал ондорсоно.

Нэр тороос маш их юм хамаардаг. Нэр тор бол амь насны үнэтэй. Нэр тор оороо эрх мэдлийн тулгын чулуу юм. Нэр ториин ачаар та аидас торуулж

үлмаар ялах болно. Харин нэр тор ганхах юм бол та эмзэг болж тал бүрээс довтолгоонд ортоно. Нэр тороо бат бох байлгаараи. Болзошгүй довтолгооныг сонор сэрэмжтэй хүлээж довтолгоонд ортохоосоо омо тас цооаж бай.

Анхаарлыг ямар ч үнээр хамаагүй олж ав. Бүхнийг гаднах торхоор нь шүүдэг. Нүдэнд харагдахгүй юм бол ямар ч үнэ цэнэгүй. Тиймээс саарал онготэй олны дүнд уусч болохгүй. Тодор, ямар ч үнээр хамаагүй нүдэнд тус. Соронз шиг олны харааг тат. Таны эргэн тойронд байгаа олон толов даруу эелдэг хүмүүсээс илүү таавар мэт, илүү гоё саахан, илүү том харагдах ёстой.

Бусдыг оорийнхоо толоо ажиллуулж үр дүнг нь ашигла. Өориин ажлыг урагшлуулахын тулд бусад хүмүүсийн ухаан, мэдлэг ба гүйдлийг ашиглаараи. Ийм тусламж таны үнэт цаг ба хүчийг хэмнэхийн хажуугаар танд бүхнийг амжуулдаг хүний бурханлиг торхийг хайрлана.

Таны туслагч нарыг бүгд мартана. Харин таныг дандаа санах болно. Бусад хүн таны омноос хишж чадах тиим ажлыг хэзээ ч бүү хий.

Хүмүүсийг оортоо оирхон байлга. Хэрэгтэй бол урхи хэрэглэ. Бусад хүмүүсээр үйлдэл хишлгэх үед та хүчтэй байх болно. Эсрэг хүн хувийн толовлогоогоо оорчилж тан дээр ирэх нь хамгийн ашигтай үйлдэл. Түүнд үлгэрийн ашиг амлаж довтол. Таны гарт бүх хозор биш.

Амжилтанд үйл хэргээр хүрч бай. Маргаан сорголдооний үед олж авсан мэт санагдсан хоромхон зуурын амжилт хоос болох нь амархан. Түүний оронд нэг ч үг хэлэлгүй харин үйлдэл хишж бусдыг зовшоорүүлэх нь хавьгүй илүү үр дүнтэй. Таилбарлах биш үзүүлэх хэрэгтэй.

Баясал цэнгэлгүй азгүй хүмүүсийн халдвараас зугт. Хэн нэг гадны хүний бүтэлгүй бүхэн таныг сүитгээжмэднэ. Учир нь сэтгэл санааны байдал нь яг овчин шиг халдвартай. Аз жаргалгүй хүмүүс гай зовлонгоо бусдад халдааж байдаг. Тиймээс та азтай, бас аз жаргалтай хүмүүстэй оирхон алхаж байгаарай.

Хүмүүс танаас хамаатай байхыг хичээ. Та бусдад хэрэгтэй чухал хүн байхын хэрээр бусдаас хамааралгүй болдог. Танд найдахын хэрээр та илүү эрх чолоотэй болно. Бусдын аж жаргал ба хөгжил цэцэглэл танаас хамааралтай байдалд оруул. Тэр цагт айх юмгүй болно. Хүмүүсийг оорийн хүчээр хийж чаддаггүй байлгахын тулд тэдэнд дандаа дутуу зааж огох хэрэгтэй.

Заримдаа олзоо гар нүцгэн болгохын тулд шударга огоомор байдал гарга. Шударга ба огоомор байдлын илэрхийлэл нь хамгийн хартай даисны сонор сэрэмжийг бохоодог. Цагийг нь олж барьсан бэлэг бас яг ийм зорилготой байдаг.

Хүмүүсээс тусламж гуихдаа тэднээс саихан огоомор сэтгэл юмуу оровч занг

хэзээ ч буу хулээ. Хэн ч ингэхгүй. Тууний оронд оорийнх нь хусэл шуналыг одоох ёстой. Та урьд омно тууний ажил хэрэгт саитар тусалсан байж болно. Одоо туунээс тусламж гуих гэж яваа бол онгорсон ачлалаа ярих хэрэг огт угуи. Тэр яаж шигээд л танаас зугтана. Тууний оронд хусэлт тавих, хэлэлцээ хийх үедээ туунд ашигтай ямар нэг талыг харуулах ёстой. Энэ ашгийг жолоогуй магтах учиртай. Тэр цагт оноох хун таны саналыг идэвхитэй дэмжинэ. Яагаад гэвэл оорт нь ашигтай учир.

Найзын дурд тоглож тагнуулч шиг аашил. Өрсолдогчоо мэдэх нь маш чухал. Үнэт мэдээлэл цуглуулахын тулд тагнуулчидыг ашигла. Ингэснээр та дайснаасаа нэг алхамын урд явах болно. Өороо тагнуулч болох юм бол бур сайн. Эелдэг эрхэмсэг яриа орнуулэх замаар далд санаагаа халхалж сураарай. Шууд биш тоируу асуулт тавь. Хариулт нь тэр хүний зорилго болоод сул талыг нээж огно. Ямар ч нохцолд сайн мордлого явуулах боломж байдгийг сана.

Даиснаа бут цохиж бай. Даисан сэргээд ошоо авна. Даисныг зовхон бие махбодийн хувьд биш сэтгэл санааны хувьд ч бүрэн цохих ёстой.

Өорийн эзгүй байгааг ашиглан нэр тор ба алдар хундээ осгох хэрэгтэй. Өлны дунд хэт

идэвхитэй эргэлдэх нь таны унэ цэнийг унагана. Та хэт их харагдаж сонсогдохын хэрээр ершин нэгэн мэт санагдана. Та нэгэнт тодорхой баир суурьт хурсэн бол тур хугацаагаар алга болох нь таны тухай их ярих, тэр буу хэл танаар бахдах уур амьсгалыг уусгэдэг. Тагцхуу хэзээ явахаа тодорхойлж сурах хэрэгтэй. Аливаа юм хомсдолд орох уед унэ цэнэ нь осдог билээ.

Цаг ургэлж урьдчилан таашигуу уур амьсгалыг бурдуулж бай. Хун гэдэг бол бусдын уйлдэлээс сайн танил зуилээ хаиж олохын донтой амьтан юм. Тэгэхээр та урьдчилан таашигуй байх ёстой. Харахад ямар ч утга учиргүймэт ийш тийш усчсэн замбараагуу уйлдэл хумуусийн тэнцвэрийг алдагдуулж таны уйлдлийг таилбарлах оролдлого хиин тэвчээрээ барахад хургэнэ.

Өоригоо хамгаалахын тулд хана хэрэм буу босгоорой. Өоригоо тусгаарлах нь нэн аюултай. Хорвоо дэлхий аюулаар дуурэн. Энд тэндгүй дайснууд биш. Хун бур л ооригоо хамгаалах хэрэгтэй. Уг нь бат бох хэрэм цаиз хамгийн наидвартай хорогдох баир мэт санагдаж байна. Тэтэл ингэж тусгаарлах нь биднийг хамгаалахаас илуу улам илуу аюулд учруулж байдаг. Үнэтэй мэдээлэл авах боломжийг хааж бас эмзэг хэтэрхий тод бай болгоно. Хумуусийн дунд байж холбоотон олох нь чухал. Дайснудаас оорийгоо хумуусээр халхалж яг бамбай шиг ашиглаж сураарай.

Хэнтэй учирсанаа мэдэж бай. Волохгуу хунийг гомдоочих виш дээ. Энэ хорвоо дээр янз бурийн зан аранинтай хумуус байдаг. Таны нэг торлийн аргад хун бур ижил хариу зуулэхгуу. Та хэн нэгнийг аилгаж, хэн нэгнийг зальдаж болно. Тэтэл зарим нь дуугуй онгорох атал ногоо нэг нь ухэн ухтлээ ошоо авдаг. Хонины арьстай чононууд олон. Тиймээс сорголдоч юмуу олзоо сонгохдоо нягт байх ёстой. Болохгуу хунийг гомдоохоос болгоомжил.

Хэнтэй ч буу нэгд. Хамгийн тэнэг хун л аль нэг талыг барьдаг. Оороосоо оор хэнд ч буу итгэ. Ялангуяа уурэг амлалтаар бусадтай оорийгоо гагнаж болохгуу. Тусгаар байдлыг хадгалсанаар та эрхмэдэлтэй байх болно. Хумуусийг хооронд нь сорголдуулэхэд тэд таны араас дагах болно.

Мунхагийг хуурахын тулд мунхаг мэт аашил. Тэнэгийг зальдахын тулд туунээс илуу тэнэг харагд. Яагаад гэвэл адгийн тэнэг ч бусдаас тэнэг гэдгээ хүлээдэггүй. Тэгэхээр бусдыг ухаантай мэт санагдуулж чадаж байгаа хун илуу зальтай. Зугээр нэг ухаантай биш танаас илуу ухаантай мэт сэтгэгдэл оорт нь торуулж чадвал та зальтан. Ингэж итгэсэн хун таньд далд санаа байгаа гэдгийг хэзээ ч сэжиглэхгүй.

Уг дуугуу бууж огох арга хэрэглэ. Сул талыг хуч болгож сур. Хэрэв та сул дорой байгаа бол зовхон нэрээ бодон тулалдах хэрэггүй. Тууний оронд уг дуугуу бууж ог. Бууж огсоноор та шархаа нохох цагтай болно. Мон дайснаа зовоох тав тухыг нь алдуулах улмаар хуч чадал нь барагдахыг хүлээх цагтай болно. Таныг бүрэн тогс ялж таашаал авах боломж буу ог. Туунээс омо бууж ог. Бууж оголт нь эрхмэдлийн зэвсэг болох тохиолдол тун олон.

Хучээ товлоруул. Хамаг чадал, эрч хучээ товлоруулж хадгал. Хамаг хучээ товлоруулж байгаад таныг ондорт гаргах нэг л тулхуурийг барьж авах ёстой. Олон унээ биш суутэй ганц унээ эзнээ он удаан жил тэжээдэг.

Яг ордны хун шиг аяглаж сур. Жинхэнэ ордны эрхэм улс торшин хор наируулга, эрх мэдлийн тогоон дотор цэцэглэж чаддаг. Энэ хун далд утгын мастер. Тэр бялдууч. Тэр ухарч бууж огно. Бас барьцгуу, их гоёмсог аягласаар нэг л мэдэхэд бусдын дээр гарчихсан байдаг. Ордны хуулийг судалж хэрэглэсэн тохиолдолд та зогсолтгуу осох болно.

Оориугоо дахин бутээ. Ниигэм танд тулгаж байгаа дурд буу хувир. Оориугоо дахиад бутээх ёстой. Олон ниитийг хэзээ ч уйдаахгуу, тэдний анхаарлыг баинга татах шинэ хувь хунийг зор. Бусад хумуус таныг тодорхойлохын оронд та оороо гадаад торхиинхоо бутээгч байсан нь дээр. Таны олон ниитийн ажил хэр яваа, олны омо гарах байдал жуужигчин мэт байвал зохино. Таны эрх мэдэл нэмэгдэж таны дур торх амьдралаас илуу агуу мэт үзэгдэх болно.

Тараа цэвэр байлга. Та ажлын чадавхиа журамт байдлын улгэр жишээ байх ёстой. Таны гар бохир уул хэрэг болоод алдаанд сэвтээгуу. Толбо суугаагууэнэ торхийг хадгал. Хуний гараар могой барьж оориин оролцоог нууж сур

Хумуусийн хэрэгцээн дээр тоглож таны шүтэн бишрэгчидийн армииг бий болго. Угаасаа хумуус ямар нэг юманд итгэх агуу хусэлтэй байдаг. Ийм хусэл нь бол. Тэдэнд шинэ итгэл огч дагуул. Таны яриа тодорхой бус мортлоо их ирээдүйтэй байх ёстой. Оюун санааны хурц тод байдал болоод ухаанаас сэтгэл хөдлөлийг дээр тавь. Танд итгэж дагасан хумууст ёс заншил бий болго. Тэд энэ ёс заншилыг гуицэтгэж таны омоос золиосонд гарахад бэлэн болно.

Ажил хэрэгтээ ямар ч эргэлзээгуу орж бай. Хэрэв ажил хэрэг хэрхэн явагдахад итгэлгүй байгаа бол эхлэхийн хэрэггүй. Таны эргэлзээ тээнэгэлзэл гуицэтгэлд саад болно. Эргэлзэх аюултай. Итгэлтэй эхэлбэл дээр. Зоригтой хун л хотыг эзэлдэг гэдэг. Даруу зан нэр тор авчирах нь ховор.

Вухнийг дуустал нь толовло. Төгсгол бол хамгийн гол нь. Туунд хурэх бух замыг толовло. Таны хунд хөдөлмөрийг юу ч биш болгож алдар нэр бусдад очиж мэдэх бух азгүй тохиолдол, саад бэрхшээл, ур дагаврыг тооцоол. Хэрэв та бухнийг дуустал бодсон бол аливаа нохцол байдал таныг зогсоохгүй ба хаана зогсохоо та оороо мэднэ. Олон нуудлийн цаадахийг бодож ирээдүйг тодорхойлж, азийг хонгохон чангаа.

Амжилтанд хурэхдээ зудэрсэн байдал буу харуул. Таны үйлдэл хонгохон хийгдэж буу мэт, мон байх ёстой зуил мэт л санагдах учиртай. Туунд оруулсан бух заль мэх холс хөдөлмороо нуу. Хун харахад нэг их хуч гаргалгуу хүрсэн мэт бай. Вур очноон ихийг хишж чадах мэт. Хичнээн их хөдөлмөрлөсөн гэх мэт сагсуу яриаг хэзээ ч буу дурс. Өориин арга залиг хэнд ч буу ярь. Эс тэгвэл таны эсрэг хэрэглэх болно.

Вух замуудыг хяна. Вусад хумуус таны тараасан хөзрөөр л тоглох ёстой. Хумуус оорсдоо сонголт хийж байгаа мэт сэтгэгдэл торуулэх нь шилдэг хууралт юм. Таны олз сонголт хиш эрх чөлөөтэй мэтээр тосоолох ёстой. Үнэн хэрэгтээ тэд ердөө л утсан хуухэлдэй юм. Ямар ч сонголт хийсэн та хожих тийм замуудыг заа. Хун хоёр зовлонгийн багыг нь сонгодог. Харин сонгосон зам нь таны зорилгод үйлчлэх учиртай. Хаашаа ч явсан шуд дуурэн байх тийм л замыг хумуусийн омо тавь.

Хумуусийн мөроодол дээр тогло. Үнэн гэдэг оороо үзэшгүй муухай болоод царай муутай тул

бугд зугтдаг. Хэрэв та хусэл мороодол нь нурсан хумуусийн уур хилэнд шатахыг ул хусвэл үнэн болоод бодит байдлыг бууярь. Амьдрал оороо их харгис хатуу богоод гашуун билээ. Тиймээс хумуус цолийн дундах баян бурд шиг мороодлийн арал уусгээд туундээ тэмуулдэг. Олон нийтийн мороодлиг залах нь агуу эрх мэдэл юм.

Хун бурийн сул талыг мэдэж бай. Хун болгонд сул тал бий. Хана болгонд цууралт бий. Вусдаас нууж эдэлдэг бяцхан жаргал, их шунал, сэтгэл ходлолоо хянаж чаддаггуи байдал, уур хилэн, оортоо итгэлгуи хулчгар байдал гээд хун болгонд бии. Сул талыг нь олохл юм бол туун дээр байнга дарж тамлан оортоо ашиг гаргана.

Хаан шиг биеэ авч яв. Тэгвэл хумуус хаан шиг хандах болно. Та ооригоо ямар байдлаар барьснаас хумуус хэрхэн хандах нь тодорхойлогддог. Шалиг дорой, саарал амьтан харагдах юм бол хэн ч хундлэхгүй. Хаан оороо ооригоо хундлэх

богоод бусдаас үүнийг шаарддаг. Итгэлтэй, эрхэмсэг байснаар титэм омсох нь зовхон таны хувь зохиол мэт сэтгэгдэлийг бусдад торүүлнэ.

Цагийг удирдах аргыг эзэмш. Яарч байгаагаа хэзээ ч бүү харуул. Яарах нь оорийн цаг болоод ооригоо удирдаж чадахгүй хүний шинж юм. Үргэлж таиван бай. Эцсийн эцэст бүх юм таны гарт оороо ороод ирэхийг мэдэж байгаа мэт бай. Цагийн онго аяс, тухайн үеийн урсгалыг мэдэрч таныг эрх мэдэлд хүргэх тэр мочийг олж сур. Цаг нь ирээгүй бол хажуу тийш зайл. Харин цаг нь ирвэл бүх хүчээрээ тэмц.

Эзэмшиж чадахгүй зүйлээ жигш. Үл тоох нь шилдэг ошоо авалт. Жижиг зүйлийг том асуудал болгосноор түүнийг амьдруулж хүч чадал огно. Даисандаа анхаарахын хэрээр тэр хүчирхэг болдог. Жижиг алдааг засах гэж оролдох үед илүү том томруун болж ирдэг. Ваигаагаар нь хаях нь ихэнхидээ зов. Та хүсч байгаа боловч оорийн болгож чадахгүй ямар нэг зүйл байгаа бол үл тоо. Та сонирхохоо байхын хэрээр бусдын хувьд үл хүрэх оргил мэт санагдаж эхэлнэ.

Шртагдашгүй үзэгдэл торүүл. Хуриц гадаад торх, бэлэг дэмбэрэлтэй гоёмсог үйл ходлол нь эрх мэдлийн тосооллийг бий болгоно. Тиймээс эргэн тойронд байгаа хүмүүсийн дунд жүжиг тавих ба тэр жүжиг нь гэрэл цацруулсан, хараа булаасан, сэтгэл ховсолзүүлсэн үйлдлээр дүүрэн байх ёстой. Энэ бүхэн таны оролцоог улам тодруулна. Нүд гялбуулсан туяан дунд та үнэн хэрэгтээ очүүхэн багыг хиисэн гэдгийг хэн ч олж харахгүй.

Хүссэнээ бодож, харин бүхэн шиг ходол. Та цаг хугацаанаас орсч, оноо үеийг эсэргүүцэж, хэний ч толгойд тороогүй санаа ярьж, хэнд ч боломжгүй мэт санагдах замыг заах тусам хүмүүс таныг үнэлэхээ болино. Тэд таныг оорийгоо хэт ондорт тавьж худал дүрэмдэхээс оор юмгүй хүн хэмээн дүгнэдэг. Вас ооригоо ондорт тавьсны чинь толоо хүмүүс таныг ишигтгэх болно. Түүний оронд олон түмэнтэй хутгалдаж, тэдэн шиг сэтгэж байгаа мэт байхын хэрээр аюулгүй. Харин оорин овормоц бодол санааг хамгийн тэвчээртэй наиз юмуу энэ бүхэн гарцаагүй таалагдах хүнд яриарай.

Загас барихын тулд усыг булингартуулдаг. Уур хилэн бол эрх мэдэлд хүрэх гэж байгаа хүний хамгийн хэрэггүй даисан. Хэрэв та эрх мэдэл, алдар нэрд хүрэхийг хүсч байгаа бол цаг

ургэлж тайван байх ёстой. Таны тайван байгаагийн хэрээр дайсан улам уурлах ба эцсийн дүнд та маргашигүи давуу талтай болдог.

Үнэгүи одриин хоолноос шууд татгалзаж бай. Үнэгүи санал болгож байгаа бүхэн аюултай. Үүний цаана шилдэг заль нуугдана. Эсвэл таныг дорлох гэж байна. Юм бүхэн үнэтэй. Толбороо дор нь хиисэн хүн бусдын орно ортэй болж, түүнд талархах, долгинох эсвэл хууран мэхлэх шаардлагагүй болно. Ер нь эрх мэдэлд хүрэх гэж байгаа хүн толбороо шууд бүрэн хиих нь ухаалаг алхам байдаг. Хэмнэхийн хажуугаар эрхмэдэл, алдар нэрийн тавцан дээр гялалзах боломжгүй. Хэрэв эрх мэдэл, алдар нэрд хүрэх гэж байгаа бол монгийг бүү хаирла. Монго таны толоо ажиллах ёстой. Өгоомор зан бол эрх мэдэлтэй хүний үндсэн шинж.

Вас өгөөмөр зан л эрх мэдэл, алдар нэрийг дагуулж аечирдаг.

Агуу хумуусийн мөрөөр буу алх. Хамгийн анхны юм ургэлж илуу, ургэлж өөөрмөц санагдах ба хөжжим гарч ирсэн бүхнээс дээр мэт байдаг. Та агуу хуний ургэлжлэл, эсвэл агуу хуний хуухэд бөл тэднээс илуу харагдахын тулд тэдний амжилтыг хөөр дахин нугалах хэрэг гарна. Агуу хуний суудэрт өрөөл тууний өнгөрсөн дөтөр хөлилдөж алга бөлнө. Өөрийн нэр ба хуеь хунийг бүтээж чадах ёстөи. Эрх мэдэл, алдар нэртэй эцгээс татгалз. Эцгийн буудгэр гэрэлд биш, харин өөрөөсөө гэрэл цацуулж чадеал эрхмэдэл, алдар нэрд хурнэ.

Ихэнхидээ ганцхан хучирхэг хуеь хун маш их гай тарьдаг. Өөрийгөө хэт өндөрт таеьсан, амгалан байдлыг эедэгч, нийгмийг уймуулэгч нэг л хун гай аечирна. Ийм хумууст хөдлөх талбар өгчих юм бөл бүх хумуус тууний нөлөөнд аетдаг. Тэдний гай өсөхийг дуугуи хүлээх хэрэггүй. Тэдэнтэй төхирөлцөх гэж буу өрөлд. Ямар ч наидеаргуи. Тэднийг өлнөөс ямар нэг аргаар тусгаарлаж, өлнөөр жигшүүлэх замаар нөлөөг саармагжуулна. Манлаилагчийг зайлуулмагц хурээлэгчид нь тарж зугтдаг. Малчинг буудчихеал хөнин сурэг тарж өдөхмэт.

Хумуусийн ухаан бөлөөд зурхийг эзэмд. Хучирхишлэл эцсийн дунд таны эсрэг эргэнэ. Хумуус таны зугт хөдлөхүйц хөрхөйг нь төруул. Ийм хумуус үнэнч цэрэг бөлдөг. Хумуусийн хөрхөйг хургэхийн тулд сул тал бөлөөд сэтгэл зүйн хуеийн өнцлөг дээр нь төглөнө. Сэтгэлээр нь төглөж эсэргууцлийг сулруулна. Хумуусийн аидас бөлөөд үнэт зүйлсээр нь төглөх ёстөи. Хуниухаан ба зурхийг төөхгүй баиеал эцэст нь тэд таныг үзэн ядна.

Өөрчлөлт хэрэгтэй хэмээн уриал. Тэхдээ хэт их өөрчлөлтөөр буу хөөцөлд. Өөрчлөлт хэрэгтэй гэдэг нь хун бурт өилгөмжтөи. Тэеч хумуус энэ өдрөөрөө амьдардаг учраас дадал зуршилтай бөлсөн байдаг. Хэт их өөрчлөлтийг хүлээж аеах чадеаргуи. Үимээн самуун уусдэг. Та эрх мэдэлд тэмуулж байгаа юмуу эсвэл дөнгөж сая эрх мэдэлтэй бөлсөн бөл хуучин арга барилыг хундэлж байгаа мэт жуужиг таеих ёстөи. Хэрэе өөрчлөлт зайлигуй шаардлагатайг мэдэж байгаа бөл өнгөрсөнийг бага зэрэг засч байгаа мэт төрх уусгэнэ.

Хэзээ ч хэт төгс мэт буу харагд. Бусдаас илуу мэт харагдах нь ургэлж аюултай байдаг. Тэтэл ямар ч сул тал нугэлгүй мэт харагдах нь бур аюултай. Атаа жөтөө хамгийн өлөн нууц дайсныг төруулдэг. Ухаалаг хун уе уе сее узуулж байдаг. Хөргуи алдаануудаа хүлээх замаар атаа жөтөөнөөс хамгаалдаг.

Зөрилгөөсөө цааш буу алх. Ялмагцаа хэзээ зөгсөхөө мэдэж бай. Ялалтын агийн бөл хамгийн

аюултай мөч байдаг. Ялалтандаа шатаж, өөртөө хэт итгэсэн хун зөрилгынхөө хажуугаар цаашаа алхдаг. Хэт лаеширах тусам улам өлөн даисантай бөлж ялж чадахгүйд хурнэ. Саитар бөдөх ба төлөөлөх маш чухал. Зөрилгөө төдөрхөйлөөд хурэнгуутээ зөгсөж сурах хэрэгтэй.

Ямар ч хэлбэргүй бай. Төдөрхөй хэлбэртэй, ил төд төлөөлөгөөтэй бөлөх үед

та бусдын довтолгоонд оорийгоо нээж огно. Хэлбэрт орж дайсандаа довтлох боломж олгохгүйн тулд баинга оорчлогдож бас ходолж байх хэрэгтэй. Монхиин хууль гэж байдаггүй. Бас үргэлж тодорхой юм ч гэж байдаггүй. Өориугоо хамгаалах хамгийн сайн арга нь ямар ч хэлбэргүй, урсамтгай яг ус шиг байх явдал. Бүх юм хувьсан оорчлогддог.

Аль нэг салбарт нэрд гараагүй бол нэр алдар, эрх мэдэлд хүрэх тун хэцүү.

Өлонхи таньдаг хүмүүстээ эрх мэдэл огч, алдар нэр хайрладаг. Тэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар танилцдаг.

Нийгмийн амьдралд идэвхитэй оролцох явдал чухал түлхэц болдог.

Хэрэв та нэр хүндтэй хүн байхыг хүсвэл сэтгүүлчидтэй харьцах харьцаандаа онцгой анхаарах ёстой. Яаж ийгээд тэднийг найз нохдоо болговол зохино. Сэтгүүлчидтэй хэзээ ч муудалцаж болохгүй.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл имиджийг осгодог гэдгийг хатуу ойлгож аль болох тэднийг ашиглан оортоо реклам хийхийг хичээх ёстой.

Нэгэн зорилготой тасралтгүй үйлдэл аливаад амжилтанд хүргэдэг.

Тал засах, ухрах, бусдыг туушын соёлтой мортлоо хатуу чанга харьцаагаар эрхэндээ оруулах зэрэг олон урлагт суралц.

Өориугоо хэзээ ч бусадтай харьцуулах ёсгүй. Ингээж харьцуулбал хэзээ ч амжилт олдоггүй аж. Харин оориугоо энэ хорвоод давташгүй ганц хувь хэмээн итгэж оориинхоо хүч чадал ирээдүйд итгэлтэй байгаа хүн л амжилтанд хүрдэг жамтай.

Өлны омо гарч ичиж зоволгүй ярьж илтгэдэг чадвартай байвал зохино. Энэ бол оортоо итгэлтэй байгаагийн нэг хэлбэр. Итгэл торохгүй бол сонгохгүй.

Хүмүүсийн хэрэгцээн дээр тоглох хэрэгтэй. Тэр цагт таны шүтэн бишрэгчдийн арми бий болно. Угаасаа хүмүүс ямар нэгэн юманд итгэхийг л хүсдэг. Та энэ хүслийнх нь үзүүр болоорой.

Таны царай торхийг бараг хүн бүхэн мэддэг болгох ёстой. Хамгийн шилдэг арга нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл байдаг. Нийгэмд хэн хэрэгтэйг хэвлэлд мэдээллийн хэрэгсэл шийдэж байна. Зурагт ба сониноор баинга гарч байгаа хүмүүсийн алдар нэр хэмжээлшгүй осдог. Нэг үгээр хэлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь оддыг торүүлэгчид юм. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр аль болох олон гарах тусам олон хүн түүнд итгэж дагаж эхэлдэг. Их бага том

жижиг гэлтгүй бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй найрсаг хандаж өөрийгөө сурталчилах хэрэгтэй. Өороо өлны нүдэнд хурц гялалзах имиджтэй, ажил уйлстэй, ямар нэг уилдэлтэй байвал зөхинө.

Муу уг буриг угсийн сангаасаа бурмосон авч хаян дандаа сайн саихан оодрог зуил ярьж баи. Амыг ажил дагадаг гэдэг.

Сонинд ярилцлага огох нь хамгийн хямдаас гадна мэдээллээ дэлгэрэнгүйхургэх боломжтой. Бас нэг давуу тал нь хумуус сонинд маш их итгэдэг. Мон нэг сонинг доод тал нь таван хун дамжуулж уншдаг гэсэн тооцоо байдаг.

Өортоо итгэхгүй байвал эрх мэдэлд хурэх боломжгүй. Эргэлзээ тээнэгэлзэл таны хуслийг нураана. Харин оортоо итгэлтэй уед та гарцаагүй ялалт байгуулдаг.

Вух саад бэрхиээл, ур дагаварыг заавал тооцоорой. Цаг зуурын нохцол байдал саад бэрхиээл танд юу ч биш.

Хуний бутэлгуитлийн хамгийн гол эх сурвалж нь аудас байдаг. Айдаст автсан хун юу ч хийж чадахгүй. Вусад хумуус ч гэсэн таныг аилгахыг л эрхэлмэнэ. Эрх мэдэл, алдар нэрд хурэхэд хатан зоригтой болж боловших заилшгүй шаардлагатай. Аймхай хунийг одорт арав ухуулж болдог. Хэн ч юу ч гэж хэлж сурдуулж дарамталж байсан аихгүй байж сураарай. Танд юм ярьж байгаа хумуусийн 99,9 хувь нь зовхон оориин болоод бусдын аудсыг ярьж дамжуулж байгааг та хатан зоригтой болсон тэр цагаасаа мэдэрч эхэлнэ. Инээд хурэх болно.

Хумуустэй уулзаж ярилцахдаа оориинхөө тухай биш зөвхөн түүний тухай л яриад байх ёстой. Хумуус өөрийнхөө тухай яриаг л сөнсдөг. Их урт яриа ярьж өгт бөлөхгүй. Өлөнхи хумуус урт яриа сөнсөх чадваргүй байдаг.

Таны нэр уе уе сөнин хэвлэлээр гарах тусам өөртөө итгэх итгэлийг тань улам бадраана. Хэвлэл мэдээллийнхэн тантай уулзах сөнирхөл их бөлнө.

Нэрд гарахыг хусэгч хэн ч байлаа гэсэн аилгүй худлаа ярьж сурвал зөхинө. Ялангуяа хунд хэцүү хуухэд насны тухай улгэр зөхиөж ярих нь тун хэрэгтэй байдаг.

Өөртөө итгэлтэй байх нь амжилтын дөхиө юм. Хумуусийн анхаарлыг аль бөлөх өөртөө татах уилдэлүүд хийнэ. Уулнаас цанаар гулгах, жөнглёр хийх, мөдөнд авирах зэргийг сурч хэвлэл мэдээллийнхэн гуилдэнэ.

Наргианч зан заавал байх ёстой. Хурц наргиантай яриатай хумуусийг өлөн нийт өөрийн мэдэлгүй дагаж байдаг.

Хуухдэд их хайртай гэж олонд харагдах ёстой. Ингэхэд улс торчид яагаад дандаа хуухэд унсэх юмуу тэвэрч зургаа авхуулдаг вэ? Халамжит эцэг, эх гэсэн оилголт олон мянган хунийг таны толоо саналаа огоход хургэдэг.

Сонин хачин цуглуулга хиш явдал нь тухайн хунийг олны анхааралд ортуулэх улмаар олны танил болоход нэн тустай байдаг. Яагаад ч юм хун зурагт юмуу сонин хэвлэлд гарахад цуглуулгын тухайяриа нь бусдын ой санамжинд бох бат улддэг ажээ.

Хумуусийн ул дэвших бас нэг шалтгаан бол бусдыг буруутгадаг явдал юм. Үнэндээ хамгийн гол буруутан нь хун оороо л байдаг. Өодлох дэвших зам маш огсуур хунд хэцүү. Та бусдыг буруутгаж биеэ омоорохоо боль. Элдэв хундрэлгүй, асуудалгүй амьдрал хаана ч угуи. Тулгарсан хундрэл бурт нэг саин тал заавал байдаг. Яг энэ саин талыг олж хараад ашиглаж сурч чадсан тэр уеэс та дэвшиж эхэлнэ.

Хун эхэлж бодоод дараа нь уйлдэл хиидэг. Харин бодохын тулд оортоо хэлэх угээ анхаарч хянах ёстой. Хэрэв та оортоо болохгүй, бутэхгүй, чадахгүй хэмээн ярьж эхэлбэл яг л энэ ёсоор болно.

Эрх мэдэл, алдар нэр олж авах олон арга замуудын нэг нь нолоо бухий хунтэй оиртох, харьцах, шадарлах, нохорлох, туншлэх, хамтрах явдал юм. Энэ хэрээр ч хииморьтой амьдардаг.

Ямар ч доромжлол шуумжлэл ирж байсан ч санасандаа заавал хурэхийн тулд зоригтой, мохошгүй бай.

Table of Contents

Эрх мэдэл

Нэгдүгээр бүлэг. Эрх мэдэл гэж юу вэ?

Хоёрдугаар бүлэг. Эрх мэдэлтэй болох найман үндсэн арга зам

Гуравдугаар бүлэг. Эрх мэдлээ харуул

Дөрөвдүгээр бүлэг. Эрхмэдлээ бүү алд

Тавдугаар бүлэг. Эрх мэдэлд урам хугарах

Мөнгө

Зургаа дугаар бүлэг. Мөнгөөр аз жаргалыг авч болох уу?

Долоо дуугаар бүлэг. Мөнгөтэй хүн

Найм дугаар бүлэг. Мөнгө ба таашаал

Ес дүгээр бүлэг. Мөнгө ба шунал

Арав дугаар бүлэг. Мөнгө ба зорь

Арван нэгдүгээр банк. Мөнгөөр эрх мэдэл ба алдар нэрийг худалдаж авах

Арван хоёрдугаар бүлэг. Мөнгөний гай

Алдар нэр

Арван гуравдугаар бүлэг. Алдар нэр ба бүхний танил хүн

Арван дөрөвдүгээр бүлэг. Алдар нэртэй болох арга замууд

Арван тавдугаар бүлэг. Дүр бүтээх

Арван зургаадугаар бүлэг

Арван долоодугаар бүлэг. Төгсгөлийн хэсэг

Секс

Арван наймдугаар бүлэг. Секс ба далд зорилго

Арван есдүгээр бүлэг. Эрчүүд сексийг юунд ашигладаг вэ?

Хорь дугаар бүлэг. Эмэгтэйчүүд сексийг юунд ашигладаг вэ?

Хорин нэгдүгээр бүлэг. Гэр бүл ба бэлгийн тогтмол харьцаа

Хорин хоёрдугаар бүлэг. Эрх мэдэл, мөнгө ба алдар нэрийн эротик төрх

Хорин гуравдугаар бүлэг. Секс мөлжлөг

Хорин дөрөвдүгээр бүлэг. Садар самуун

Эрх мэдэл, алдар нэрд хүрэх зарчимууд